



ISBN: 978-9919-0-4700-9
МОНГОЛ УЛС
СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛЬ
БОТЬ 3 (2025 №1)

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№3 (2025 №1)

Редакцын зөвлөл:

Эрхлэгч, Ерөнхий редактор: Д.Эрдэнэчимэг доктор (Ph.D),
профессор

Гишүүд: Б.Мөнхбаяр доктор (Ph.D)
Т.Пүрэвсүрэн доктор (Ph.D), профессор
Б.Дэнсмаа доктор (Ph.D), дэд профессор
Д.Бямбадорж доктор (Ph.D)
Ц.Цогзолмаа доктор (Ph.D)

Сэтгүүлийн нарийн бичгийн дарга: Б.Мөнхбаяр
Ботийг эрхэлсэн: М.Мөнхцэцэг, Б.Мөнхбаяр

Улаанбаатар
2025



**Соёл эрдэм дээд сургуулийн Эрдмийн зөвлөлийн
2025 оны 2-р сарын 25-ны өдрийн хурлаар
хэвлэхийг зөвшөөрөв.**

Эрдэм шинжилгээний бичиг –III боть (2025 №1)-д СЭДС-аас 2024 оны 8-р сарын 4-нд Япон улсын Элчин сайдын яам болон Японы Обирин их сургуультай хамтран зохион байгуулсан “Монгол-Японы эрт, эдүгээ, ирээдүй” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний ээлжит бага хурлаар хэлэлцүүлсэн эрдэмтэн судлаачдын илтгэлүүд орсон болно. Тус хуралд Япон улсаас суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд **Игавахара Масарү**, Оберин их сургуулийн Ерөнхийлөгч, профессор **Хатаяма Хироаки** нар хүрэлцэн ирж оролцсоныг онцлон тэмдэглэж байна. Мөн ботид хэл шинжлэл, утга зохиол судлал, орчуулга зүй, соёл судлалын чиглэлээр эрдэмтэн судлаачдын сүүлийн үед бичсэн эрдэм шинжилгээний өгүүлүүдийг толилуулж байна.

Эрдэм шинжилгээний бичиг [SCIENTIFIC JOURNAL]

Соёл эрдэм дээд сургуулийн гадаад хэл шинжлэл, хэл бичиг, мэдээллийн технологийн эрдэм шинжилгээний цуврал. Уб., 2025, 168 х

Өсөх пресс ХХК-д хэвлэв.

ISBN: 978-9919-0-4700-9

ННА-81

ДАА-403

ХАЯГ:

Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, I хороо, Олимпын гудамж,
Соёл эрдэм дээд сургууль.
Шуудангийн хайрцаг 48/88

И мэйл хаяг: info@soyolderdem.edu.mn

Веб сайт: www.soyolderdem.edu.mn

Page: <https://www.facebook.com/soyolderdemedu>

Утас: +976 70116947, 70118584

Факс: 11-328584, 11-326947

“Эрдэм шинжилгээний бичиг”- III боть (2025 №1)

-ийн хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Өсөх пресс ХХК

Цаасны хэмжээ: B5, 17,6x25,

Хэвлэлийн хуудас: 14 хх

Хэвлэсэн тоо: 200 ш

copyright©Соёл эрдэм дээд сургууль, 2025

ГАРЧИГ

“МОНГОЛ-ЯПОНЫ ЭРТ, ЭДҮГЭЭ, ИРЭЭДҮЙ” ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ЭЭЛЖИТ БАГА ХУРЛЫН НЭЭЛТИЙН ҮГ

| | |
|--------------------------|--|
| Макихара Сончи: | Соёл Эрдэм дээд сургуулийн УЗ-ийн дарга, Японы Оберин их сургуулийн хүндэт доктор.....6 |
| Хатаяма Хироаки: | Оберин их сургуулийн Ерөнхийлөгч, профессор8 |
| Игавахара Масарү: | Япон Улсаас Монгол улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд12 |

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛҮҮД:

| | |
|------------------------------------|--|
| Fasc 1. Л.Дашням | Монгол мал- Залуучуудын анхааралд14 |
| Fasc 2. Хори Киёоши | Эдийн засгийн хөгжил болон жижиг дунд үйлдвэрлэл -энтрепренерүүдийн гүйцэтгэх үүрэг18 |
| Fasc 3. Тозаки Хажимэ | Аялал жуулчлалын хөгжлийн бодлогыг дэмжих зорилгоор Монгол, Японы хамтын ажиллагааг эрчимжүүлэх тухай27 |
| Fasc 4. Ж.Баатарцогт | Монгол, Японы хоорондын соёлын харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх асуудалд38 |
| Fasc 5. Б.Мөнхбаяр | Монголын шинэ үеийн анхны дуу ба Хятад, Японы соёлын нөлөө43 |
| Fasc 6. Г.Суурь | Бүх нийтийн боловсролын системийн төрөлжүүлэх боломж: Монгол улсын авьяаслаг сурагчдад зориулсан гүнзгийрүүлсэн сургалт ба улсын төрөлжсөн олимпиадын тогтолцооны жишээн дээр51 |
| Fasc 7. Киношита Масаюки | Суралцахуй ба хөдөлмөр эрхлэлт Learning and Labor – Оберин их сургууль үйлчилгээ сургалтын тухай.....56 |
| Fasc 8. Б.Туул | Монгол, Япон хэлний “Хүү” болон “Ко” хэмээх үгийн утгыг харьцуулах нь59 |

ХЭЛ ШИНЖЛЭЛ:

| | |
|------------------------------------|---|
| Fasc 9. Е.В.Сундуева | Монгол хэлний “Хужир” гэдэг утгатай дэвсгэр газрын нэрс73 |
| Fasc 10. Дэгжилт | Монгол уран бичлэгийн гол онцлог, ерөнхий бүтэц77 |
| Fasc 11. Мөшээл, Бо Мина | Монгол зуучлуурын хэлэн дэх Англи зээллэг үгийн хэрэглээний байдал (<i>Монгол Улсын Засгийн газраар жишээлэх нь</i>)88 |
| Fasc 12. Ц.Цогзолмаа | Уламжлалт бус аргаар Англи хэл судлах нь.....93 |

УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ:

| | |
|-----------------------------|---|
| Fasc 13. Тоба Байкру | Ийм хэмээн миний сонссон нь99 |
| Fasc 14. Дай Юн Жин | Уран зохиолын илэрхийлэл ба түүний зураг дүрсжүүлэлт105 |
| Fasc 15. Хасчимэг | Урлагийн дүр хийгээд бэлгэдэл115 |
| Fasc 16. Тэргэл | Нобелын шагналт зохиолч Анни Эрногийн “Урт удааны сар” романы шинэчлэлт чанар122 |

Fasc 17. Эү Хи Мин Зохиолч Аянгын “Шатдаг ус” зохиол дахь амь ахуйн хамгаалалтын сэдэвт утга зохиолын задлалт хийх нь130

СОЁЛ СУДЛАЛ:

Fasc 18. Сарантуяа Монгол түүхэн зохиолд соёлын биет бус өвийг дүрслэн хадгалж, дамжуулан өвлүүлж ирсэн уламжлал, туршлага137

Fasc 19. Томикава Монгол бөхийн цолын түүх уламжлал болон зангианы
Рикиду тухай товч өгүүлэх нь147
Даланбаяр

ОРЧУУЛГА ЗҮЙ:

Fasc 20. Асами Коичиро Б.Явуухулангийн орчуулсан Хайкугийн Англи-Орос хэлний орчуулгын харьцуулал157



第7回国際学術シンポジウム

「モンゴルと日本-過去・現在・未来」
社会経済教育歴史宗教環境観光
について

7 дахь удаагийн
Олон улсын эрдэм шинжилгээний
хурал

“Монгол, Японы эрт-одоо-ирээдүй”
нийгэм, эдийн засаг, боловсрол,
түүх, аялал жуулчлалын тухай

主催機関：モンゴル文化教育大学

共催機関：桜美林大学

後援機関：在モンゴル日本国大使館

Зохion байгуулагч：Сойл Эрдэм дээд сургууль

Хамтран зохион байгуулагч：Оберин их сургууль

Дэмжигч байгууллага：Монгол улс дахь Япон улсын элчин сайдын нам

2024.08.04

“МОНГОЛ-ЯПОНЫ ЭРТ, ЭДҮГЭЭ, ИРЭЭДҮЙ” ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ЭЭЛЖИТ БАГА ХУРЛЫН НЭЭЛТИЙН ҮГ



МАКИХАРА СОИЧИ

*(Соёл Эрдэм дээд сургуулийн УЗ-ийн дарга,
Японы Оберин их сургуулийн хүндэт доктор)*

Бидний зохион байгуулж буй Олон улсын симпозиумд цаг заваа зориулан хүрэлцэн ирсэн та бүхэнд чин сэтгэлээсээ баярлалаа.

Юуны түрүүнд Япон улсаас Монгол улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Игавахара Масарү танд чин сэтгэлээсээ талархал илэрхийлж байна. Мөн Улаанбаатар хотоос хүрэлцэн ирж, энэхүү хуралд оролцож байгаад талархаад баршгүй. Бас үүний зэрэгцээ Япон улсын Оберин их сургуулийн захирал профессор Хатаяама Хироаки болон хамт ирсэн Оберин их сургуулийн хүндэт зочид

төлөөлөгч та бүхэнд чин сэтгэлийн талархлаа илэрхийлье.

Монгол улсын Соёл Эрдэм дээд сургуулиас зохион байгуулж буй манай өнөөдрийн олон улсын эрдэм шинжилгээний хуралд хүрэлцэн ирж оролцож буй та бүхэнд баярлалаа. Та бүхний хамтын ажиллагааны ачаар энэхүү хурал амжилттай зохион байгуулагдаж байгаад байна.

Соёл Эрдэм дээд сургууль, Япон улсын Оберин их сургуультай хамтран 2 жилдээ 1 удаа “Монгол, Японы Эрт - Одоо - Ирээдүй” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Монгол болон Япон улсад ээлжлэн зохион байгуулдаг. Бидний хамтран зохион байгуулж буй энэ удаагийн симпозиумд “Монгол, Япон нийгэм, эдийн засаг, боловсрол, түүх, шашин, хүрээлэн буй орчин, аялал жуулчлал” гэсэн өргөн сэдвийн хүрээнд 7 дахь удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулагдаж байна. Өнөөдрийн манай симпозиумаар хэлэлцүүлж байгаа та бүхний үнэ цэнэ чухал санал, санаачилга бүхий илтгэлүүд болон судалгаанууд тань бидний хувьд маш чухал зүйл болж байна.

Соёл Эрдэм дээд сургууль анх 1993 онд байгуулагдсан ба Япон хэлний мэргэжилтэн, Япон Монгол орон судлалын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн анхны хувийн сургууль болно. Тэр цагаас хойш өнөөг хүртэлх 31 жилийн туршид 5000 орчим суралцагч оюутан залууст Япон хэлний боловсрол, Япон соёлыг эзэмшүүлэн боловсон хүчин бэлтгэсэн билээ. Эдгээр боловсон хүчин нь одоо Монгол улс болон Япон улсын соёлын найрамдалт харилцаа, боловсрол, эдийн засаг, гадаад харилцааны “ГҮҮР” болж, томоохон хэмжээний хувь нэмрээ оруулж байгаа гэдгийг баталгаатай хэлж чадна. Ийнхүү та бүхэнд эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөгөөд, энэхүү мэндчилгээгээ өндөрлөж байна. Та бүхэндээ чин сэтгэлээсээ талархаж байна.

モンゴル文化教育大学

理事長、桜美林大
学名誉博士
牧原創一

皆様、本日はお忙しい中、私どもの国際シンポジウムにご参加いただき、誠にありがとうございます。

まず初めに、在モンゴル日本大使館特命全権大使である井川原閣下に心より感謝申し上げます。ウランバートル市から遠方までお越しいただき、このシンポジウムの意義を高めてくださり、感謝の念に堪えません。

また、桜美林大学の学長をはじめ、はるばる日本からご参加いただいた皆様にも、深い感謝の意を表します。

さらに、ご出席いただいた全ての皆様に、心より感謝申し上げます。皆様のおかげで、このシンポジウムが成功裏に開催されることを確信しております。

モンゴル文化教育大学は、桜美林大学と「モンゴルと日本 - 過去・現在・未来」をテーマにした国際学術シンポジウムを、二年おきに交互にモンゴルまたは日本で実施してまいりました。今年は「モンゴルと日本 - 社会・経済・教育・歴史・宗教・環境・観光」をテーマとした第7回国際学術シンポジウムとなります。

今日の国際学術シンポジウムにご参加された皆様の貴重なご挨拶、ご講演、研究論文の発表と知見の共有は、私たちにとって非常に有益なものとなるでしょう。

モンゴル文化教育大学は、1993年にモンゴル国初の前身である日本語学校の設立からスタートしました。ここ31年で、5000名近い日本語教育を受けたモンゴル人材を育成し、社会に送り出してまいりました。これらの人材は現在、モンゴルと日本の親善文化、教育、経済、外交交流の懸け橋として、大いに貢献していると言えるでしょう。

最後になりますが、皆々様の益々のご健勝をお祈りいたしまして、私の挨拶とさせていただきます。皆様、誠にありがとうございます。



ХАТАЯМА ХИРОАКИ
*(Японы Оберин их сургуулийн
Ерөнхийлөгч, профессор)*

Эрхэм хүндэт Соёл Эрдэм дээд сургуулийн ерөнхийлөгч Макихара Соичи, Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, Эрхэмсэг ноён Игавахара Масарү, Соёл Эрдэм дээд сургуулийн захирал Д.Эрдэнэчимэг, Шинэ Монгол бүрэн дунд сургуулийн Карьер хөгжлийн төвийн дарга бөгөөд Шинэ Монгол бага сургуулийн зөвлөх багш Галбадрах Суурь, мөн энэхүү симпозиумд илтгэл тавих

нийт илтгэгчид болон Япон-Монголын олон улсын 7 дахь симпозиумд өнөөдөр бидэнтэй нэгдэж хүрэлцэн ирсэн бүх хүмүүст чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Энэхүү симпозиум нь анх 12 жилийн өмнө буюу 2012 оны 11-р сарын 11-нд зохион байгуулагдсан билээ. Уг арга хэмжээг Монгол Улсаас Сагамихара дахь Өргөмжит консулын газрын дэмжлэгтэйгээр Оберлин их сургуулийн Тама Академи Хиллст зохион байгуулсан түүхтэй юм. Симпозиум нь Оберлин Эрдмийн хүрээлэнгийн ерөнхийлөгч асан Сато Тоёши болон өнөөдөр энд морилон суугаа профессор Макихара нарын тусламжтайгаар эхэлсэн бөгөөд энэхүү симпозиумын ирээдүйн чиг хандлагыг тодорхойлсон хэд хэдэн чухал зүйлүүд энэхүү анхны уулзалтад багтсан байв.

Өөрөөр хэлбэл: 1. Симпозиум нь Япон, Монгол хоёрыг холбогч гүүр болж, 2. Боловсрол, соёл, түүх, шашин шүтлэг, байгаль орчин зэрэг өргөн хүрээний өнцгөөс хоёр орныг ойлгох, 3. Оюутан залуучуудын үзэл бодлыг тусгах явдал билээ. Эхний зүйл бол мэдээжийн байх ёстой зорилго бөгөөд Сато Тоёши багш нь Сагамихара дахь Монгол Улсын өргөмжит консулаар ажиллаж Япон, Монгол хоёр улсын харилцаанд сэтгэл зүрхээ зориулан, ижил хүсэл эрмэлзэлтэй Макихара багштай хамтран хоёр орны хөгжилд анхаарал хандуулж ирсэн байдаг. Ялангуяа боловсрол нь улс орнуудын харилцааг идэвхжүүлэх түлхэц болдог учраас энэхүү симпозиумыг голлох үүрэг гүйцэтгэх үйл ажиллагаа хэмээн чухалчилж ирсэн билээ.

Тус симпозиумын 6 дахь чуулган 2022 онд Токиод болж, дараа нь манай их сургуулийн хүндэт докторын зэрэг олгох ёслол үйлдсэн үед профессор Макихара хэлсэн үгэндээ профессор Сатогий тухай ийнхүү дурдсан билээ. “Боловсрол бол чухал”, “Яагаад гэвэл улс орны хөгжлийн үндэс учраас” хэмээн Сато Тоёши багш байнга хэлдэг байсан тухай дурсан ярьж, түүнтэй санал нэг гэж дүгнэсэн билээ. Энэ явдлыг одоо ч би маш сайн санана. Хоёрдугаар зүйлийн хувьд, анхны симпозиумд энэхүү ойлголтын хүрээнд боловсрол, соёл, шашин шүтлэг, хэл, байгаль орчин зэрэг өргөн хүрээний сэдвээр хоёр орны судлаачдын илтгэл тавигдсан юм. Тэр үеийн баримтыг сөхөж харвал дараах сэдэвтэй илтгэлүүд тавигдаж байжээ. “Монгол судлалыг бүтээсэн хүмүүс” (Хитоцүбаши их сургуулийн гавьяат профессор

Кацухико Танака), “Богд хаант засгийн газрын 1911 онд Японтой хийсэн дипломат хүчин чармайлт, зорилгын тухай” (О.Батсайхан, ШУА-ийн судлаач), “Монгол орон Японы нийгмийн ухааны сурах бичигт” (Оберлин их сургуулийн профессор Мачида Рюкичи), “Монгол ургийн модыг хэрхэн бүтээх вэ” (Соёл Эрдэм дээд сургуулийн профессор Л.Дашням), “Монголын салхи” япон хэл сурах бичгийн тухай эргэцүүлэн бодох нь” (Оберлин их сургуулийн профессор Сайто Нобуко), “Монголчуудын үндсэрхэг үзлийн тухай” (Соёл Эрдэм дээд сургуулийн профессор С.Баясгалан), “Монгол дахь Христийн шашны өнөөгийн байдлын тухай” (Хасэгава (Масе) Оберлин их сургуулийн дэд профессор), “Ашигт малтмалын орон Монгол улсаас харагдах Хятад, Оросын их гүрнүүд ба гурав дахь хөрш орны нөлөөллийн тухай” (Япон улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд асан Кидокоро Такуо)

Хоёр дахь болон түүнээс хойших симпозиумууд нь анхны удаагийн жишгийн дагуу өргөн хүрээний салбарт мэдлэг хуримтлуулах бодлогыг тууштай баримтлав. Олон улсын симпозиум зохион байгуулахад хоёр орны судлаачид зарим хэсэгт эмзэг сэдвүүдээр нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлж чадсан нь тус симпозиумын уг санаа зөв бөгөөд хоёр орны их сургуулиудын багш оюутнуудын хооронд нөхөрсөг итгэлцэлтэй харилцаа бий болсныг илтгэж байгаа биз ээ.

Энэ удаагийн симпозиумд бид Макихара ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр “Япон, Монголын өнгөрсөн, одоо, ирээдүй” гэсэн үндсэн сэдвийн хамт “Япон, Монголын залуучуудын ирээдүйн төлөө” гэсэн дэд гарчгийг оруулахаар шийдлээ. Энэ нь Коронавируст халдварын цар тахал, дэлхийн олон хэсэгт үргэлжилж буй мөргөлдөөн нь залуучуудын ирээдүйд хандах хандлагад зогсонги мэдрэмжийг бий болгож байна гэсэн харилцан ойлголт дээр үндэслэсэн юм. Энэ нь мөн энэхүү симпозиумын гурав дахь чухал зүйл болох оюутан залуучуудын үзэл бодлыг тусгахад чиглэгдэж байна. Иймд уг симпозиумд олон оюутан илтгэгчээр оролцож байгаагаараа онцлогтой болж байна.

Өнөөдөр манай их сургуулийн Либерал Арт академийн оюутан Киношита илтгэл тавина. Анхдугаар чуулганд тухайн үед манай их сургуулийн Либерал арт академийн 4-р дамжааны оюутан байсан Като Эрико “Монголд салхин цахилгаан үүсгүүр бэлэглэх үйл ажиллагааны тайлан” сэдвээр, мөн академийн 3-р курсийн оюутан байсан Уэда Юкико “Монголын байгаль орчны сургалт” сэдвээр тус тус илтгэл тавьсан билээ. Энэхүү симпозиумын үр дүнд оюутан хоорондын харилцаа идэвхжиж, ирээдүйн судлаачдыг төлөвшүүлж байгааг онцлон тэмдэглэмээр байна.

Энэхүү симпозиум нь эхнээс баримталсаар ирсэн зорилго ёсоор Монгол, Япон улсын хөгжил, ирээдүйн боловсон хүчин бэлтгэлд хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна. Та бүхэнд амжилт хүсье.

桜美林大学学長 畑山浩昭

親愛なるモンゴル文化教育大学 牧原創一理事長、駐モンゴル日本国
特命全権大使 井川原賢(いがわはら まさる)閣下、モンゴル文化教育大学エ

ルデネチメグ学長、新モンゴル小中高一貫学校・キャリア開発センター長兼新モンゴル小学校顧問のガルバドラッハ・スウリ先生、

また本シンポジウムで発表の諸先生方、そしてご臨席の皆様、本日は第7回日本—モンゴル国際シンポジウムにご参集くださり、心からお礼申し上げます。本シンポジウムは、今を遡ること12年前、2012年11月11日に第1回の大会が開催されました。会場は桜美林大学・多摩アカデミーヒルズで、当時の在相模原モンゴル国名誉領事館から後援を受けて行われました。桜美林学園の故佐藤東洋士総長と、本日ここにいらっしゃる牧原先生の肝いりでシンポジウムはスタートしたわけですが、この第1回大会に、その後の本シンポジウムの方向を運命づけるいくつかの重要な要素が、すでに含まれていました。すなわち、①日本とモンゴルの懸け橋になるようなシンポジウムであること、②そのためには、教育、文化、歴史、宗教、環境など幅広い視点で両国を理解すること、③学生・若者の視点を盛り込むことです。

1点目については、言わずもがなかもしれません。佐藤東洋士先生は、在相模原モンゴル国名誉領事を務めるなど日本とモンゴルの国際交流に大きな情熱を注いでおられ、志を同じくする牧原先生と共に、両国の発展に注力されてきました。特に、国際交流において教育が果たす力の大きさを認識しておられ、このシンポジウムはその中心的役割を果たす活動として大変重要視されていました。

2022年に、東京で開催された第6回シンポジウムに続いて行われた、本学の名誉博士号授与式のスピーチのなかで、牧原先生が佐藤先生とのエピソードとして、「「教育は大事ですよ」「教育は国の発展の基礎ですから」と佐藤東洋士先生からよく聞かされていました。全くその通りです」と紹介されていたのは記憶に新しいところです。

2点目については、この理念を反映して、第1回シンポジウムでは、両国の研究者から教育、文化、宗教、言語、環境といった、幅広い切り口の発表が行われたことです。当時の記録を辿ってみると、以下のタイトルで発表がされています。（肩書はすべて当時のもの。当時の発表順）「モンゴル学をつくった人々」（田中克彦 一橋大学名誉教授）、「1911年ボクトドハン政府の日本との外交努力とその意図について」（バトサイハンモンゴル科学アカデミー研究員）、「日本の社会科教科書におけるモンゴ

ル」(町田隆吉桜美林大学教授)、「モンゴルの家系図の付け方について」(ダシニャムモンゴル文化教育大学教授)、「日本語教科書『モンゴルの風』を考える」(齋藤伸子桜美林大学教授)、「モンゴル人の民族主義について」(バヤスガランモンゴル文化教育大学教授)、「モンゴル国キリスト教の現状について」(長谷川(間瀬)恵美桜美林大学准教授)、「資源国モンゴルから見た中国・ロシア両大国と第三の隣国の動きについて」(城所卓雄前駐モンゴル日本国特命全権大使)

第2回目以降のシンポジウムでも、第1回で培われた、幅広い分野の知見を積み重ねる方針は継続されました。国際シンポジウム開催では、時に敏感にならざるを得ないようなテーマであっても、両国の研究者が胸襟を開いて議論を積み重ねてくることができたのは、開催の理念が正しかったこと、両国・両大学の関係者が友情をもって信頼関係を築き上げてきたことの証明ではないでしょうか。今回のシンポジウムでは、牧原理事長と相談して「日本とモンゴルの過去・現在・未来」というメインテーマの次に「日本とモンゴルの若者の将来のために」というサブタイトルをつけることにしました。これは、新型コロナウイルスの世界的な感染拡大、世界各地で続く紛争などが、若者の将来に閉塞感をもたらしているのではないかという共通の問題意識に立脚するものです。これはまた、本シンポジウムの3つ目の重要なポイントである、学生・若者の視点を取り込むことにも繋がります。事実、多くの学生発表者が、本シンポジウムに関わってきていることも大きな特徴となっています。本日は、本学リベラルアーツ学群の木下さんが発表することになっています。第1回大会では、当時本学リベラルアーツ学群4年生だった加藤絵里子さんが「モンゴルに風車を送る活動に関する報告」を、同じくりベラルアーツ学群の3年生だった植田有希子さんが「モンゴル環境研修の報告」を行いました。本シンポジウムの成果が、学生交流に波及し、未来の研究者を育てていることは特筆すべきことです。改めて開催の趣旨に立ち返り、本シンポジウムがモンゴル・日本の発展と未来の人材育成に寄与するものとなるよう願う次第です。

本日はどうぞよろしくお願いいたします。

桜美林大学 学長 畑山 浩昭



ИГАВАХАРА МАСАРУ
*(Япон улсаас Монгол улсад суугаа
Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд)*

Соёл Эрдэм дээд сургуулийн УЗ-ийн дарга Эрхэм ноён Макихара Соичи, Оберин их сургуулийн захирал Эрхэм ноён Хатаяма Хироаки болон энд хүрэлцэн ирсэн Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Өнөөдөр 7 дахь удаагийн “Монгол, Японы эрт - одоо - ирээдүй” сэдэвт хамтарсан эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулагдаж байгаад баяр хүргэе.

7 дахь удаагаа зохион байгуулж буй энэхүү олон улсын эрдэм шинжилгээний бага хурал нь Оберин их сургууль болон Соёл Эрдэм дээд сургууль хооронд байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд тулгуурлан зохион байгуулагдаж байгаагаараа онцлогтой бөгөөд хоёр орны эрдэмтэн судлаач, багш нар шинэ мэдлэг мэдээлэл олж авах тун сонирхолтой агуулгатай болж байна. Энэхүү бага хурлыг зохион байгуулахад хүчин чармайлт гаргасан Соёл Эрдэм дээд сургууль, Оберин их сургуулийн холбогдох хүмүүст талархлаа илэрхийлье.

Энэхүү бага хурлыг зохион байгуулж буй Соёл Эрдэм дээд сургууль нь байгуулагдахаасаа өмнө 1993 онд “Ютопия” хэмээх япон хэлний сургуулийг нээснээс хойш япон хэл болон Япон орон судлалаар мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэж ирсэн. 90-ээд онд япон хэл ихээр сонирхон сурч байх үед Улаанбаатар хотод олон япон хэлний сургууль, хувийн их, дээд сургуулиуд байгуулагдсан хэдий ч ихэнх нь хэдэн жилийн дараа хаагдаж байсан. Тэр дунд Соёл Эрдэм дээд сургууль УЗ-ийн дарга Макихарагийн гайхалтай удирдан зохион байгуулах авьяас чадвар, чин халуун хүслийн ачаар Японы олон компани, сургуультай холбоо тогтоон 30 жилийн турш Монголын нийгмийн өөрчлөлтийг даган шаардлагатай хүний нөөцийг бэлтгэн гаргасаар иржээ. Тус Элчин сайдын яамны ажилтнуудын дунд ч Соёл Эрдэм дээд сургуулийн олон төгсөгчид амжилттай ажиллаж байгаа бөгөөд ЭСЯ-наас алхаад 5 минутын зайтай дээд сургууль гэдгээрээ бид 30 жилийн турш сайн түншийн хувьд харилцаагаа бататгасаар ирсэн билээ. Өнгөрсөн оны намар харьяа ахлах сургууль байгуулж, шинэ сургуулийн байр ч тун удахгүй ашиглалтад орох гэж байна. Цаашдын ажил үйлс нь улам бүр хөгжихийг хүсэн ерөөе.

Энэ жил Япон, Монголын хооронд соёлын хэлэлцээр байгуулагдсаны 50 жилийн ойтойгоо золгож байна. Уг хэлэлцээр байгуулагдсанаар харилцан оюутан хүлээн авах, хамтарсан судалгаа хийх, соёлын арга хэмжээ зохион байгуулах боломжтой болсон юм. Хэдийгээ тогтолцоо бий болсон ч түүнийг үр ашигтай ашиглах “Хүн” үгүй бол харилцаа хөгжихгүй. Өнөөдрийн бага хурлаар аль ч салбар бай бүхий л хамтын ажиллагааны үндэс суурь нь “Хүн” гэдгийг сайтар ойлгож харилцан ойлголцлоо гүнзгийрүүлэх аваас баяртай байх болно.

Төгсгөлд нь, Монгол орны нийгэм хөгжин дэлгэрэхийг, Япон, Монголын найрамдалт харилцаа батжин бэхжихийг цаашлаад хоёр орны төдийгүй бүс нутаг, олон улсын хамтын нийгэмлэг энх амгалан байж, цэцэглэн хөгжихийг хүсэн ерөөе. Баярлалаа.

牧原・モンゴル文化教育大学理事長、
畑山・桜美林大学学長、
ならびにお集まりの皆様、おはようございます。
駐モンゴル特命全権大使の井川原です。

本日は、第7回国際学術シンポジウム「モンゴルと日本 過去・現在・未来」の開催、誠におめでとうでございます。

第7回を迎える今回の国際学術シンポジウムは特に桜美林大学とモンゴル文化教育大学との交流協定に基づいて共催され、両国の研究者、教育者が新たな知見を得ることができる興味深い内容となっております。本シンポジウムの開催に向けてご尽力いただきましたモンゴル文化教育大学、桜美林大学の関係者の皆様に感謝申し上げます。

本シンポジウムを主催するモンゴル文化教育大学は、1993年にその前身である「ユートピア日本語学校」を開校して以来、日本語及び日本事情に精通した人材育成に取り組んでこられました。90年代の日本語学習ブームの頃には、ウランバートル市内にたくさんの日本語学校や私立大学ができましたが、ほとんどは数年で撤退していきました。その中でモンゴル文化教育大学は、牧原理事長のたぐいまれな経営手腕と熱い思いにより、多くの日本企業や学校と提携を結び、30年に渡りモンゴルの社会変化に伴って必要になっていく人材を輩出し続けてきました。当館職員の中にも、モンゴル文化教育大学出身者が多く活躍していますし、当館から歩いて5分の大学ということで、我々は30年に渡り、よいパートナーとしての関係を培ってきています。昨年秋には付属高校も設立され、新しい校舎もまもなく完成しようとしています。益々のご発展を祈念いたしております。

さて本年、日本とモンゴルは文化取極50周年を迎えました。この取極ができたことによって、相互に留学生受け入れ、共同研究や文化イベントを実施することができるようになったわけですが、制度ができて、それを有効に活用できる「人」がいなければ、関係は発展しません。本日のシンポジウムによって、どのような分野であっても、全ての協力の基盤となるのは「人」であるということを再度認識し、相互理解を深めていただければ幸いです。

最後になりましたが、モンゴルの社会の発展、日本とモンゴルの友好関係の強化、さらに二国間の枠を超えた地域や国際社会の平和と繁栄を願い、私の挨拶とさせていただきます。

ありがとうございました。

МОНГОЛ МАЛ - ЗАЛУУЧУУДЫН АНХААРАЛД

Л.Дашням

(Монгол Улсын Ардын багш,
доктор, профессор)

Би мал аж ахуйн мэргэжлийн хүн биш Энэ чиглэлээр дагнасан судалгаа ч хийдэггүй. Монголын түүх, соёл, монголчуудын оюуны амьдралыг анхаарч анзаарч явдаг соёл судлаач, үндсэн мэргэжлээрээ бол Олон улсын эдийн засагч хүн юм. Гэвч би энэ эрдэм шинжилгээний хурал дээр, Монголын нийгмийн хөгжилд онцгой үүрэг гүйцэтгэсэн, цаашид ч илүү их анхаарах учиртай мал аж ахуйн салбар, ялангуяа монгол малын тухайд залуусын анхааралд өртүүлэх хэдэн санаа хэлье юу гэж бодлоо.

Хэрвээ бид Монголын эрт, эдүгээ, цаашдын хөгжлийн тухай ярилцах гэж байгаа бол миний бодлоор энэ асуудлыг орхигдуулж огт болохгүй л дээ. Хэн бүхэн Монголыг мал аж ахуйн орон, биднийг малчид л гэж ойлгож ирсэн Одоо ч зарим нь тийм л бодолтой байгаа байх. Сайнаар ярьвал сонгодог нүүдлийн мал аж ахуйн орон гэж нэрлэж байгаа болов уу. Үнэхээр Монгол шиг уудам нутагтаа малаа маллан, нүүдэллэн амьдарч буй хүмүүс дэлхийд ховорхон! Унаган байгальтайгаа салшгүй ойр нягт аж төрж, амгалан тайван, гол нь сэтгэл ханамжтай, өөрийн гэсэн жаргалтай амьдралаа эрхшээдэг болохоор монгол амьдрал зарим талаар сонгодог гэж үзэхээр нь ч үнэн байж болно.

Байгалийн нөхцөлд зохицон амьдарч тэсвэр хатуужилтай, үржих төлжих чадвараараа шалгарсан мал, түүнийг шилж сонгох, адуулах, ашиг шимийг авах арга ухаан ч гүнзгийрч туршлагажиж, мал маллах монгол арга барил ч шалгарч сайжирсан нь ч тэрхүү сонгодог хэмээх үг, утга агуулгыг илэрхийлэхэд тус дэм болсон шиг байна.

Үлгэрт гардагаар бол Монголын хамгийн ядуу хүн “таван хар ямаатай, тангад шар нохойтой, өвсөн овоохойтой, өндөгөн тогоотой” байж л дээ. Японд ч дээр үед таван ямаатай хүн мөн л ядуудаа ордог байсан байлгүй. Тангад нохой гэдэг нь монгол банхарын уг шаг гэгддэг Төвөд нохой юм.

1990-оны өмнө бид өөрийн орныг мал аж ахуй- үйлдвэрийн орон гэж нэрлээд малынхаа “амьсгалаас бусдыг ашиглахыг” зорьдог байлаа Тэгж ч чаддаг богинохон боловч үе байсан юм Одоо бол тийм биш болсон. Хэдийгээр мал маань 70- 80 сая хүрч, нэг хүнд ноогддог малын тоогоор бид дэлхийд тэргүүлсэн хэвээр байгаа ч мал аж ахуйн салбар маань дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ дөнгөж 10.5 хувийг үйлдвэрлэдэг, ажиллах хүчний 21.6 хувь энэ салбарт хүртээлтэй хэвээрээ л байгаа. Хүн амын дийлэнх хувь хот, суурин газар амьдарч, “малын бус” ажил амьдралтай болсон. Мал биш уул уурхай хүмүүсийн анхаарал татдаг цаг ирсэн байна. Албан бус мэдээгээр эдүгээ Монголын 250 -аад мянган иргэн /хөдөлгөөнтэй байгааг нь оролцуулбал түүнээс ч их! / гадаадын 50 гаруй оронд өөр өөрийн хүсэл,

зорилго, мөрөөдөл тэмүүлэлээрээ амьдарч байгаа. Зундаа бол манайд гадаадын жуулчдаас гадна өөрийн “гадаад монгол жуулчин” олон ирдэг болсон.

Бүх юм өөрчлөгдөж байна Их хурдтай, эрчимтэй өөрчлөгдөж байна. Монгол хүн, монгол мал, монгол амьдрал бүгд өөр болж байгаа Зарим нь ч бүр танигдахаа больж байна Үүнийгээ бид хөгжил гэж нэрлэдэг Бусадтай л адил болж байна гэж таашаадаг.

Гэвч амьдрал гэдэг ганцхан загварынх байдаггүй юм байна. Энэ хөгжилд хүн бүр таатай байна уу? гэвэл тийм биш! Зарим нь үнэхээр хөөрч баярлаж, магтаж бахдаж байна. Зарим нь юм бодож байна. Магад ч үгүй бүр жаахан гунигтай болж ирж байна. Тийм хүмүүсийн нэг нь би юм. Тийм учраас ч би өөрийн дотор юу бодогдоод байдагийг та нөхөдтэй хуваалцаюу гэсэн юм.

Энэ өвөл Монголын хувьд амаргүй “даваа” байлаа. Зуд турханд олон аймаг нэрвэгдсэн. Ер нь ч өвөл болгон л тодорхой хэмжээгээр тийм байдаг л даа. Бид байгалийн эрхшээлээс бүрэн салж чадаагүй л байгаа. Тэгж чадсан үндэстэн ер нь байгаа юмуу үгүй юү?

Судлаачдын бичиж байгаас үзэхэд сүүлийн 70 гаруй жилд манай оронд 13 удаа их зуд турхан болсон юм байна. Түүнд нийтдээ 45 сая мал хорогдсон гэнэ. Миний мэдэхээр, бүх малынхаа 20 гаруй хувийг үхүүлж, 8-9 мянган өрх айл малгүй болж байсан ч удаа бий л дээ. Энэ оны 4 сарын нэг мэдээнд улсын хэмжээгээр 6.8 сая мал хорогдлоо гэж дурьдсан байсан Тэнд:

Малынхаа: 70 хувийг алдсан өрх - 2541
80 хувийг алдсан өрх - 1180
90 хувийг алдсан өрх - 586
малгүй болсон өрх - 509

гэж бүр тодорхой мэдээлсэн шүү! Ямар их гамшиг нүүрлэсэн жил байсан нь тодорхой харагдаж байгаа байх. Одоо ийм хүнд өвлийг туулсан нутаг газраар очиход малчид ер юу ч болоогүй юм шиг айван тайван налайгаад, ямар ч гуниггүй “Байгаль-Эх биднийг чангахан шалгалаа! Яая гэлтэй билээ, бидний л хувь заяа юм даа Одоо тэгээд хэнээс, юу нэхэж гомдохов, аргаа олж, амьдрах л хэрэгтэй байна Өөр яахав!” гээд сууж байна

Малчид гэдэг тийм л улс юм. Манайхны ярьдагаар “ хот нь харласан” хэрнээ Наадамаа хийгээд л баярлалдаж байна. Мянга мянган жилийн өмнө байсан, XX зуунд, XXI зуунд байсаар л байгаа ийм амьдрал цаашдаа ч үргэлжлээд л байх уу?, Жилийн жилд үхэж үрэгддэг хэдэн арван сая малаасаа ядаж өчүүхэн жаахан хэсгийг нь ч ашиглаж чаддаггүй хэвээрээ л байгаад байх уу? гэдэг асуулт намайг зовоож байна.

Энэ асуулт ялангуяа манай залуусын өмнө шийдвэрээ нэхэн томоос томоор босож ирж байна Тэгэх ч учиртай! Яагаад гэвэл огт малгүй бол, тэр тусмаа нүүдлийн мал аж ахуй үгүй бол Монгол Монгол биш болно! Байх ёстойг байлгана гэдэг бол бүхнийг царцааж, бүхнийг музейн үзвэр болго гэсэн үг биш л дээ Байх ёстойг байлгана гэдэг хөгжүүл, өөрчил, өнөөдөр ямар байх ёстой вэ? тэр хэмжээ, хэвэнд нь оруул! гэсэн үг юм. Ийм үг голцуу л залуу залгамж үеийнхэнд зориулагддаг. Өөрсдөөсөө олон зүйл асуухын сацуу мал аж ахуйгаа хөгжүүлэхийн тулд Монголын төр юу хийж, юу анхаарч байгааг бас асуух байх л даа. Төрөөс анхаарч байгаа, хийж хэрэгжүүлж байгаа ажил

огт байхгүй гэж хэлж болохгүй Бодлого дэвшүүлж, хийх бүтээхийг үе шаттай хэрэгжүүлж л байна. Харин хүсэн хүлээсэн үр дүнд хүрч байна уу? гэвэл ний нуугүй хэлэхэд ер чадахгүй байгаа. Манайд “Төр бол хамгийн муу менежер” гэдэг үг хаанаасаа ч гараад ирсэн юм бэ, газар авч, зарим сайн ажил ч бүх нийтийн дэмжлэг авалгүй гацаж цалгардах явдал бишгүй тохиолддог. Улстөрждөг, талцдаг, юмыг нэг санаагаар хийж бүтээж, урагшлахаа зарим талаар больсон, тэрбайтугаа саад тотгор ирж хайдаг болсон мэт ойлгогддог. Тиймээс ч

- мал аж ахуйг эрчимжүүлэх
- малыг эрүүлжүүлэх
- бүтээгдэхүүнийг чанаржуулах
- мэргэжилтнийг чадваржуулах
- шинэ техник технологи нэвтрүүлэх
- бүртгэл мэдээллийг сайжруулах
- удирдлага, зохион байгуулалтыг орчин үеийн болгон сайжруулах

мэтийн нэн чухал ажлууд хүртэл манайхны ярьдагаар “түүхийрдэг”, саармагждаг, дутуу хагас биелэлээ олдог байдал үргэлжилсээр л байгаа юм.

Зарим зорилт, төлөвлөлт ч, миний бодлоор, бодлогын хувьд хагас дутуу боловсорч байна Амлалт ихдэж, алсын хараа дутаж байж мэдэх ч зүйл хэлж ярьсаар л байна. Би нэг жишээ яриа Монголчууд “морьгүй хүн бол монгол биш!” гэж хэлдэг. Гэтэл одоо хурдны мориноос бусад адуу бол малын тоонд орохоо бараг больж, хэрэгцээ багатай “таваарт” тооцогддог болох нь шиг байна. Малаа мотоциклээр /нэг үе “Хонда” чухал сайн эдэд ордог байсан/ хариулдаг байсан бол одоо Приус гэдэг машинаар хариулдаг болсон. Мал маань техникийн явдлаар явдаг болсон болохоор тарга тээвэрэг авч амждаггүй, ядарч зүдэрдэг, сувай суйдан болдог, тиймээс ч үхэж үрэгдэх нь их болсон байна. Машинтай малчид улам улам залхуу, хүний хүн болж малаа таргалуулах хариулах биш өөр юманд санаа тавьдаг болж! Малын үүлдэр угсааг сайжруулж, аж ахуйг эрчимжүүлэх бол муу зорилт биш л дээ Зайлшгүй хийх ажил! Гэтэл энэ ажлыг хэт хавтгайруулж мянган мянганыг туулж шалгарсан монгол үүлдрийн малаа үгүй хийвэл бид түүхэн алдаанд хүрнэ Одоо тийм байдал хавтгайраад байна Цэвэр монгол удмын мал ховордож, зарим газар олдохуйяа бэрх болсоор байгаа Социализмын үед зориуд санаа тавьж их хүч хөдөлмөрөөр бий болгосон Монгол нөхцөлд зохицсон үүлдэр угсааг бараг цөмийг нь үрэн таран хийсэн.

Уг нь үүлдэр угсааг нь сайжруулсан ч монгол малын маллагааг монгол хүн л илүү сайн мэднэ Тийм хүн одоо мөн цөөхөн болсон Малчид их залуужиж, бараг цөмөөрөө шахуу хот орон газар руу бодол санаа, толгой нь чиглэсэн байна. Манай алдарт хоньчид хөдөлмөрийн баатрууд З.Очир, С.Цогтгэрэл гээд хонио харуулангаа өдөрт бэлчээрийн мал хэчнээн төрлийн өвс ногоо, ургамал иддэг юм бол гээд тоолж үздэг байж. Тэднийхээр хонь ямаа өдөрт 120-150-иад төрлийн ургамал иддэг юм байна Тэрнийг дуулсан академич Б Ринчен гуай “бидний хоолны хачрыг мал маань өөрсдөө махандаа шингээчихсэн байдаг юм” гэж хоржоонтой үг хэлсэн нь бий. Бэлчээрийн малын бүтээгдэхүүн, экологийн шинж чанарын тухай яриа бол тусдаа том яриа! Нарийн ширийнийг ярих цаг бидэнд одоо алга байна. Ийнхүү би зарим

нэг асуудал, байгаа байдлыг тоймлосон болохоор одоо манай залуус, магадгүй монгол япон залуус хамтарч Монголын мал аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд ямар оролцоотой, ямар тустай ажил хийгээсэй гэж хүсэж байгаагаа л хэлье.

- Төрөл төрлийн монгол угшлын малын тусгайлсан бүс нутаг бий болгож, монгол малын фермийн аж ахуй хөгжүүлэх

- Малыг гаралтай түүхий эдийн хөдөлгөөнт юм уу мини үйлдвэрлэлийг бий болгох

- Малчдын амьдралын нөхцөлийг сайжруулж, шар үхрээр чирдэг биш өөрөө явдаг, эсвэл чиргүүлт хэлбэрийн орчин цагийн орон сууцны төрөл бүрийн хэлбэрийг бий болгох

- Малчдад мэдлэг олгох, соёлоор үйлчлэх ажлуудыг оновчтой болгох

- Булаг шандыг хаших, цас, борооны ус тогтоох, цөөрөмжүүлэх, усжуулах ажил хийх

- Хөдөөд ажлын байдлаас хамаарсан буюу улирлын шинжтэй “хөдөлгөөнт баг”-ийн арга хэлбэрийг нэвтрүүлж хүн хүч нэмэгдүүлэх

- Бэлчээрийн малын экологийн цэвэр бүтээгдэхүүний хэрэглээг өргөтгөх, дэлхийд сурталчлах, хүртээл болгох зэргээр хамтын ажиллагааныхаа талбар хүрээг өргөтгөж, хэлбэрийг олон янз болгомоор байна

Гол нь элдэв ажил хийх талаар ахин дахин ярих, байн байн хуралдах биш бодтой ажил хийж, бодтой үр дүнд хүрмээр байна. Монгол амьдрал, монгол соёлын үндэс нь монгол мал, орчин үежүүлсэн нүүдлийн амьдрал гэж боддог учраас л би монгол малын тухай ямагт боддог байгаасай гэж залуучуудаасаа хүсэн ийм их алтан цагийг тань дэмий үрж байгаа юмаа

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ БОЛОН ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ
- ЭНТРЕПРЕНЕРҮҮДИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ-

Хори Киёоши

*(Оберин их сургуулийн Либерал арт академийн
профессор, дэд захирал, доктор)*

1. Танилцуулга: “Жижиг, дунд үйлдвэр”, “Энтрепренер”-д чиглэсэн
сонирхол

Энэ жил би их сургуулийн багшаар 35 дахь жилдээ ажиллаж байгаа бөгөөд энэ хугацаанд жижиг, дунд үйлдвэр, тэнд ажиллаж буй хүмүүс, шинэ бизнес хөгжүүлэхээр зэхэж буй “Энтрепренер” гэгдэх хүмүүсийн гүйцэтгэх үүргийг сонирхож судалж ирсэн билээ. Жижиг, дунд үйлдвэрүүд (ЖДҮ) нь цар хүрээ багатай, жижиг бизнесүүд бөгөөд тус тусдаа ялгарч харагдахгүй ч нийт бүлгээрээ улс орны эдийн засгийн маш том хэсгийг бүрдүүлдэг.

Дор дурдах гэж буй Sony, Honda зэрэг томоохон компаниуд өнөөдөр дэлхийд нэр алдартай ч анх үүсэхдээ маш жижиг үйлдвэр хэлбэрээр гараагаа эхэлж байсан билээ. Энэ утгаараа жижиг, дунд үйлдвэрийг ирээдүйд томоохон компани болж өсөх нөөц бололцоотой гэж ойлгож болно. Компаниудын тоо нэмэгдэж, өсөн хөгжихөд ажлын байр бий болж, хүмүүсийн орлого дээшлэх зэрэг улс орны эдийн засгийн хөгжилд эергээр нөлөөлдөг. Иймээс улс орны эдийн засгийн хөгжилд бизнес эхлүүлж, түүнийгээ хөгжүүлж буй энтрепренерүүдийн үүрэг оролцоо туйлын чухал байдаг. Энэ удаад зарим нэг Японы бизнес эрхлэгчдийг жишээ болгон, энтрепренерүүд бизнес эхлүүлэхдээ ямар хүсэл тэмүүлэлтэй байдаг, ямар хүмүүс амжилттай бизнес эрхлэгчид байдаг талаар эргэцүүлэн бодохыг хүсэж байна.

2. “Модны цагариг” загварын менежмент:

Нийгэмд ээлтэй компани болцгооё

I. “Энтрепренер” гэж юу вэ?

Эхлээд өнөөдөр хэлэлцэх "энтрепренер" гэдэг үгийн утгыг авч үзье. Энэ нь шууд утгаараа "бизнесээ эхлүүлж буй хүн" гэсэн үг юм. Бид шинээр хувиараа компани, бизнес эхлүүлж буй хүмүүсийг энтрепренер гэж нэрлэдэг бол тэд яагаад бизнес эхлүүлдэг юм бэ? Бизнес эхлүүлэхдээ ямар зорилго тавьдаг вэ?

Би Оберлин их сургуулийн оюутнуудад "Микро эдийн засгийн онол" хичээл заадаг. Академик талаас нь авч үзвэл "компани бүрийн эцсийн зорилго" бол ашиг олох явдал гэсэн үзлээс гадна өөр хэд хэдэн үзэл байдаг. Тэгсэн хэдий ч ихэнх микро эдийн засгийн сурах бичигт (ялангуяа анхлан

суралцагчдад зориулсан) "Компани бол дээд хэмжээний ашиг олохыг зорилго болгодог" гэж тайлбарласан байдаг. Их ашигтай ажилладаг компаниуд нь нэр хүндтэй байдаг жишээтэй бөгөөд аль ч улсад эдгээр компаниудад ажилд орох хүсэлтэй оюутнуудын тоо их байдаг. Иймд энтрепренерүүд бизнесийн үйл ажиллагаагаар дамжуулан их ашиг олохыг хүсэж бизнесээ эхлүүлдэг гэж таамаглах боломжтой. Доор бид Японы алдартай бизнес эрхлэгчдийн үг үйлдлээс жишээ болгон бизнесийн үйл ажиллагааг эхлүүлэх, хөгжүүлэх үйл явцад ашиг олоход хэр их ач холбогдол өгч байсныг хэдэн жишээгээр авч үзэцгээе.

II. "Модны цагариг" Загварын менежмент: Ноён Цукагоши Хироши

Хамгийн эхэнд танилцуулах гэж буй хүн бол Нагано мужийн Ина хотод төвтэй "Ina Food Industry" хэмээх компанийг үүсгэн байгуулагч Хироши Цукагоши юм. Одоогоос 20-иод жилийн өмнө тэрээр "Модны цагариг загварын менежмент" нэртэй ном бичсэнийг Японы олон бизнесменүүд уншиж, англи хэл рүү орчуулж, гадаадын бизнесменүүдэд ч нөлөөлсөн.

"Ina Foods Industry" нь далайн ургамлаас хийдэг агарын төрөлжсөн үйлдвэрлэгч юм. Энгийн хэрэглэгчдэд "Kanten Para" брэнд гэдгээрээ алдартай бөгөөд дотоодын агарын зах зээлийн 80 хивийг эзэлдэг. Агар нь Япон амттаны орц гэх мэт хүнсний бүтээгдэхүүнд их ашиглагдахаас гадна хүйтэнд хатуурч, бүлэнд хайлдаг уян хатан чанараараа эм ба үйлдвэрийн бүтээгдэхүүний түүхий эд болгон өргөн хэрэглэдэг. Бодит байдлаар "Ina Foods Industry"-ийн нийт борлуулалтын зөвхөн 20 орчим хувь нь хүнсний хэрэглээнд зориулагддаг.

Дээр үед агарын үйлдвэрлэл өвлийн хүйтэн нөхцөлд хийгддэг байсан тул Нагано мужийн Ина нутгийн цас ихтэй тус үйлдвэрт ажиллаж байсан ажилчдын ажиллах орчин маш хүнд байсан. Үүсгэн байгуулагч ноён Цукагоши ашгийнхаа багагүй хэсгийг зарцуулж, ажиллах орчныг сайжруулахаар үйлдвэрлэлийн үйл явцыг нэлээд автоматжуулав. Мөн ажилчдын орон байр, гэр бүлийн нөхцөл байдлыг харгалзан үзэж ая тухтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж ирсэн. Үүний нэг жишээ бол ажилтны гэрийн халаалт, гаражийн дээврийг барих зардлын тодорхой хэсгийг компаниас гаргадаг. Иймэрхүү хандлага нь ажилчдын компанид үнэнч байдлыг нэмэгдүүлэхэд ихээхэн түлхэц болдог. Ноён Цукагоши хэлэхдээ: "Ихэнх хүмүүс амьдралынхаа дийлэнх хугацааг ажил дээрээ өнгөрөөдөг. Ажил хийж байгаа хүн аз жаргалыг мэдрэхгүй бол ажиллах хэрэг юун?"

Ноён Цукагошигийн уриа бол "Аажуу өсөж, дунд зэрэг ашиг олох". Байгуулагдсан цагаасаа хойш 50 орчим жилийн турш борлуулалт болон ашгаа хослуулан нэмэгдүүлсээр ирсэн бөгөөд борлуулалт буурсан жил байсан ч одоо борлуулалт, ашиг нь дахин нэмэгдсээр байна.

3. Жижиг, дунд үйлдвэр бол том компаниудын "үрсэлгээ" юм.

I. Дэлхийн хэмжээний корпорацуудын үүсгэн байгуулагчдын "үзэл санаа"

Японд ойролцоогоор 3.6 сая компани байдаг. Үүний 99.7 хувь нь “жижиг, дунд үйлдвэр” аж. Төдий хэмжээний бизнесийн маш их боломжууд, маш олон төрлийн амжилтын гараа байдаг. Тэгвэл бизнес эрхлэгчид бизнесийн боломжийг хэрхэн хайж олох вэ? Ингээд өдгөө дэлхийд алдартай болсон Японы хоёр компанийн үүсгэн байгуулагдах үеийн удирдлагуудын үзэл санааг танилцуулья.

Sony-г үүсгэн байгуулагчдын нэг Ибука Масару хуучин нэрээр "Токуо Tsushin Kogyo" ХК-ийг байгуулах баримт бичгээ боловсруулахдаа түүнийг байгуулах тэргүүн зорилго нь "Сайн инженерүүдийн ур чадварыг дээд зэргээр харуулах боломжоор хангагдсан чөлөөт, нээлттэй, тааламжтай орчин бүхий мөрөөдлийн үйлдвэр байгуулах"-д оршино гэж бичсэн байдаг. Компанийн менежментийн үндсэн чиглэлийн хувьд “Үндэслэлгүй ашиг хонжоо хайх үзлээс татгалзаж, агуулгыг баяжуулах, практик үйл ажиллагаанд анхаарлаа төвлөрүүлж, тодорхой зорилгогүйгээр цар хүрээгээ томруулахгүй байх” мөн “Менежментийн цар хүрээний хувьд харин ч цомхон байхыг илүүд үзэх ба том компаниудын удаан нүсэр менежментийн улмаас ахицгүй үлдсэн салбарт технологийн дэвшил, менежментийн үйл ажиллагаа явуулахыг зорьж байна” хэмээсэн ба энэ нь том компаниудын шийдвэрлэхээс зайлсхийдэг асуудалд хүч үзэхийг чухалчилдаг нь харагдаж байна. Түүнчлэн “Үндэслэлгүй ашиг хонжоо хайх үзлээс татгалзана” гэж бичсэнээс харвал ашиг хөөх нь түүний бизнесийн гол зорилго биш байсан нь ойлгомжтой байна. “Хонда Мотор” ХК нь автомашин төдийгүй мотоцикл үйлдвэрлэгч гэдгээрээ дэлхийд алдартай ба анх 1946 онд Шизүока мужийн Хамамацу хотод байгуулагдсан жижиг үйлдвэр юм. Компанийн анхны бүтээгдэхүүн нь унадаг дугуйн туслах хөдөлгүүр байсан бөгөөд хожим нь мотоциклийн үйлдвэрлэл болж хувирсан. Компанийг үүсгэн байгуулах үед үүсгэн байгуулагч Хонда Соичиро нь армийн хуучин радио станцын хөдөлгүүр хаягдах орхигдсоныг харж, ямар нэгэн зүйлд ашиглах талаар бодож байсан гэдэг. Ингээд эхнэр нь хол газар дугуйгаар явж дэлгүүр ордог байсан тул түүнд туслах зорилгоор унадаг дугуйнд нь хөдөлгүүр суулгасан гэдэг. Турших зорилгоор Хондагийн эхнэр анх унаж байхад түүнийг харсан хүмүүс Хонда руу ирж, дугуйн туслах хөдөлгүүрээ зарахыг хүссэн байна. Бизнесийн боломж байгааг мэдэрсэн ноён Хонда хөдөлгүүрийг өөрөө зохион бүтээж, өөрийн бүтээгдэхүүн болгон борлуулж эхлэв. Тэгэхдээ ноён Хонда ч компаниа байгуулахдаа ашгийг гол зорилгоо болгоогүйг харж болно.

II. Энтрепренерүүдийн үзэл санаа: Бусдад туслах

Ноён Ибука, Хонда хоёрын үзэл санаа нь энтрепренерүүдэд нийтлэг нэгэн шинж чанарыг бидэнд сануулж байна. Гол нь тэд ашиг олох гэж бизнесээ эхлүүлдэггүй, харин бусдад хувь нэмрээ оруулах гэсэн хүсэлдээ хөтлөгдөн үйл ажиллагаа явуулдаг. Ноён Ибука нь инженерүүд чөлөөтэй ажиллаж, авьяас чадвараа илэрхийлдэг орчин бий болгохыг эрмэлзэж байв. Ноён Хонда нь эхнэрийнхээ хүнд хүчир ажилд туслахыг хүссэн учраас хөдөлгүүрийг зохион бүтээжээ. Бидний эхэнд танилцуулсан ноён Цукагоши Хироши ч ажилчдынхаа ажиллах орчныг сайжруулахад бүх хүчээ зориулав.

Бусдад туслах нь бизнесийн үндэс юм. Ашиг бол дагалдаж ирдэг шагнал гэж бид ярьдаг. Тэдний бусдад туслах хүсэл эрмэлзлээр зохион бүтээсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь үйлчлүүлэгчид болон нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн тохиолдолд тэдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээнд мөнгө төлөгдөж, тэд ашигтай болдог. Ноён Ибука, Хонда нар тэдгээр компанийг үүсгэн байгуулсан үе бол Япон улс дэлхийн 2-р дайн дууссаны дараах хүнд байдлаас сэргэн босох үе байж таарсан юм. Автомашин, гэр ахуйн цахилгаан хэрэгслийн хэрэглээ хомс байсан тул эдгээр урьд өмнө өмчилж байгаагүй бараа бүтээгдэхүүнийг боломжийн үнээр хангаж чадвал энэ нь дангаараа нийгэмд оруулах томоохон хувь нэмэр байжээ. Эдийн засгийн өсөлт сайжрах хэрээр хэрэглэгчид өдөр тутмын амьдралд шаардлагатай багц бүтээгдэхүүн, үйлчилгээг авах боломжтой болж, илүү чанартай, авсаархан, хөнгөн, загварлаг, өнгө хэлбэрийн өргөн сонголттой бүтээгдэхүүний эрэлт үүсдэг. Одоо 21-р зуунд хүмүүс худалдан авалт хийхдээ “нийгэмд нөлөөлөх” байдалд их анхаарал хандуулдаг болж байна. Ижил бүтээгдэхүүн худалдаж авахдаа ч хүмүүс байгаль орчинд ээлтэй, аюулгүй, эрүүл зүйлийг хайдаг болжээ. Түүнчлэн түүхий эд татах, үйлдвэрлэл, түгээлтийн үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, гадаадын иргэдийг ажилд оролцуулах зэрэг олон талт байдлыг хүндэтгэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь худалдан авагчдын сонирхлыг илүү татдаг болжээ. Уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн даяаршил өрнөж буй өнөө үед ийм нийгэмд тулгуурласан бизнесийн сэтгэлгээ зайлшгүй шаардлагатай болж байна.

4. Бизнесийн боломж хаана байна?

Өдөр тутмын их сургуулийн хичээлийн явцад залуу оюутнууд надаас энэхүү асуултыг байнга асуудаг. "Би яаж сайн бизнесийн боломжийг олох вэ?" Энэ асуултад хариулахын оронд би нэгэн энтрепренер хүний жишээг тэдэнтэй хуваалцдаг. Түүнийг Мицуи Такааки гэдэг. Тэрээр IC хар тугалган хүрээ гэж нэрлэгддэг хагас дамжуулагчтай холбоотой эд ангиудаар дэлхийн зах зээлд 30 орчим хувийг эзэлдэг “Mitsui High-Tech” ХК үүсгэн байгуулагч юм. Тэрээр дайн дууссаны дараахан Кюүшюүд нарийн пресс хэвний хэв үйлдвэрлэх жижиг үйлдвэр байгуулсан бөгөөд 1960-аад онд АНУ-д туршлага судалж явахдаа Цахиурын хөндийд хаягдаж орхигдсон жижиг төмрийн хэлтэрхий олж (сайн ажвал IC хар тугалган хүрээ байлаа), түүнийг судалсны дүнд IC хар тугалган хүрээг дотооддоо амжилттай үйлдвэрлэхэд хүрсэн.

Ноён Мицуи Америкт төмрийн хэлтэрхий олохдоо IC хар тугалган хүрээний тухай ч байтугай IC (хагас дамжуулагчийн интеграл хэлхээ) гэж юу болохыг ч сайн мэддэггүй байв. Гэсэн хэдий ч түүний сонин хэлбэр дүрсэнд татагдсан ч юм уу, тэрээр уг төмрийн хэлтэрхий юу болох талаар эргэн тойрноосоо сураглав. Тэгээд тэрээр хэд хэдэн зүйлийг мэдэж авчээ. IC хар тугалганы хүрээ нь маш нарийн төвөгтэй хэлбэрийн металл бүтээгдэхүүн тул 1960-аад он хүртэл металл гадаргууг химийн бодисоор зэврүүлдэг "химийн сийлбэр" хэмээх аргыг ашиглан үйлдвэрлэдэг байжээ. Үнэтэй химийн бодис ашиглан маш их цаг хугацаа, хүчин чармайлт шаардагддаг тул өртөг өндөр байсан юм. Харин ноён Мицуй металл хавтанг прессээр цоолох арга

нэвтрүүлснээр өртөг болон үйлдвэрлэлийн хугацааг эрс багасгаж, өмнөх бүтээгдэхүүнээс бараг 7 дахин хямд үнээр бүтээгдэхүүнээ амжилттай нийлүүлж чадсан. Тус компанийн бүтээгдэхүүн нь эхэндээ дэндүү хямд байсан тул чанарт нь эргэлзээ төрж худалдан авагчаа олж чадаагүй ч яваандаа том компаниудаас их хэмжээний захиалга авах хэмжээнд хүрч компани хурдацтай хөгжиж эхэлжээ.

Энэ жишээг оюутнууддаа хэлэхдээ би тэдэнд "Сайн бизнесийн боломжуудыг олох гурван арга"-ыг танилцуулдаг.

- (i) Эргэн тойрноо сайн ажиглах: Санаанд оромгүй газруудад боломж гарч ирж магадгүй. Зарим тохиолдолд зам дээрээс олдсон төмрийн хэлтэрхий хүртэл амжилтад хүргэдэг.
- (ii) Асуулт асуух: Асуулт асууснаар та мэдэхгүй зүйлээ мэдэж авна. Хэрэв та асуулт асуухгүй бол юу ч мэдэхгүй.
- (iii) Өөрийн гэсэн чадвартай, мэргэшсэн салбартай байх: Ноён Мицуй пресс хэвний үйлдвэрлэл чиглэлээр мэргэшсэн хүн байсан тул шинэ арга бодож олж чадсан.

Өдөр тутмын хичээл зүтгэлээсээ шалтгаалаад дээрх гурван зүйлийг амьдралдаа хэрэгжүүлэх чадвартай байх ёстой. Залуучууд та бүгдэд би итгэж байна.

経済発展と中小企業～起業家の果たす役割～

堀 潔

(桜美林大学リベラルアーツ学群教授・副学長)

1. はじめに～「中小企業」「起業家」への関心～

私は大学の先生になって今年で35年めになりますが、その間、中小企業やそこで働く人々、そして新しいビジネスを興そうとする「起業家」と呼ばれる人の果たす役割に関心をもって勉強を続けてきました。中小企業は文字通り規模の小さな企業で、一つ一つの企業は目立たないけれども全体としては一国経済の非常に大きな部分を占める存在です。後述しますが、いまは世界中の人が知っているソニーやホンダも、最初はホントに小さな町工場でした。そのような意味では、中小企業は将来大企業になるかもしれない企業と考えることができるかもしれません。

企業の増加と成長発展は人々の雇用と所得の増加をもたらし、一国経済の発展につながります。そう考えると、ビジネスを起こし成長発展させる起業家の役割は国の経済発展にとってたいへん重要です。今回は何人かの日本の起業家を例にとりあげながら、起業家がどのような思いをもってビジネスを起こすのか、また起業家として成功する人たちはどのような人たちであるのか、について考えてみたいと思います。

2. 「年輪経営」～よい会社になりましょう～

(1) 「起業家」とは？

まず、本日とりあげる「起業家」という言葉の意味を考えてみましょう。「起業家」とは文字通り「事業を起こす人」です。自分で新しい会社を

始める人、あるいは新しい事業を始める人のことを我々は起業家と呼びますが、ではなぜ起業家は事業を始めるのでしょうか？ 起業家がビジネスを興そうとする目的は何ですか？

私は桜美林大学で「ミクロ経済学」を学生に教えています。学説史上、「企業の目的」については、この利潤最大化仮説以外にもいくつかの仮説が発表されていますが、ミクロ経済学のテキスト（とくに初学者向け）にはたいてい「企業の目的は利潤の最大化」であると書かれています。たしかに大きな利益をあげている会社には有名な会社が多く、どこの国でもそうですが、そのような会社は学生諸君の就職先としても人気を集めます。このように考えると、おそらく起業家たちもビジネスを通じて大きな利益をあげることが期待できるから自分でビジネスを始めるのではないかと考えることはできると思います。以下では、日本で「名経営者」と呼ばれた人たちの言動から、彼らが自身の事業活動を始め、発展させていく過程でどれほど利益を重視していたのかについて、少し具体的に考えてみることにしましょう。

(2) 「年輪経営」～塚越寛氏～

ひとりに紹介したいのは、長野県伊那市に本社のある「伊那食品工業」という会社の創業者、塚越寛氏です。この方が執筆された「年輪経営」という本は20年ほど前、日本のビジネスマンに多く読まれ、英語にも翻訳されて外国のビジネスマンにも影響を与えました。

伊那食品工業は寒天の専門メーカーです。一般消費者には「かんでんパパ」のブランドで知られ、国内シェアは80%を占めています。ただ、寒天は和菓子の材料など食品として使われるのみならず、冷やすと固まり温まると溶ける、そして弾力がある寒天の性質を利用して、医薬品や工業製品の原料としても広く使われています。実際、伊那食品工業の売り上げ全体のうち食品向けの用途は2割ほどだそうです。

かつては寒天の製造は冬の寒さを利用して行われていましたので、雪深い長野県伊那地方で工場働く従業員たちの作業環境は非常に過酷なものでした。創業者の塚越氏は従業員の作業環境改善のために利益の相当部分を製造作業の自動化投資などに充てました。また、従業員の住宅環境や家族の状況などにも配慮して、働きやすい環境を整備していきました。従業員の自宅の暖房費や車庫の屋根の建設費の一部を会社が助成するなどはこの一例です。こうした配慮は従業員たちの会社への忠誠心を高めるのに大いに役立っています。塚越氏はこう述べています。「多くの人が人生の多くの時間を労働に充てている。働く人たちが幸せを感じなかったら働いていることのどこに意味があるだろうか」。

塚越氏は「成長は緩やかに、利益はほどほどに」をモットーに掲げています。創業以来50年近く増収増益を続け、一度は減収となった年もありましたが再び増収増益を続けています。

3. 中小企業は大企業の「苗床」

(1) 世界企業の創業者の「想い」

日本には約360万の企業があります。そのうちの99.7%が「中小企業」です。それだけ多くのビジネスチャンスがあり、多様な成功の種があります。では、どうやって起業家はビジネスチャンスに出会うのでしょうか？ここでは現在では世界的に有名な企業となっている2つの日本企業の、創業当時の経営者たちの想いを紹介しましょう。

ソニーの創業者のひとりである井深大（いぶか・まさる）氏は、自らが起草した「東京通信工業株式会社設立趣意書」のなかで、会社設立の第一の目的を「真面目なる技術者の技能を、最高度に発揮せしむべき自由闊達にして愉快なる理想工場の建設」であると述べています。具体的な会社の経営方針として、「不当なる儲け主義を廃し、あくまで内容の充実、実質的な活動に重点を置き、いたずらに規模の大を追わず」「経営規模としては、むしろ小なるを望み、大経営企業の大経営なるがために進み得ざる分野に、技術の進路と経営活動を期する」と述べていて、どちらかと言えば大企業がやりたくないようなニッチな課題に挑戦しようとする気概が感じられます。また「不当なる儲け主義を廃し」と書いていますから、利益を事業目的としていなかったことは明らかです。

本田技研工業は自動車だけでなく自動二輪（オートバイ）のメーカーとして世界的に有名ですが、1946年に静岡県浜松市で創業した小さな町工場でした。初期の製品は自転車補助エンジンで、その後自動二輪車の製造に変化していきます。創業当初、創業者の本田宗一郎氏は放置されていた旧陸軍の無線機用のエンジンを何かに利用できないか考えていたのですが、遠くまで自転車で買い物に行く妻を助けたい、との思いでエンジンを自転車にとりつけたのがきっかけだったと言われています。最初は本田氏の妻がテストライダーとして、このエンジン付き自転車に乗っていたのですが、それを見た人が次々と本田氏のもとを訪れ、ぜひ改造エンジンを売ってほしいと頼み込んだそうです。ビジネスチャンスを感じた本田氏は自らエンジンを設計し、自社製品として販売することになります。本田氏もまた、創業当初は利益を求めていたわけではありませんでした。

(2) 起業家の想い～他社への貢献～

井深氏、本田氏の考えから、起業家に共通するひとつの共通した特徴が想起されます。それは、起業家が利益を得るために企業するのではなく、他者に貢献したいという気持ちから行動を起こした、という点です。井深氏は技術者たちが創意工夫を発揮することのできる自由な活躍の場を実現しようと思いました。本田氏は、妻の重労働を助けたいと思ってエンジンを手掛けました。最初に紹介した塚越寛氏も、従業員の労働環境の改善に力を注ぎました。他社への貢献が、まずはビジネスの基本であります。

よく言われることですが、利益は後からついてきます。彼ら他人のために貢献したいと思って開発し提供した製品やサービスが顧客や社会に受け

入れられた時、その製品やサービスに対しておカネが支払われ、彼らは利益を得ることになるのです。

井深氏、本田氏が創業した頃の日本は、第二次世界大戦終結後の惨憺たる状況からの復興の時代でありました。自動車や家電製品の家庭普及率も低かったので、以前には所有できなかったモノがたくさんあり、自動車や新型の家電製品を手頃な価格で提供することができれば、それだけで相当な社会貢献になりました。経済成長が進んでくると、生活に必要な製品やサービスは一揃え手に入れることができてきますので、今度はより品質の良いものを、より小型軽量なものを、よりデザインの優れたものを、いろいろな色や形のなかから選ぶことができるものを、人々は求めるようになります。21世紀の現在では、人々の消費行動のなかに「社会性」が重視されるようになってきています。同じモノを買うにも、より環境に優しい商品を、より安全な、より健康に良いものを求めるようになってきています。また、原材料の調達や製造工程、流通過程において、障害者や高齢者、外国人などの労働参加も可能であるような多様性を尊重した製品やサービスが人々の共感を得ることもあります。気候変動や社会のグローバル化が進展する現代においては、このような社会性のあるビジネスマインドが求められているのではないのでしょうか。

4. ビジネスチャンスはどこに？

私が日々の大学教育で接している若い学生たちからしばしば質問されることがあります。それは「どうすれば、よいビジネスチャンスを見つけられますか？」という質問です。この質問への回答の代わりに、私はある起業家の例を学生たちに紹介しています。

彼の名前は三井孝昭（みつい・たかあき）。ICリードフレームという半導体関連部品の世界市場で約30%のマーケットシェアを占める「株式会社三井ハイテック」という会社の創業者です。彼はもともと終戦直後に九州で精密プレス金型を製造する小さな町工場を起こしますが、1960年代にアメリカに見聞旅行に出かけた折にシリコンバレーで拾った小さな金属片（これがICリードフレームだった）がきっかけとなり、ICリードフレームの国産化に成功しました。

三井氏がアメリカで金属片を拾ったとき、彼はリードフレームどころかIC（半導体集積回路）のことすらよくわかっていませんでした。しかし、その奇妙な形にひかれたのか、その金属片のことについて聞きまわってみようです。その結果、いくつかのことがわかってきました。ICリードフレームは精密で複雑な形状の金属製品であったので、1960年代までは金属の表面を薬品で腐食させる「エッチング」と呼ばれる工法で製造されていました。高価な薬品を使って手間をかけて作るのでコストも高かったのですが、三井氏はプレス金型で金属板を打ち抜く工法でコストと製造時間を大幅に減らし、それまでの製品の7分の1ほどの値段で製品を供給することに成功したのです。最初はあまりの安さに品質を疑われて買い

手が見つかなかったそうですが、やがてある大手企業からの大量受注をきっかけに会社は急成長していきました。

この事例を学生に示しながら、私は「よいビジネスチャンスをつかむ3つの方法」を学生たちに提示しています。

- ① 周りに注意すること。
意外なところにチャンスはあるかもしれない。道に落ちていた金属片が成長へのきっかけとなった例もある。
- ② 質問すること。
質問することによって知らないことを知ることができる。質問しなければ何もわからない。
- ③ 自分の得意分野、専門分野を持つこと。
三井氏はプレス金型製作の専門家だったから、新たな工法を発想することができた。

日頃の心がけ次第で、以上の3項目は実践できるはずです。私は、若者たちに期待しています。

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ
ДЭМЖИХ ЗОРИЛГООР МОНГОЛ, ЯПОНЫ ХАМТЫН
АЖИЛЛАГААГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ

Тозаки Хажимэ

*(Оберин их сургуулийн Бизнесийн
удирдлагын академийн профессор)*

1. Оршил буюу Монголын өнөөгийн байдал Япончуудын нүдээр:

Япончуудын хувьд Монгол ямар улс вэ? Япончуудын сургуульд сурах хугацаанд заавал судлах ёстой дэлхийн түүхийн хичээлээс Чингис хаан тэргүүтэй Монголын эзэнт гүрний гаргасан амжилт нь олон Япон хүмүүст хүчтэй сэтгэгдэл төрүүлсэн буй за. Монголын эзэнт гүрэн бол Азийн улс гэдэг утгаараа Хятадын газар нутгаас ч илүү тэлж Европ тивд хүрсэн билээ. Хятад гүрэн болон бусад улсын түүхийг харсан ч, хүн төрөлхтний түүхийг сөхөж харсан ч Македонийн Александр хүртэл биелүүлж чадаагүй өрнө дорныг хамарсан агуу том эзэнт гүрнийг Монголчууд байгуулж чадсан юм. Ялангуяа морин цэргийн ур чадвар нь тухайн үеийн тулааны арга барилыг бүрэн өөрчилсөн нь дэлхий дахинд маш том нөлөө үзүүлсэн билээ.

Хэдий тийм ч одоогийн Монгол улс нь Япончуудын хувьд төдийлөн танигдаагүй учир битүүлэг улс гэхэд хилсдэхгүй. Монгол бол олон алдартай сүмочдыг төрүүлсэн орон боловч одоогийн сүмо бөхийн иргэдийн сонирхол өмнөх шигээ идэвхтэй биш болсон ба Монголын тухай гэвэл сумогоос илүү мэдээлэлгүй Япончууд олон бий. Энэхүү шалтгаанаас болж Монголыг зорих Япон хүмүүсийн тоо хязгаарлагдмал хэвээр байгаа гэж хэлэхэд болно.

Сүүлийн жилүүдэд аялал жуулчлалын үр өгөөжөөр Азийн бүс нутаг даяар эдийн засаг идэвхжиж, олон Ази жуулчид бүс нутагтаа харилцан аялж байна. Японы хувьд Монгол бол жуулчдын "ариун дагшин газар" гэж үздэг Балба, Бутан зэрэг орнуудаас ч бага танигдсан улс юм болов уу гэж санагдах үе байдаг. Учир нь, Балба, Мьянмар зэрэг улсууд нь хойно дурдагдах ажиллах хүчний хомсдолд нэрвэгдээд байгаа Японд ажиллах хүч нийлүүлэх гол эх үүсвэр болсон бөгөөд эдгээр улсаас Японд ирж суралцдаг оюутнууд их байдаг, хэвлэл мэдээллийн хэрэгслээр Бутантай холбоотой мэдээлэл төрөл бүрээр танилцуулагдаж, аялал жуулчлалын орон гэдгээрээ тодорхой хэмжээнд танигдсан байдаг.

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнууд, ялангуяа Азийн улс орнууд олон улсын аялал жуулчлал, гадаад жуулчдын эрэлт хэрэгцээг хангах замаар эдийн засгийг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Аялал жуулчлал нь эдийн засгийг идэвхжүүлэх төдийгүй улс оронд өргөн хүрээний үр өгөөжийг өгөх боломжтой салбар юм. Нөгөө талаар сүүлийн жилүүдэд жуулчдын хэт их урсгал буюу “аялал жуулчлалын ханалт” гэдэг сөрөг үр дагавар, нөхцөл байдал илэрч байгаа хэдий ч зохих арга хэмжээг авч чадвал аялал жуулчлалаас хүртэх үр шим нь ихээхэн далайцтай байх болно.

Иймд аялал жуулчлалыг хөгжүүлэхэд эерэг болон сөрөг талуудыг доор нэгтгэн дүгнэж, Монгол, Японы хооронд аялал жуулчлалыг хэрхэн эрчимжүүлэх талаар санал бодлоо хуваалцъя.

2. Аялал жуулчлалын хөгжлийн бодлогоор бий болох боломжууд:

Аялал жуулчлалыг хөгжүүлснээр хүмүүс харилцан улс орноор зочилж нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, социал медиа гэх мэт элдэв мэдээлэлд төөрөлдөлгүйгээр өөрийн мэдрэмжид үндэслэн дүгнэх боломжийг олгодог. Мэдээжийн хэрэг, энэхүү шууд мэдрэмж нь ихэвчлэн түр зуурынх бөгөөд түүн дээр үндэслэн дүгнэлт гаргах нь зүйтэй эсэх нь тусдаа асуулт юм. Хязгаарлагдмал мэдрэмж дээр үндэслэн буруу шийдвэр гаргах эрсдэл байсаар байгаа нь үнэн. Гэсэн хэдий ч өдөр тутмын амьдралаас холдон харь газрын орон зайд цагийг өнгөрөөх нь хүний мэдрэмжийг хурцалж, баяжуулж байдаг. Аялал жуулчлалыг дамжуулан хүмүүс хоорондын амьд харилцаа үүссэнээр бие биеэ ойлгоход ахиц дэвшил гарч, улмаар улс төрийн тогтвортой байдалд ч мөн эергээр нөлөөлөх боломжтой.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх нь эдийн засагт ч томоохон үр өгөөжтэйг дурдахад илүүц биз ээ. Аялал жуулчлалтай холбоотой салбарууд өргөн цар хүрээтэй. Аялал жуулчлалын үйлчилгээ болон зочид буудал, тэдгээрийг тойрсон хөтөч, бэлэг дурсгалын үйлдвэрлэл зэрэг олон салбарууд зэрэгцэн оршдог ба агаарын тээвэр, автобус, такси зэрэг тээврийн салбарууд ч чухал үүрэг гүйцэтгэж, аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого амжилтад хүрэх эсэхэд шууд нөлөөлдөг. Олон тооны жуулчид зочилж төрөл бүрийн үйлчилгээ авснаар бүс нутгийн орлого нэмэгдэж, санхүүгийн чадавх бэхжих ба ашиг шимийг нь нутгийн оршин суугчийн төлөө зарцуулж, амьдрахад таатай орчин бүрдүүлэхэд иргэд ба жуулчдын хооронд харилцан ашигтай харилцаа (win-win) бий болно.

Мөн агаарын хөлөг үйлдвэрлэл зэрэг салбарыг үл тооцвол ер нь аялал жуулчлал нь ажлын байрыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулж, хөдөлмөрийн зах зээлийн бодлогод эергээр нөлөөлдөг. (Харин нисэх буудал дахь газрын үйлчилгээ зэрэг ажилд хүч их хэрэгцээтэй хэвээр байна. Японд энэ салбарт ажиллах хүчний хомсдолтой тул аялал жуулчлалын хөгжилд саад болж байна) Аялал жуулчлалын салбар нь зарчмын хувьд нэмүү өртөг үйлдвэрлэх өндөр бүтээмжтэй байдгийг бас дурдах хэрэгтэй. Тухайн улс орны байгаль, соёлын өвд тулгуурлан жуулчдын анхаарлыг татаж, аялал жуулчлал хөгжих хирээр жуулчдын урсгал нэмэгддэг. Тэдгээр өвийг зохих ёсоор хадгалан арчлахад хөрөнгө санхүү шаардлагатай байдаг боловч (үүнийг аялал жуулчлалын хангалтын тухай хойд хэсэгт дурдана) аж үйлдвэрлэлийн салбараас ялгаатай нь томоохон хэмжээний шинэ хөрөнгө оруулалт шаарддаггүй юм.

Нөгөөтгээгүүр, үйлчилгээний салбарт найрсаг зочломтгой чадварыг (hospitality) өрсөлдөх чадварын нэг хэлбэр гэж онцолдог. Иймээс аялал жуулчлалын олон дэд салбарт техник технологийг үр дүнтэй ашиглахад бэрхшээлтэй байдаг бөгөөд хүн хүч ихээхэн шаарддаг салбар юм. (Хиймэл оюунаар ажиллах хүч хэмнэх боломж мэдээж бий ба Японд "Хачин зочид буудал" гэдэг нэр бүхий зочид буудалд үйлчилгээг автоматжуулж байгаа боловч хараахан хангалттай үр дүнд хүрээгүй) Өөрөөр хэлбэл, хүний нөөцийн асуудал бусад салбартай харьцуулбал илүү нухацтай бөгөөд аялал

жуулчлалыг хөгжүүлэхдээ хэрхэн нэмүү өртөг өндөртэй, бүтээмжтэй, олон тооны аялал жуулчлалын хүний нөөцийг хөгжүүлэх вэ гэдэг асуудалтай тулгараад байна. Харамсалтай нь одоогийн байдлаар Японы аялал жуулчлалын салбар нь ерөнхийдөө бага үнээр их борлуулж ашиг олох хэлбэр давамгайлснаар ашиг багатай, ажиллах хүчинд хүртэх хувь ч бага байдаг. Өөрөөр хэлбэл, бусад салбартай харьцуулахад цалин бага хэвээр байгаа учраас чадварлаг хүмүүс энэ салбарт орох, үлдэхэд хүндрэлтэй байдаг.

Мөн, Японы онцлог түүхийг харгалзан үзэх хэрэгтэй. Мэйжигийн шинэчлэл эхлэх хүртэл буурай хөгжилтэй байсан Япон улс хөгжингүй бусад орнуудад дийлэгдэх эрсдэл тулгамдаж байсан тул барууны орнуудын түвшинд хурдан гүйцэх шаардлага гарч байсан билээ. Иймд шаргуу ажиллан хөдөлмөрлөхийг тэргүүнд тавьж, аялал зугаа цэнгэлийг үл тоомсорлох болж, сүүлдээ 1990-ээд онд “эдийн засгийн хөөс” хагарах хүртэл хэвээр байсан юм. Иймд аялал жуулчлалд төдийлөн ач холбогдол өгдөггүй, их дээд сургуулиудын аялал жуулчлалын ангиудыг сайн анхаараагүй байсан учраас авьяаслаг боловсон хүчнийг татахад хүндрэлтэй байжээ. (Японд аялал жуулчлалын боловсролыг системчлэхгүй байгаа нь энэ салбарыг Японы эрдэм шинжилгээний хүрээлэлд төдийлөн үнэлдэггүйн нэг шалтгаан юм.) Цаашилбал, 2020 онд тархсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр аялал жуулчлалын салбарууд нь нийгмийн өөрчлөлтөөс шалтгаалсан эрсдэлд маш эмзэг гэдэг ойлголт нэмэгдсэн. Мөн цар тахлын улмаас бизнес нь дампуурч, аялал жуулчлалын салбараа орхихоос өөр аргагүйд хүрсэн хүмүүс эрсдэлээс зайлсхийх үүднээс эргээд ажлын байрандаа буцаж ирээгүй байгаа юм. Энэхүү нөхцөл байдлыг өөрчлөхийн тулд аялал жуулчлалын салбарын (буюу нийгэм бүхэлдээ) оршин тогтнох стратегийн тулгуур багана болох “сэргэх чадвар (resilience)”-ыг сайжруулахаар идэвхтэй ажиллаж байна. Эдгээр хүчин чармайлт нь хэр зэрэг тодорхой үр дүнд хүрч чадах нь уг салбаруудын ирээдүйд томоохон нөлөө үзүүлэх болно.

3. Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх:

Аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд шаардлагатай дэд бүтцийг бүрдүүлэх шаардлагатай. Эхний алхам бол зорчих тээврийн хэрэгсэл болон тээврийн системийг бүрдүүлж, хөгжүүлэх явдал юм. Жуулчдыг тав тухтай, сонголт сайтай зорчих нөхцөлөөр хангах шаардлагатай. Мөн юун түрүүнд аюулгүй байдлыг хангана. Зам тээврийн осол гаргах орчин нөхцөлөөс зайлсхийж, таксины жолооч нарыг балмад үйлдэл гаргахаас бүрмөсөн сэргийлэх ёстой. Авто замын сүлжээг сайжруулах, аюулгүй зорчих зам тээврийн дүрмийг мөрдүүлэх, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний чанарыг чангатгах зэрэг шийдэгдээгүй олон асуудал аль ч оронд бий. Эдгээр үзэгдлүүд сайжрах нь нутгийн иргэдийн хувьд ч мөн хүсүүштэй зүйл байх нь дамжиггүй. Иймд төрөөс тээвэртэй холбоотой салбаруудад төсвийн хөрөнгө оруулалтаар материаллаг ба зохион байгуулалтын хосолсон бодлогоор цогц шийдвэрт тулгуурлан идэвхтэй дэмжих хэрэгтэй. (Нийгмийг зорчих хөдөлгөөний арга хэрэгслээр хангаж өгөх нь халамж, эрүүл мэндийн бодлогыг давхар дэмжихэд тустай. Үр дүнд нь иргэд хоорондын харилцан зорчих боломж сайжирч нийтийн эрүүл мэндэд эергээр нөлөөлж, цаашилбал эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг бууруулна). Мөн, дэд бүтцэд зочид буудал гэх

мэт түр байрлах байгууламжид мөн хамааралтай. Монголын хувьд нэг давуу тал нь эсгий гэрт түр байрлах өвөрмөц шийдлийг санал болгох боломжтой юм. Ялангуяа сүүлийн жилүүдэд Глампинг (Glamour camping гэх ба хөдөө хээр газар зочид буудлын түвшний үйлчилгээг үзүүлдэг) хэмээх ойлголт газар авч эдгээрийг хослуулах нь шинэ эрэлт хэрэгцээг үүсгэх магадлалтай. Түүнээс гадна жуулчид бүр өөр өөрийн сонголттой байдаг тул хаана ч очсон хотын амьдралд дуртай жуулчдад үйлчлэх боломж бүхий зочид буудлыг бас бэлтгэх шаардлагатай.

Хүний нөөц нь цаашид аялал жуулчлалыг хөгжүүлэх томоохон түлхүүр болно гэдгийг өмнө дурдсан. Монголд ч Японы нэгэн адил цаашид аялал жуулчлалын хүний нөөцийг хэрхэн хөгжүүлэх талаар нэн даруй судлах шаардлагатай гэмээр байна. Энэ тал дээр ялангуяа их дээд сургуулиуд томоохон үүрэг гүйцэтгэж чаддаг. Аялал жуулчлалын хүний нөөц бол зөвхөн гадаад хэлний мэдлэгтэй байхаас гадна тухайн улс орны соёл, улс төрийн байдлын талаар өргөн хүрээний сүүлийн үеийн мэдлэгтэй байх, өөрийн туршлага хуримтлуулан өсөн дэвжих чадвартай байхыг шаарддаг. Ийн чадварыг дээд боловсролын байгууллага болох их дээд сургуулиудад эзэмших боломжтой. Оберлин их сургуульд аялал жуулчлалын чиглэлээр мэргэшсэн олон багш нар байдаг. Энэхүү симпозиумыг шинэ эхлэлийн цэг болгон ашигласнаар бид Оберлин их сургууль болон Монголын их сургуулиуд хооронд аялал жуулчлалын хүний нөөцийг хөгжүүлэх хамтарсан хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх боломжийг нэн даруй судлахыг хүсэж байна.

4. Аялал жуулчлалын тогтвортой хөгжил:

Энэ хүртэл дурдсанчлан аялал жуулчлалын хөгжил нь улс үндэсний хөгжлийн стратегийн хувьд туйлын чухал юм. Гэтэл нөгөө талаар сүүлийн үед дэлхийн аялал жуулчлалын бүс нутгуудад “аялал жуулчлалын ханалт”-ын асуудал оршиж байна. Жуулчид хэт ихээр айлчлан ирэх нь орон нутгийн иргэдийн амьдрал ба байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байна. Цар тахал дэгдэхээс өмнө уг асуудал хурцдаж эхэлж байсан. Цар тахлын өмнөхөн WTO (Олон улсын аялал жуулчлалын байгууллага)-ын нэгдсэн хуралдааны гол сэдвүүдийн нэг нь аялал жуулчлалын ханалтын асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай байв. Гэвч цар тахал эхэлснээр жуулчдын тоо алга болж, уг сэдэв улс орнуудын эрх баригчдын хувьд огт хамааралгүй асуудал болжээ. Тэгээд цар тахлын үед дарагдаж байсан аялал жуулчлалын эрэлт цар тахал намжсаны дараа огцом ихсэж, цар тахлын өмнөх үеэс илүү эрэлт нэмэгдсэн. Үүний үр дүнд аялал жуулчлалын ханалт дахин ноцтой асуудал болж байна.

Ирээдүйд бид олон улсын аялал жуулчлалыг нухацтай хөгжүүлэхийг хүсэж байгаа бол аялал жуулчлалын өндөр хөгжилтэй орнуудын жишгээс суралцаж, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх үүднээс цаг тухай бүрийн нөхцөл байдалтай сайтар танилцаж, гарч болзошгүй ба гарч буй аливаа асуудалд яаралтай хариу арга хэмжээ авахад бэлэн байх шаардлагатай. Үүний тулд аялал жуулчлалтай холбоотой статистик мэдээг хөтлөх ёстой. Цаашилбал, хариу арга хэмжээг сайжруулахын тулд бүс нутаг бүрийн аялал жуулчлалын байдлыг мониторинг хийх тогтолцоог боловсруулж, бодит нөхцөл байдлыг хурдан олж мэдэх (fact finding) чармайлт гаргах ёстой.

Аялал жуулчлалыг хэзээ ч хэт хямд үнээр борлуулж болохгүй. Авах хөлс нь өгч байгаа үйлчилгээний чанартайгаа уялдаатай байх нь чухал. Ингэхгүйгээр бид аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэдийн тоог өсгөж чадахгүй, цаашдын хөгжилд ч хөрөнгө оруулалт хийх боломжгүй. Үнэндээ энэ нь Японы аялал жуулчлалын салбарт тулгараад байгаа томоохон асуудлын нэг юм.

5. Япон дахь аялал жуулчлалын салбарын ирээдүй, Монголын хүний нөөцийн хөгжил:

Аялал жуулчлалын хүний нөөцийн ач холбогдлыг өмнө олонтоо дурдсан бол Японд аялал жуулчлалын хүний нөөцийн хомсдол байсаар байна. Энэ нь харин эргээд Монгол залуучуудад маш том боломж болж байна гэсэн үг. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр манай их сургууль болон Монгол улсын цаашдын хамтын ажиллагаа нь хоёр орны эдийн засаг, нийгмийн хөгжилд шууд сайнаар нөлөөлнө гэдгийг дээр дурдсан. Японы нийт хүн амын тоо буурсаар байгаа бөгөөд ажиллах хүчний хомсдол нь томоохон асуудал болоод байна. Энэхүү нөхцөл байдал дунд цар тахлын улмаас ажиллах хэв маягийн шинэчлэл хийснээр илүү цагаар ажиллах цагийн дээд хязгаарыг чангатгасан. Энэ нь “2024 оны асуудал” хэмээх нэршилтэй шинэ асуудал юм. Үүнээс үүдэн Японы засгийн газар гадаадын ажиллах хүчинд найдлага тавин цагаачлалын хуулиа эргэн харж, ур чадварын дадлагажигч зэрэг хүлээн авах боломжтой ажиллах хүчний тоог нэмэгдүүлж байна. Монгол залуус ч гэсэн энэ боломжийг ашиглан Японд амжилт гаргах хэрэгтэй. Тэд энэхүү мэдлэг туршлагаа эх орондоо буцаж ирээд Монголын аялал жуулчлалын бизнесийн хөгжилд хувь нэмрээ оруулна байх гэж найдаж байна.

Мөн, Японы аялал жуулчлалын онцлог бол найрсаг зочломтгой үйлчилгээнд нэмэлт үнэ төлбөр авахгүй байхыг нэр төрийн хэрэг хэмээн авч үздэг. Энэ нь чанартай үйлчилгээ үзүүлэхийг эрмэлзэж, түүгээрээ бахархаж байгаа хэлбэр хэдий ч зохих шан хөлс авахыг эрмэлздэггүй нь хэт их эрэлтийг бий болгоход нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн өнцгөөс харвал нэг төрлийн бараа үйлчилгээний үнэгүйдүүлэлт (dumping) гэж ойлгож болно. Үүнээс болж хүний нөөцийг хөгжүүлэх хөрөнгө хүрэлцэхгүй, аялал жуулчлалын ханалт үүсэх шалтгаан болж байна. Найрсаг зочломтгой үйлчилгээний шан хөлсийг зохих ёсоор хүртэж, эрэлт нийлүүлэлтийг тэнцвэржүүлэхэд ашиглах, олсон ашгийг чадварлаг хүний нөөцийг хөгжүүлэхэд зарцуулах нь чухал билээ. Түүнээс гадна, чинээлэг давхаргыг татах хүчин чармайлт гаргах хэрэгтэй. Үүний тулд аялал жуулчлалын өндөр ур чадвартай хүний нөөцийг хөгжүүлэх, тэдэнд чиглэсэн дэд бүтцийг хөгжүүлэх нь (бага оврын тийрэлтэт онгоцны хэрэглээг дэмжих гэх зэрэг) чухал юм.

6. Дүгнэлт:

Дээр дурдсанчлан аялал жуулчлалын хөгжил нь үндэсний хөгжил, эдийн засгийг хөгжүүлэх асар том нөөц бололцоотой байсаар байх болно. Гэвч нөгөө талаар аялал жуулчлалын ханалт үүсэх, аялал жуулчлалын боловсон хүчний хомсдол, тээвэр, зочид буудал зэрэг аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх гэх мэт нэн даруй шийдвэрлэх шаардлагатай олон асуудал

бий. Энэхүү симпозиумыг шинэ эхлэлийн цэг болгон ашигласнаар Япон, Монгол хоёр бие биеэсээ суралцан хамтран ажиллаж, аялал жуулчлалын хөгжлийн шинэ загварыг дэлхий дахинд танилцуулж, хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

観光振興政策の推進におけるモンゴルと日本の協力体制の構築

桜美林大学ビジネスマネジメント学群教

授 戸崎 肇

1. はじめに 日本人にとってのモンゴルの現状

日本人にとってモンゴルとはどのような国であろうか。日本人が学生時代にならず学習する世界史の学習からは、多くの日本人にとって、モンゴルはチンギス・ハーンを中心とする蒙古帝国の活躍が、何といても強く印象に残っているだろう。アジアの国家として、モンゴルは、中国をもしのぐ広大な版図をヨーロッパにまで広げた。あの中華帝国をもってしても、そしてより広く世界を見渡しても、さらに歴史をさかのぼっても、アレクサンダー大王でもなし得なかった東西にまたがる大帝国を実現させたのである。その馬によるその機動力は、当時の戦いの在り方を根本から覆すだけの衝撃を全世界に与えたのであった。

それが、今では、多くの日本人にとって、あまりよく知らない国となっており、むしろ神秘の国のようなとらえかたをされているといっても過言ではないかもしれない。確かに、モンゴルは、大相撲の名力士を多数排斥する国としては知られているが、大相撲人気もかつてほど高いものではなく、日本人の多くにとって、それ以上の知識がどこまであるかといえば、はなはだ疑問が残る。

その結果といってもいいかもしれないが、現在、モンゴルを訪れる人の数はまだまだ限られているといっても過言ではない。近年、アジア全域において観光による経済振興が盛んに行われ、多くの人々がアジア域内を歩き来している中、日本にとってモンゴルは、ネパールやブータンといった多くのディープな観光者に「聖地」と見なされている国々以上に、よく知られざる場所と見られているのではないかと、思うてしまうことがある。なぜなら、ネパールやミャンマーなどは、後にみるように、現在、深刻な労働力不足の問題に悩まされている日本にとって、大きな労働力の供給源となってきており、多くの留学生が日本で学んでいるし、ブータンはメディアなどで様々な形で紹介されており、観光先として一定の人気を誇っているからだ。

近年、世界各国、特に多くのアジアの国々は、国際観光、インバウンド需要の取り込みによる経済振興に積極的に取り組んできている。これから見ていくように、観光には、経済効果をもたらすだけでなく、様々な面で国全体にメリットをもたらす可能性をもっている。もちろん、その反面において、昨今問題になっているような「オーバーツーリズム」のような

マイナスの効果・事態を引き起こしていることも確かである。しかし、そうした問題が生じないようにしっかりと考えて観光振興を行っていくことで得られるメリットは極めて大きいものとなりえる。以下では、観光振興がもたらすプラスの面とマイナスの面を整理した上で、今後、モンゴルと日本の間でどのような観光振興が進められていくべきかについて考えていきたい。

2. 観光振興政策がもたらす可能性

観光振興は、人々が直接、お互いの国を訪問することで、SNSなどの情報に紛らわされることなく、自分自身の経験に基づいて相手の状況について判断し、評価を下だすことにつなげることができる。

もちろん、そうした直接的な経験も、多くの場合は刹那的なものであり、それに基づく判断が望ましいものとなるかはどうかは大きな疑問が残るところではある。かえって限られた経験の下に誤った判断を下出すことになる危険性は大きいと言わざるを得ない。しかし、日常とは違い異空間において時を過ごすことは、それだけ神経も研ぎ澄まされることにもなるし、感受性が豊かになることもある。こうした直接的な人の往来を通じて、お互いの本質的理解に進む可能性が増加し、政治的な安定にもつながっていくことは十分に期待できる。

そして、もちろん、観光振興を推進することで大きな経済的効果がもたらされることが期待できる。観光に関わる産業の裾野は広い。旅行業と宿泊業を中心として、その周辺には、ガイド業、お土産産業など多くの関連業務を担うセクターがあるし、航空会社やバス・タクシーなどの交通産業も、観光振興を進めるための極めて重要なインフラとして、観光振興政策の成否を左右するものである。そして、多くの観光客が自国を訪れて様々な形で消費活動を行ってくれれば、その地の財政力は高まり、それが住民福祉などのために還元され、住民にとっても魅力ある地域づくりが行われていけば、住民と観光客との間で極めて望ましいwin-winの関係性が構築されることになる。

また、航空などの装置産業は別として（とはいえ、グランド・ハンドリングなど、空港での業務では多くの労働力が依然として必要である。日本ではこの分野での労働力が不足しており、今後の観光振興政策の推進上、大きなボトルネックとなっている）、一般的に観光関連産業は、雇用吸収力が高いという、労働政策上の魅力がある。

そして、本来の観光産業は付加価値生産性が高いことも注目されるべきところである。根本的にはそれぞれの国の自然や文化といったものが魅力の中心となり、観光振興によって多くの観光客が流入する中、それらを適切に保持するための資金は必要となるものの（この点については後にオーバーツーリズム対策のところであらためて検証する）、製造業などのような大規模な新規投資を必要としないからである。

一方、接客を伴うサービス産業は、ホスピタリティ（おもてなし）がその競争力を形成するものとして重視される。そのため、観光産業における多くの分野においては、機械などによる合理化が難しく（AIによる省力化については、確かに代替可能性が高くなっており、日本における「変なホテル」など、実際にサービスを機械化によって置き換える試みがなされているが、まだまだ十分な成果をあげていない）、労働集約型となる性質がある。つまり、人的資本が他産業に比べてより重要になるということでもあり、観光振興を行っていく場合には、いかに付加価値生産性の高い、優秀な観光人材を多く育成していくか、ということが問題となる。

しかし、残念ながら現状においては、日本の観光関連産業は全般的に薄利多売構造にあり、収益率が低く、その結果、労働分配率も低くなっている。つまり、待遇が他の産業に比べて低くとどまっているために、優秀な人材がなかなかこの業界に入っていない、あるいはとどまらないという構造になっている。

また、日本の場合の特殊事情としては、明治維新以降、弱小国家として他国からの脅威に対抗するため、早急に欧米先進国に追いつくような努力が求められた結果、労働に大きな価値が置かれ、余暇の活動が軽視される傾向が、1990年代、バブル経済が崩壊するまで続いてきた。その中では、観光を重視するような見方は高く評価されず、大学における観光学部などに対する評価も低く、優秀な人材を引き込むことが困難であった（日本における観光教育の体系化が図られてこなかったことも、この分野が総じて日本の学术界での評価が依然として低いことの要因となっている）。

さらには、2020年から本格化した世界的なコロナ禍の影響で、観光関連産業はイベントリスクに対して極めて脆弱な体質を持っているとの認識が高まってしまった。コロナ禍によって経営不振となり、観光関連産業を離れざるをえなかった人々が、その経験に懲りて、元の職場にあえて戻ってこない、という現象も生じている。

こうした事態を改善すべく、観光関連業界（さらには社会全体が）はさかんに「レジリエンス（回復力）」の向上を生き残り戦略の柱として位置づけ、取り組みを進めようとしている。こうした取り組みがどこまで具体的な成果を挙げることができるかが、観光関連産業の今後を大きく左右することにもなるだろう。

3. 観光振興のためのインフラ整備

観光振興を推進していくためには、そのためのインフラストラクチャー（インフラ）を整備していかななくてはならない。

まずは移動手段、交通体系の構築・整備である。観光客にとって快適かつ利便性が高い移動手段を提供していく必要がある。そして何よりも安全性の確保がなされなければならない。交通事故が起こるような環境であってはならないし、タクシーなどのドライバーによる強盗行為などが発生するようなことは断じて防がなければならない。道路網の整備、安全運転ル

ールの徹底、車両整備の厳格化など、取り組むべき課題はどの国も多く抱えている。こうした面が改良されていけば、それは地元の人々にとっても望ましいことであることは間違いないだろう。そのためには、政府は総合的な政策判断のもとに、交通関係に対する公共投資をハード・ソフトの両面において積極的に推し進めていく必要がある（移動の自由を社会的に保障することは、福祉政策、医療政策の推進にもつながることである。人々の交流の機会を保障すれば、人々の社会的健康は増進され、それによって医療費も削減されることになる）。

宿泊施設についても同様である。モンゴルの場合、ゲルを利用した独自の宿泊体験を楽しむことができるという強みがある。特に近年はグランピング（グラマラス (glamorous) とキャンピング (camping) を掛け合わせた造語で、ホテル並みのサービスを野外で愉しむ魅力的なキャンプという意味）が市民権を得てきており、それを組み合わせることで、需要開拓は進むであろう。ただし、観光客は多様な嗜好性をもっている。どこでもアーバンライフを楽しみたい層にも対応できるような宿泊施設の展開も図っていかなければならない。

人的側面については、今後の観光振興を図っていく上で大きなカギとなることはすでに述べた。モンゴルにおいても、日本の場合と同様、観光人材の育成を今後どう進めていくかを早急に検討していく必要があるのかもしれない。この点、特に大学が果たすべき役割は大きい。観光人材としては、単に語学力だけではなく、関係する国の文化や政治状況など、幅広く、かつ最新の知識と、経験を糧に成長する力が求められ、そうした基礎力を養うことができるのは、高等総合教育機関である大学であるからである。桜美林大学には観光に関するスペシャリストである教員が多く所属している。今回のシンポジウムを起点として、早急に、桜美林大学とモンゴルの大学との間で共同の観光人材育成プログラムを開発し、運営していくことを模索していきたい。

4. 持続的な観光とするために

これまで見てきたように、観光振興は国家の成長戦略として非常に重要である。ただ、その一方で、昨今、世界中の観光地で問題となっているのは「オーバーツーリズム」である。過度に多くの観光客が殺到することで、地元の人々の生活に支障をきたし、また自然環境にも悪影響を与えている。

オーバーツーリズムの問題は、コロナ禍が発生する以前に、すでに深刻化していた。コロナ前のWTO（国際観光機関）の総会の主要議題の1つは、オーバーツーリズムの問題にどう対応すべきか、であった。その後、コロナ禍が発生することで観光客そのものがいなくなり、オーバーツーリズムの問題は各国の当局にとって、全く対象外の問題となったのである。しかし、コロナ禍が収束すると、コロナ禍で抑えつけられてきた旅行熱が一気に解放されることになり、観光需要は急速に回復し、コロナ禍前をし

のぐほどの盛況となっている。その結果、オーバーツーリズムの問題が再度深刻化している。

今後、本格的に国際観光の促進を行っていかうとするのであれば、観光先進国の例に学び、持続的な観光となるように、きちんとその時々の実態を把握することにつとめ、何か問題が起きそうな場合、起こりつつある時には、迅速な対応策をとることができるような体制を構築しておくことが必要である。そのためにも、観光関連の統計の整備を行っておかなければならない。さらには、対応力を高めるために、各地での観光状況に対するモニター制度を整備し、即自的なファクト・ファインディングに努めなければならない。

観光は決して安易に安売りすべきものではない。その質に応じた見返りを確実に得ることが重要である。それがなければ、観光に従事する人々の再生産ができないし、さらなる発展に向けた投資もできない。実は、この点が、日本の観光業界が抱えている大きな問題である。

5. 日本における観光業界の今後とモンゴルの人材育成

何度か観光人材の重要性について触れてきたが、日本では、観光人材が総じて不足している。

そのことは、翻って見ると、ここにモンゴルの若者にとって大きなチャンスを見出すことができるということである。これも先に言及しているところだが、今後、本学とモンゴルとの間で観光人材の育成にあたることは、両国の経済的・社会的発展に即効性をもつことになる。

日本ではそもそも人口が減少しており、労働力不足が大きな問題となっている。そうした中、コロナ禍をきっかけに働き方改革が進み、残業時間の上限規制も厳格化された。これがいわゆる「2024年問題」という形で現出しているものである。このため、日本政府は外国人労働力に期待をよせ、入国管理法の見直しを進めており、技能実習生などの受け入れ枠を拡大している。モンゴルの若者たちも、この機会をとらえ、日本での活躍を模索すべきであろう。そして、その経験をもって自国に戻り、モンゴルの観光事業を推進し、高度化していくことが期待される。

また、日本の観光においては、ホスピタリティはただで提供することが美德であるという意識がある。しかし、高品質なサービスの提供に努め、そのことを誇りとしながら、それに対する適切な報酬を得ようとしなないことは、過剰需要を生じさせているということもできる。つまり、経済学的に見ればある種のダンピング（不当廉売）とみなすこともできるのだ。このために、人材育成のための原資が不十分となり、オーバーツーリズムが発生する1つの要因ともなっている。ホスピタリティの提供に対して、それに対する正当な対価を求め、それをもって需給の均衡を図り、またその収益によって優秀な人材の育成の原資としていくことが重要である。

さらには富裕層の獲得にも努めるべきであろう。そのためにも、高度な観光人材の育成と、彼らをターゲットとしたインフラ整備（ビジネスジェットの乗り入れ促進など）が重要となってくる。

6. まとめ

これまで述べてきたように、国の成長を促し、経済を発展させていく上で、観光振興は大きな潜在的な可能性をもし続けるだろう。しかし、その一方で、オーバーツーリズムの発生、観光人材の不足、交通・宿泊といった観光インフラの整備など、早急に解決すべき問題も山積している。今回のシンポジウムを新たな起点として、日本とモンゴルがお互いに学び、協力することによって、世界に新しい観光開発モデルを提示できるようにしていけるよう、お互いに提携して取り組んでいけることを期待したい。

МОНГОЛ, ЯПОНЫ ХООРОНДЫН СОЁЛЫН ХАРИЛЦААГ
ГҮНЗГИЙРҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛД

Ж. Баатарцогт

(Урлаг судлалын ухааны доктор Ph.D, профессор)

Өнөөдрийн эрдэм шинжилгээний хуралд оролцож байгаа Оберлин Их сургуулийн хүндэт эрдэмтэн багш нар, мөн цаг зав гарган идэвхтэй оролцож байгаа судлаачдад талархал илэрхийлье. Оберлин Их сургууль Монгол Японы Соёлын харилцааны нэгэн гүүр болж байдагт бид баяртай байдаг. Жил бүрийн зун, профессор багш Toba Baikan [Байгал]-аар удирдуулсан оюутны групп монголд оронд тогтмол ирж монголчуудын түүх соёл, ахуй амьдрал, Монгол орны байгальтай танилцаж ажиглалт хийдэг болсон нь хоёр орны соёлын харилцааг гүнзгийрүүлэхэд тодорхой хувь нэмрээ оруулж байгаа сайн жишээ мөн.

2024 он. Монгол Японы хооронд Соёлын Харилцааны хэлэлцээр байгуулагдсаны 50 жилийн ойн баярын жил. Соёлын харилцааны энэхүү хэлэлцээр бол онцгой чухал хэлэлцээр байсан юм. 1972 онд хоёр орны хооронд дипломат харилцаа байгуулагдсанаас хойш бүтэн хоёр жил хоёр орны харилцаа төдийлөн идэвхжээгүй байдаг. Харин Соёлын харилцааны хэлэлцээр байгуулагдсанаар хоёр орны харилцаа эрс идэвхэжсэн хэмээн судлаачид дүгнэдэг бөгөөд энэ хэлэлцээр бол үнэн хэрэгтээ дипломат харилцааг амилуулсан маш чухал алхам байсан гэж хэлж болно. Энэ цагаас хойш Японы эрдэмтэд, судлаачид монголд ирж байгаль орчин, мал аж ахуйн чиглэлээр суурин судалгаа хийж эхэлсэн, дадлагажигч багш, оюутны солилцоо эхэлсэн, МУИС-д япон хэлний тэнхим байгуулагдаж япон хэлний мэргэжлийн сургалт эхэлсэн, Монголын радиогийн дэргэд Япон хэлний редакц байгуулж япон хэлээр нэвтрүүлэг эхлүүлэх шийдвэр гарсан, Японы гэрэл зургийн мастеруудын үзэсгэлэн, япон киноны өдрүүд зэрэг соёлын олон арга хэмжээ зохиогдож эхэлсэн нь нэн дурсамжтай. Монгол Японы Найрамдлын нийгэмлэгийн ажиллагаа эрс идэвхэжсэний зэрэгцээ Японтой харилцах салбар нийгэмлэгүүд олноор байгуулагдаж үйл ажиллагаа явуулж эхэлсэн түүхтэй. Япон хэлний сургалт явуулж байгаа бүх шатны сургуулиудаар дамжиж японы соёл монголд идэвхтэй түгээж байгааг дурдахад таатай байна. Өнөөдөр, хоорондоо японоор ярилцаж яваа монгол залуучууд гудамжинд тааралдах нь ердийн үзэгдэл болсон байна.

МУИС-ын дэргэд япон хэлний сургалт эхэлж байсан тэртээ 1970-аад оны дунд үед Япон хэлний ангид орсон оюутнуудаас, “-Чи яах нь вэ? Тагнуул болох нь уу?” гэж ёжилж асуудаг байсан хэмээн Цэвэгмаа сан ярьдаг байсныг санахад инээдэмтэй.

Соёлын харилцаа уран сайхны соёлын салбарт жилээс жилд хөгжиж байгаа боловч хангалттай биш байна. Урлаг, уран сайхны соёлын хамтын

ажиллагаа, солилцоог гүнзгийрүүлэхэд оюутан залуучуудын оролцоо чухал байна. Үүнтэй холбогдуулан дараах хэдэн санал хэлье гэж санасан юм.

- Японы анимэйшн киноны урлаг дэлхийд гайхагддаг. Японы хүүхэддэйн /анимэйшн/ хүүхэд залуучуудын сэдэвтэй уран сайхны киноны хөтөлбөрүүдийг монголын телевизийн сувгуудад олшруулах арга замыг хамтран хайх.

- Монгол ардын үлгэрийн сангаас япон хэлэнд хөрвүүлэх, японы үлгэр домгийн арвин сангаас монгол хэлнээ хөрвүүлж хоёр орны бяцхан уншигчдын хүртээл болгохыг чухалчлах.

- Залуу уран бүтээлчдийн хамтын ажиллагааг өрнүүлэх, үүний тулд, жишээлбэл Монголын Кино телевизийн сургуулийн оюутнууд, Японы ижил төстэй мэргэжлээр сурч буй оюутнуудын хамтарсан сэдэвчилсэн богино хэмжээний баримтат кинонууд хийлгэх байх асуудлыг судлах.

- Монголын уран зургийн дээд сургуулийн оюутнууд, Японы уран зургийн мэргэжлээр суралцаж буй оюутнуудын уран бүтээлийн үзэсгэлэн Улаанбаатар, Токиод гаргаж байх.

- Монгол Японы зураач оюутнуудын хээрийн хамтарсан дадлагыг Монголын хөдөөд хийлгэдэг болох. Монголын мал аж ахуйн соёлд өнгө зүсний ялгарамж нэршил олон арваар тоологдоно. Адууны зүс гэхэд л өөр хэлэнд шууд оноон хөрвүүлэх боломжгүй ойролцоо өнгө зүсний ялгарамж нэн олон. Нэг л зүсмийн боловч халиун морь, хул морь, саарал морь, цавьдар морь, шарга морь гэх зэргээр ойролцоо өнгөөр ялгагдана. Өнгөний эдгээр ялгарамжийг хөдөөний хүүхдүүд бүгдийг бага наснаасаа ялгаж мэддэг болдог. Зураач оюутнуудын хээрийн дадлага чухам өнгөний ийм ялгарамжийг ойлгоход чухал. Дээр нь морины явдал хөдөлгөөнд шогших, сайварлах, жороолох, хатирах, давхих гэсэн ойлголт байх жишээтэй. Энэ ойлголт нь уран бүтээлд хөдөлгөөний дүрслэлийн төсөөллийг буй болгоход хэрэгтэй.

-Мөн дизайны чиглэлээр суралцдаг оюутнуудын хамтарсан үзэсгэлэн тухай тухайн сургуулиуд дээр гаргаж байх нь нэг нэгнээсээ харилцан сурахад тустай гэж санагддаг. Соёлд ялагч, ялагдагч гэж хэзээ ч байдаггүй, бие биеэ л харилцан баяжуулдаг зүй тогтолтой. Нүүдэлчдийн соёлын нэгэн онцлог бол нүүж суухад тохирсон эдлэл хэрэглэлийн минимализм юм. Тийм ч учраас нүүдэлчдийн ахуйд зохицсон хэрэглээний дизайн хөгжсөн байдаг. Оюутнуудын хээрийн хамтарсан дадлага монголчуудын эд хэрэглэлийн дизайны урлагийн өвөрмөц дүр төрхтэй танилцах бас нэг боломж болох юм.

- Оюутны хөгжмийн цөөхүүл хамтлагуудын тоглолтын хөтөлбөрийн солилцоог хөгжүүлэхэд хоёр тал анхаарах ёстой. Цөөхүүл хөгжмийн хамтлаг гэж тодотгож байгаа нь зардал сүйтгэлтэй холбоотой болно. Жишээлбэл Оберлин Их сургуулийн урлагийн салбарын өдрүүд /гурав хоног, тав хоног/-ийг Улаанбаатар хотноо, Монголын Хөгжим, Бүжиг, Циркийн сургуулийн өдөрлгүүдийг Оберлин Их сургууль дээр тодорхой давтамжтайгаар зохиодог болвол сонирхолтой бөгөөд багш оюутнууд бие биенээсээ харилцан суралцахад тус нэмэр болно гэж санагдадаг.

-Монголын хөгжмийн урлагийг Япон оронд сурталчилж байгаа гол зүтгүүр бол Монгол Улсын Морин хуурын чуулга билээ. Энэ чуулга сүүлийн хорь гаруй жил гучаад удаа Япон оронд аялан тоглож Японы олон мянган

үзэгчдэд монголчуудын хөгжмийн урлагийг сурталчлан таниулсаар ирсэн юм. Олон удаагийн эдгээр тоглолтыг зохион байгуулсан гавьатан нь Оберлин Их сургуулийн төгсөгч, хатагтай Норико Сато гэдгийг тэмдэглэн хэлэхэд таатай байдаг.

Эдүгээ Япон оронд морин хуур сонирхогчдын тоо 700 гаруйд хүрсэн гэсэн албан бус мэдээ байгаа бөгөөд мэргэжлийн түшинд ойртож байгаа морин хуурчдын цөөхүүл хамтлагууд ч Японы зарим хотуудад бий болсон тухай яригддаг. Өнгөрсөн 7-р сарын 17,18 –ны өдрүүдэд Өмнөговь аймагт зохиогдсон Олон улсын морин хуурчдын YII наадамд морин хуурын ая эгшгийг бишрэн хүндэтгэдэг цөөнгүй япон хүмүүс ирж, морин хуурын наадмыг сонирхов. Морин хуур суралцагч Такэючи Юмико /53 настай/ сонирхогчдын ангиллын уралдаанд оролцож, шагналт байрын өргөмжлөл хүртсэнийг тэмдэглэхэд таатай байна.

Токио, Осака хотуудад манай морин хуурчид сайн дурын сургалтууд явуулсаар удаж байна. Энэ бол сайшаалтай хэрэг мөн боловч хангалттай биш юм. Тийм учраас, тухайлбал Оберлин Их сургуулийн Урлагийн салбарт Морин хуурын мэргэжлийн сургалтыг эхлүүлэх юм сан гэсэн бодол надад байдаг юм. Ийм саналыг би өнөөдөр дэвшүүлж байна. Туршлагатай, мэргэжлийн тэргүүлэх зэрэглэлийн багшаар хангах боломж бидэнд бий. Миний энэ саналыг судлан үзэхийг Та бүхнээс хүсье.

モンゴルと日本の文化交流を発展させることについて

J.バートルトツオクト モンゴル文化教育大学副理事長、
モンゴル日本文化交流促進アリアンス協会会長、
モンゴル国立文化芸術大学名誉教授、モンゴル国立音楽学校教授

本日のシンポジウムに参加していただきました桜美林大学の先生方並びにお忙しいところお越しいただいた皆様、誠にありがとうございます。桜美林大学がモンゴルと日本の文化交流の架け橋になっていることを大変嬉しく思います。桜美林大学のバイカル教授が毎年夏の環境研修を担当してモンゴルの文化、生活様式、モンゴルの自然を日本の学生に紹介してきたのは両国の文化交流の深い発展に貢献している一つの例でございます。

2024年はモンゴルと日本の文化交流の協定を結んだ50周年の記念の年である。1972年に日本とモンゴルが外交関係樹立して以来2年間は両国関係はあまり活発ではなかった。しかし、文化交流の協定が結んで以来、両国の外交関係が一歩進んだと研究者らが言っていて、本協定が実際に外交関係を生かした非常に大事な出来事だと言えるだろう。この時期から日本の科学者及び研究者がモンゴル国を訪れて自然環境、牧業分野に興味を持って研究を行った。また研修生の教員、交換留学生在が訪問した。モンゴル国立大学日本語学科が創設され、日本語教育がスタートした。モンゴルラジオにおける日本語局が創立されて日本語の番組を放送することが決定された。日本の写真展示会また日本の絵映画デーなど数多くのイベントが開催されていたのは思い出になっている。

モンゴルと日本の友好関係が一步進んだため日本との関係が活発的に発展した。日本語教育を通して日本文化がモンゴルで流行していることに感謝している。今日、日本語で話している若者が市内にいるのは普通のことになっている。モンゴル国立大学の日本語コースが1970年代中頃に日本語を勉強していた学生たちに対して”あなたはスパイになるんですか”とよく言われていたとツェベグマーさんが言っていたことが面白かった。文化交流が年々発展しているが十分ではない。芸術と芸術文化の協力と交流を深めるには、学生や青少年の参加が重要である。これに関しては、私は以下のような提案をしたい。

- 日本のアニメは世界中で有名である。そこで、アニメや若者たちの興味を持たせる番組をモンゴルのテレビなどで見せる方法を検討する
 - モンゴルの民話を日本語に訳して、日本の民話と昔話をモンゴル語に訳して両国の子供たちに提供する。
 - 青年アーティストの協力を広げるため、モンゴル国立文化芸術大学におけるラジオテレビ学部の学生たちと同じ専門で勉強している日本の学生たちと協力してもらって短編ドキュメンタリーを制作することを検討する
 - モンゴル美術大学の学生とウランバートルと東京で日本美術を学ぶ学生による作品展を開催する。
 - モンゴルと日本の画家専攻の学生たちの共同研修をモンゴルの田舎で行うこと。モンゴルの牧業の文化にも色のシンボルや名称がある。馬の色だと他言語に訳するために非常に難しい。同じ種であっても、茶色の馬、サーモン色の馬、灰色の馬、黄褐色の馬、黄色の馬など、似た色で区別できる。田舎の子供たちは、子供の頃からこれらの色の違いを区別することを学ぶ。このような色の違いを理解するには、学生画家による現場実習が重要である。それに加えて、バック、いななき、ギャロップなどの馬の動きの概念がある。この概念は、芸術における動きの視覚的なイメージを作成するのに役立つ。
 - また、デザイン専攻の学生たちの合同展示会を開催することも相互学習に役立つと思う。文化には勝者も敗者も決してなく、お互いを豊かにするパターンがある。遊牧文化の特徴の一つは、移動に適したミニマルズムの家具である。だからこそ、消費者向けデザインは遊牧民のライフスタイルに合わせて進化した。学生たちの共同フィールド実習は、モンゴル製品のデザイン芸術の独特なイメージを知るもう一つの機会となるだろう。
 - 学生音楽グループの交流演奏プログラムの発展に注意を払うべきである。
例えば、桜美林大学の芸術の日(3日間、5日間)がウランバートルで、モンゴル音楽、ダンス、サーカス学校の日が桜美林大学で開催され、教師と学生が互いに学び合うのに役立つとしたら興味深いだろう。
 - 日本でモンゴル音楽を紹介しているのはモンゴルの馬頭琴アンサンブルである。
- このアンサンブルは過去20年間に30回日本を訪れて、何千人もの日本の聴衆にモンゴル音楽を紹介してきた。

- 上記のコンサートを主催したのは桜美林大学卒業生であるSato Norikoという人である。現在、日本で馬頭琴に興味がある人々は700人近くになったという非公式なニュースがある。専門家のレベルに近づいている馬頭琴バンドが日本にあるという話もある。先月南ゴビで開催された国際馬頭琴の第7回フェスティバルにも日本人の観客もいた。馬頭琴を練習しているTakeuchi Yumikoさん(53歳)がアマチュア部門に出場し、受賞できたことを大変嬉しく思う。東京と大阪でモンゴルのボランティア馬頭琴のコースが始まったが、まだ十分とは言えない。そこで、桜美林大学の芸術専攻に馬頭琴専門コースをスタートさせることについて私は考えている。私たちは経験がある馬頭琴専門の教員を紹介することが可能である。

私のこの意見を検討していただければ幸いです。どうぞよろしく願いいたします。

МОНГОЛЫН ШИНЭ ҮЕИЙН АНХНЫ ДУУ БА ХЯТАД, ЯПОНЫ
СОЁЛЫН НӨЛӨӨ

Б.Мөнхбаяр

*(Соёл эрдэм дээд сургуулийн Эрдмийн зөвлөлийн гишүүн,
Хэл бичгийн ухааны доктор (Ph.D))*

Бичгийн утга уран зохиолын харилцан нөлөөллийн ойлголт нь уран зохиолын уламжлал шинэчлэлийн асуудлаас ялгаатай асуудал байдаг. Өөрөөр хэлбэл бичгийн зохиол дахь харилцан нөлөөлөл ба уламжлал шинэчлэлийн асуудлууд нь бие биенээс ялгардаг хоёр тусдаа, биеэ даасан ойлголт болох юм. Ийм нарийн заагтай хэдий ч хоорондоо маш нягт харилцаа холбоотой оршдог.

Юуны өмнө утга зохиолын уламжлал шинэчлэлийн харилцааны талаарх ойлголт нь цуваа цагийн хүрээнд авч үзэх ёстой ойлголт байдаг. Тэгвэл харилцан нөлөөллийн асуудал нь бичгийн зохиолын хам цагийн хүрээгээр тайлбарлах ёстой ойлголт байдаг. Энэ бол уран сайхны үзэгдэлд туссан аливаа асуудлыг авч үзэх онол арга зүйн чухал тал нь болдог. Учир нь:

- Хэрэв уламжлал, шинэчлэлийн харилцааны тухай асуудал нь аль нэгэн зохиол бүтээлд үзүүлсэн дүр дүрслэл, өгүүлэмж хэрэг явдал, агуулга утга санаа нь дараа үеийн, хожим хойч үеийн зохиол бүтээлд хэрхэн яаж тэлж шинэчлэгдсэн, хожим хойч цаг үеийн нийгмийн үйл хэргийг үзүүлэхэд хэрхэн яаж холбогдож байгаа, утга учир, агуулгын далайц нь яаж нийцэж байгаа, үнэт зүйлийн мөн чанараа хэрхэн яаж хадгалж ирсэн тухай ойлголт байдаг учраас жишээ нь XIII зуун, XV зуун, XVII, XIX зуун, XX зуун, XXI зууны зохиол бүтээлд Чингис хааныг хэрхэн дүрслэн үзүүлж ирэв, XXI зууны зохиол бүтээл дэх Чингис хааны тухай үнэлэмж, дүрслэл нь, өмнөх цаг үеийн алинтай нь хамгийн их төстэй, үнэлэмж, үнэ цэнийн хувьд адил байгаа, алинаас нь хамгийн их ялгаатай байгааг тодорхойлно гэсэн үг болох юм.
- Тэгвэл утга зохиолын харилцан нөлөөллийн асуудал нь өмнөх ба хойнох үеийн бүтээлийн дүр дүрслэлтэй холбогдох биш, нэгэн цаг үед байгаа ижил төстэй зохиол бүтээлийн туурвил зүйн сэтгэлгээтэй хэрхэн яаж холбогдож байгаа, юугаар ижил, юугаараа өөр ялгаатай үнэлэмж бүхий байгааг тодорхойлно гэсэн үг болох юм. Тэгэхээр нэгэн цаг үеийн олон зохиолчийн нэг үйл хэрэг явдлын талаар бичсэн зүйлээс аль нь хамгийн үнэн, зөв, уран сайхантай, бодитой, цаг үеийнхээ нийгмэм гоо зүй, уран сайхны үнэлэмжийг шингээж чадаж вэ гэдгийг илрүүлнэ гэсэн үг болох юм. Жишээ нь, Чингис хааны тухай өгүүлсэн 2000-2010 оны хооронд бичигдсэн зохиол бүтээлүүдээс хамгийн сайн, хамгийн зөв, хамгийн нөлөө бүхий байгаа зохиол бүтээлийг нь утга зохиол судлалын онолын үүднээс тодорхойлно гэсэн үг болох юм.

Утга зохиолын онолын уламжлал шинэчлэл ба харилцан нөлөөллийн асуудлын хоорондоо ялгарах гол ялгаа нь үүнд орших бөгөөд үүнийг дараах зургаар бүдүүвчлэн үзүүлбэл:

Б – уламжлал шинэчлэл
А – харилцан нөлөөлөл

Б

| | |
|--|--|
| <p>Төв Азийн уран зохиол Төвөд-Монголын уран зохиол Монгол-Оросын уран зохиол</p> | <p>- аман зохиол - эртний уран зохиол - дундад зууны уран зохиол - ХҮП-ХХ зууны уран зохиол</p> |
| <p>А</p> | <p>ХХ зууны уран зохиол ХХI зууны эхэн үеийн уран зохиол</p> |

гэсэн харьцаа бүхий болох юм. Үүнд: босоо буюу цуваа тэнхлэгийн дагуу буюу аман зохиолоос ХХI зууны эхэн үе уран зохиол хүртэлх уран зохиол хоорондын холбоо нь уламжлал шинэчлэлийн харилцаа бол, хэвтээ тэнхлэгийн дагуу хам цагийн хүрээнд байрлах Төв Азийн уран зохиол, Төвөд-Монголын уран зохиол, Монгол-Оросын уран зохиолын харилцаа холбоо нь харилцан нөлөөлөл юм.

Тэгэхээр уран зохиол дахь харилцан нөлөөлөл бол тухайн цаг үе, нийгэм газар зүй, хоёр улс үндэстний эрх ашиг, шашин соёл урлагийн харилцаа холбоогоор дамжин нэгээс, нөгөөд нөлөөлөх явдал болж байгаа юм. Өөрөөр хэлбэл хоёр буюу түүнээс олон газар орон, орон зайд боловч, нэгэн адил ойролцоо цаг үед, адилхан нэг утга сэдэв чиглэлтэй, ижил төстэй агуулга, санаатай зохиол бүтээл олон байдгийг уран зохиолын харилцан нөлөөлөл гэдэг ойлголтын хүрээнд авч үзнэ гэсэн үг юм.

Монголын уран зохиолын хувьд ийм баримт олныг дурдаж болно. Жишээ нь: Дундад зууны үеийн олон монгол зохиол энэтхэг төвдөөс орж ирсэн буддын шашны үзэл номлол, сэтгэлгээний загвараар, тэдний урлаг уран зохиол бүтээх дэг маягаар бүтээгдсэн байдаг. Ойрын баримт гэхэд л Ч.Лодойдамба “Тунгалаг Тамир” романаа оросын зохиолч М.Шолоховын “Дөлгөөн Дон” романаас суралцаж туурвисан тухай өөрийнх нь дурсамж байдаг. Тэгэхээр М.Шолоховын “Дөлгөөн Дон”, Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир”, Өвөр Монголын зохиолч Бүрэнтөгсийн “Дэлгэр Хангай” энэ гурван романы хоорондын холбоог харилцан нөлөөллийн ойлголтоор тайлбарлана гэсэн үг юм.

Гэхдээ харилцан нөлөөлөл гэхээр нөгөө улс үндэстнийхээ утга зохиолоос шуудаар хуулбарлан хэрэглэхийг хэлнэ гэж ойлгож болохгүй. Монголын уран зохиол судлаачдад ийм асуудал тулгарч байсан бөгөөд, үүнийг Д.Нацагдоржийн “Од” болон Оросын яруу найрагч С.Есениний “Одод” шүлэг хоёроос харж болно.

“Одод”
*“Холхи одод минь, өнгөт
 одод минь”*

“Од”
*“Холхи газраас гялалзан
 харагдах өнгөт од оо!”*

Хонгор биендээ чи юу
 өвөрлөн нууна вэ?
 Гүн бодол урсгагч
 одод минь
 Хүний сэтгэлийг чи,
 ямар хүчээр эзэгнэнэ вэ?
 Жирвэлзэх одод минь
 жижигхэн одод минь
 Ямар хүч, ямар сайхан юм
 чам дээр оршино вэ?
 Ямар юмаараа тэнгэрийн
 одод минь чи
 Агуу чадалт эрдмийн хүчийг
 татна вэ?
 Гэрэлтэхийн цагтаа чи
 яагаад
 Гэгээгээрээ таалан, тэнгэрт
 даллана вэ?
 Холхи одод, тэнгэрийн
 одод
 Хонгор сэтгэлий минь
 ялдамхан илбэнэ.”

Хязгааргүй огторгуйн дунд
 зугаалах олон улаан оч оо!
 Нарт ертөнцийн дотор суугаа
 марс од оо!
 Манай хүн төрөлхтөн чамтай
 танилцахыг хэдийнээс хүсэв.
 Алтан сайхан бие дээр чинь
 ямар хүн, эрдэнэ оршином?
 Уул ус, цэцэг мод чинь юугаар
 бүтсэн бэ?
 Манай ертөнц шиг янз янзын
 юм холин байна уу?
 Нийгэм журмын байдал чам
 дээр тогтсон уу? үгүй юу?
 Од чиний тэндээс энэ дэлхий,
 ямар өнгөтэй үзэгднэм.
 Орчлонт ертөнц гэдгийг
 мэдсэн үү? үгүй юу?
 Янаглал амраглалын дөл
 аль зэрэг хурц вэ?
 Юунд манай ертөнцөд захиа
 үл илгээнэ, чи?
 Эрдэмт Марс од оо! Чи,
 нэгд нэгээр харж байна.
 Энэ дэлхийн түмэн байдлыг
 юу гэж сонирхоно, чи
 Огторгуйн оргилын олон эрдэмтэн,
 чамайг хэдийнээс сонирхов.
 Урьдаар нийгэм журам байгуулж
 дараагаар чамтай ураг больё гэнэ.”

Уг хоёр шүлгийн талаар С.Лочин “Суут хоёр одны ховор тохиол” өгүүлэлдээ: “Энэхүү хоёр шүлгийг зэрэгцүүлэн үзвэл нэг нь нөгөөгөө яг хуулбарлачихсан байна гэхийн аргагүй ч, ерөнхий аяс тухайлбал, одон дээрх нууцыг сонирхон, түүнийг танин мэдэх гэсэн их эрмэлзлэл, тэмүүлэл, од чи эртнээс энэ дэлхийн эрдэмт мэргэдийн оюун ухааныг эзэмдэн, өөртөө татсаар ирлээ гэсэн ерөнхий нэг санааг гаргажээ. Тиймээс ч хоёул уянгын бадруун амьсгал бүхий нэг уншсан хүний сэтгэлд хоногшсон, сайхан шүлэг болжээ. Энэхүү хоёр “Од”-ыг бүтээгчид хэн болохыг ч бид андахгүй мэднэ. Үүний нэгийг нь орос зөвлөлтийн их шүлэгч С.А.Есенин, нөгөөг нь монгол түмний билигт хүү Д.Нацагдорж бичсэн. Энэ гайхамшигт шүлэгчдийн намтар, уран бүтээлийг хооронд нь харьцуулбал зөвхөн “Од” шүлгүүд нь төстэй биш болох нь харагдана. Үүнд: нэг нь 1910-1925 онуудад буюу 15 жил, нөгөө нь 1923-1937 буюу 14 жил уран бүтээлээ туурвиж, нэг нь 30 насандаа, нөгөө нь 31 насандаа авъяас билгийнхээ ид өрнөж байсан үед, зуурдын тохиолоор нас баржээ. Аль алиных нь шүлэг эх хэлнийхээ урлах, уяруулах чадварыг илтгэн, “чихнүү чимэгт” уянгалаг аясыг өөртөө шингээсэн яруу сайхан ажээ. Нэг нь перс оронд хэзээ ч очиж байгаагүй ч тэр нутаг, тэндэхийн эмэгтэйчүүдийг магтан дуулж, тэр орны тухай гайхамшигт мөчлөг шүлэг бүтээжээ. Нөгөө нь

Энэтхэг, Итали оронд очиж үзээгүй ч мөн л тэр орнуудын тухай, тэндэхийн эмэгтэйчүүд, залуусын хайр дурлалын тухай зүрхэнд шингэсэн яруу шүлгээ зохиожээ. Мөн хэн хэн нь хуучин нийгэм задран, хувьсгал ялж байсан цаг төрийн өөрчлөл, хувьслын үед амьдарч байсан бөгөөд хоёул яг ижил замаар биш ч, хувьсгалыг хүлээн авч, түүнд итгэж, хувьсгалын хэрэгт үзгэн “жад”-аа барин тэмцэж, өөр өөрийн орны хувьсгалын их удирдагчдын дүрийг уран зохиолд товойлгон, нэг нь эх орондоо хамгаас түүрүүн В.И.Лениний тухай “Эх дэлхийн ахмад” найраглалаа, нөгөө нь Д.Сүхбаатарын тухай “Монгол ардын суут” жүжгээ бичжээ. Мөн ард түмнийхээ өнгөрсөн үеийн тэмцлийн түүхт явдлаас сэдэвлэн “Пугачёв”, “Учиртай гурван толгой” зохиолуудаа бүтээжээ. Ингэж л уран бүтээлээрээ од болж байсан хоёр найрагч маань “Од” шүлэг бичигдээсн нь өөр өөрийн учиртай байсан нь мэдээж бөгөөд одоо энэхүү хоёр шүлэг хэдийд бичигдсэн, яагаад ижилдүү болсон тухайд бодлоо хэлье. С.А.Есенин “Звезды” буюу “Одод” (“Од” гэж монголоор орчуулан хэвлэсэн) шүлгээ 1911-1912 оны үед бичсэн гэж зөвлөлтийн утга зохиол судлагчид үздэг юм байна. Д.Нацагдорж “Од” шүлгээ 1931 онд бичсэн бөгөөд гар бичмэл нь хадгалагдаж байгаа тул бичсэн оны хувьд элдэв эргэлзэл төрөх ёсгүй. Есенины шүлгийн хувьд гэвэл “Од” зэрэг арваад шүлгээ өөрөө хоёр дэвтэрт бичиж, 1911, 1912 он гэж бичсэн бичмэл эх нь бас байдаг аж. Тэгэхлээр Есенин энэ шүлгээ бичсэн он нь ойролцоогоор тодорхой байгаа юм. Ийн энэ хоёр шүлэг хориод жилийн хойно урд бичигдсэн болохоор Д.Нацагдорж маань Есениний шүлгийг үзсэн байж болох нь. Тэгээд ч төсөөтэйдүү байна гэж болмоор ажээ. Үнэхээр

“Холхи одод минь, өнгөт одод минь” (С.Е)

“Холхи газраас гялалзан харагдах өнгөт од оо!” (Д.Н)

“Хонгор биендээ чи юу өвөрлөн нууна вэ” (С.Е)

“Алтан сайхан биен дээр чинь ямар хүн, эрдэнэ оршном” (Д.Н)

“Ямар хүч, сайхан юм чам дээр оршино вэ?” (С.Е)

“Хүний сэтгэлийг чи ямар хүчээр эзэгнэнэ вэ?” (С.Е)

“Манай хүн төрөлхтөн чамтай танилцахыг хэдийнээс хүсэв” (Д.Н)

“...чи яагаад гэгээгээрээ таалан, тэнгэрт даллана вэ” (С.Е)

“...Олон эрдэмтэн чамайг хэдийнээс сонирхов” (Д.Н) гэсэн бараг ижил

шахам мөрүүд байгаагаас гадна, шүлгийн ерөнхий аяс, өнгө төстэйг дээр өгүүлсэн. Гэвч энэ бүхнээс үндэслээд Д.Нацагдорж, Есениний шүлгийг уншиж, түүнээс санаа авсан гэх юм уу, түүрүүн гарсан шүлгийг арай тодотгон, түүнийг дуурайн бичжээ гэхийн үндэс байхгүй. Яагаад гэвэл ганцхан уран зохиолд ч биш шинжлэх ухааны бусад салбарт ч өөр өөр газрын эрдэмтэн мэргэд бие биенийхээ судалгаа шинжилгээний тухай юу ч мэдэлгүй байгаад ижил нээлт хийн, шинжлэх ухаанд хоёулангийнх нь нэр мөнхрөн орсон нь олонтоо байдгийг үл өгүүлэн зөвхөн баримт сэлтийг харьцуулан үзвэл С.Есенин энэхүү шүлгээ хэдийбээр 1911-1912 оны үед 17-18 настайдаа бичсэн авч 1958 он хүртэл, өөрөөр хэлбэл 46 жилийн турш сонин сэтгүүл болон түүвэр зохиол зэрэгт нь орж хэвлэгдэж байгаагүй ажээ. 1958 онд Е.А.Есенина, А.А.Есенина нар эмхтгэн бэлдэж, “Московский рабочий” хэвлэлийн газраас хэвлэсэн С.А.Есениний нэгэн боть зохиолд энэхүү шүлэг анх хэвлэгдсэн бөгөөд энэ түүвэрт орсон зохиолын тайлбарыг хийсэн Е.А.Есенина,

Ю.Л.Прокушев нар энэ тухай (анх хэвлэж буйгаа) дурдаж, мөн 1961-1962 болон 1966-1967 онд “Художественная литература” хэвлэлийн газраас Есениний зохиолыг 5 ботиор хэвлэхдээ мөн энэ тухай дурдсан байна. Дээр дурдсан хоёр дэвтэрт байгаа 10-аад шүлгийн талаар Есенинийг 1909-1912 онд Спас-Клепиковын сургуульд сурч байхад нь багшилж байсан Е.М.Хитров гэгч хүн “...Есенин бичсэн шүлгүүдээ над авчирч өгдөг байсан... Сургууль төгсөхийн нь өмнө би түүнийг шүлгүүдээ эмхтгэж өг гэхэд шүлгээ дэвтэрт бичиж авчирч өгсөн...” гэж 1924 онд “Спас Клепиковын гэгээрлийн ажилтан” нэртэй гар бичмэл сэтгүүлд дуртгал бичин, уг шүлгүүдийг тэрхүү сэтгүүлд гаргажээ. Үүнээс үүдээд Д.Нацагдорж, тэрхүү гар бичмэл сэтгүүлд хэвлэгдсэн шүлгийг олж үзсэн юм биш үү? гэх асуулт гарч болох авч, Рязань мужийн Константиново сууринаас 30-аад километр зайтай байдаг тэрхүү жижигхэн хотод, цөөхөн хувиар гаргасан гар бичмэл сэтгүүлийг гарсан дор нь (1924 онд) Д.Нацагдорж монголд байхдаа харахан олж үзэж амжаагүй байх гэж бодогдоно. Нөгөөтэйгүүр жил гаруйн дараа буюу 1925 оны намар Ленинградод очин нэг жил хиртэй (1926 оноос германд явсан) болохдоо ч гэсэн нэгэн жижигхэн хотын дунд сургуулийн гар бичмэл сэтгүүлийг эрж олоод үзсэн гэх баримт алга. Д.Нацагдорж хэдийгээр энэ шүлгийг олж үзэх ямар ч боломж үгүй ч, маш ховор тохиолоор үзсэн гэвэл, түүнтэй адилдуу шүлгийг 7 жилийн дараа биш, тэр дороо бичих байсан байх аа! Ийнхүү үгээр урлахдаа гайхамшигтай хоёр зохиолч маань “Од” хэмээх шүлгүүдээ тус тусдаа бичжээ гэж бодном. Ингэж тус тусдаа бичсэн атлаа төстэй болсноороо бидний сонирхлыг улам ч татаж, яруу найраг гэгч яруу сайхан зүйлийг ойлгох, түүнийг хэрхэн бүтээдгийн нууцыг олж мэдэх их хүслийг улам оргилуулж байна. Яруу найрагчид хүсэл тэмүүлэл, алс ирээдүйгээ зөгнөх зөгнөл энэ бүхнээ сэтгэн боловсруулж, уран үгээр дүрслэн гаргах нь нарийн төвөгтэй процесс бөгөөд найрагч бүрийн “тархин дахь лаборатори” өөр өөрийн давтагдашгүй өвөрмөц онцлогтой байдаг авч, нэгэн зохиолд яруу сайхныг танин мэдрэх, түүнийг тусган авах, харьцуулан дүгнэх үнэлэлт тохирох нь бас байдаг ажээ. Энэ тохиол гэхдээ од шиг хүмүүсийн оюун ухааны нэгэн ёсны шалгуур болж, сар мичдийн тохиол шиг ховорхон тохион өнгөрдөг бололтой. Энэхүү тохиолын нэгэн нь тэртээ 40-өөд жилийн өмнө Константиново суурины цэх цагаан хустай орос нутгийн тэнгэр, Гүн галуутай нуурын толион мандалд туссан монголын цэлмэг хөх тэнгэрт нэгэн зэрэг тохион өнгөрчээ. Энэ хоёр шүлгийг нарийвчлан ажиглавал нэг нь өөрийн ганц биенээс түг түмэн ододод хандсан байгаль ертөнцийн тухай уянгын шүлэг гэж болмоор байхад, нөгөө нь нийт хүн төрөлхтний өмнөөс ганц Марс гаригт хандан бичсэн иргэний уянгын юм уу, улс төрийн шүлгийн шинжтэй байгаа нь энэ хоёр шүлгийг эсрэгцүүлж байгаа биш, харин харилцан бие биенээ нөхөж, нэгэн бодгаль шинжтэй болгож байна.” хэмээн уран зохиолын харилцан нөлөөллийн талаас нь ийн авч үзжээ.

Нөгөө талаас утга зохиолын онол судлалд, 1. Цаг хугацаа, орон зайн хүчин зүйлээс хамаарч 2. Уншигч, түгээгчийн сэтгэл зүйн үнэлэмжтэй холбоотойгоор 3. Тухайн бүтээлийн ерөнхий өнгө аяс, дэвшүүлсэн асуудалтай уялдаж уран зохиолын төрөл зүйлүүдийн хооронд харилцаа холбоо, харилцан нөлөөллийн орчин буй болдог гэж үздэг байна. Тэгвэл дууны уран бүтээл нь

утга зохиолын харилцаа холбоо, харилцан нөлөөллийн үзэгдлийн хамгийн тод жишээний нэг болдог билээ. Үүнийг: 1921 оны хувьсгалын дуунаас, 1930-аад оны үеийн анхны нийтийн дуунаас харж болно.

Монголын шинэ цагийн хувьсгалын анхны дуунуудын нэг болсон “Улаан туг” дууг 1922 онд С.Буяннэмэх зохиосон байдаг. Дууг үзвэл:

“Улаан тугийг мандууля

Улсын сүрийг бадрууля

Урьдын муусайн харгисуудыг

Уухай хийгээд дарья

Сүртэй тугаа хийсгэе

Сүрлэг жагсаалаар явцгаая.

Сүүлийн үеийн хөрөнгөтнийг

Сөнөөн устгаад дарцгаая

Ура ура ура аа

Улсын сүр бадрагтун

Ардын улаан цэргүүд ээ

Ангийн хувьсгалыг хамгаалж

Аливаа дэлхийн харгисуудтай

Алалдах байлдааныг бэлтгэе

Байгуулсан ардын засагтаа

Бат тангаргийг өргөж

Баруун дайсан этгээдийг

Байлдан тулан эсэргүүцье

Ура ура ура аа

Улсын бүр бадрагтун

Сүхбаатар жанжны

Сүүлийн зоригийг хурцатгаж

Сөргүү дайсны өмнөөс

Цөхрөлгүй тулцгаая

Элдэв зүйгүй суртлыг

Эвдэн цэвэрлэж зайлуулж

Эв хамт нийгэм журмыг

Эртхэнээс байгууля

Ура ура ура аа

Улсын бүр бадрагтун”

гэсэн энэ дууг хуучин “Улаан туг”-ийн аялгуугаар дуулдаг байжээ. Тэгвэл хуучин “Улаан туг” дууныг үгийг үзвэл:

“Жанжин тугийг мандуулаад

Зэвхий гаминг дарцгаая.

Жан Шамбалын оронд

Заавал ч үгүй төрцгөөе.

Шар тугийг мандуулаад

Шажны сүрийг бадруулаад

Шавь нар болсон бид нар

Шамбалын дайнд мордоцгооё.

Ногоон тугийг мандуулаад

Ноёдын сүрийг бадруулаад
Ножид болсон гаминг
Номхон бороор дарууля”

гэсэн ийм үгтэй аж. “Улаан туг” дууг шинэ цагийн Монголын урлагийн олон ахмад зүтгэлтний хууч яриа хийгээд Магсар хурцын Дугаржав зохиосон байх магадлалтай аж. Гэтэл эл дууны аялгуу нь хятадын сонгодог бүтээлийн аялгуу болсныг бид анхааран үзэх ёстой болж байна.¹ Учир нь Франц улсад болсон тогтлолын үеэр:

-Надад гайхамшигтай санагдсан юм аль вэ? гэвэл морийг дуурайн сонсогдсон. Энэ чинь Монголын соёлын уламжлалаас зээлсэн тийм үү? Гэхэд (өөр нэг хүн) -Аан би шал өөр зүйл сонссон. Энэ чинь "рок" шинжтэй гэж надад санагдсан байна -Үгүй шүү дээ ахин сонсох уу?

гэсэн харилцан яриаг ч үл орхиж болно. Тэгэхээр энэ бол утга соёлын харицлан нөлөөллийн суудлын үүднээс авч үзэх ёстой бөгөөд тэр тусмаа дорно дахины улс үндэстнүүдийн утга соёлын харилцаа холбооны асуудлаар тайлбарлах ёстой бөгөөд ялангуяа манай хөгжим судлаачид эл асуудлын аялгууны талаарх учгийг тайлбарлах ёстой гэж үзэж байна.

Дараачийн нэгэн бүтээл бол Монгол түмний дунд алдаршсан “Хүмүүн төрөлхтөн” дууны аялгуу болно. Эл дууны шүлгийг Цэрэнлхам хэмээх монгол эмэгтэй 1932 онд зохиосон юм. Шүлгийг үзвэл:

“Хүмүүн төрөлхтний дотроосоо
Хүнд ихээр дарлагдсан
Хөөрхий бидний бүсгүйчүүд
Хүмүүжлийн замыг дагацгаая'
Эрдэм соёлоос хоцорсон
Эмэгтэй олон бид нар
Эрхт засгийн удирдлагыг
Эрх биш дагацгаая, нөхөд өө
Багш Лениний сургаалыг
Бахдан дагаж явцгаая

Одоо бидний бүсгүйчүүд
Урьдын бүдүүлэг байдлыг
Одоо даруй устгахыг
Олон бүгдээрээ хичээцгээе'
Эмэгтэй олон бид нар
Эрдэм соёлдоо боловсорч
Эв хамтын байдалд
Эрхбиш дэвшицгээе”

гэж байх бөгөөд өдгөө манай нийтгийн дуу бүжгийн манлай нэгэн бүтээл болсон билээ. Гэтэл энэ дууны аялгуу нь 鉄道唱歌 /Tesudou shouka/ буюу “Галт тэрэгний дуу” хэмээх галт тэргээр явж байгаа замын тэмдэглэл, зураглалын өнгө аястай, газрын нэр хийгээд тус, тус газар нутгийн онцлогийг товч танилцуулсан, танин мэдэхүйн зориулалттай олон нийтийн дууны аялгуу

¹ https://www.youtube.com/watch?v=6L_rqULCTaU&t=174s 2 мин 40 сек-50 сек хүртэлх аялгуу

ажээ. Галт тэргэний шугам дагуу зохиогдсон нэлээн урт дуу байна². Энэ дууны Монголд нөлөөлсөн учир шалтгааныг тодруулахад 1905-аад оны үеийн Японы нийгэм улс төр олон нийтийн харилцааны байдлыг тодруулах шаардлагатай бөгөөд Япон улсаас ч Монгол судлалыг анхаарах болсон цаг үетэй холбогдох юм. Тиймээс урлагийн бүтээл уран зохиолын харилцаа нөлөөллийн асуудал нь тухайн цаг үеийн улс хоорондын харилцаа холбооны олон баримтаар тодорхойлогдож мөн чанар нь илрэх чухал асуудал болно. Энэ бүхнээс үүдэн өгүүлэхэд, эдгээр асуудал нь:

1. Утга зохиолын харилцаа холбоо харилцан нөлөөллийн хамгийн тод жишээ болж байна.
2. Монгол –Япон, Япон –Монгол, Монгол-Хятад, Хятад- Монголын урлаг, утга соёл харилцаа холбооны гүн зузаан түүхэн замналтайг илэрхийлж байна.
3. Өнөө цагийн, орчин үеийн нийгэм, хууль эрх зүйн ойлголтоос өөрөөр, харилцаа холбооны түвшинд нь харьцуулан судлах онол арга зүйгээр судлах ёстой баримт юм. Өөрөөр хэлбэл ийм мэт асуудал нь өнөөгийн оюуны эрх зүйн хүрээнд үйлчилдэг plagiarism буюу хуулбарлах тухай асуудлаас огт өөр онолын асуудлаар тайлбарлагдах ёстой ойлголт мөн.

***The influence Japanese and Chinese Culture in First Songs
of The Mongolian New Time [1920, 1930]***

In literary theory

1. Depending on time and space factors
2. In connection with the psychological value of the reader and distributor
3. In harmony with the general tone and atmosphere of the work and the issues raised

The environment of relationships and interactions occurs between the genres of literature SONG - is the most obvious example.

1. Song is the clearest example of the mutual influence of literary communication
2. Mongolia-Japan, Japan-Mongolia, Mongolia-China, China-Mongolian art and cultural relations have a deep historical path.
3. Different from today's modern social and legal concepts, it should be studied using the theoretical and methodological methods of comparative research at the level of communication. [not plagiarism]

² <https://www.youtube.com/watch?v=wD3LGxJswe0&t=234s>

БҮХ НИЙТИЙН БОЛОВСРОЛЫН СИСТЕМИЙН ТӨРӨЛЖҮҮЛЭХ
БОЛОМЖ: МОНГОЛ УЛСЫН АВЬЯАСЛАГ СУРАГЧДАД
ЗОРИУЛСАН ГҮНЗГИЙРҮҮЛСЭН СУРГАЛТ БА УЛСЫН
ТӨРӨЛЖСӨН ОЛИМПИАДЫН ТОГТОЛЦООНЫ ЖИШЭЭН ДЭЭР

Г.Суурь

(Шинэ Монгол академийн

Ажил мэргэжлийн хөгжлийн төвийн захирал)

本研究の目的は、公教育における公正と卓越性の課題の検討を通して、モンゴルの公教育のなかに才能教育をいかに制度化できるかという課題を考察することである。この課題を実証的に明らかにしながら、モンゴルの公教育および才能教育、選抜システムの特徴を分析する。

21世紀以降の公教育、特に学校教育に対する社会的な期待に着目すれば、経済成長や国際競争力を念頭においた社会的要請がある一方で、個人的な要請は多様化しつつあり、それらへの対応は公教育・私教育の両方において重要な課題となっている。そもそも公教育と私教育の線引きが曖昧になり、学校教育の守備範囲の拡大の必要性によって、公教育という概念自体が拡大されつつあることは多くの研究によって指摘されることである（永田2005、中島 2020）。既存の公教育制度の限界が浮きぼりになり、多様な児童・生徒のニーズへの対応の必要性が増している現象は、世界各国で共通してみられる。また、サラマンカ声明が出された1994年以降、「インクルーシブ教育」や「特別ニーズ教育」という新たな教育理念が広がり、才能教育は公教育で対応しきれなくなっている子どもたちへの対応のみならず、エリート教育に代表される国家・社会的な要請が期待されるようになり、「才能教育の拡大・多様化」という大きな変化が生じている（関内 2020、p.66）。公教育概念の拡大に対して、才能教育の拡大・多様化はさまざまな可能性をもたらすものであり、これは「才能教育の通常教育への近接・融合化」としてアメリカの才能教育を中心に分析されている（関内2020、p.193）。

また、才能教育を国家の経済発展、グローバル人材育成のために活用しようとする動きが近年多くのアジア諸国を中心にみられる。国際バカロレア(International Baccalaureate)やケンブリッジ・プログラムをはじめとする国際標準カリキュラムは、「グローバル時代の教育モデル」(Resnik 2012)として各国の教育政策とカリキュラム改革などを通して公教育制度のあり方に影響を及ぼしており、各国の教育システムの多様化・国際化を

促す一要因になっている。特に、多くのアジア諸国においては、「欧米で基準が作成され、アジアがその基準を高額で購入するという構造」(中島 2019)が指摘されている。これは「グローバル・スタンダード」の名目のもと、アジア諸国に対して西欧諸国の教育基準に沿った教育改革を迫るものであると言える。モンゴルは、早くからグローバル化の影響を受けてきた背景があり、オリンピックや深化学級などの才能教育を通して教育の卓越性を追求してきた国であるが、特に国際学力比較調査PISAが実施されるようになって以来、公立学校へ国際標準カリキュラムを導入するとどまらず、国際標準カリキュラムに準拠した教育改革を行ってきた。国際標準カリキュラムを実施するケンブリッジ学校を才能教育として位置づけ、他のアジア諸国同様に欧米の基準を、プログラムの購入を通じて設定することで効率的に公教育の教育水準を向上させようとしている。

以上の問題背景から、公教育の制度設計をもとにした質保障に関連して、才能教育への期待が大きくなっていることがわかるのであり、その際に教育の公正(equity)と卓越性(excellence)のバランスを検討しながら、公教育の課題を考えていくことが求められる。こうした問題背景に基づいて、本研究はモンゴルを事例に、公教育の中にいかに多様な個と能力を認め、その個人的要請および社会的要請に応えることができるのかという課題を考察する。以下、本論文の構成を述べる。

第1章では、先行研究の検討とそこから浮かび上がる研究課題と調査方法を提示する。まず第1節では、本稿の議論を進める上で重要な才能教育とエリート教育の概念を明確にし、第2節で、「公教育概念の拡大とガバナンスの自律化」の議論を中心とした公教育制度の変容の動向を捉える。第3節で、教育における公正と卓越性に関するこれまでの議論について整理し、公教育が大きく変容しつつある状況、公教育制度における公正と卓越性を検討することに重要な意義があることを指摘する。第4節では、「才能教育の拡大・多様化」という新たな議論とが公教育概念の拡大に対して相互に作用していることを図で提示し、諸外国の動向と課題をまとめる。第5節では、才能教育の社会的側面への着目の必要性を提示し、メリトクラシー論を整理し、歴史的な試験の役割の変容から、その役割の変化が「能力」そのものの捉え方の変化と大きく関連している点を指摘する。次にナショナル・メリトクラシーを超えたグローバル・メリトクラシーといわれる、新たなグローバルな能力主義(メリトクラシー)が出来上がりつつある背景についてまとめる。第6節ではモンゴルの先行研究を整理し、第7節で本研究全体の課題を導き出し、問いと方法を述べる。

第2章では、モンゴルの教育において公教育と私教育がいかなる現状にあるかを考察するために、モンゴルの近代学校教育制度の成立からの歴史的経緯とナショナル・カリキュラム改革の変遷、学校教育における試験・選抜システムの特徴をまとめる。最後に、海外留学トラックを形成し、

元私塾であったが公教育へ参入した私立学校など、公教育の変容をもたらしているいくつかの事例を通して、モンゴルにおける公教育の拡大・多様化の現状と近年の動向をまとめる。

第3章では、モンゴルの才能教育制度の全体的な構造に着目し、公教育におけるその機能と構造を明らかにする。まず、才能教育の範囲と法的基盤を整理し、その制度的展開を追い、オリンピックのしくみをもとに才能教育としての機能を分析する。次に、オリンピック実施を普通教育学校の中で可能にしている教員人材の育成を担う教員オリンピックの構造を整理する。そうした上で、普通教育学校の中に選抜・育成を担う才能教育機関の中心的なエージェントとなる深化学級の実態を分析する。最後に、オリンピックと深化学級がいかに役割分担して、密接に関わりながら才能教育を担っているか、その構造とメカニズムを、公正と卓越性の視点から検討する。

第4章では、モンゴルの公教育の目標や内容の変化やカリキュラム改革、さらにはグローバル化への対応などのより大きな全体像を把握するために、具体的に教育目標や内容の変化、カリキュラムの国際標準化の影響などに着目した。まず、モンゴルの教育のグローバル化を端的にあらわす2010年から開始された国際標準カリキュラムを準拠にしたナショナル・カリキュラム改革を対象として、それがナショナルな教育内容としていかなる方向性へ導き、影響を及ぼしているのかを分析した上で、才能教育の範囲内で、国際プログラム校として設置された才能学校「バイリンガル学校」がいかなる実態にあるのかを分析した。こうした国際プログラム校が公的予算で設置・運営されている特異な状況を通して、モンゴルの学校教育に生じている公正と卓越性の課題を、教育のグローバル化の影響という視点を含めて分析した。

以上の検討を踏まえ、第5章の総合考察では、調査を通じて見えてくるモンゴルの教育システム及び選抜システムの特徴を考察し、それまでの議論を踏まえて、公教育において才能教育の果たしうる機能とその可能性、グローバル化の影響と公教育概念の拡大、さらにはモンゴルが抱える公正と卓越性の課題および公教育の中に才能教育を制度化する意義について考察した。本研究の知見は以下のようにまとめることができる。

まず、深化学級とオリンピックなど、モンゴルの主要な才能教育機関は、すべての学校の約75パーセントが小中高一貫の普通教育学校であるという特徴を持った一般学校教育制度を補完し、高度な能力を持つ児童・生徒を選抜する機能を担い、さらに才能児の発掘・伸長を担うようになったことが明らかになった。これはモンゴルの才能教育の最大の特徴である。

以上に述べた才能教育機関の構造と機能から、モンゴルの公教育全体の公正と卓越性の課題が浮き彫りになった。モンゴルの公教育は、卓越性を継続的に追求し、公正の出口の側面である多様な教育達成の保障を促

進してきた一方で、教育機会をそろえるという公正の入り口の側面について、不十分な状況にあることが示された。公正と卓越性のバランスを担保するために、公正が卓越性の土台となる教育政策を実現することは理想ではあるが、バイリンガル学校などを通じたモンゴルの現状からは、公正が追求されることは非常に難しいという実態が見えてくる。モンゴルのような世界への遅れを取り戻し、早く追いつこうとする状況下にある発展途上諸国では、学校教育政策を通して社会的格差の是正を目指すどころか、反対に格差をさらに広げてしまう帰結をもたらす構図があることが浮き彫りになった。さらに、モンゴル特有の文脈や状況と先行研究で見てきたグローバル化、グローバル・メリトクラシーの到来とが相互に影響し合い、若者がモンゴルの国境にとらわれず国外へ留学している。そうした実態は、国内の公教育、学校教育の目的や人々の価値に大きな影響を及ぼし、公教育概念の拡大に拍車をかけていると言える。

終章において、本研究の見解を最終的に総括した。特に、才能教育は、公教育から切り離されてしまうおそれのある卓越した児童・生徒を包摂する公正の側面と学力向上を促進する卓越性の両方の側面を併せ持った制度であるため、公教育における公正と卓越性のバランスを検討する上で鍵となる制度であると言える。すなわち、公教育における卓越性と公正の比重のおき方、才能教育のあり方によって、教育の質保障の課題を調整していくことができると考えられる。次に、本論文の理論的・方法論的・実証的な貢献について簡単に述べれば、本研究が才能教育研究の議論のみならず、教育社会学のメリトクラシーの理論を踏まえ、学校教育の中に制度化された才能教育の社会的側面、すなわち、その公教育における選抜機能などの構造と機能に着目した点は、既存の研究への理論的貢献であると考えられる。さらに、才能教育に基づいて卓越性を重視している学校教育制度を事例として、モンゴルの公教育の中に才能教育が果たしうる機能を明らかにした点は本研究の、既存の才能教育、教育社会学のメリトクラシー論への実証的な貢献であると考えられる。

次に、本研究から得られる示唆は以下のとおりである。モンゴルにおいては今後、既存の才能教育機関を能力伸長と教育水準向上を促すモンゴル特有の制度として捉え、才能教育制度をさらに発展させていくことが求められる。さらに、今後の教育政策において、教育の公正に重点をおいた資源配分を考えていくことが最重要課題であることを示唆している。これまで以上に教育の公正（教育機会をそろえるという入り口の側面）を重点的に追求し、資源配分を公正に行なっていくことが、長期的な視点でモンゴルの教育の卓越性の実現を促す基礎となるという点は、本研究のから言える政策的提言である。

最後に、本研究は公教育の公正と卓越性の課題および選抜システムの特徴を浮き彫りにすることができたが、公立学校以外での選抜、雇用に

おける選抜などについては取り扱っていない。特に、公教育概念の拡大・多様化を促している私立学校の実態に着目し、さらなる調査・解明を行うことで、モンゴルの社会で成り立っている特異な制度、選抜構造を全体的に把握し、分析できる。さらに、実際に才能教育を通して社会移動を遂げている児童・生徒（卒業生）のケースを質的に調査し、個々の状況を分析し意味づけしていくことも今後は求められる。

引用文献

永田佳之、2005『オルタナティブ教育 —国際比較に見る21世紀の学校づくり—』新評論。

中島千恵、2019「公教育制度の第3ステージへの模索 —自律的公設学校の国際比較—」『比較教育学研究』第58号、141-144頁。

中島千恵、2020「特集の趣旨」『比較教育学研究』第61号、2-8頁。

関内偉一郎、2020『アメリカ合衆国における才能教育の現代的変容』三恵社。

Resnik, J., 2012, “The Decentralization of Education and the Expansion of the International Baccalaureate,” *Comparatiye Education Review*, Yol.56(2), pp. 248-269.

Learning and Labor
—桜美林大学サービスラーニングについて—

KINOSHITA, Masayuki
(J. F. Oberlin University College of
Arts and Sciences)

1. 桜美林大学サービスラーニングとは

桜美林学園の創立者・清水安三は、学園のモットーとして『学而事人 (Gakujijijin)』を掲げた。英語では『Learning and Labor』、“学びて人に事（つか）える”という意味である。学問は「自分のため」だけではなく、「助けを求める誰かのため」のものであるというこの言葉は、私たちオピリンナー（桜美林学園学徒）一人一人の胸に刻まれている。

桜美林大学におけるサービスラーニングとは、この『学而事人』を実践に移すための授業である。そのフィールドは、大学近隣地域をはじめ、福島などの被災地、戦争の爪痕の残る沖縄、そして海外にまで及ぶ。私たちオピリンナーは、大学とフィールドを行き来することで、体験を伴った学習をする。そして、授業で学んだ知識を活かし、社会貢献活動を行うのである。サービスラーニングとは、大学とさまざまな地域を繋げる、インタラクティブプログラムであると言って良いだろう。

2. モンゴル環境研修について

桜美林大学で実施される多くのサービスラーニングのうちの一つが、今回報告する「海外サービスラーニング・モンゴル環境研修」である。このプログラムは、桜美林大学・都馬バイカル教授が指導・引率し、本学の提携校であるモンゴル文化教育大学（ウランバートル市）の協力のもとで行われる。内容は、モンゴルの歴史、文化を学ぶこと。そして、現地での調査、視察、遊牧民生活体験、現地の学生との交流などを通じ、モンゴルの環境問題及び異文化に対する理解を深めることである。到達目標として、モンゴルに対する日本の支援及び国際貢献を考えること、現地の大学生たちと協働して、継続可能な社会の構造を目指す意識を共有すること、そして、モンゴル文化を理解することにより、日本のことを再認識し、更なる国際平和を考えられるようになることが掲げられている。

3. 昨年のモンゴル環境研修

ここからは、私の体験を踏まえて、このサービスラーニングについて報告していく。

私は昨年夏、この「海外サービスラーニング・モンゴル環境研修」に参加した。その理由は、「自分の語学力を試したかった」「自分のコミュニ

ケーション力を活かしたかった」「現地の仲間との協働作業を通して、自分を成長させたかった」以上3点である。日程は、2023年8月7日から14日までの8日間。メンバーは、桜美林大学学生10名の他、立教大学の学生17名、常磐大学の学生3名、各大学教員3名の合計33名であった。

初日から6日目の朝まで、私たちはウランバートル郊外にあるシリンボラグというキャンプ地で、移動式住宅「ゲル」に泊まる生活をした。ここで私たち学生が困ったのは、WiFiがほとんど通じなかったことである。日ごろからインターネットに接している私たちにとって、最初は戸惑いを感じた。しかし、徐々にそのような生活にも慣れ、私たちはそれぞれの研究を進めながら、モンゴルの自然を満喫し、乗馬を楽しみ、現地の人たちと交流していた。気がつけば、私たちはネットを忘れ、モンゴルの緩やかな時の流れで生活するようになっていたのである。

4. 現地での学び

私たちはそれぞれのテーマでモンゴルを研究しながら、サービスマーケティングに努めた。

私の研究テーマは「モンゴルの経済発展と環境破壊」。私が驚いたのは、3日目に訪れたウランバートル郊外の光景だった。そこには、すでに掘り起こされた後の寥廓たる黄土が、地平線の彼方まで広がっていたのである。かつてそこには、緑の草原があり、馬やラクダなどの動物が生きていた。しかし、目の前に映るのは、むき出しとなった黄色い大地であり、動いているものは油圧ショベル、ホイールローダーなどの掘削機であった。もちろん、これはモンゴルに数多くある風景の、ほんの1か所に過ぎない。掘り起こされた黄土は、鉱物粒子とともに空に舞い上がり、偏西風に乗って、中国に、韓国に、そして3日後には日本に降り注ぐ。そう、黄砂のことである。黄砂は、目や気管支への疾患を引き起こす。「モンゴルの経済発展は、環境だけでなく、人間の健康をも引き換えにしている」私がそう考えることができたのも、この研修に参加し、実際に現地を見ることができたからこそである。この問題について、私はモンゴル文化教育大学の学生たちと語り合った。現地の人たちとの交流、これもサービスマーケティングならではの特色である。彼らモンゴルの若者たちも、「都会で経済的に豊かな暮らしをしたい」と思う反面、「環境問題も改善させたい」という思いを持っていた。

5. 首都ウランバートルにて

シリンボラグのゲルを拠点に草原での学びを進めていた私たちだったが、日程の後半で首都ウランバートルを訪れる機会を与えられた。ウランバートルはシリンボラグとは正反対で、近代的なビルが林立しており、道路は大渋滞、その車の多くが決して安い価格ではないトヨタのプリウスであった。この光景に、私は1990年から続くモンゴルの経済発展の力強さを感じずにはいられなかった。ウランバートル市内のJICAモンゴル事務局を訪れた時のことである。私は職員の一に、市内に来る途中で見かけた、

いくつもの建設中のマンションについて尋ねた。すると、それらのマンションは、ほとんどが投資用であるということを教えられた。しかも、資金を調達してから建設するのではなく、資金を集めながら建設するのだそうだ。そのような成り行きまかせの計画でも、今後のモンゴルの経済成長を考えれば十分成り立つのだという。私はこの実情に過去の日本を重ねずにはいられなかった。経済発展による国民所得の上昇の結果、投資対象が実物として存在しないものにまで及ぶ。これは1980年代の日本同様、バブルではないのか。モンゴルの経済成長が止まった時、これら投資用のマンションは、資金不足により建設がストップする。モンゴルのバブルが弾けた時、残るものは、緑の草原と引き換えに得た灰色のコンクリートの残骸だけである。この件についても、モンゴルの学生たちと話し合った。そこで出た意見をまとめると、「草原は貴重な観光資産であり、未来永劫、モンゴルに利益をもたらす。自然を活用した経済政策、これがモンゴルの進むべき道である」であった。

6. おわりに

以上のように、私はこのサービ斯拉ーニングで、自分の追究するテーマについて深く学習し、現地の人とコミュニケーションを取りながらその学びを共有することができた。私以外のメンバーも、食文化、宗教、国際支援、都市問題、屠畜文化、ジェンダー問題、内モンゴルとの比較、歴史、大気汚染など、それぞれのテーマに沿って研究を深めた。誰もがサービ斯拉ーニングという学びのスタイルのもと、日本で学んだことをモンゴルで活かすために、人々と交流し、協働してきたのだ。私たちの学びと活動はモンゴルの人々に受け継がれ、モンゴルの人々から新たな人々に受け継がれていくことだろう。

『Learning and Labor』

この言葉は、人と人をつなぎ、「学びは永遠である」ということを、私たちに示している。

参考文献:

桜美林大学『サービ斯拉ーニング』

<https://www.obirin.ac.jp/about/basic/>(2024.6.13.閲覧)

都馬バイカル『海外サービ斯拉ーニング(モンゴル環境)』都馬バイカル(2023)

木下雅之『モンゴルの経済発展と環境破壊』(2023)

МОНГОЛ, ЯПОН ХЭЛНИЙ “ХҮҮ” БОЛОН “КО” ХЭМЭЭХ
ҮГИЙН УТГЫГ ХАРЬЦУУЛАХ НЬ

Б.Туул

(Соёл Эрдэм ДС, Япон судлалын тэнхим,
Магистр)

Хорьдугаар зууны дунд үе хүртэл хэлний утга судлал нь хэлний үгийн сан судлал, гүн ухаан, учир шалтгааны ухаан, уран илтгэхийн ухаан, толь бичгийн хүрээнд авч үзэж байсан бөгөөд энэ үеэс хэл шинжлэлийн нэгэн салбар болон хөгжих үндэс суурь тавигджээ. Германы латин судлаач Карл Рейзиг 1839 онд “Утга судлал” хэмээх нэр томъёог хэрэглэж, улмаар Францын хэл шинжлэлч М.Бреал хэлний гүн бүтцийн судалгааг хийсэн нь энэ чиглэлийн олон арван бүтээлүүдийн анхдагч болсон хэмээн үздэг. Ерөнхий хэл шинжлэлд олон хэлний утга судлалын асуудлыг шинжлэх онол эш, арга зүй, түгээмэл зүй тогтол, судлагдахуун, нийтлэг үндэслэлийг боловсруулж, тусгай хэл шинжлэлд тэрхүү онол арга зүйг баримтлан, хэлний утга судлал хөгжиж байна. Академич Ш.Лувсанвандан монгол хэлний утга судлалын талаар өөрийн бүтээлдээ онол ба дадлагын талаас нь авч үзсэн байдаг. Тэрээр хэлний гадна тал буюу хэлбэрийг судлахын хамт мөн дотоод тал болох агуулгыг нь судалсан бөгөөд авиалбарын утга ялгаруулах шинжийг “Авиа фонем нь үг, морфемын утгыг ялгах дохионы тэмдгийн үүргийг гүйцэтгэхдээ гол төлөв ганц ганцаараа биш бусад фонемтэй хэд хэдээрээ хавсарч үг морфемын утгыг ялгах нэгэн нийлмэл дохионы тэмдгийн үүрэг гүйцэтгэнэ”³ хэмээн үзжээ.

Монгол хэлний үгийн сан-утга зүйн айг бүтэц, утга, үүргийн хэв шинжээр нь ганц утгат үг, хос утгат үг, олон утгат үг, ойролцоо утгат үг, ижил үг, эсрэг утгат үг, төсөө утгат үг, төрөл утгат үг, харьяа утгат үг, өөрчлөл хэмээн ангилсан⁴ байдаг бөгөөд энэхүү ангиллын дагуу монгол хэлний “Хүү” хэмээх үг нь олон утгат үг болох бөгөөд үглэвэр “хүү”-гийн утгалбар нь орчин цагийн монгол хэлэнд хэрхэн илэрч буйг япон хэлний “ко” хэмээх үгтэй утгын үүднээс харьцуулан, хэрэглээний тухайд ерөнхий ажиглалт хийв. Юуны өмнө монгол хэлний “Хүү” хэмээх үгийн түүхэн гарал үүслийг харахад түрүү үеийн түүхэн сурвалж бичгүүдэд “Хүү” гэдэг үг байхгүй бөгөөд үүний оронд бүстэй эрэгтэй хүүхдийг “Хөвгүүн” {Khubegun} Но хун гэх буюу “Хөвүүн” гэдэг үгийг хэрэглэж байжээ. Тухайлбал Монголын нууц товчоонд өгүүлсэнээр төлөөлүүлэн авч үзье.

**Чингис хааны язгуур, дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ-чино, гэргий Гуа-Маралын хамт тэнгис далайг гэтэлж ирээд Онон мөрний*

³ Лувсанвандан Ш. “Орчин цагийн монгол хэлний бүтэц” УБ 1967, х 99

⁴ Бадамдорж Д. “Монгол хэлний үгийн сангийн утга зүй” УБ 2015, х 149

эх Бурхан халдун ууланд нутаглаж Батцагаан гэдэг нэгэн **хөвүүнийг** төрүүлжээ.⁵

Батцагааны **хөвүүн Тамача, Тамачийн **хөвүүн** Хоричар мэргэн, Хоричар мэргэний **хөвүүн** Уужим буурал, Уужим бууралын **хөвүүн** Саль-хачау, Саль-хачаугийн **хөвүүн** Ихнүдэн, Ихнүдэний **хөвүүн** Шинсочи, Шинсочийн **хөвүүн** Харчу...⁶*

Алун-гуа, Добу мэргэнд ирээд Бүгүнүтэй, Бэлгүнүтэй гэдэг нэртэй хоёр **хөвүүнийг төрүүлэв.⁷*

Урьд Добу мэргэнийг амьд бүхий цагт төрсөн Бэлгүнүтэй, Бүгүнүтэй хоёр **хөвүүн, эх Алун-гуагаас эчнээ хэлэлцсэн нь: "Бидний эх, ойр төрлийн эрэгтэй хүнгүй ба эргүй бөгөөтөл энэ гурван **хөвүүнийг** төрүүлэв. Гэр дотор ганц Малиг баяуд овгийн зарц хүн байна. Энэ гурван **хөвүүн**, түүний хүүхэд биз" гэж эхээс далд хэлэлцэхийг нь Алун-гуа мэдээд,⁸*

Бас Алун-гуа, таван **хөвүүнээ сургаж өгүүлрүүн: "Та таван **хөвүүн**, миний нэгэн хэвлээс төрсөн биш үү. Та нар ганц ганцаар салбал нэжээд сум мэт хүнд хялбархан дийлэгдэнэ. Та нар эв эеэ нэгтгэвэл тэр багласан таван сум мэт бэх болж, хэнд ч хялбар дийлэгдэхгүй болно" гэв. Тэгжэ байтал Алун-гуа эх нь үгүй болов.⁹*

Энэ мэтчилэн “Хөвгүүн”гэдэг үгийг зонхилон хэрэглэдэг байжээ. Харин тухайн үед “Хүүхэн”буюу “Kheuhēn”гэсэн үг нь бүстэй эрэгтэй хүүхэд, тэр дундаа бага балчир хүүхдийг заадаг байсан нь түүхэн эх сурвалжаас тодорхой болж байна. Харин “Хүүхэд” буюу “Kheuhed” гэсэн үг нь “Хүүхэн” гэсэн үгэн дээр олон тоо үүсгэдэг “Д” залгагдсанаар, үгийн эцсийн “Тогтворгүй Н” үсэг гээгдэж улмаар “Хүүхэд” гэдэг үг үүссэн байна.Тогтворгүй “Н” гэдэг нь монгол бичгийн “Нар, Наран”, “Сар, Саран” “Сүү, Сүүн” зэрэг үгэнд байдаг бөгөөд араас нь дагавар буюу залгавар залгагдахад гээгддэг. Ингэснээр утгад өөрчлөлт үл ордог байна.

Дундад үеийн монгол хэлний “Хүүхэн”, “Хүүхэд” зэрэг үгийн утгын хэрэглээг дараах жишээнээс харж болно.

**Бүтэхийн урьд учирч*

Бүхий улсыг хураалцаж

Бүрэн их төрийг хашилцаж

Бүгдээс үлэмж хүчээ өгч

*Эцэг эх, эм **хүүхнээ** орхиж*

Эзэнд хүчээ өгсү гэж явсан чинь

Эдүгээ Нармай их улсад хайр болсон чинь

Гагц намайг эс дурссан юун буй...

⁵ Монголын Нууц Товчоо, УБ 2004, х52

⁶ Монголын Нууц Товчоо, УБ 2004, х52

⁷ Монголын Нууц Товчоо, УБ 2004, х54

⁸ Монголын Нууц Товчоо, УБ 2004, х55

⁹ Монголын Нууц Товчоо, УБ 2004, х55

Энэ тохиолдолд “Эм хүүхнээ орхиж” гэдэг нь эхнэр, үр хүүхдээ орхиж гэсэн утгатай. Эзэн чингис хаан бие барахад Сөнидийн Гилүгүдэй баатар үг өчрүүн

**Хас болсон төр чинь богинодоном за
Хайрт Бөртгөлжин хатан чинь бэлэвсэрэм зэ
Хасар,Бэлгүтэй хоёр дүү чинь бэлэвсэрэм зэ
Хамран зөөсөн улс чинь тархам за
Хангай хааныг хажуулам за Хатад хүүхэн “хүүхдүүд” чинь хүйлэн хайлан ирэхүүд¹⁰*

гэж гарч байна. Мөн

**Чингис хаан зарлиг болруун
Хад чулуунд арьс үгүй
Хатан төмөрт дүрс үгүй
Хайран төрсөн биед мөнх үгүй
Хатуужин явагтун
Үнэн үгэндээ хүрсэн хүний сэтгэл бэх
Өчүүхэн дураан барьж олон лугаан зохь
Үнэхээр энэгүн нөгчих бие бишүү
Хойд сайнаан эрэгтүн
Хубилай хүүхэний (хүүгийн) үг өөр (ухаалаг)¹¹*

**Хятадын Жүй өвгөний эм нэгэн хөвүүн төрөхүүд гэрээс солонго татвай.Тэр бэлгийг Лаха Ибаху мэдэж ,хаанд тустай чиг байз,хортой чиг байз.Энэ хүүхнийг (хүүг) бяцханаас нь үгүй болголтой гэж өчив.¹²*

**Эсэн эмэг эхдээ Самар гүнжид”Энэ хүүхнийг (бяцхан хүүг) алья хэмээсэнд “Энэ миний дүү,чиний зээ биш үү”Энэ хэзээ өсөж өшөө авах буй. Хөвгүүн минь тогоон бөгөөс ингэмү”хэмээн эс болбай.¹³*

**Өгидэй тайбуд”Чи хүнд их больё хэмээвээс Харгачугийн Сэцэг бэйжээс төрсөн хүүхэн 3 настай буй.Монголд хүргэвээс энэ биенээс болох. Хойч үр чинь дархан болох” хэмээсэнд¹⁴*

Мөн Өвөрмонголын Улаанцав аймгийн Урад ардын дуунд

**Хоёр зуу гаруй хүүхэн цэрэг (эр цэрэг)
Хоёр ёу гүрний байлдааны түрүүнд
Хорин юу сумтай Чи Жүү буу минь
Хоёр мөрний дараасын түрүүнд...¹⁵*

гэж гарч байгаа нь сонирхол татаж байна. Гэхдээ хүүхэн гэдэг үгийг нутгийн аялгууны талаар тайлбарлах боломжтой гэж хэлж болно.Жишээ нь: **Нутгийн аялгууны зарим үг нь утга зохиолын хэлний үгтэй утга зөрүүтэй явдал байна.Жишээ нь цахар аялгуунд хүүхэн гэж хар хүнтэй суугаагүй охин хүнийг*

¹⁰ Ш. Чоймаа, М. Баярсайхан, Э. Мөнх-Учрал, “Шар тууж” УБ 2006, х 47

¹¹ Ш. Чоймаа, М. Баярсайхан, Э. Мөнх-Учрал, “Шар тууж” УБ 2006, х 53

¹² Асрагч нэргийн түүх

¹³ Ш. Чоймаа, М. Баярсайхан, Э. Мөнх-Учрал, “Шар тууж” УБ 2006, х 66

¹⁴ Ш. Чоймаа, М. Баярсайхан, Э. Мөнх-Учрал, “Шар тууж” УБ 2006, х 66

¹⁵ Ж.Төмөрцэрэн “Монгол хэлний үгийн сангийн судлал” УБ 2001, х128

хэлэхээс гадна эрэгтэй,эмэгтэй багачууд хүүхдийг настай өвгөд хөгшид “Хүүхэн” гэж дуудах нь олон.Гэтэл утга зохиолын хэлэнд гэр бүлтэй болсон эмэгтэй хүнийг хэлэх нь элбэг¹⁶ гэж дурьдсанаас үзэхэд энэ үг нь нутаг нутийн аялгуунд харилцан адилгүй утгатай байх магадлалтай байна. Мөн орчин цагийн хүүхэн гэсэн үгтэй дүйцэх үг нь “Охин” гэх буюу “эм” гэдэг үгийг хэрэглэж байжээ. Хүний эхнэр болсон бол “Эм” гэх буюу “Гэргий” үгүй бол “Охин” гэж хэрэглэдэг байсан . Жишээ нь: **Харчугийн хөвүүн Боржигидай мэргэн бүлгээ. Боржигидай мэргэний гэргий нь Монголжингуа, түүнээс төрсөн хөвүүн Торголжин баян. Торголжин баян, Борогчин гуа гэргийтэй, Боролдайсуялби гэдэг залуу зарцтай, дайр бор хоёр хүлэг морьтой бүлгээ. Торголжин баяны хөвүүн Дува сохор, Добу мэргэн хоёр бүлгээ.*

**Дува сохор өгүүлрүүн: "Тэр нүүдэл иргэний дотор, тэрэгний мухлагийн өмнө нэг сайхан охин сууж явна. Хүний гэргий болоогүй бол Добу мэргэн дүү чамд гуйж гэргий болгоё" гээд түүнийг үзүүлэхээр Добу мэргэн дүүгээ илгээв.*

**Добу мэргэн, тэр нүүдэлд хүрч охиныг үзвэл үнэхээр алдартай, гоо сайхан охин бөгөөд хүний гэргий болоогүй ажээ. Нэр Алунгуа гэнэ.*

Эдгээр ишлэлээс харахад хүүхэд гэдэг үг нь мөн өргөн хэрэглэгдэж байсан ба ганц ба олон тоон дээр давхар хэрэглэгдэж байжээ. Жишээ нь:

**Добу мэргэн, тэр бугын махыг ачиж явтал замд хүүхдээ хөтөлсөн нэгэн ядуу хүн учрав.*

**Урьд Добу мэргэнийг амьд бүхий цагт төрсөн Бэлгүнүтэй, Бүгүнүтэй хоёр хөвүүн, эх Алун-гуагаас эчнээ хэлэлцсэн нь: "Бидний эх, ойр төрлийн эрэгтэй хүнгүй ба эргүй бөгөөтөл энэ гурван хөвүүнийг төрүүлэв. Гэр дотор ганц Малиг баяуд овгийн зарц хүн байна. Энэ гурван хөвүүн, түүний хүүхэд биз" гэж эхээс далд хэлэлцэхийг нь Алун-гуа мэдээд...*

Үүнээс үзэхэд эртний болон дундад үеийн монгол хэлэнд “Хүү” гэсэн үг байхгүй бөгөөд харин “Хүүхэн” “Kheuhen” гэсэн үг нь бага насны эрэгтэй хүүхдийг заадаг, “Хүүхэд” буюу “Kheuhed”нь олон болон ганц тоог заадаг байсан нь тодорхой харагдаж байна. Харин зарим нэг судалгаанд “Хүү гэдэг үг нь хүүхэн, хүүхэд гэсэн үгийн язгуур юм. Хүү гэсэн үг дээр “хан” “хэн” залгавар залгагдаж “хүүхэн” гэсэн үг үүссэн .Улмаар “Хүүхэн” гэсэн үгэн дээр олон тоо үүсгэдэг “-д, -т” залгагдаж “Хүүхэд” гэсэн үг үүссэн хэмээн дурьдсан байна. Энэ бол орчин цагийн монгол хэлийг крилл бичгийн дүрэмд нийцүүлэн хүчээр тайлбарлах гэж оролдсоны үр дагавар гэж бодож байна. Ер нь аливаа үгийн уг гарал, язгуурыг судлахдаа уйгуржин монгол бичгээр хэрхэн бичдэгийг орхигдуулах аргагүй. Жишээлбэл энэхүү “Хүү” хэмээх үгийг монголоор хэрхэн бичдэгийг галиглан үзвээс “*Khu*”гэж бичнэ .Харин “Хүүхэн”гэдэг үгийг монгол бичгээс галиглаваас “*Kheuhen*” гэж бичих бөгөөд,хүүхэд гэхийг “*Kheuhed*”гэж бичнэ. Үүнээс үзэхэд ”Хүү” хэмээх үг нь тусдаа бие даасан үг бөгөөд, харин “Хүүхэд,Хүүхэн” гэсэн үгнүүд нь нэг язгууртай болохыг илтгэж байна. Үүнийг цааш судлан үзвээс, ер түрүү үеийн монгол хэлэнд “Хүү”гэсэн үг байдаггүйг анзаарсан бөгөөд харин “Хүүхэн

¹⁶ Ж.Төмөрцэрэн “Монгол хэлний үгийн сангийн судлал” УБ 2001, х126

буюу ***Kheuhen***” гэдэг үгийг өргөн хэрэглэдэг байжээ. Гэхдээ өдгөө Орчин цагийн монгол хэлэнд Хүүхэн гэсэн үг нь “Нас бие гүйцсэн эмэгтэй хүн” гэсэн утгатай байдаг бөгөөд өөр утгыг үл заана. Гэтэл түүрүү үеийн болон дундад үеийн монгол хэлнээ “Хүүхэн” (***Kheuhen*** гэж галиглана) гэдэг үг нь хүүхэд, тэр дундаа бүстэй хүүхэд буюу эрэгтэй хүүхэд гэсэн утгыг зааж байсан ажээ.

Монгол хэлний “Хүү” хэмээх үгийн утга зохиолд илрэх байдал

Монгол ардын дууны шүлгэнд болон утга зохиолд ихээр тохиолдох “Хүү “хэмээх үг нь чухам ямар утгатай болохыг авч үзье. Эдгээрт гарч буй “Хүү” гэдэг үг нь дан ганц үр хүүхдийг илэрхийлнэ гэвэл өрөөсгөл болно. Жишээ нь :

**Хулсан ташуур нь байгаасай*

Хуруундаа өлгөөд явах юмсан хүү минь ээ хө

Хууль цаазгүй болоосой

Хуучин нутаг Яруудаа очих юмсан хүү минь ээ хө(Ардын дуу Хулсан ташуур)

Дээрх дууны түүхийг аваад үзэхэд хязгааргүй цэргийн албанд явсан залуу хайртай бүсгүйгээ мөн эх нутгаа үгүйлж дуулдаг тухай гардаг. Тиймээс дээрх дууны шүлгэнд байгаа “Хүү” гэдэг үг нь хүйсийн хувьд нь эмэгтэй хүнийг илэрхийлж байгаа нь тодохой байна.

**Ганди юу модондоо*

Галуу нь эргэнээ хө

Газрын маань холоос

Хүү маань ирнээ хө (Ардын дуу Ганди мод)

Дээрх дуунд мөн адил амраг сэтгэлтэй хүүхнээ хүсэн мөрөөдөх тухай дуу болохоос бус, үр хүүхдийн тухай өгүүлээгүй юм.

**Цэнхэрлэн харагданаа хө*

Цэцэг жимстэй уул байнаа хө

Чин зоригийг барьвал

Цэнгэж болмоор уул байнаа хө

Алаглан харагданаа аа хө

Алим жимстэй уул байнаа хө

Аавын хоёр хүү чинь

Амьдарч болмоор уул байнаа хө (Д.Нацагдорж. Цэнхэрлэн харагдана)

Энэхүү шүлэг нь 1920 -1930 оны хооронд бичигдсэн гэж үздэг ба тухайн үеийн монгол хэлнээ “Хүү “ гэдэг үг нь мөн л дотны сэтгэлтэй эр, эм хүмүүс гэсэн санааг илэрхийлсэн байгааг ажиглаж болно.

**Гэтэл хүүхэн өчүүхэн ч эмээх зовох байдалгүй бөгөөд харин ламд дургүй учрыг хэлж хараан загнаж, хөөн гаргасанд лам заалдъя гэвч хуврагийн ёсоо эвдсэн тул аргагүй гунирхан байшингийн босгыг тэвэрч: Хүү минь би чамд хайртай Одоо би хаашаа очих вэ? Өөр хүнтэй ханилах хамаагүй Гагцхүү намайг бүү орхи хэмээн хоёр нүднээсээ ертөнцийн хар нулимсыг борооны дусал адил асгаруулна. (Д.Нацагдорж. Ламбагауйн нулимс 1930 он)*

Нацагдоржийн энэ өгүүллэгт гэвш Лодон хайртай бүсгүйгээ “Хүү минь би чамд хайртай” гэж хэлж буйгаар дүрсэлжээ. Тэгэхээр энэ үед “Хүү” гэдэг үг нь яах аргагүй эмэгтэй хүнийг, тэр дундаа дотны сэтгэлтэй эм хүнийг заадаг байсан нь батлагдаж байна. Гэхдээ тухайн үед “Хүү” нь дан гагц эмэгтэй хүн гэсэн утгыг үл заасан агаад мөн эр хүйсийг ч заадаг байжээ. Жишээ нь:

**Хуучин хүү хул морин дээрээ хөндлөн сууж, хатируулсаар хүрч ирэх бөгөөд цагаан даавуу алчуураар толгойгоо ороосон агаад ширэлдсэн хар гээгийн сэрвийсэн хэдэн үс шанаа уруу нь унжин. (Д.Нацагдорж “Хуучин хүү” өгүүллэг)*

**Дайралцвал дайралцья
Даалин хөөргөө тавилцья*

Хэлэлцвэл хэлэлцье

Хэт хутгаа тавилцья

Зээ хүү минь үнэхээр тиймүү зэ (Ардын аман зохиол Дайралцаан)

Үүнээс үзэхэд ардын болон уртын дууны төгсгөл дэх “Хө” болон “Хүү” гэдэг нь нэг үг байх магадлалтай байж болзошгүй юм.

Орчин цагийн монгол хэлнээ “Хүү” хэмээх үгийн илрэх байдал

Орчин цагийн монгол хэлэнд “Хүү” хэмээх үг нь дараах утгаар хэрэглэгдэж байна. Үүнд

1. Бүстэй хүүхэд буюу залуу эрэгтэй хүүхэд
2. Амьтны үр төл
3. Зээлийн хүү
4. Шатрын хүү

Хүний нэрэнд илрэх байдал

Өдгөө орчин цагийн монгол хэлнээ “Хүү” болон “Хүүхэн” гэдэг үг хүний нэрэнд байх нь элбэг тохиолддог бөгөөд эртнээс нааш хүйс заадаггүйг байснаараа онцлог юм.

**Есүхэй баатарын эцэг Бартанбаатар, Бартанбаатарын эцэг Хүүхэнбаатар*

Эрт үеийн монгол хэлнээ эрэгтэй хүний нэрэнд залгадаг байсан бол өдгөө орчин цагийн монгол хэлэнд хүний нэрэнд илрэхдээ эдгээр хоёр үг нь хүйс ялгадаггүй байна. Жишээ нь: Шархүү, Шархүүхэн, Хадхүү, Борхүү, Борхүүхэн, Улаанхүү, Цагаанхүү, Чулуунхүү, Сайнхүү, Хүрэлхүү, Магнай хүү, Ханхүү, Идэрхүү, Балхүү гэх мэт. Гэхдээ өнөө үед хүүхэд эдгээр нэрийг өгөх хандлага буурсан талтай. Орчин цагийн монгол хэлэнд хамгийн өргөн утгаар хэрэглэгдэж байгаа нь утга нь дээр дурьдсан “Үр хүүхэд, Эрэгтэй хүүхэд” гэсэн санаа юм. Жишээ нь :

**Эрээн бараантай хорвоогийн замд бүдчиж явахдаа*

Эрдэнэс олсон би азтай хүн

Энгэрт минь зүүгдэх нэг насны гоёлоо

Энэ орчлонгоос хүртсэн би жаргалтай хүн

Хэвлийдээ тээсэн арван сарын минь хугацааг

Хир удаан амьдрахаар биш хэн болсноороо нөхөж төлөөрэй минийхүү

Хэлж жишээлж зүйрлэмгүй төрөлтийн их өвдөлтийг

Хэнгэргийг минь цоортол дуулгах сайн мэдээгээр шагнаарай **миний хүү**

Даргын ширээнд сууж баяжаарай гэхгүй ээ ээж нь

Дорд үзэгдэж гудайхгүй л яваарай **миний хүү**

Мөнхийн ус , ач тус нэхэхгүй ээ ээж нь

Мөрөөдөлтэй, зорилготой л амьдраарай **миний хүү (Б.Бядаа “Хүүтэй хүн алздаггүй гэсэн”)**

**“Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-д заасны дагуу ...*

**Годруулбал, ахмад настны тэтгэврийн зээлийн хүү жилийн 18 хувийн хүүтэй байсныг 15 хувь болгож буурууллаа.*

**Шатрын хүү урагшаа зоригтой тэмүүлбэл бэрс болдгийг Чи үзсэн үү? Өвөг дээдс маань бидэнд. Үнэхээр гайхамигийг бүтээж өгсөн.*

Дээр өгүүлсэнийг дүгнэн үзвэл “Хүү” гэдэг үг нь бие даасан үг бөгөөд дундад эрт үеийн монгол хэлэнд байгаагүй болох нь харагдаж байгаа бөгөөд дундад үеийн монгол хэлнээ зөвхөн эмэгтэй хүйс заадаг байсан ба аажмаар эр хүйсийг мөн заадаг болжээ. Мөн “Хүүхэн” буюу “Kheuchen” гэдэг үг нь “Хүү” гэдэг үгнээс үүсээгүй, өөрөө язгуур үг мөн бөгөөд эртний монгол хэлэнд зөвхөн эрэгтэй хүйс заадаг байсан хэмээн үзэж болох юм. Харин “Хүүхэд” буюу “Kheuhed” гэдэг үг нь “Хүүхэн” гэдэг үг дээр олон тоо үүсгэх “-д” –г залгаж үүссэн үг бөгөөд орчин цагийн монгол хэлнээ “Хүүхдүүд” гэж ярьж байгааг анхаарах нь зүйтэй болов уу. Учир нь давхар олон тооны “-ууд-үүд” дагавар залгаж байгаа болно. Түүнчлэн “Хүү” гэдэг үг нь эрэгтэй хүйс төдийгүй эмэгтэй хүйс заадаг байсан. Харин цаг хугацааны хувьд хэдийнээс зөвхөн үр хүүхэд гэсэн санааг илэрхийлэх болсныг судлаад үзэхэд монгол бичгээс крилл бичигт албан ёсоор шилжсэнээр хэл зүйн дүрэмд өөрчлөлт орж, улмаар энэхүү “Хүү” гэсэн үг нь утгын хувьд “Үр хүүхэд”, “Эрэгтэй хүүхэд” гэсэн санааг илэрхийлэх болжээ.

Ийнхүү “Хүү” нь орчин цагийн монгол хэлэнд үр хүүхэд гэсэг утгыг заадаг бөгөөд, ”Зээлийн хүү”, ”Шатрын хүү” гэсэн үгнүүдээс үзэхэд “Ямарваа нэгэн зүйлээс урган гарсан” буюу “бяцхан, жижиг” гэсэн санааг давхар агуулдаг гэж үзэж болох юм. Улмаар харь үг биш уугуул монгол үг байх хамгийн их магадлалтай болов уу. Тэгвэл чухам “Хүү” гэсэн үг хэдий үеэс монгол хэлнээ нэвтэрсэн болохыг нотлох түүхэн сурвалж одоохондоо байхгүй байгаа бөгөөд бидний судалгаагаар монгол ардын болон уртын дууны төгсгөл дэх “Хө” болон “Хүү” гэдэг нь нэг үг байх магадлалтай хэмээн үзэж байна. Учир нь эдгээр үгс монгол бичгээс галиглавал хоёулаа “Khu” гэж бичих бөгөөд нэг үг байх магадлалтай ба утга санааны хувьд нөгөө хүнээ дотночилон дууддаг болохыг ардын аман зохиолоос харж болно.

**Даалин хөөргөө тавилцья*

Хэлэлцвэл хэлэлцье

Хэт хутгаа тавилцья

Зээ хүү минь үнэхээр тиймүү ээ(Ардын аман зохиол Дайралцаан)

**Торгоны маань хээ гэдэг нь*

Товгорхон ч байна уу даа ай хөөрхий хонгор минь ээ **хө**

Томоогүй шүү сэтгэл гэдэг чинь

Хэнээсээ ч болов доо хөөрхий хонгор минь ээ хө (Ардын дуу “Торгоны хээ”)

Энэхүү “Хүү” хэмээх үгийг цаашид нутгийн аялгууны талаас нь судалж, аль нутгийн аялганд ямар утгаар тохиолдож байгаа, мөн аль аймгийн хүний нэрэнд хамгийн их орсон байгаагаар нь өргөн хүрээний судалгаа хийвэл гарал үүслийн хувьд илүү тодорхой болох магадлалтай гэж бодож байна. Ер нь аливаа үгийн үгсийн сангийн судалгааг хийхдээ зөвхөн крилл үсгийг харах биш, монгол бичгээр хэрхэн бичдэгийг заавал харьцуулж үзэх нь зүйтэй юм.

Монгол хэлний “Хүү” хэмээх үгийг япон хэлний “子” буюу “КО” хэмээх үгтэй харьцуулах нь

Япон хэлнээс монгол хэл рүү орчуулга хийх, судалгааны бүтээл уншиж танилцах явцад япон хэлний “子” буюу “КО” гэдэг үг нь утгын хувьд монгол хэлний “Хүү” гэдэг үгтэй ижил төстэй тал байгаа нь ажиглагдсан. Орчин цагийн япон хэлэнд “子” буюу “КО” нь дараах утгыг агуулна. Үүнд:

1. Хүний болон амьтны үр төл
2. Зээлийн хүү
3. Хүний нэрэнд орно
4. Эмэгтэй хүн

Эдгээр хэрэглээний онцлогоос харахад монгол хэлний “Хүү” болон япон хэлний “子” буюу “КО” нь маш төстэй болох нь тодорхой байна. Жишээ нь:

I. Хүний болон амьтны үр төлийг заах

*子供kodomo-хүүхэд 息子musuko-хүү 子ko-үр хүүхэд 男子danshi-эрэгтэй хүүхэд 女子jyoshi-эмэгтэй хүүхэд *子馬ko uma-унага 子牛ko ushi-тугал 子犬ko inu-гөлөг 子猫ko neko-муурын зулзага 子山羊ko yagi-ушиг

Жишээ 1: 近年、日本で少子化問題に対する関心や懸念が高くなってきている。 Орч: Сүүлийн жилүүдэд японд төрөлт багасах (хүүхэд цөөрөх) асуудал маш их анхаарал татаж байна.

Жишээ 2: 北海道の牧場で、さわやかな風を受けた子馬たちが母親に寄り添ってすくすくと育っている。

Орч: Хоккайдогийн хээрийн сэвэлүүр салхинд цовоо унаганууд эхийгээ бараадан цовхчин тоглоно.

II. Зээлийн хүү

日本の銀行の利子が低いということは、銀行口座を開設している人なら誰でも知っていることですよ。 Орч: Япон банкны хүү хамгийн бага гэдгийг данс эзэмшигч хэн бүхэн мэднэ биз дээ.)

III. Хүний нэрэнд илрэх нь

Жишээ: 日本の皇太子妃雅子さまは、来年5月に皇后となることについて「心許(こころもと)ない」と不安を示す一方、日本国民のために力を尽くすと、文書で発表した。

Орч: Японы эзэн хааны хатан болох Масако авхай ирэх оны 5 сард болох хаан өргөмжлөх ёслолын тухайд “Айж байгаа хэдий ч японы ард түмний тусын тулд хичээх болно” хэмээжээ.

Япон хүмүүсийн нэрэнд “子” нь нэлээд элбэг тохиолддог. Эрт үед бол зөвхөн эрэгтэй хүний нэрэнд ордог байсан уг үг нь өдгөө голчлон эмэгтэй хүний нэрэнд ордог.

Reiko Sachiko Michiko Mariko Michiko Sumiko
Kaneko. Жишээ нь 玲子、幸子、美智子、真理子、恵子、すみ子、金子

Гэхдээ Waku Waku телевизээс эдгээр нэртэй холбоотой нэгэн сонирхолтой судалгаа явуулахад япон залуусын ихэнх нь “子” орсон нэрийг хуучинсаг, уйтгартай хэмээн үзэж ирээдүйд хүүхэддээ ийм нэр өгөхөөс татгалзсан байна. Энэ нь монгол хэлний Чулуунхүү, Цоожхүү, Шархүү зэрэг нэр сүүлийн үед мөн ховор болж байгаатай ижил байгаа юм. Магадгүй монгол залуусын дунд судалгаа явуулбал төстэй хариу гарахыг үгүйсгэхгүй.

Ү. Эмэгтэй хүнийг заана.

Угтаа бол Япон хэлэнд энэхүү нэр нь язгууртан гаралтай эмэгтэйн нэрэнд их ордог байсан.

Жишээ: 1899年、大久綱二が『女学講義』に寄せた「婦人の名に付くる〈子〉の字の説」で、「子」が貴人の名に使われることから「子」は尊称と思われるかもしれない。

Орч: 1899 онд Огүчи Южи “Эмэгтэйчүүдийн талаарх судалгаа” лекцэндээ өгүүлэхдээ “Ко” гэдэг үг нь язгууртан хүний нэрэнд ордог байсан учраас хүндэтгэлийн нэрэнд орох талтай хэмээн өгүүлсэн байдаг.

Япон хэлний “子” буюу “КО” гэдэг үг нь эрт цагийн япон хэлнээ дан эм хүйс заадаг байсан. Жишээ нь Японы Хайкү шүлэгч Ёсано Акикогийн шүлэгт:

*その子二十櫛にながるる黒髪のおごりの春のうつくしきかな

Хонгор хүү (бүсгүй) минь хорин настай. Сул асгарсан гил хар үс нь хаврын шөнө мэт үзэсгэлэнтэй

*あの子どもどこにいるのやら Хайрт хүү минь (хүүхэн, бүсгүй) хаа байгаа бол 星空の続くあの町あたりか Одтой тэнгэрийн доорх тэр нэгэн хотод уу

細い風の口笛が Исгэрэн үлээх салхин миний

恋の傷あとにしみる... Сэтгэлийн шарх минь сэдрээж.. (Itsuki Hiroshi Yozora буюу Шөнийн тэнгэр дуунаас)

Дээрх жишээнүүдээс харахад монгол хэлний “Хүү” гэдэг үг болон япон хэлний “子” гэдэг үг нь хоорндоо утгын болон хэрэглээний хувьд маш төстэй болох нь ажиглагдаж байна. Мөн эдгээр үг нь хоорондоо дуудлагын хувьд нилээн төсөөтэй бөгөөд, монгол ба япон хэл нь хоёул Алтайн Язгуурын хэл болохоор нэг угсаа гаралтай үг байхыг ч үгүйсгэхгүй аргагүй юм. Харин монгол хэлнээс ялгаатай нь япон хэлний “Ко” буюу 子 Хүү гэсэн үгэнд олон тооны “共” гэсэн дагавар нэмэгдэж “子供” буюу Хүүхэд гэсэн үг үүссэн нь эрхбиш анхаарал татаж байна.

Дүгнэлт

Монгол хэлний “Хүү” болон япон хэлний “ко” хэмээх үгийн гүн бүтцийг жишиж, хэрэглээний хэл шинжлэлийн талаас нь ерөнхий ажиглалт хийгээд дараах товч дүгнэлтэнд хүч байна. Үүнд:

1. “Хүү” хэмээх үг нь монгол хэлний “Хө” гэдэг үгнээс гаралтай бөгөөд нөгөө хүнээ дотночилон дууддаг буюу дотно сэтгэлийн хүнээ дууддагаараа ихээхэн төсөөтэй байна. Тиймээс ийнхүү үзэх бүрэн үндэслэлтэй хэмээн хэлж болно.
2. Нөгөө талаас “Хүү” гэдэг үг нь харь үгээс гаралтай гэж үзвэл Хятад хэлний “Пүнлүү” буюу “Пү” гэсэн үгээс үүссэн байх магадлалтай. Хэрэглээгээ дагаад “Пү” нь “Пүүлэх” гэдэг үгнээс “Хүү хүүлэх” гэсэн үг үүссэн байдаг. Энэ нь их зүйлээс “Жижиг зүйл” буюу зээлийн хүү, шатрын хүү зэрэг үг монгол хэлэнд нутагшиж үлдсэн байж болох юм.
3. Япон хэлэн дэх “Ко” гэсэн үг нь дуудлагын хувьд монгол хэлний “Хүү” гэсэн үгнээс үүссэн байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ япон хэл нь ханз үсэг хэрэглэдэг хэлний хувьд 子 гэсэн ханз нь утгын хамт хятад хэлнээс япон хэлэнд шууд орж ирсэн бөгөөд энэ нь япон болон монгол хэлний эдгээр үг нь хоёул хятад гаралтай байх магадлалтай.

Ном зүй:

1. Гонгор Д, Халх товчоон, УБ 1970
2. Монголын нууц товчоо, УБ 2004
3. Нацагдорж Д, Хуучин хүү, Ламбагуайн нулимс цахим өгүүллэг
4. Пэрлээ Х, Нууц товчоонд гардаг газар усны зарим нэрийг хайж олсон нь, УБ 1958
5. Сумьябазар Б, "Монголын Нууц Товчоо, үсгийн галиг", "The secret history of Mongolia, transliteration", УБ 1990
6. Төмөрцэрэн Ж, Монгол хэлний үгийн сангийн судлал, УБ 2001
7. Чоймаа Ш, Баярсайхан М, *Мөнх-Учрал* Э, Шар тууж, УБ 2006
8. Yosano Akiko Tanka
9. Waku Waku Terebi 「日本人のお名前」 Япон хүний нэрний учир нэвтрүүлэг
10. 井藤伸比古 「子のつく名前の誕生」 2011年8月11日 Ито Нобүхико “Ко орсон хүний нэр хэрхэн үүссэн талаар” судалгааны ажил 2011.8.11

モンゴル語のHUという言葉の源流に関する研究 —日本語の「子」との比較

序論

最近のモンゴル語学研究ではモンゴル語語彙に関する研究が不足している。モンゴルは単なる国ではなく、広大な領土を持つ民族であったため、モンゴル語とモンゴル文化を持つ少数民族が世界各国にいる。例えば、モンゴル語を話す中国内モンゴル自治区、新疆ウイグル自治区のモンゴル族、ロシアのブリヤート民族、トゥヴァ民族、アフガニスタンのハザール民族などが挙げられる。そこで、モンゴル語の語彙の源流に関する研究をもっと幅広く行うべきだと考えられる。

理論：

- モンゴル語のHUの研究のきっかけと背景
- 歴史書物におけるHUの働き
- モンゴルの文学に現れるHUの意味と役割
- 古代モンゴルにおけるHUの意味と働き、現代国語におけるHUの意味と働き
- 日本語の「子」との比較

以上の通り、研究を行う

モンゴルの縦文字は難解であるため、全国的に縦文字を廃止するように指示した。まず1941年にラテン文字（ローマ字）の使用を試みたが、たった3か月で禁止された。強制的にキリル文字を使う準備を進め、1946年に正式にキリル文字の使用を始めた。

キリル文字化してから新しい国語文法が作られ、それに伴い言葉の源流が不明化したと考えられる。

モンゴル語のHUは匈奴（HUN）（4世紀から6世紀にかけて中央アジアに住んでいた騎馬遊牧民）のHUが源流であると考えられる。モンゴル語のHUN, HUMUUN（人）、HUMANの語源であると考えられる。

本論

今、世界で最も人気を集めているモンゴルのロックバンドHUが2016年に結成されてから、特にヨーロッパの音楽フェスティバルに参加してきた。その名前も、HUである。バンド名の由来も匈奴の意味からとったと言われている。

また、現代のモンゴル語のHuの意味は「男子」つまりBoysである。ところが、この言葉の意味を探ってみたところ、古代モンゴル語にはHUという言葉がないことに気が付いた。

それではいつごろからこの言葉が使われるようになったのだろうか。

“元朝秘史”によると当時はHUという言葉がまだ使われてなかったことがわかる。当時はHUBEGUN（男子）HUUHEN（女子）という言葉が広く使われていた。

現代モンゴル語で女性を意味するHUUHENという言葉は当時は、逆に男性を意味していた。19世紀の初めになると、このHUという言葉が文学や歌詞の中で使われるようになり、当時は女性を意味していた。今では子供や男性の意味しか使われないが、変更され「女性」から「男性」を指すようになったようである。

日本語の「子」との比較

現代モンゴル語と日本語の両方にHUとKOは同じ役割を果たしている。

1. 人間の子供、動物の子供 (子牛、子馬、子猫)

| | |
|-------------------|-------------------|
| 子供-хүүхэд | * 子馬-унага |
| 息子-хүү | 子牛-тугал |
| 子-үр хүүхэд | 子犬-гөлөг |
| 男子-эрэгтэй хүүхэд | 子猫-муурын зулзага |
| 女子-эмэгтэй хүүхэд | 子山羊-ушиг |

2. 日本の銀行の利子が低いということは、銀行口座を開設している人なら誰でも知っていることですよね。(Orч Япон банкны Нуу хамгийн бага гэдгийг данс эзэмшигч хэн бүхэн мэднэ биз дээ.)

3. Reiko Sachiko Michiko Mariko Michiko Sumiko Kaneko

玲子、幸子、美智子、真理子、恵子、すみ子、金子
モンゴル人の名前にもよくついているHuである。例えば

Chuluunhu, Sharhu, Borkhu, Tsagaanhu など。

現代日本語におけるKO「子」は昔、女性を意味していたことがわかる。日本の俳句や短歌によく出てくる「子」だが、書き言葉として使われていた。

例えば：その子二十櫛にながるる黒髪のおごりの春のうつくしきかな (与謝野晶子)

Хайртай хүү (бүсгүй) минь хорин настай. Сул асгарсан гил хар үс нь хаврын сар мэт үзэсгэлэнтэй

演歌 (夜空)

| | |
|--------------|--|
| あの子どこにいるのやら | Хайрт хүү минь хаа байгаа бол |
| 星空の続くあの町あたりか | Одтой тэнгэрийн доорх тэр нэгэн хотод уу |
| 細い風の口笛が | Исгэрэн үлээх салхин миний |
| 恋の傷あとにしみる... | Сэтгэлийн шарх минь сэдрээж |

また、日本では「子」に関する研究を行っている研究者がいる。



WakuWakuテレビの世論研究によると最近の若者は「子」がついた名前が古臭いと考えていることがわかった。昔は「子」が貴人の名前に使われることから「子」は尊称と思われていたことを強調している。

結論

1. 最後に、このようにもモンゴル語HUと日本語のKOは両方とも昔は尊称、また文学の書き言葉として使われていたことがわかった。

2. また、昔はHUとKOはどちらも「女」を意味していた。
3. 両方とも何かから生まれた小さなものを意味する。例えば、子供—Huhed
利子—Zeeliin Hu
4. HuもKoも人名に付くことが多い。両方とも昔の名前の意味を持つ。

Abstract

COMPARING THE MEANING OF THE WORD “KHU”
IN MONGOLIAN AND “KO” IN JAPANESE

In the Mongolian language vocabulary a certain word is identified by its structure, meaning, and purpose that whether it is a word with a single meaning, double meaning, plural meanings, synonym, antonym, or words with a similar root. According to the identification, the word “khuu” is a word with plural meanings, thus it was compared with the word “ko” in Japanese for their meanings and uses.

ХЭЛ ШИНЖЛЭЛ



МОНГОЛ ХЭЛНИЙ “ХУЖИР” ГЭДЭГ УТГАТАЙ
ДЭВСГЭР ГАЗРЫН НЭРС

Е.В.Сундуева

*(ОХУ, Улаан үд хот, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын
Монгол Төвөд Будда судлалын хүрээлэнгийн
Хэл шинжлэлийн салбарын эрхлэгч,
Хэл бичгийн ухааны доктор (Sc.D), дэд профессор)*

Хужир бол хөрсний дээд давхаргад байдаг, амархан уусдаг давсны нэгдлийг агуулсан, нэгэн янз хөрс юм. “Монгол хэлний товч тайлбар толь”-д: “хээр газар ургадаг шүлтэрхэг талст бодис, өнгө цагаан”, “Хорин нэгт тайлбар тольд”: “шор болоод цайн үзэгдэх өвс ургахгүй газрыг хужирт газар хэмээмүй” гэжээ. Хужир нь гүн биш, давсархаг чулуулаг юм уу, эсвэл давслаг хөрсөн доорх ус ууршихад ургадаг бодис юм. Намаг болон давстай нуурын эрэг, ширгэсэн нуурын ёроолоор байдаг аж. “Монгол хэлний толь”-д “хужиртай усны ширгэх, нойтон юмны хатах үед хужир ялгаран гарч ирэх”-ийг *хужир* суух хэмээн тайлбарлажээ. Тийнхүү хужир уснаас үүдэн бий болох чанараар нь Э.Равдан устай холбоотой газрын нэрийн зүйлд түүнийг багтаан үзжээ.

“Хужир” хэмээх утгатай газрын нэрс дунд том хэсэг нь үзэгдлийг нүдээр үзэх мэдрэлийн үндсэнд бий болжээ. Тухайлбал, хужирын цагаан өнгө хамгийн түрүүн нүдэнд дайралдана. Сонг. бич. монг. *šayidam* ‘хужир, марз, хужир марз гарах газар; хужиртай тал; элсэрхэг довын хоорондох намагтай газар’ [Lessing, 1960, p. 161], монг. *цайдам* ‘том газарт үргэлжлэх хужирт намаг; хужираар элбэг тал; *Ордост* манх хоорондох нойтон нуга’ [Казакевич, 1934, 17-р тал], *цайдам* ‘хужир; хөндий тал’ [Цэвэл, 1966, 780-р тал], бур. *сайдам* ‘давстай усны сав газар’ гэсэн үг лав *šayī-* ‘юмны өнгө зүс цагаавтар болох, цайрах’ гэдэг үйл үгээс үүссэн байх. Үүнийг Ковалевскийн тольд учрах сонг. бич. монг. *šayidam* үгийн ‘цагаан идээ: цөцгий, тос г.м.’ [Kowalewski, 1844, p. 2076] гэсэн утга нь батлана. *-дам* гэж үг бүтээх дагавар *-дан* гэж үйл үгээс үүсгэдэг дагаврын хувилбар толно. Түүний аргаар *qaniyadun, qaniyadum; iniyedun, iniyedum* [Kowalewski, 1844, p. 722, 278] гэдэг үгс бий болсон.

Буриадын эрдэмтэн Ц.Б.Будаевын таамаглалаар, энэ үг нь төвөд хэлийн холбоо үгээс үүссэн: *ца* ‘давс’ + *дам* ‘шавар’= ‘давстай шавар’ [Будаев, 1976, с. 175]. Монгол нутгийн нийлмэл газар усны нэрийн бүрэлдэхүүнд *цайдам* гэдэг үг гол болон харьяалагдсан үүрэг гүйцэтгэдэг: *Хүйтэн шар цайдам Овоот цайдам, Хар цайдам; Цайдамын булаг, Цайдам толгой* г.м. Буриад газар усны нэрсийн санд *Цайдам* гэж нуур, тосгон болон хонь өсгөх фермын нэр тохиолдоно.

Сонг. бич. монг. *qujir* ‘хээр газар ургадаг шүлтэрхэг талст бодис, давс’ [Kowalewski, 1844, p. 944] гэсэн үг бас **quj* ‘бүдэг, зэвхий, цайвгар’ гэж язгуураас үүсчээ. Тус язгуур *qujii-* ‘цайх, цонхийх, зэвхийх’ [Lessing, 1960, p.

993], *qijigir* ‘хомхруугаас халцарсан’ [Kowalewski, 1844, p. 944], монг. *хужгар*, бур. *хужагар* ‘бүдэг, цайвгар’. Буриад хэлэнд *хужармаг* гэсэн үг *-маг* гэж багасгах дагаварын аргаар бий болсон (монг. *нуурмаг* ‘хиймэл нуур, усан хадгаламж, цөөрөм’). Хужир гэсэн үг Ибн-Муханны тольд *qəžer* гэж хэлбэртэй орсон, зарим түрэг хэлэнд зээлдэсэн: алт. *кудьур*, хак. *хучур*, тув. *күжур*. Алтай хэлний үгийн гарлын тольд **kuzir* гэж өвөг монгол хэлбэрийг өвөг түрэг. **Kajir* ‘хужир марз; элсэрхэг эрэг; хайрга, хайрын чулуу; элс’ болон өвөг түнгүүс-манж. **kuzur-* ‘газраар бөглөх’ [EDAL, 2003, p. 693–694]-тэй зэрэгцүүлнэ.

Э.Равданы ажиглалтаар, *хужир* гэж үгээс *хужирт*, *хужиртын*, *хужирлаг*, *хужирын* гэж тэмдэг үгс үүсэж монгол нутгийн олон газар усны нэрэнд оролцоно: *Хужирт эрэг*, *Хужиртын сэрвэн* г.м. [Равдан, 2008, 194-р тал]. Буриад ба Эрхүү мужийн газрын зурагт *Гуджирное* нуур, *Кужуртуй*, *Хужартуй* гол мөрөн, *Гужирь*, *Гуджертуй*, *Хужертуй*, *Нижняя Гуджирка*, *Хужар*, *Хужир*, *Малый Хужир*, *Оботын-Хужир*, *Улан-Хужир*, *Хара-Хужир* гэдэг тосгоны нэрс байна.

Тунамал уснаас үүдэлтэй эрдсийн нэг нь *мараа* болно. Тэр нь хужрын адил хонхор, хотгор газар тогтсон хур тундас ширгэхийн хамт түүний суурь дээр ургаж бий болдог байна. Монг. *мараа*, бур. Түнх. *мараан*; монг. *марз*, *марц*, бур. *марса* ‘мал гөрөөсний идэх шор мараа, хужиртай газар’ гэсэн үгс ‘гэгээн, хурц, гялгар; эрээн’ гэж шинжийг агуулна.

Буриад хэлэнд *эрээн марьяан* гэж холбоо үгэнд *эр/мар* язгуурнуудын сэлгэцийн учир бий. Сибирийн газар зүйд *марьяан* гэж нэр томьёо ‘эрээн марьяан ургамалтай өвөр, элэг, өлгий, өлх’ гэж утгатай. Бас **marm / marč* язгуур ижил утгатай үгсийг бүтээнэ. Үүнд: *мармагар* ‘цоохор, нөрөөтэй’, *марчгар* ‘цоохор’, *марцаргана* (ургамлын нэр). Эрдэмтэн Алис Саркёзи марз гэж үгийг төвөд хэлний *ma ru tshwa* гэж үгтэй харьцуулна.

В.И.Рассадины бодлоор, *mara-ča*, *mara-ja*, *mara-yan* хэлбэрүүд монг. *мяраах* ‘гэтэлхийлэн очих, гэтэж ойртох’ гэж үйл үгээс үүссэн. Тэгэхдээ *марса*, *мараа*, *марц* бол ‘хужирын хажууд ан гөрөөсийг отоож суудаг газар’ гэж утгатай болно [Рассадин, 1987, 6-р тал].

Равдан гуай *мараа* нь нүүдэлчдийн ахуйд ач холбогдолтой тул мараат газрыг гойдлон түүнд нэр оноох нь мөн түгээмэл ажээ. Түүний тольд дэвсгэр нэрийн үүргээр 4 нэрэнд оржээ: *Хавтгай мараа*, *Хонхор мараа*, *Хонхорын мараа*, *Тайн мараа*. Харин мараа оноосон гишүүний үүргээр тольд хоёр зуун долоон нэрэнд орсон байна: *Мараат тал* ‘солончаковая степь’, *Марааны ам* ‘солончаковая падь’ [Равдан, 2008, 185-р тал]. Буриадын газар усны нэрийн санд *мараа*, *марза* гэдэг үгс ороогүй.

Монгол хэлэнд **bor / borj* гэж язгууртай дэвсгэр нэрс байна. Монг. *борзон* ‘хужирт шавар, намаг’, Товч тайлбар тольд *борзон* ‘малд өгдөг нэг зүйл шороон хужир, бас арьс элдэхэд хэрэглэнэ’ [Цэвэл, 1966, 94-р тал]; *боролжин газар* ‘ховор өвс ногоотой хужирт газар’. Энэ *бор/борз* язгуур ‘жигд биш, адруу, будруу, биржгэр, барчгар, боржгор’ гэсэн шинж агуулна. Буриад хэлэнд адил утгатай *бордигор*, *боржогор*, *борьёгор* гэж тэмдэг үгс байна.

Түүнээс гадна буриад *бурзагар* ‘цагаан цоохороор нүдэнд дайралдсан (хужир тухай)’, *бурзан* ‘цагаан’ гэж үгийн утга анхаарал татаж байна. *Бурзан*

сагаан, сагаан бурза гэдэг холбоо үгс цагаан өнгөтэй үзэгдлийг тодорхойлно: буурал үс (бур. Барг. *Үнэмни сагаан бурза болоо*), талх (бур. Барг. *сагаан бурза болотороо талхаар будалдаха*), цас (бур. Аг. *Газааһаа бурзан сагаан болоод орожо ерээ, Сагаан бурза саһан орожо байна*).

Забайкальский мужийн *Борзя* гэдэг тосгоны нэр Бурза гэж голын нэрээс үүсчээ. Хятад улсад Орос элчээр ажилласан Н. Спафарий 1675 оны өвөл тус газраар явж, өдрийн тэмдэглэлдээ энэ голыг *Бюрзя* гэж хэлбэрээр бичсэн байна [Спафарий, 1862, 181-р тал]. Буриад хэлэнд *бооржо* гэж ‘давстай нуур’ гэж утгатай үг байсан. Урд цагт тэр газар давстай нуураар элбэг байсан гэж мэдээж. Тэнд давсыг үйлдвэрийн аргаар малтаж авдаг байжээ.

Төв Халхад хэрэглэх монг. *халтар газар* ‘хужир’ [Казакевич, 1934, 26-р тал], Шинжааны ойрад *халтар* ‘ургамалгүй нүцгэн, цагаан тал’ үгс байна. Гол утга нь *qaltar* ‘1) хээр, хар хээр адууны ам, хамар, суга, цавьд цайвар, шарангуй өнгө хольцолдсон нь; 2) тэмээний хар зүсэмд шаравтар өнгө хольцолдсон нь; 3) нохойны биеийн зүсэм хар бөгөөд нүд ам, хөлийн орчин үс шар, цайвар газартай нь; 4) цэвэр биш, хир буртагтай, алаг тарлаг болсон нь’ юм. Тэгэхдээ **qaltar* гэж язгуурын үдсэн утга нь ‘цагаан толботой, халцархай’ болно.

Монг. *шал* ‘огт өвс ургамалгүй, гантасан, хур бороогүй үед чулуу шиг хатуу, хуурай хужир’, хальм. *шал* ‘шим муутай’: *усн уга цол, өвсн уга шал*. Тус үгийн бусад утгалбарууд нь *šala* ‘байшин барилга, гэр орон зэргийн тоосго чулуу, мод зэргээр хийсэн дэвсгэр; индэр, тайз; гудамжны засмал зам’ [Kowalewski, 1844, p. 1447], монг. *шал*, бур. зап. *шала*, калм. *шал*, ойр. Синьцз. *шала* ‘дагтаршсан талбай’, бур. *шала газар* ‘гишгэчиж дагтаршсан газар’, *шала харгы* ‘хөрсөн зам’ ‘хатуу, дагтаршсан’ гэж гол шинжийг илэрхийлнэ.

Монг. *тойром* ‘дугариг хэлбэртэй ган болсон, өвс ургамалгүй хатсан хужир’, Монгол хэлний тольд ‘ус бороо элбэгтэйд нуур болж, ус бороо ховортойд шавар шалбааг болох буюу бү хатаж хуурай будардаг хужирлаг зөөлэн цагаан шороо бүхий халцгай хонхор газар’, Товч тайлбар тольд ‘нуур байгаад хатаж ширгэсэн шаварлаг хөрстэй газар’, сартуул. *tōrom* ‘тогтмол ус; шавар тойром’: *borō orōdž tōromdō us toytow* [БНМАУ дахь..., 1988, с. 330], бур. Хори *тоором* ‘нуурмаг; хужиртай бяцхан газар’ үзэгдлийн хэлбэрийг үзэхийн үндсэн бий болсон.

Тус үг *toyiru-* ‘юмны гадуур эргэх, хүрээлэх’ гэж үйл үгээс үүсч, *тойром* // *тоором* ‘дугариг юм, тойрж эргэмээр юм’ болно. Ижил язгуурт үгсийг утга бас л дугаригтай холбоотой: монг. *тоорцог* ‘бөмбөгөр хэлбэртэй нэгэн зүйл малгай’, бур. *тооробишо* / *тойробишо* ‘шовгор малгай’, *тойрсог* ‘аяга’, бур. Булаг. *тоором* ‘тэмдэг, тамга’.

Монгол Улсад *тоором* гэж үгтэй бараг гурван мянга газар усны нэр тохиолддог. Энэхүү баримтаас тойром нь тал-хээрийн бүс дэх Дорнод, Дорноговь, Дундговь зэрэг аймаг илүүтэй, Хангай-Хэнтий бүсийн Сэлэнгэ, Хөвсгөл зэрэг аймагт цөөвтөр байдаг болох нь харагдах байна [Равдан, 2008, 163-р тал]. Буриад газар усны нэрийн санд *Торма*, *Тором*, *Холбоо-Тором* гэж нуурын нэрс нэрс байна.

Монг. *хаг* гэж үг олон утгатай ‘хир, өнгөр; хогжруу; тоос; хужир; хөвх’. Гол утга нь ‘ямар нэг юуман дээгүүр тогтох зүйл’: хөвх бол чулууны хаг, хогжруу бол толгойн хаг, өнгөр бол шүдний хаг, оч бол төмрийн хаг’. Хужир бол газрын хаг болно. Буриад хэлэнд *хаг* гэж үгэнд ганц ‘хаг өвс’ гэж утга үүсэж, ‘хужир’ гэж утга хөгжөөгүй. Шинэ баргачуудын хэлэнд *шүү* гэдэг үг ‘хужир’ гэсэн утгатайгаар хэрэглэгдэдэг: *шүү долоох* ‘хужир долоох’, *хужир шүү* ‘хужир мараа’. Тус үг хятад хэлнээс (胡 *hú* ‘шүү’) зээлдсэн юм.

Амтлах мэдрэлийг илэрхийлсэн үг бол сонг. бич. монг. *šor, šorbuγ* ‘давс багатай хужир’ [Lessing, 1960, p. 756], монг. *шор, шорвог* ‘солончак с малым количеством соли’ [Казакевич, 1934, 23-р тал]. Дунд үеийн «Мукаддимат-ал-Адаб» гэсэн тольд *šorta γaγar* ‘хужир’ гэж хэлбэртэй холбоо үг байна [Поппе, 1938, 337-р тал]. Гол утга нь ‘зургаан амтны доторхи давсны амт мэт амт; давс хужрын мэт амт; хоол ундны давс ихдэсний нь’. Төгсвөрт, шууд бусаар амтлах мэдрэл монг. *долоовор* ‘хужир’ гэж үгэнд илэрч байна. *Долоо-* гэж үйл үгээс үүсэж, мал гөрөөсний идэж долоох дуртай газар гэж утгатай. Тийм учраас *хужир* гэсэн үгийн шилжсэн утгань ‘хамгийн дуртай идэш уушны зүйл’ болно.

Ийнхүү, хужир гэж утгатай дэвсгэр нэрээс ихэнх нь нь цагаан, хужгар өнгөтэй холбоотой, нэг нь амтлах мэдрэлийн ачаар бий болсон. Монгол газар нутгийн дэвсгэр нэрсийн үүсэхийг судалгаа хэл ба соёл, хэл ба сэтгэхүйн хоорондын харилцааг судлахад тустай болно.

Ном зүй

1. Будаев Ц. Б. О некоторых топонимах Ноёхона // Ономастика Бурятии. Улан-Удэ: БФ СО АН СССР, 1976. С. 168–201.
2. Казакевич В. А. Современная монгольская топонимика. Л.: АН СССР, 1934.
3. БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг. I. Халх аялгуу. Улаанбаатар, 1988.
4. Поппе Н. Н. Монгольский словарь «Мукаддимат ал-Адаб». М.–Л.: Изд-во Акад. наук СССР, 1938. Ч. I-II. Рассадин В. И. Промысловая лексика в говоре окинских бурят // Диалектная лексика в монгольских языках. Улан-Удэ: БФ СО АН СССР, 1987. С. 3–20.
5. Равдан Э. Монгол орны газар нутгийн нэрзүй. Улаанбаатар, 2008. 534 т.
6. Спафарий Н. Путешествие через Сибирь от Тобольска до Нерчинска и границ Китая. СПб.: Тип. В. Ф. Киршбаума, 1882. Цэвэл Я. Монгол хэлний тайлбар толь. Улаанбаатар, 1966.
7. Kowalewski J. E. Dictionnaire mongol-russe-français. Kasan: Imprimerie de l'Université, 1849. Vol. I-III.
8. Lessing F. D. Mongolian-English Dictionary. Berkeley – Los Angeles: University of California Press, 1960.
9. Starostin S., Dybo A., Mudrak O. Etymological Dictionary of the Altaic Languages / with assistance of Ilya Gruntov and Vladimir Glumov. Leiden – Boston: Brill, 2003.

МОНГОЛ УРАН БИЧЛЭГИЙН ГОЛ ОНЦЛОГ,
ЕРӨНХИЙ БҮТЭЦ

Дэгжилт

(БНХАУ, МУИС-ийн ШУС-ийн ХУС-ийн докторант)

Монгол уран бичлэг бичнэ гэдэг нь гагц үсэг юм уу үгийг сайхан бичиж чадаад болчих биш, ерөөс уран бичлэгийн хэлбэр зохиомж, уран сайхны сэтгэлгээ, агуулга хэлбэр хоёрын нэгдэл, утга санаа уран дүрслэлийн зохицол, энэ бүхний төгс зохиомжийг олж илэрхийлэх мэдрэмж ... зэрэг олон талын мэдлэг, чадвар, боловсролыг эзэмших хэрэгтэй байдаг. Хэрэв бүтээлдээ энэ бүх чадвараа төгс илэрхийлэн, урлаж чадах аваас, сая уран бичлэгийн нийгэм гоо зүй, уран сайхны хэмжүүрт нийцсэн бүтээл болох юм. Өөрөөр хэлбэл уран бүтээлийн агуулга хэлбэр хэлбэрийн сайхныг хослуулсан содон бүтээлийг үүдэн бүтээж чадах юм. Уран бичлэгийн агуулга хэлбэр, түүний зохиомж гэдэг нь уран сайхны сэтгэлгээ, туурвил зүйн хэв маяг, энэ бүхэнд таарч нийцсэн бичлэгийн тиг хэлбэрээ зөв сонгон тогтоох, урлагийн бүтээл болгох зэрэг нарийн үйл явц дарааллын нийлбэр болох юм. Энэ талаас нь уран бичлэг нь нийлэг урлагийн шинжтэй болж, үзэгч, хэрэглэгчдэд гоо сайхныг мэдрүүлдэг юм. Тиймээс одоо уран бичлэгийг уран бичлэг болгодог чухал элементүүдийн талаар задлан авч үзэх нь зүйтэй. Үүнд:

ГОЛ ҮГ

Аливаа уран бичээчдийн бичлэг дэх утга санаа, хэлэх гэсэн агуулга, уран сайхны цогцлолыг тухайн бичвэрийн гол үг нь илэрхийлдэг. Гол үг нь хэрэв ямар нэгэн уран бичлэг байлаа гэхэд түүний хамгийн чухал үндсэн цогц болох учраас ийм гол үгийг хэрхэн туурвихад уран бичээчид анхаарлаа нарийн нягт, нямбай хандуулдаг. Гол үгийг сонгоход дараах хэдэн зүйлийн элемент чухал үүрэгтэй байна. Үүнд:

- **Агуулгаа тогтоох:** Ямар нэгэн уран бичлэгийн бүтээлийг зохион бүтээхэд юуны өмнө гол үгээ сонгон тогтоох хэрэгтэй. Гол агуулгад эрт эдүгээ үеийн шүлэг дуулал, мэргэдийн сургаал, хувь бичээчийн зохиосон шүлэг юм уу эсвэл бусад хүмүүсийн сайн мэдэх тухайн агуулгыг хамгийн зөв, оновчтой илэрхийлэх, гүн утга бүхий мөр шад, бадаг зохиол зэрэг байж болно. Тиймээс уран бичээчид тухайн бичлэгтээ өөрийн хүсэл сонирхол, хэрэгцээ, зориулалт чанар энэ бүхнээ үндэслэн гол үгээ сонгож, тухайн агуулгын цөмийг тогтооно.
- **Үсэг, үгийн тигээ тогтоох:** Бичих эхийн агуулга, утга санаа, үгийн тоо, бичээсний их бага, олон цөөнхийгээд хэрэгцээгээ үндэслэн үгийн тигээ тогтоодог. Жишээ нь: Төв байдлын тухай агуулга байлаа гэхэд түүнийг хичээнгүй тигээр бичих юм уу эсвэл ямар нэгэн уянгын шүлэг, дуулал байлаа гэхэд үзэгч хэрэглэгчдийн хүлээн авах мэдрэмж,

таашаал, гоо зүйн сонирхол зэрэг олон талыг анхааран ихэвчлэнгүйлгэн буюу таталган тигээр бичсэн байдаг.

- **Бичлэгийн хэлбэрийг тогтоох:** Уран бичих эхийн агуулга хийгээд хэрхэн бичих бичлэгийн тигээ сонгон тогтоосны дараа бичлэгийн хэлбэрээ боловсруулдаг. Энэ нь өөрийн хэрэгцээ шаардлагадаа тулгуурлан *дөрвөлжин бичээс, өлгөө бичээс, хос уянгын хэлбэр, тэгш дөрвөлжин бичээс, дэвүүр хэлбэртэй бичих* бичлэгийн олон янз маяг хэлбэрийг тогтоож болно.
- **Хаяавар:** Хаяавар гэдэг бол нэгэн бичээсний доторх гол үгийн гаднах тодорхойлолт үгийг хэлдэг. Энэ бол нэр, цаг хугацаа, газар орон гэх мэт бичээчийн паспортын агуулга болно. Ямар нэгэн шилдэг уран бичлэгийн бүтээл байлаа гэхэд түүний гол үгийг үнэхээр гоо зүй, уран сайхны сэтгэлгээгээр илэрхийлэх ба түүний хамт хаяавар үгийг ч сайхан бичиж, сайтар тохируулах хэрэгтэй болдог. Хаяавар үгийн их бага, олон цөөн зэрэг нь гол үгийн зарим үл хүрэлцэх газрыг нөхсөн шинжтэй байж болдог. Ингэж тухайн уран бичлэгийн бүтээлээ нэгэн органик цогц болгон хэлбэршүүлэн тогтворжуулдаг. Энэ бол уран бичлэгийн хэлбэрийг улам гоо зүйтэй, сонирхолтой, сэтгэлгээтэй, амьд болгож буй хэрэг юм. Хаяаварт гол үгийг хэний ямар шүлгээс бичсэн зэрэг агуулга орж болно. Тиймээс хаяаврыг бичихдээ нарийн бодож тунгаах шаардлагатай болдог. Хэрвээ бичсэн хаяавар нь зохисгүй бол, гол үгтээ нөлөөлөх тул сайн анхаарах хэрэгтэй юм. Хаяаврыг өмнөх хаяавар, хойнох хаяавар гэж хоёр төрөлд хувааж болно. Өмнөххаяавар гэдэг бол гол үгийн зүүн талд бичигддэг тэр хаяаврыгхэлж байна. Ийм өмнөх хаяаврын агуулгад, тухайн бичвэрийг хаанаас, юунаас бичсэн, тухайлбал, ямар хүний, ямар билиг сургаалаас хичээнгүйлэн бичсэн, ямар байгууллага нэгж, хувь хүнд зориулан хүргэсэн зэрэг агуулгыг илтгэдэг. Гэхдээуран бичлэг бүхэнд өмнөх хаяаврыг заавал бичих алба байдаггүй. Зарим уран бичлэг өмнөх хаяаваргүй байдаг. Хэрэв өмнөх, хойнох хаяаврын аль нэг нь байвал тэрхүү уран бичлэгийг дан хаяавартай уран бичлэг, дан хаяавартайбичээс гэж нэрлэдэг. Тэгвэл хойнох хаяавар гэдэг бол үндсэндээ нэрийн бичвэр юм. Хойнох хаяаварт тус бичээсийг бичсэн цаг, газар орон, бичээчийн нэр зэрэг агуулга багтдаг. Гол үгийн их бага,хаяавар бичих газрын бодит байдлыг нь үндэслэн өмнөх, хойнох хаяаврын үгийн олон цөөнийг харгалзан өмнөх, хойноххаяаврынхаа үгийн олон цөөнийг тогтоож болно. Хаяавар үгийн их багыг гол үгийн тигээс ялгаж багаар юм уу өөр тигээр бичдэг нь өдгөө бичгийн соёл болон хэлбэршин тогтсон байна. Хойноххаяаврыг гол үгийн эхнээс дундын нэг үгийн зай тавьж дорогш бичдэг уламжлалтай.
- **Тамга:** Тамга бол уран бичлэгийн зохиомж, байгууламжийн чухал бүрэлдэхүүн хэсэг мөн. Тамга бол уран бичлэгийн бүтээлийг “*Луу зурж нүдийг нь амлуулах*” мэт үйлдэл, нөлөө үзүүлдэг юм. Уран бичлэгийн бүтээлийн “*цагаан цаас*”, “*хар бэх*”, “*улаан тамга*” гурав харилцан нөхцөлдөн, нэгдээдүзэгч, сонирхогч хэрэглэгчдэд гойд сайхан урлагийн мэдрэмжийг хүртээдэг.Тодорхой нэгэн бүтээлд гол үг

ба хаяаврыг чанартай бичихээс гадна тамга дарах үндсэн ёсыг ч сайтар мэдэж эзэмшсэн байх нь уран бичээчийн нэгэн үүрэг болдог. Монгол уран бичлэгт хэрэглэдэг тамга нь ихэвчлэн *нэрийн тамга*, *хөтөлбөр тамга*, *бүслүүр тамга*, *дүрст тамга* зэрэг дөрвөн зүйлийн тамга байдаг. *Нэрийн тамга* нь бичээчийн хувь хүний мэдээлэл, овог нэр бүхий тамга байдаг. Нэрийн тамга нь сийлсэн үгийн онцлогоороо *улаан үгт буюугүдгэр тамга*, *цагаан үгт буюу хотгор тамга* гэж хоёр зүйл байж болдог. Хэрвээ нэг бүтээлд хоёр тамга хэрэглэхэд боллоо гэхэд нэг төрлийн тамгыг хоёр удаа дарах биш, хоёр төрлийн тамгыг нэг, нэг удаа дарж хэрэглэдэг уламжлалтай. Гоо зүй, уран сайхны талаасаа энэ нь зохимжтой байдаг бөгөөд дарахдаа хоёр тамгын дунд адагтаа нэг тамга дарах хэмжээний зай үлдээж дардаг. Өөрөөр хэлбэл хоёр тамгыг шахалцуулан дарж болдоггүй. Мөн түүнчлэн хоёр тамгыг хэрэглэхдээ их төлөв улаан үст буюу гүдгэр тамгыг дээр нь, цагаан үгт буюухотгор тамгыг доор нь дардаг. Хоёр тамгын дардасны хэмжээний их бага нь адил буюу адилавтар байхыг шаарддаг. Энэ нь бичгийн соёлын нэгэн илэрхийлэл болдог. Дардасны хэмжээний их, бага нь зөрөөтэй тамгыг хамт цугт нь дарахыг аль болох цээрлэнэ. Нэрийн тамгыг хойнох хаяаврын хамгийн сүүлчийн үгийн эгц доор талд нэг тамгын зайтай дарах буюу баруун талд нь зэрэгцүүлэн дардаг. Нэрийн тамгыг нэг буюу хоёр дарах үес хамгийн сүүлчийн тамгыг тус бүтээлийн гол үгийн хамгийн сүүлчийн үгээс доор дарж болдоггүй соёлтой. *Хөтөлбөр тамга* гэдэг нь уран бичлэгийн бүтээлийн зүүн дээд тал дахь нэгдүгээр гол үгийн өмнө буюу нэг, хоёрдугаар гол үгийн дундуур дардаг эхний тамгыг хэлдэг. Хөтөлбөр тамгын хэлбэр нь босоо дөрвөлжин, зууван, дугараг, гурвалжин зэрэг янз бүр байж болох ба хэлбэрийн хувьд чөлөөтэй байдаг онцлогтой. Түүнчлэн хөтөлбөр тамга нь хотгор, гүдгэр тамгын аль ч байж болно. Тамгын агуулга нь уран бичээчийн бахархан дээдэлдэг үг хэллэг, билиг сургаал, шүтээн зураг дүрс зэрэг байж болно. Хөтөлбөр тамгыг гол үгийн бүх өндрийн гуравны хоёр хувиас дээш газарт дарах хэрэгтэй. Энэ нь хэтэрхий доор дарж болохгүй гэсэн үг болно. Хөтөлбөр тамгыг бодит байдалдаа тулгуурлан, хаана дарвал өнгө үзэмж, утга санаа, зохиомж бүтэцтэй нийцэх эсэхийг сайтар бодож тунгаасны эцэст тогтоож байгаад дардаг. Энэ бол үнэхээр хэрэгцээгүй буюу зохисгүй юм бол албан хүчээр, “дарахын төлөө дарах” гэж байж болохгүй гэсэн үг болно. Хөтөлбөр тамгыг дарахдаа гол үгээ бичиж дууссаны дараа бичээсээ хол газар өлгөж байж, зохиомжоо харж байгаад хаана нь дарахаа тогтоож байж дарвал зохино. *Бүслүүр тамга* гэдэг бол өнцөг дарах тамга юм. Зарим уран бичлэгийн бүтээлд нэрийн тамга ба хөтөлбөр тамгыг аль алиныг нь дарсан боловч, хэрэв тухайн бичлэгийн талбайн зарим газар нь хоосон мэт харагдах, санагдах үед бүслүүр тамга дарж нөхвөрлөдөг юм. Ийм үүрэг зорилгод нь тулгуурлан бүслүүр тамгыг бас *нөхөх тамга* ч гэж хэлэлцдэг уламжлал Өвөр Монголын уран бичлэгийн хүрээнд хэвшин тогтжээ. Бүслүүр тамгын агуулгад бичээчийн эх нутгийн нэр хийгээд арван хоёр эш эрхтний

дүрс байдаг. Бүслүүр тамгын дардас нь хөтөлбөр тамгын дардаснаас бага байх ба их төлөв дугараг юм уу дөрвөлжин хэлбэртэй байдаг. Бүслүүр тамгыг уран бичлэгийн бүтээлд, ер нь онцгой байдал л үл гарах аваас цөөн хэрэглэдэг зарчимтай. *Дүрст тамга* гэдэг бол үг юм уу бичиг сийлдэггүй, хадны зураг, амьтны дүрсийг сийлсэн байдаг нэгэн зүйл тамга болно. Үүнийг бас *зурагт тамга* буюу *хүрээт тамга* гэж нэрлэдэг. Монгол уран бичлэгийн урлагийн хөгжилтэй уялдан одоогийн олон монгол уран бичээч уран бичлэгийн бүтээлдээ өөрийн бахархаж, биширдэг зураг, амьтан, бурхны хөрөг зэргийн дүрст тамгыг хэрэглэх болсон байна. Бичээч өөрийн хүсэл сонирхол, бичлэгийн хэв байдал, дүр төрх зэрэгтээ тулгуурлан дүрст тамгыг сонгон, уран сайхны ур маягийн үүднээс хэрэглэж болно. Тамга дарахад *Тамгын будаг (тос)* их чухал. Тамганытос будгийн сайн, муу нь тамга ба тухайн бүтээлийн чанар чансаа, уран сайхан, гоо зүй, туурвил зүйн сэтгэлгээг нь хүлээн авах, ойлгох зэрэг хэрэглэгч, сонирхогчдод нөлөөлдөг тул уран бичлэгт хэрэглэх тамгын будгаа сайтар бодож байж сонгох шаардлагатай болдог. Уран бичлэгийн тамганд албан хэрэгт хэрэглэдэг тамганы будаг, тосыг хэрэглэж болдоггүй соёлтой. Өнөө цагийн уран бичээчид уран бичлэгийн тамгандаа бичлэг зурагт хэрэглэж ирсэн уламжлалт шаазан савтай будгийг хэрэглэх хэрэгтэй. *Тамганы дэвсгэр* гэж бас нэгэн чухал ойлголт уран бичлэгийн урлагт байдаг. Уран бичлэгийн бүтээлд тамга дарахдаа бичээсний цаасны доор талд, тэгш юм дэвсэх аваас тамганы дардас нь тод гардаг талтай. Тэгвэл уран бичлэгт тамга дарах үед бичлэгийн цаасны доор дэвсдэг энэхүү эдийг *тамганы дэвсгэр* гэдэг. Тамганы дэвсгэрт харимхай чанартай жиопи эдийг дэвсвэл сайн байдаг. Энэ зүйл нь тэгш зөөлөн бөгөөд харимхай чанартай байдаг тул тамганы дардас цэвэр тод гардаг. Аливаа уран бичлэгийн урлагт *Тамга дарах* гэдэг нэгэн үйл явц байдаг. Тамгаа уран бичлэгийн цаасандээр дарах үес юуны өмнө тамгын нүүр талыг цэвэрлэх хэрэгтэй. Учир нь зарим тамгыг хэрэглээгүй удсанаас болж үгийн зурлага, зураг дүрс нь баларсан байдаг. Тиймээс тамгаа сайтар цэвэрлэсний дараа, тамгын бичиг зураг зэргээ сайтар шалгасны хойно, гараараа хүчтэй дарж зүүнш, баруунш, дээш доргош хөдөлгөн, хөнгөхөн өргөж, цааснаас аажим алгуураар салгадаг. Энэ бүхэн нь магадгүй энгийн ойлголт мэт боловч, уран зураг, уран бичлэг зэрэг зураасан зураг, бичгийн урлагийн хүрээндээ нэг талаас гоо зүйн, нөгөө талаас ажилдаа хариуцлагатай хандаж буй илэрхийлэл зарчим болдог тул ийн нарийвчлан авч үзэж байгаа юм.

МОНГОЛ УРАН БИЧЛЭГИЙН ХЭРЭГЛЭЭ, СУРАХ АРГА БАРИЛ

Монгол уран бичлэг нь хэрэглээний хувьд ямар ач холбогдолтой байдаг вэ? гэдэг бол чухал асуудлыг нэг мөн. Монгол уран бичлэг бол монгол үндэстний туурвил зүйн сэтгэлгээ, уран сайхны сэтгэлгээ, гоо зүйн үнэлэмжийн тод илрэлийн нэг бөгөөд, үгийнурлагийг мэдрэх мэдрэмжийг хөглөж өгдөг, хүний сэтгэлийг хөдөлгөн баясгадаг өвөрмөц онцлогтойн дээр, сурган хүмүүжүүлэх, ухааруулах, бичгийн урлагийн болон уран зургийн

мэдрэмж, танилтыг хөгжүүлэхэд чиглэсэн уламжлалт өв соёл, нийлэг урлагийн нэг төрөл болох юм.

Монгол уран бичлэг нь юуны урьд хүмүүсийн мэдлэгийг тэлэх, оршин буй зүйлийн гоо сайхныг олж харах чадвартай болгох, боловсруулан хөгжүүлэх нөлөө үзүүлдэг. Учир нь уран бичлэг нь зөвхөн бичлэгийн ур чадварын илрэл төдий биш, хэлний боловсрол, тооны ухааны мэдлэг, зурж төлөвлөх, дуу бүжиг хийгээд урлагийн олон талын мэдлэг, мэдрэмжийн илрэл болдог учраас сонирхогч, үзэгч олон нийтийг тэгж хөгжүүлдэг байна.

Хэрэв сайн, зөв зохиомж боловсруулалт бүхий бичгийн уран дүр бүтээсэн уран бичлэгийг бичье, бүтээгэвэл наад захдаа уран зургийн гярхай хурц хараа, мэдрэмжтэй, цаашлаад уран зураг сайн зурж чаддаг авьяас билигтэй, үгийн урлаг, шүлэг холбооны талаар мэдлэгтэй, байх хэрэгтэй болдог. Иймээс уран бичлэг нь зөвхөн хүмүүсийн бичлэгийн ур авьяасыг сайжруулах төдий хэрэгцээтэй биш гэдэг нь тодорхой мэдэгдэж байна.

Түүнчлэн уран бичлэг нь үзэгч, сонирхогч, олон нийтэд гоо зүйг мэдрүүлж байгаа талаасаа тэдний бие сэтгэлийг тайтгаруулан, үзэл санааг нь ухаарал, бясалгал бодролоор тэлж өгөх хэрэгцээтэй байдаг. Зарим судлаач эрдэмтэд “Уран бичлэгт шамдагсдын зүрхний тамир нь сайн байдаг гэдэг. Учир нь хүмүүсийн сэтгэл санаа баясангуй, анхаарал төвлөрсөн үед сэтгэхүй хөгжингүй болж бүтээлч чадвар нэмэгдэж шинийг үүдэн бүтээдэг”¹⁷ гэж үнэлсэн байдаг. Түүгээр ч үл барам “Зөв мөртөө сайхан бичих нь нэг хүний нарийн хянамгай, төв голч зан чанар ба хариуцлагатай оврыг далдаар илтгэхийн дагуу хүмүүст гоо сайхны хүртээл олгодог”¹⁸ гэж тодорхойлсон байдаг.

Энэ мэт уран бичлэгийн талаарх онолын судлал, судалгаа шинжилгээний үр дүнд тулгуурлан, уран бичлэгийн хэрэглээ ба сурах аргын тухайд дараах хэдэн талтай холбогдох болов уу хэмээн үзэж, доорх үзэл баримтлалыг дэвшүүлж байна. Үүнд:

Нэгд, Уран бичлэг сурч, улмаар түүнийг хэрэглэж, үүдэн бүтээх нь өнөө цагийн нийгмийн амьдрал ба бичгийн соёл, бичгийн урлагийн хөгжлийн үндсэн шаардлага мөн. Монгол хэл, монголүндэсний бичиг бол бидний өдөр тутмын ажил үйл, хичээл ном, хөдөлмөр зүтгэл, амьдрал үйлстэй салшгүй нягт харьцаатай байдаг билээ. Нийгмийн амьдрал ба нийгмийн соёлын түвшин хийгээд урлагийн төрөл зүйлүүдийн салан тусгаарлалын ба нийлэгжлийн үйл явц хурдтай өрнөж, хөгжиж, өөрчлөгдөн байгаа өнөө үед, монгол уран бичлэг ч улам гүнзгийрэн хөгжиж, улам түгээмэлжихийн хэрээр түүнээс үзүүлэх нөлөө, үйлдэл нь, бичгийн урлагийн гойд сайхан шинжээрээ нийгмийн оюун санаа, хөгжил дэвшил, боловсон соёлын бүтээн байгуулалтад эерэг байдлаар үйлчилж, сэтгэлгээг гүнзгийрүүлж байна.

¹⁷ Дэгжилт “Монгол уран бичлэгийн үндсэн мэдлэг”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо”, 2018 он.

¹⁸ Д.Цэрэнбат “Монгол уран бичлэгийн жолоодомж”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо”, 2001 он.

Хоёрт, Уран бичлэг нь үсэг бичигт суурилсан гоо сайхны таашаал бүхий зураасны урлаг юм. Энэ талаасаа уран бичлэгийн гоо сайхны өртөг нь нарийн гүн агуулгатай юм. Уран бичлэгийн хэлбэр зохиомжийн гоо сайхан, бичсэн эхийн агуулга, бийр бэхийн нэгдэл зэрэг нь уран бичээчийн соёл боловсрол, урлагийн чанар, үзэл санаа шингэсэн бүтээлч чанартай оюуны ажиллагаа мөн болохоор, үзэгч олон нийтэд оюуны таашаал мэдрүүлж, сэтгэлийг нь баясгаж, харааны сэрлийг нь хөгжүүлж, баярлангуй атлаа нам тайвуу зан чанартай болгодог. Тэгэхээр уран бичлэг нь нийгэм олон нийтэд сургаал сэхээрлийг олгодог байна. Урлаг нь бүхэлдээ гоо сайхны эрэлхийлэл болох тул, уран бичлэгийн урлаг ч мөн адил гоо сайхны мэдрэмжийг түгээж байгаагаараа нийгэм олон нийтийг хүмүүжүүлэх нөлөө тусгалтай байдаг байна.

Гуравт, Бийрээр уран бичлэг бичих, уран бичлэг бичиж сурч боловсрох үед арга зөв, сэтгэл төвлүүн, хөдөлгөөн тааламжтай бол бие махбодын эрүүл чийрэгт ашиг тустай байдаг. Бийрийн бичлэг нь амьсгалын хийгээд олон зүйл тамирын хөдөлгөөнтэй адилавар онцлогтой, чадвартай, нөлөөтэй байдаг. Уран бичээч нар, ер нь баялаг сайхан оюуны амьдралтай байж, сэтгэл санаа төвлүүн тогтуун, үзэл санаа зоригоор уужуу тайвуу байдаг тул олон зүйлийн сэтгэл санааны тээр дарааснаас ангижирч, урлагийн уудам хорвоод чөлөөтэй зорчин байдаг. Энэ нь тэдний урт наслахын бас нэгэн чухал учиг болж байгаа юм.

Дөрөвт, Аливаа үндэстний уран бичлэг, тэр тусмаа монгол үндэстний бүтээсэн монгол уран бичлэг нь улс үндэстнийхээ утга соёл, уран сайхны сэтгэлгээ, туурвил зүй, нийгэм гоо зүйн үнэлэмж шингэсэн түүхэн дэх өвөрмөц бүтээгдэхүүний нэг байж ирснээрээ, улс үндэстнийхээ бичгийн соёл, хэл бичгийн шинжлэх ухаан, уран сайхны сэтгэлгээний өсөлт дэвшил, туурвил зүйн сэтгэлгээний гүнзгийрэл, нийгэм нийтийн гоо сайхны мэдрэмжийг дээшлүүлэхэд чухал ач холбогдлоо үзүүлсэн юм. Өдгөө цагийн монгол уран бичлэг нь ч үндэстний уламжлалын үнэт зүйл, хөгжил дэвшлийн шинэчлэлт сэтгэлгээг агуулсан, монгол үндэстний уламжлалт бичгийн соёлын чухал өв болж байгаа билээ. Ялангуяа уламжлалт бичгийн энэ нандин соёл урлагаа хойч үеийнхэндээ залгамжлуулах нь ач холбогдолтой үзэгдэл болох юм. Хүүхдэд бага наснаас уран бичлэг сургах нь зөвхөн үндэстний бичиг соёлоо мэдэх төдий биш, зөвхөн бичгийн тигийг нь сайхан болгож байгаа учир биш, ерөөс тэдний уран сайхны сэтгэлгээ, үсэг үгээр хэлэх гэсэн санаа, дотоод сэтгэлийн далд мэдрэмжээ илэрхийлэх, урлагийн танин мэдэхүй, гоо зүйн боловсролыг нь дээшлүүлэх, оршин буй үзэгдэлд агуулагдаж буй нууц, далд чухал шинжийг харах, таних чадвартай болгон төлөвшүүлэхэд суурь болж байгаа юм.

Тавд, Өнөө цагийн нийгмийн хөгжил дэвшил, ахуй амьдралын өсөлт, техник технологийн хурдац зэрэг олон хүчин зүйлийн нөлөөгөөр, монгол уран бичлэг нь нийгэм олон нийтийн аж төрлийн өдөр тутмын хэрэглээний нэгэн соёл нь болж хэвшиж байна. Өдөө монгол уран бичлэг нь ном сэтгүүлийн нэр, гарчиг, ханын сонин, хос уянга, дурсгалын бичээс, чулуун хөшөөний бичээс, пайз тэмдэг, гэр өрөөний засал чимэглэлээс авхуулаад уран бүтээлийн үзэсгэлэн дэлгэцийн бие даасан нэгэн үзмэр-урлагийн бүтээл болж чадсан нь,

монгол уран бичлэг өөрийн хэрэглээний үйлдлээ бадруулсаар байгаагийн бодит баталгаа нь болж байна.

Энэ бүхэн нь Монгол үндэстэн өөрсдийн бүтээн буй болгосон үндэсний бичгээрээ эртнээс аваад өдгөө болтол тасралтгүйгээр, монгол уран бичлэгийнхээ өвөрмөц онцлогийг хадгалан, уламжлуулан залгамжлуулж, шинэчлэн баяжуулж хөгжүүлж ирсэн гайхамшигтай түүхийг харуулж байгаа юм. Ийм учраас, хэмжиж болшгүй гүн, мацаж дийлшгүй өндөр, өгүүлэхүйеэ бэрх уран энэ холбоос уран бичлэгийн жинхэнэ ур чанар, юуг бичих, яаж бичих, юуны тулд бичих гэх зэрэг асуудлууд нь уран бичээчийн ухамсарлан шийдвэрлэх ёстой нэгэн шалгуур нь болдог юм. Нөгөө талаар энэ асуудал нь, уран бичлэгийн хэрэглээний үнэ цэнийг зөвөөр ойлгох, зөвөөр ухааруулах хэрэгтэй гэсэн томоохон асуудал болдог юм. Энэ асуудал нь *Бичээчийн биеийн байдал, Бичээч бичгийн хэрэгсэл, бийр бэхсээ барих, Бийрээ дэвтээх, бэх идүүлэх, бийр шилэмдэх, Бийрийн бичлэгийн мэргэжлийн ур чадвар* зэрэг биеэ даасан элементүүдийг агуулсан нэгэн тогтолцоог бий болгодог юм.

Аливаа уран бичлэгт суралцаж, түүнийг сурч эзэмшинэ гэдэг нь урт хугацааны хатуу, шаргуу хичээнгүй хөдөлмөр, нягт нямбай хандлага шаардах үйл явц байдаг. Эхлээд сонин, содон, өвөрмөц атлаа уран бичлэгийн ур чадал, авьяас билгийг мэдрүүлсэн, зохиомж байгууламж, гоо зүй, бичигдсэн утга санаа, агуулгын тэгш зохицол бүхий бичээсийг дуурайж бичүүлдэг. Энэ нь уран бичлэгт анх суралцагчдад бичгийн урлагийн амтанд орох, уран сайхны сэтгэлгээгээ хөгжүүлэх үндэс суурь болдог зайлшгүй гүйцэтгэх ёстой сонголт болно.

Уран бичлэг анх сурч буй хүмүүс, юуны өмнө өөрт таалагдсан, өөрийн бахархан дээдэлдэг уран сайхан, шилдэг бичлэгийн тигийг сонгон, түүнийг өөрийн мэдлэг оюун танин мэдэхүйгээрээ нарийн нягтлан шинжиж байж дуурайн бичих ёстой. Ийн бичихийн учир нь үг, үсгийн бүтэц, зохицол, бийрээр хэрхэн бичдэг, бичгийн үндсэн зурлагыг яаж урладаг, хэрхэн шийдвэрлэдэг зэрэг олон асуудалтай өөрийн нүүрээр учирч буй үйл явц болох юм. Мэдээж анх сурагчдад бэрхшээл, хүндрэл бага бус тохиолдох нь дамжиггүй. Зөвхөн бийрээ зөв барих, бийрээ хэрэглэх арга ухааныг сурч мэдэхэд л нэлээд цаг, хүч хэрэгтэй болдог. Энэ мэт хэрэглээ, гүйцэтгэлийн практик шинж бүхий асуудлуудаас дээр томьёолсон уран бичлэг гүйцэтгэлийн тогтолцооны элементүүд гарч ирэх ба эдгээрийг нарийвчлан авч үзэх нь зүйтэй.

Нэг. Биеийн байдал

Бичиг зохиолын ямар нэгэн эхийг, зөв сайхан, уран сайхны мэдрэмж, урлаг, гоо зүйн сэтгэлгээ шингээн уран бичлэгээр бичихийн тулд нэн түрүүнээ бичээч өөрийн биеийн байдлаа анхаарч, сайтар бэлтгэх хэрэгтэй. Энэ нь бичлэгийн сайн муу болох, зөв сайхан болох, уран сайхны туурвил зүйн сэтгэлгээгээ хэрхэн илтгэх зэрэг онол практикийн асуудлуудтай шууд харилцаа холбоотой байдаг. Бичгийн мэргэд *“Бие тэгшихэн бол бийр тэгш, бийр тэгшихэн бол үг, үсэг тэгш”* гэдэг билээ. Үсэг, үгийг бичихдээ бие тэгш, сэтгэл намжуун, амьсгал тогтуун, харцаа бийрийн үзүүрт төвлөрүүлж,

анхааралтай байж чадвал сайхан бичиж чадах юм. Уран бичлэг бичих биеийн байдлыг сууж бичих ба зогсож бичих гэсэн хоёр зүйл хуваадаг.

- *Сууж бичих* гэдэг нь цаасаа ширээн дээр дэлгэж, ширээний өмнө сууж байгаад бичихийг хэлнэ. Үүнд толгой тэгшхэн, бие эгц, гар эвтэй, хөл тогтуун байх хэрэгтэй. Толгой тэгшхэн гэдэг нь бичих үед толгойгоо өмнөшөө бөхийлгөсхийж, ширээний нүүрээс нэг тохой орчим зайтай байлгахыг хэлнэ. Толгой тэгш, хүзүү сээр эгц, бичих үгдээхарцаа, анхаарлаа төвлөрүүлсэн байх хэрэгтэй. Ингэж чадвал бичсэн үгээ зөв, тэгш олж харах ба жигд тэгшээр бичиж чадах бөгөөд удаан бичсэн ч нүдэнд хоргүй юм.
- *Бие эгц* гэдэг нь хоёр мөр тэгшхэн, цээж тэнүүн, нуруугаа тэнийлгэн, лавсайхан суухыг хэлнэ. Үүнд цээж ба ширээний хооронд нэг нударгын орчим зайтай байлгах хэрэгтэй. Нуруугаа хэт бөхийлгөж ширээтэй наалдаж болохгүй. Бие эгц бол амьсгалахад харш саадгүй, чичирхийлэл үүсгэхгүй байх боломжийг бүрдүүлдэг. Удаан бичсэн ч ядрал багатай байдаг нь биеийн эгцээс хамаардаг.
- *Гар эвтэй* гэдэг нь баруун гараар бийрээ барьж, зүүн гараар цаасаа дарж, цаг ямагт бичлэгийн шаардлагаар солин шилжүүлж тохируулахад хөнгөн, хурдан байхыгхэлж байна. Хоёр гараа эвтэй байлгавал бие ядрахгүй, бичлэгийн явцад хүндрэлгүй, бичлэг шулуун сайхан болдог.
- *Хөл тогтуун* гэдэг нь хоёр хөлөө газар дээр эвтэйхэн тавьж, тайвуу тэгшхэн байлгахыг хэлж байна. Өсгий өндийх буюу хөлөө жийж, хөлөө солбицуулж суувал зөв тогтуун биш болж, бүх биеийн суух байдалд нөлөөлсний улмаас, уран бичлэгийн гүйцэтгэл, үр дүнд сөргөөр нөлөөлөх боломжийг бий болгодог.
- *Зогсож бичих*. Зогсож бичих нь хоёр зүйл байна. Нэг нь цаасаа ширээн дээрээ дэлгэж ширээний өмнө зогсож бичихийг хэлж байна. Нөгөө нь цаасаа тусгай зориулалтын тавцан, самбар, тавиур, ханан дээр өлгөөд хажууд нь зогсоод бичихийг бас хэлнэ.
- *Ширээний өмнө зогсоогоор бичих* гэдэг бол хоёр хөлөө аяндаа салгаж, зүүн хөлөө бага зэрэг өмнөш тавин, толгой ба дээд биеэ мэхийлгэж, цаасаа харан, зүүн гараар ширээгээ түшиж, баруун гар ба тохойгоо өргөж бичихийг хэлж байна. Энэ мэтээр хөл гар, толгой ба биеэ эвтэй зохицуулбал дээрээс бүх бичлэгийг ажиглаж, бичлэгийн их бага, бүдүүн нарийн, тэгш жигдийг тэнцүүлэхэд маш тустай юм.
- *Цаасаа өлгөж бичих* гэдэг нь бичлэгийн орон байр нь босоо болсноос биеийн байдал ч аяндаа дагаж хувирах хэрэгтэй. Бичих явцад нүдний харцаар тавцанд өлгөсөн цаас болон биеийн хоорондох зайг эвтэй тохируулахын хамт, дээш дорogшоо бичиж шилжихийг хоёр хөлийн жийлт ба нугаралтаар тэнцүүлнэ. Нөгөө талаар бэх дүрэх хэмжээгээ тохируулах хэрэгтэй. Хэрэв хэтэрвэл бэх дорogш урсах буюу дуслах явдал гарна. Зогсож бичих нь бичлэгийн хүнд хэлбэрт ордог тул бичээчээс нэлээн ур чадвар, мэдлэг мэргэжил шаардана. Зогсож бичсэн уран бичлэг тооны хувьд цөөн байдаг нь үүнтэй холбоотой.

Хоёр. Бийр барих

Уран бичлэгт, тухайн бичлэг гоо зүй уран сайхны төгс зохицолтой, зөв сайхан болох эсэх нь бичээч бийрээ хэрхэн барьж бичсэнээс ихээхэн хамаардаг. Тийм учраас бийрийн зөв барилт анх сурагчдын заавал, сайтар сурч эзэмших ёстой үндсэн гол элемент болох юм. Бийрийн зөв барилтаас бичээчийн ур чадварын илэрхийлэл, алс ирээдүйдээ улам мэргэших, өсөн сайжрах зэрэг олон хүчин зүйл хамаарна. Бийр барихад эрхий хуруу, долоовор хурууны өндгөөр бийрийн ишийг хавчиж, дунд хурууны өндгөөр дотогшоо хумин, ядам хурууны хумсны угаар гадагшаа түлхэж, чигчий хуруугаа ядам хурууны доор талд аяндаа наалдуулж хавсруулна. Бийр барихад доорх хэдэн талыг анхаарвал зохино.

- *Таван хуруугаа бүр эв зүйтэйгээр тогтсон оронд тавьж байгаад, бийрийн ишээ барих бөгөөд гарын алгаа өндөг атгасан мэт хөндий байлгана.* Ингэж барьсан бийр лав тогтуун, бичих үед уран амьдлаг явуулж чадна.
- *Бийрийн иш цаастайгаа эгц, гарын бугуйгаа цаасны нүүртэй зэрэгцээ байлгана.* Ингэвэл бийрийн иш эгцхэн, үзүүр нь мөн эгц болж, гарын алга цаастай дөчин таван градусын өнцөг үүснэ. Бийрийн үзүүр нааш цааш хөдлөхөд маш амьдлаг соргог чөлөөтэй байдаг.
- *Бийрээ атгахдаа чанга сулыг тэнцүүлэх хэрэгтэй.* Их хэвийн буюу том хэмжээгээр үг бичих бол бийрээ бага зэрэг сул атгана. Гэхдээ хэтэрхий сул бол бийр явуулахад хүчгүй болох тул тохируулах шаардлагатай. Бага хэмжээ бүхий үг бичихэд бийрээ чанга атгана. Мөн хэтэрхий чанга бол хуруу, бугуй хөшүүн болж, бийрээ эргүүлэхэд хэцүү болж, энэ нь бичлэгийн гүйцэтгэлийн үр дүнд сөргөөр нөлөөлж болно.
- *Бийрээ барихдаа, бийрийн ишийн дээр юм уу доороос барихыг мэдрэмжээрээ тохируулах хэрэгтэй.* Энгийн байдлаар сууж байгаад, бага юм уу, дунд зэргийн хэмжээгээр уран бичлэг бичлээ гэхэд бийрийн ишийн доор хэсгээс барьдаг. Харин том хэмжээгээр эх бичихэд бас гүйлгэн, таталган бичлэг бичихэд бийрийн дээгүүр баривал эвтэй байдаг. Ер нь бийрээ дээгүүр баривал бугуй эргүүлэхэд чөлөөтэй, доогуур баривал тогтуун байдаг онцлогтой.

Гурав. Бийр дэвтээх, бэх идүүлэх, бийр шилэмдэх

- *Бийр дэвтээх:* Шинэ бийрийг хэрэглэх үед эхлээд бүлээн усанд бийрийнхээ үзүүрийг зөөлөртөл дэвтээн, үсэн дээрх цавууг нь угаан цэвэрлэнэ. Ингэхдээ хэт халуун усанд дэвтээвэл бийрийн үс атирч, хорвойх буюу бийрийн үзүүр гэмтдэг тул, үүнээс сэргийлж усаа зөв тааруулах шаардлагатай. Дэвтээсэн бийрийн үзүүр зөөлөрсний дараа, үсэнд шингэсэн усыг нь сайтар шувтарч үзүүрлэх хэрэгтэй.
- *Бэх идүүлэх:* Дэвтээж үзүүрлэсэн бийрээ зууруулд дүрж, бэхийг идүүлэхдээ хэмжээг нь сайтар тохируулах хэрэгтэй. Урьдаар бийрийн бүх үсийг бэхэнд дүрж, бэх идүүлээд, торгон цаасан дээр сайтар шимтгэж авсны дараа, бийрийн 1/2 хэсэгт бэхийг идүүлж хэрэглэвэл

зохистой байдаг. Энэ бол бага хэмжээгээр эхийг бичих үед тохирно. Хэрвээ дунд, том хэмжээгээрхийг бичих бол бийрийн бүх үсийг бэхэнд дүрж, бэхээ сайтар тохируулна.

- *Бийр шилэмдэх:* Энэ бол дэвтээсэн бийр буюу нэгэнт бичиж байгаа бийрийн үзүүрт нэг талаараа бэх идүүлж, нөгөө талаараа бийрээ үзүүрлэхийг хэлж байгаа болно. Бийрээ сайтар үзүүрлэж чадсан эсэхээс бичлэгийн яс чанар, үсэг, үгийн сайхан муухай, гарын тигийн хэв маяг шууд хамаарах учраас, бийрээ нягт нямбай шилэмдэх ёстой. Бийр барьсан баруун гарын алгаа дээшээ хандуулсаар бийрийн иш аяндаа зүүнш хандаж хэвтээ байдалд орно. Энэ үед эрхий хуруугаар бийрийн ишийг дээд талаас нь хөнгөн дарж, долоовор хуруу ба дунд хуруугаар гадар талын доор хажуугаас өргөн, ядам хуруу ба чигчий хуруугаар дотор талаас нь түшнэ. Иймэрхүү байдалтай бийрээ хэвтээгээр зуруул дээр тавьж, ахин дахин шүргэн урвуулж хөрвүүлж шилэмдэнэ. Энэ мэтээр хэд хэдэн удаа шилэмдэж, бийрт шовх үзүүр гарсны дараа, бийрээ босгож үгээ бичнэ

Дөрөв. Бийрийн бичлэгийн мэргэжлийн ур чадвар

- *(Нэг) Бийрийн бичлэгийн өнгө онцлог, урлагийн шинжэ:*

Бийрийн бичлэгт өнгө онцлог, хэв маяг, урлагийн шинжээ гүйцэд илэрхийлье гэвэл бийрээ зөв хэрэглэх ёстой. Бийрийг хийсэн эдийн бүтэц, түүний үзүүрийн зөөлөн бөгөөд уян хатан онцлог зэргийг ойлгон мэдэж, сурч боловсрох явцад бийр хэрэглэх мэргэжлийг эзэмшинэ. Анх бийр барьж үг, үсэг бичихэд гар чичрэх буюу маш хөшүүн санагдаж, бийр нь ер санаагаар хэрэглэгдэж өгөхгүй, бичсэн үг, үсэг ч мурий зөрүү юм уу, эсвэл бүдүүн нарийн нь тэнцвэргүй болж байдаг. Гэвч санаа тавьж мэрийн сурвал удалгүй хэвшиж үг үсгийг сайхан бичиж чадна. Бийрийн бичлэгийн өнгө онцлог, уран сайхны шинжид *бийр эхлэх, бийр явуулах, бийр хураах, бугуй хөдөлгөх, бугуй дэрлэх, бугуй ба тохойгоо өргөх* зэрэг элемент чухал үүрэг гүйцэтгэдэг.

- *Бийр эхлэх:* Аливаа үг, үсгийг бичих үед, өргөсөн бийрийн үзүүрээ цаасанд анх тулган, нэг үсгийн хамгийн эхний нэг зурлагаас эхэлж бичдэг. Бийр эхлэх нь нэг үсгийн эхлэлт буюу эсвэл нэг үсгийн доторх нэг зурлагын эхлэлт мөн. Эхний зурлагын бүдүүн нарийн, хэлбэр шинж нь дорогшоо бичих хэмжээ баримжааг тогтоодог. Бийр эхлэхэд ямар байх нь нэг үг, нэг үсэг, нэг мөр, цаашлаад нэг хуудас бичлэгийн зөв оновчтой эсэхэд нөлөөлдөг. Тиймээс бийр эхлэхдээ сайтар хичээж, их бага, өргөн нарийныг оновчтой хадгалж бичих хэрэгтэй.
- *Бийр явуулах:* Бийр явуулахад бийр эргүүлэх ба нугалах, бийрийн өргөлт ба даралт, бийрээ дарсхийх, зогсосхийх, өргөсхийх зэрэг мэргэжлийн ур чадвар багтана. Монгол бичиг бол босоо хэлбэртэй бичиг. Босоо бичигт үгийн нурууг тэгш, эгц гаргах нь хамгийн чухал юм. Анх сурагч нар нэг доор, шууд энэ арга, мэргэжлийн ур чадварыг эзэмшиж чадахгүй хэдий ч, зохих сургалтын явцыг гүйцэтгэснээр аяндаа сурч төлөвшдөг.

- **Бийр хураах:** Бийр хураах гэдэг нь бийрээ тулгаснаас эхлээд нэг бүтэн үгийг, нэг үгийн үсгийг, нэг үгийн саланги дагаврыг бичиж дуусаад, бийрээ өргөж авах бичлэгийн гүйцэтгэлийн үйл явц байдлыг хэлж байна. Энэ нь аливаа үсэг ба дагавар үгийн эцсийн зурлагыг бичиж төгсгөх явцыг л зааж байгаагаас нэг үгийг бичих явц дундаа бийр өргөхөөс ялгаатай юм. Монгол бичиг бол босоо бичиг учраас үг бүхэн нь толгой, бие, сүүлтэй. [эхэн, дунд, төгсгөлтэй] Иймээс үгийн эцсийн зурлагыг сайхан бичээд бийрээ зөвөөр хураах нь бүхэл үгийн урлагийн чанарт зохих нөлөө үзүүлдэг юм. Ер нь бийрээ хураахад огцом таталж хураах биш аажим сайхан хураах хэрэгтэй.
- **Бугуй хөдөлгөх:** Бийрийн бичлэгт бугуйн хөдөлгөөн нь тухайн уран бичлэгийн гүйцэтгэлийн үр дүнд нэлээд нөлөөлдөг учраас энэхүү ёс учир, ур чадварыг эзэмшихгүй байж болохгүй. Анх сурч буй хүн, бийрээ зөв барьсны суурин дээр үгийн зурлагын дэс дараагаар бийрээ явуулах ба ингэхдээ бугуйгаа эвтэйхэн хөдөлгөж сурна. Бугуй хөдөлгөх үед үгийн зурлагын шаардлагаар бийрийн үзүүрээ өргөх ба тавих, явуулах ба зогсоох, түлхэх ба татах, эргүүлэх зэргээр бийрээ явуулах явцад бугуйн хөдөлгөөнөө мэдрэмжээрээ эвтэйхэн зохицуулах ёстой. Том хэмжээгээр үг бичих үед бугуйн хөдлөх нь их байдалтай байх бол, бага жижиг хэмжээгээрүг бичихэд бугуйн хөдөлгөөн нь харьцангуй бага байдаг. Бугуйгаа бичлэгийн шаардлагаар хөдөлгөж сурах нь уран бичлэг зүй зохистой болохтой шууд хамааралтай байдаг.
- **Бугуй дэрлэх:** Бугуй дэрлэх гэдэг нь бугуйн нэгэн хөдөлгөөн бөгөөд уран бичлэг анх сурч буй хүн хэрэв жижиг, дунд хэмжээгээр үг бичихэд хэрэглэх арга,техник юм. Жижиг хэмжээгээр үгбичих үед гарын бугуйгаа ширээн дээр наалдуулж бичих нь бугуй дэрлэх үйл явц болно. Харин дунд хэмжээгээр үг, үсэг эх бичих үед бугуйгаа жаахан өргөсхийж бичих нь мөн бугуй дэрлэх хөдөлгөөн болно.
- **Бугуй ба тохойгоо өргөх:** Бийрийн бичлэгт гүйлгэн, таталган бичлэг хийх, том хэмжээгээр үг, үсэг, эхийг бичих үед гарын бугуй, тохойгоо ямагт өргөж бичдэг. Ингэж өргөвөл сая бийрээ чөлөөтэйгөөр нааш цааш, эргэн тойрон эргүүлэх боломжтой болно. Тэгэхээр бугуй ба тохойгоо өргөх нь том хэмжээгээр үг, үсэг, эх бичихэд тохирдог бичлэгийн техник болж байна. Бугуй ба тохойгоо өргөж бичиж сурахад нэлээдгүй ур чадвар шаардагддаг. Бийр барьсан гар чичирхийлбэл, үг, үсэг, эхээ сайхан бичиж чадахгүй. Тиймээс тодорхой хугацааны хичээл зүтгэл, нягт нямбай сургалтын ажиллагааг дүүргэсний эцэст бичлэгийн энэхүү ур чадварыг эзэмшиж чадах юм.

МОНГОЛ ЗУУЧЛУУРЫН ХЭЛЭН ДЭХ АНГЛИ ЗЭЭЛЛЭГ ҮГИЙН
ХЭРЭГЛЭЭНИЙ БАЙДАЛ

(Монгол Улсын Засгийн газрын мэдээллийн сүлжээний жишээн дээр)

Мөшээл (БНХАУ, ӨМБИС, МСДС)

Бо.Мина (БНХАУ, ӨМБИС, МСДС)

Агуулгын товч: Тус өгүүлэл нь корпус хэл шинжлэлийн үүднээс Монгол Улсын Засгийн газрын сонин мэдээг эх хэрэглэгдэхүүн болгож, 200.000 үгийн сан бүхий хэлний материалын хөмрөг байгуулан, хөмрөгт гарч буй англи зээллэг үгийг үгийн аймаг, утгын төрөл, зээлсэн арга, толгой үг ба давталт зэргээр нь бүртгэхийн зэрэгцээ одоо байгаа толь бичгүүдтэй харьцуулж, монгол зуучлуурын хэлэн дэх англи зээллэг үгсийн хэрэглээний бодит байдлыг харуулахыг зорив.

Түлхүүр үг: Хэлний материалын хөмрөг, англи зээллэг үг, бодит хэрэглээ,

Хэл бүхэнд зохих хэмжээний зээллэг үг оршдог бөгөөд нэг хэл нь нөгөө хэлээсээ үг зээлэн хэрэглэх нь хэл бүхэнд байдаг түгээмэл үзэгдэл болно. Ажил мэргэжлийн хөгжил, даяаршил, соёлын хамтын ажиллагаа зэрэг олон талын үйл хэрэг, нөлөөнөөс харь хэлнээс үг зээлэх нь үгсийн сангаа өргөтгөх чухал арга зам болж байна. Англи зээллэг үг нь монгол хэлний үгийн сангийн судалгааны чухал судлагдахуун болсны хувьд, эрдэмтэд олон талаар анхаарлаа хандуулсаар иржээ. Зээллэг үгийн ухагдахууны талаар, Норжин нараас “Зээллэг үг бол монгол хэлний үгийн сангийн бүрэлдэхүүн нэгж болсон, үгийн санжсан утгатай харь хэлний үгийг хэлнэ. Жишээ нь Англи зээллэг үг гэвэл, англи хэлнээс гаралтай буюу англи хэлээр дамжиж зээлсэн англиас ирэлтэй үгийг заана” [1] гэв.

Зээллэг үгийн гарал ирэл ба толгой үгийн талаар, “Монгол хятад товчилсон үгс хийгээд зээллэг үгийн толь”-д хятад, төвөд, манж, түрэг, араб, орос, англи, герман зэрэг 28 хэлнээс монгол хэлэнд орсон 6000 илүү харь гаралтай үгийг оруулж, “CNN, IBM” товчилсон үг жич “информатик, кабин, трактордох” зэргийг багтаасан 520 зурвас англи гаралтай үгийг тэмдэглэсэн байна. [2].

Н.Балжинням “Одоо монгол хэлэнд англи, араб, грек, герман, латин, орос, перс, санскрит, төвөд, уйгур, франц, хятад, япон зэрэг 30 гаруй хэлний үг байна. Адил бус цаг үед өрнө дахины дорно дахины олон хэлнээс монгол хэлэнд орсон 3000 гаруй үгийг жагсаан оруулж, үүнд 204 үг орчим англи зээллэг үгийг тэмдэглэж, 6.80% харьцлыг эзэлнэ” [3] гэв.

Зээллэг үгийг монгол хэлэнд буулгах дүрмийн талаар, Норжин нараас англи хэлний зээллэг үгийг монгол хэлэнд янз бүрээр хөрвүүлэн буулгаж байгаа эмх замбараагүй байдалд чиглүүлэн, монгол хэлэнд хөрвүүлэн тэмдэглэхдээ монгол хэлний цагаан толгойн үсэгт буулган тэмдэглэх, дуудлага бичлэг хоёр талыг нь харгалзуулан тэмдэглэх, хятад хэлний авиагаар

дамжуулан тэмдэглэхгүй гэх гурван зарчмыг баримжаа болгоно гэж, улмаар зээллэг үг ба харь гаралтай үгийн ялгааг тодорхойлон өгөв. Иймээс монгол хэлний зээллэг үг нь хэлний хэрэглээний түгээмэл үзэгдэл болж зээллэг үгийн талаар урьдах хүмүүсийн судлал нэлээд амжилт олж, хойнох судлалдаа бат бэх суурийг тавьж өгсөн байна.

Нэг. Судалгааны материал

Монгол Улсын Засгийн газар нь Монгол улсын улс төр, аж ахуй, цэрэг дайн, эм эмнэлэг, шинжилгээ мэргэжил, иргэдэд үйлчлэх зэрэг олон талыг хамарсан ерөнхийлсөн чанартай сүлжээ нет болно. Энэ удаагийн судалгааны эх хэрэглэгдэхүүн нь Монгол Улсын Засгийн газар хэмээх сүлжээн мэдээ буюу <https://zasag.mn>-ий 2017 оноос 2023 он хүртэлх мэдээ болно. Эх хэрэглэгдэхүүнийг тоочлон бүртгэхэд 200.000 гаруй үгийн сантай байж, үүний дундаас 95 англи зээллэг үг олов. Материалын хөмрөгийн бүртгэлийн байдал доорх хүснэгт №1 мэт байна.

| Он | 2021 | | | | | 2022 | 2023 | | Нийт |
|-----------|--------|------|------|------|------|--------|--------|--------|------|
| Сар | 7 | 8 | 9 | 10 | 11 | 9 | 1 | 3 | |
| Толгой үг | 1994 | 2135 | 7303 | 9337 | 9325 | 35.009 | 61.349 | 79.015 | |
| Нийт | 30.093 | | | | | 35.009 | 140367 | | |

Хоёр. Монгол улсын засгийн газрын zasag.mn сайтад илэрсэн англи зээллэг үгсийн хэрэглээний задлалт

(Нэг). Үгийн аймаг:

Хөмрөгт нийт илэрсэн англи зээллэг үгээ үгийн аймгаар буюу жинхэнэ нэр, үйл үг, тэмдэг нэр гэх гурван төрөлд ангилж болно. Бүртгэлээс үзэхэд, жинхэнэ нэр хамгийн олон байх бол, дараа нь тэмдэг нэр ба үйл үг орж байна. Англи зээллэг үгээ үгсийн аймаг, толгой үгийн тоо, харьцлыг хүснэгт №2-т үзүүлэв.

| Үгийн аймаг | Жинхэнэ нэр | Үйл үг | Тэмдэг нэр |
|------------------|-----------------|-------------------------|------------------|
| Толгой үгийн тоо | 84 | 2 | 9 |
| Харьцал | 88% | 2% | 10% |
| Жишээ | Доллар (dollar) | Экспортлох (export+л+х) | Хелико (helical) |

(Хоёр) Утгын төрөл:

Хөмрөгт илэрсэн англи зээллэг үгийн утгын төрлийг 10 зүйлд ангилж болно. Тухайлбал, улс төр, аж ахуй, шинжлэх ухаан, сурган хүмүүжил, тамир урлаг, ахуй амьдрал, хэмжүүрийн нэгж, бусад гэх мэт. Утгын төрлийн хувьд, англи зээллэг үг нь голдуу ахуй амьдрал, шинжлэх ухаан, аж ахуй зэрэг хэдэн талаас ирэлтэй байна. Тоо баримт нь хүснэгт №3-т үзүүлсэн мэт байна.

| Утгын төрөл | Үгийн тоо | Харьцал | Жишээ |
|-----------------|-----------|---------|---|
| Ахуй амьдрал | 17 | 18% | Парк (park) |
| Аж ахуй | 16 | 16% | Инвестмент (investment) |
| Шинжлэх ухаан | 13 | 13% | Чатбот (chatbot) |
| Улс төр | 10 | 10% | ЕС (European Commission) |
| Эм эмнэлэг | 10 | 10% | Гепатит В (hepatitis B) |
| Бусад | 10 | 10% | Фэйсбүүк (facebook) |
| Тамир урлаг | 7 | 6% | Пауэрлифтинг (powerlifting) |
| Аж үйлдвэр | 6 | 6% | Автокран (autocrane) |
| Хэмжүүрийн нэгж | 4 | 4% | МВ (Mbyte) |
| Сурган хүмүүжил | 3 | 3% | IELTS (The international English Language Testing System) |

(Гурав) Зээлсэн арга:

Хөмрөгт илэрсэн англи зээллэг үгийг зээлсэн аргаар нь хөвүүлсэн зээллэг үг, үүсмэл зээллэг үг, латинчилсан зээллэг үг гэж гурван төрөлд ангилав. Үүнд хөрвүүлсэн зээллэг үг гэдэг нь авиа ба утга нь цөм харь хэлнээс зээлсэн үгийг хэлж байна. Жишээ нь: бактери (бактери), коронавирус (титимлэг хэлбэрийн вирус), коллеж (тусгай мэргэжлийн дээд сургууль) зэрэг.

Үүсмэл зээллэг үг гэдэг нь монгол хэлний хэл зүйгээр хэлбэржсэн зээллэг үгийг хэлж байна. Жишээ нь экспортлох (гадаадад гаргах), импортлох (гадаадаас оруулах) зэрэг. Латинчилсан зээллэг үг гэдэг нь англи галиг буюу кирил галигаар товчлон бичиж утга илтгэдэг үгийг хэлж байна. Тус хөмрөгт англи галиг ба кирил галиг хоёр хэлбэрийн англи зээллэг үг илрэв. Жишээ нь кг (кирилл, килограм), м (кирилл, метр), МВ (англи, тоо баримтын хадгалалтын нэгж), РН (англи, хүчил шүлтийн хэмжээ) зэрэг болно. Зээлсэн аргын талаар хөрвүүлсэн зээллэг үгийн харьцал нь хамгийн олон байгаа ба дараа нь латинчилсан зээллэг үг ба үүсмэл зээллэг үг эзэлж байна. Англи зээллэг үгийн зээлсэн арга, үгийн тоо, харьцлыг хүснэгт №4-т үзүүлэв.

| Зээлсэн арга | Хөрвүүлсэн зээллэг үг | Латинчилсан зээллэг үг | Үүсмэл зээллэг үг |
|--------------|-----------------------|------------------------|---------------------------|
| Үгийн тоо | 65 | 29 | 2 |
| Харьцал | 68% | 30% | 2% |
| Жишээ | Доллар (dollar) | TV (television) | Экспортлох (export + л+х) |

(Дөрөв) Толгой үг ба давталт:

Хөмрөгт нийт 95 зурвас англи зээллэг үг илэрч өндөр давталтаар нь монгол зууч дахь олон хэрэглэгдэж байгаа англи зээллэг үгийг бүртгэн олов. Бүртгэлийг үндэслэвэл, монгол зууч дахь өмнө 10 нэрст жагсаагдаж байгаа англи зээллэг үгийг хүснэгт №5-д үзүүлэв.

| Толгой үг | Уул үг | Давталт |
|-------------|-------------|---------|
| Тн | Ton | 373 |
| Спорт | sport | 265 |
| Доллар | Dollar | 207 |
| Экспорт | Export | 162 |
| Стандарт | Standart | 74 |
| Тендер | Tender | 49 |
| Бизнес | Business | 45 |
| Коронавирус | Coronavirus | 44 |
| Кв | Kylobyte | 32 |
| Парк | Park | 27 |

(Тав) Одоо байгаа толь бичигтэй харьцуулах нь:

Толь бичиг бол үгийн сангийн хураангуй тусгал байж үг хэл үсэг бичгийн бодит хэрэглээний дүрэмжлийн чухал бүхий гар авлага ба лавлалт болох юм. Иймээс бодит хэрэглээ дэх англи зээллэг үгийг толь бичигтэй харьцуулан задлах нь шинэ англи зээллэг үгийг илрүүлэх, байнга хэрэглэгдэх зээллэг үгийг тодлох ба хожмын үг зээлэх чиглэл хандлагыг зохих хэмжээгээр тусгаж чадна. Үүний тул материалын хөмрөгт илэрсэн 95 англи зээллэг үгээ “Кирилл монгол хадмал толь”, “Шинэ монгол хятад толь”, “Монгол хэлний гадаад үгийн толь”, “Монгол хэлэнд орсон гадаад үгийн хураангуй тайлбар толь” зэрэг дөрвөн толь бичигтэй харьцуулав.

Харьцуулсны дүнд материалын хөмрөг дэх англи зээллэг үг нь “Кирилл монгол хадмал толь”-д 18 толгой үг илэрч, “Шинэ монгол хятад толь”-д 29 толгой үг илэрч, “Монгол хэлний гадаад үгийн толь”-д 21 толгой үг илэрч, “Монгол хэлэнд орсон гадаад үгийн хураангуй тайлбар толь”-д 20 толгой үг илрэв.

Зөвхөн материалын хөмрөгт илэрч, толь бичигт илрээгүй англи зээллэг үг 58 толгой үг байна. Жишээ нь коронавирус, пауэрлифтинг, ковид зэрэг. Дөрвөн толь бичигт бүр илэрч өнгөрсөн нь 9 толгой үг байна. Жишээ нь экспорт, стандарт, вагон зэрэг болно.

Дүгнэлт:

Тус удааны бүртгэлээр дамжин олсон монгол хэлэн дэх англи зээллэг үгийн хэрэглээний байдал доорх мэт байна. Үүнд.

Нэгд, үгсийн аймгийн талаар жинхэнэ нэр (88%) хамгийн арвин илэрч, дараа нь тэмдэг нэр ба үйл үг болно.

Хоёрт, зээллэг үгийн утгын төрлийн хувьд голдуу ахуй амьдрал, шинжлэх ухаан, аж ахуй зэрэг талаар хэрэглээний харьцал нэлээд олон байна.

Гуравт, Зээлсэн аргын талаар хөрвүүлсэн зээллэг үгийн харьцал хамаг олон (68%), дараа нь латинчилсан зээллэг үг ба үүсмэл зээллэг үг болно. Тус материалын хөмрөгт англи галиг ба кирилл галигаар тэмдэглэсэн латинчилсан зээллэг үг илрэв.

Дөрөвт, Давтамжийн талаар өмнө 10-т жагсаагдаж байгаа англи зээллэг үг нь “тн, спорт, доллар, экспорт, стандарт, тендер, бизнес, коронавирус, кв, парк” зэрэг болно.

Тус өгүүлэл бол ӨМӨЗО-ны Үндэстний хэрэг эрхлэх зөвлөлийн төсөл” Монгол зуучлуурын хэлний корпус т суурилсан англи зээллэг үгийн судалгаа” (MW-ҮВ-2021026), ӨМБИС-ийн эрдэм шинжилгээний суурь мөнгөний тусгай төсөл” Монгол зуучлуурын хэлний корпус т суурилсан сэтгэлгээний задлалтын судалгаа”(2023JBBJ002)-ийн үе шатны чанартай бүтээл болно.

НОМ ЗҮЙ

[1] Норжин нар: “Монгол хэлэн дэх англи зээллэг үгсийн бичлэгийн дүрэм ба хамаа бүхий өгүүлэл материал”, Өвөр Монголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 2007 он. P5, P7.

[2] “Монгол хятад товчилсон үгс хийгээд зээллэг үгийн толь”, Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо, 2003 оны 1 сар.

[3] Н.Балжинням: Монгол хэлний гадаад үгийн толь”, 2005 он P3, P4.

[4] 黄昌宁, 李涓子: 《语料库语言学》, 商务印书馆, 2007年, P23..

УЛАМЖЛАЛТ БУС АРГААР АНГЛИ ХЭЛ СУДЛАХ НЬ

Ц.Цогзолмаа,

(ШУТИС, ХШУС, доктор, ахлах багш.)

Агуулгын товч: Оюутан англи хэлийг сурах явцдаа англи шүлэг орчуулан цээжлэх даалгаврыг гүйцэтгэнэ. Улмаар англи хэлний өгүүлбэрийн бүтцийг ойлгох, бүтцийн дагуу өөрийн өгүүлбэрийг зохион ярих, бичих чадвартай болох ба цээжилснээр хувь хүний чадвараа хөгжүүлэх дадал зуршилтай болох гэсэн өөрийн санааг дэвшүүлэн туршилт хийсэн үр дүнгээ тайлбарлах зорилготой юм. Оюутан өөдрөг итгэл шүлгийн 12 мөр өгүүлбэр бүрийг задлан шинжлээд 1. Англи хэлний зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр, хавсарсан нийлмэл өгүүлбэр бүтцийг ойлгоно. Шүлгийг орчуулгыг хийхдээ уран найруулга хийж сурах, цээжилснээ сэргээн санаж уран унших нь сэтгэн бодох чадварыг хөгжүүлнэ. Шүлгийн утга санааг ойлгосон хүн сэтгэл хөдлөлөө удирдах чадвар, нийгэмтэйгээ харилцах чадвар, бэрхшээлийг даван туулах чадвар, сүнслэг байдлаа хөгжүүлэх чадвар, сэтгэн бодох чадвар гэсэн таван чадвараа хөгжүүлэх дадалтай болно. Найман долоо хоног шүлэгтэй ажилласан байдлыг шалгах асуулга авч англи хэлний ярианы чадварт гарсан эерэг өөрчлөлтийн үр дүнг графикаар харууллаа.

Түлхүүр үг: сэтгэн бодох чадвар, бүтэц ашиглан өгүүлбэр зохиох

Оршил

Орчин үеийн технологийн эринд хувь хүний хөгжлийг чухалчлах болжээ. Бид англи хэлийг дүрэм тайлбарлах хүрээнд зохиосон өгүүлбэрүүдийг голдуу судалж байгаа билээ. Орчин үед эрдэмтэд хүний суралцах чадварыг сэтгэл зүйтэй холбож үздэг олон судалгааны өгүүлэлд бичих болжээ. Жишээлбэл тархи судлалын шинжлэх ухаанд хүн сэтгэл хөдлөлд өртсөн үйл явдлын мэдээллийг далд ухамсартаа тогтоон санаж авдаг, шинэ зүйл сурахдаа өмнө нь сайн сурсан зүйлтэйгээ харьцуулалт хийж хурдан суралцдаг болохыг судалгаагаар харуулсан билээ.

Дэлхийн өөдрөг үзэлтнүүд буюу “Optimist International” байгууллага нь хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих зорилготой 1919 онд АНУ-ын Кентакки мужийн Луисвилл хотод байгуулагдсан ба одоогоор 20 улс нэгдсэн 3000 бүлгэм дэлхий даяар үйл ажиллагаа явуулдаг. Уг төрийн бус олон улсын байгууллага нь 1922 онд Кристиан Даа Ларсоны “Өөдрөг итгэл” буюу “Optimist Creed” шүлгийг амьдралын гүн ухаан, уриагаа болгосон. Эмнэлэгт өвчтийг эдгээх, багийн спортод дасгалжуулагч тамирчдаа урамшуулах, өөдрөг үзэл бодлыг түгээх зорилгоор бясалгал, батламж өгүүлбэр зэргээр хувь хүний

хөгжлийн сургалтад ашигладаг. Тэгвэл бид англи хэлийг оюутанд заахдаа уг шүлгийг цээжлэх даалгавар өгч хүн сэтгэл санаагаа удирдах болон бэрхшээлийг шийдэх зэргээр үр өгөөжтэй суралцуулах туршилтыг хийлээ.

Шүлгийн өгүүлбэрийн бүтэцийн задлан шинжилгээ

Өөдрөг итгэл шүлэг нь хүн өөдрөг бодолтой болгох үйлдлийг заадаг арван хоёр мөр өгүүлбэртэй юм. Өгүүлбэр бүр “өөртөө амла” эсвэл “өөртөө би амлая” гэсэн хэлбэртэй хэрэглэж болдог. Энд бусдад хандсан байдалтайг хэлбэрийг үзвэл:

The Optimist Creed

Promise Yourself

To be so strong that nothing can disturb your peace of mind.

To talk health, happiness and prosperity to every person you meet.

To make all your friends feel that there is something worthwhile in them.

To look at the sunny side of everything and make your optimism come true.

To think only of the best, to work only for the best, and to expect only the best.

To be just as enthusiastic about the success of others as you are about your own.

To forget the mistakes of the past and press on to the greater achievements of the future.

To wear a cheerful countenance at all times and give every living creature you meet a smile.

To give so much time to the improvement of yourself that you have no time to criticize others.

To be too large for worry, too noble for anger, too strong for fear, and too happy to permit the presence of trouble.

Туршилтанд өөрт хандсан хувилбартай шүлгийг сонгон тайбарлахад хавсарсан нийлмэл өгүүлбэрийн бүтэцтэй нь 1, 2, 3, 6, 8, 9-р мөрүүд, энгийн өгүүлбэрийн бүтэцтэй нь 4, 5, 7, 10-р мөрүүдийн өгүүлбэрүүд юм.

Харин сүнслэг байдлыг хөгжүүлэх чадварыг илэрхийлсэн 11-р мөр нь энгийн өгүүлбэр, 12-р мөр нь хавсарсан нийлмэл өгүүлбэр юм. Эхний 1-10 мөрүүдийн өгүүлбэрүүдийн зааварчилгаа нь аливаад ямар итгэл үнэмшилтэйгээр үйлдэх буюу хүн ертөнцтэйгээ ямар бодлоор уялдаа холбоотой харилцах ёстойг илэрхийлэж байна.

I promise myself to think well of myself and to proclaim this fact to the world, not in loud word, but in great deeds.

I promise myself to live in the faith that the whole world is on my side, so long as I am true to the best that is in me.

Сүнслэг оюун ухаан бол амьдралын утга учрыг тодорхойлох чадвар юм. Сүнслэг оюун ухаан гэдэг нь хүмүүсийн өдөр тутмын стресс, түгшүүр, хайр, баяр баясгалангийн далд ухамсрын эх үүсвэр болох бүх зүйл утга учир, зорилготой гэдгийг ухамсарлаж, үйлдэл хийх арга гэж ойлгож болно. Өөрт

хандсан байдлаар орчуулга ба хувь хүний хөгжлийн чадвараар үзүүлэлтээр ангилсан байдлыг хүснэгт 1-г үзүүлбэл:

1. Өөрийн сэтгэл санаагаа удирдах чадвараа хөгжүүлэх тухай

| | |
|--|---|
| 1. I promise myself to be so strong that nothing can disturb my peace of mind. | Миний сэтгэлийн амар амгаланг юу ч алдагдуулахгүй хүчирхэг нэгэн байхаа өөртөө амлаж байна. |
| 10. I promise myself to be too large for worry, too noble for anger, too strong for fear, and too happy to permit the presence of trouble. | Бэрхшээлд хүлээцтэй, айдаст хүчирхэг, бухимдалд ихэмсэг, зовнилд уужуу байна гэж өөртөө би амлая. |

2. Нийгмийн харилцаа буюу найз нөхөдтэйгээ харилцах тухай

| | |
|--|--|
| 2. I promise myself to talk health, happiness, and prosperity to every person I meet. | Уулзах хүнтэйгээ эрүүл энх, аз жаргал, хөгжил дэвшлийн талаар ярилцахаа өөртөө би амлая. |
| 3. I promise myself to make all my friends feel that there is something worthwhile in them. | Найзуудынхаа үнэн цэнийг өөрсдөд нь мэдрүүлж харилцахаа өөртөө би амлая. |
| 8. I promise myself to wear a cheerful countenance at all times and give every living creature I meet a smile. | Амьд оршихуй бүрд инээмсэглэл бэлэглэн үргэлж баясгалантайгаар угтахаа өөртөө би амлая. |

3. Өөрийгөө урамшуулах болон ур чадварыг хөгжүүлэх тухай

| | |
|--|---|
| 4. I promise myself to look at the sunny side of everything and make my optimism come true. | Өөдрөг сэтгэлээ тэтгэх юм бүхний гэгээтэй талыг харна гэж өөртөө би амлая. |
| 5. I promise myself to think only the best, to work only for the best, and to expect only the best. | Зөвхөн сайныг хүлээж, сайхан болгохоор ажиллан, сайныг бодно гэж өөртөө би амлая. |
| 6. I promise myself to be just as enthusiastic about the success of others as I am are about my own. | Бусдын амжилтыг өөрийн юм шиг урамшин баярлана гэж өөртөө би амлая. |

4. Бэрхшээлийг даван туулах чадварыг хөгжүүлэх тухай

| | |
|--|--|
| 7. I promise myself to forget the mistakes of the past and press on to the greater achievements of the future. | Өнгөрсний алдааг уучлан ирээдүйн их үйлсдээ тэмүүлэхээ өөртөө би амлая. |
| 9. I promise myself to give so much time to the improvement of myself that I | Бусдыг шүүмжлэх завгүйгээр өөрийгөө хөгжүүлэхэд цаг хугацаагаа зориулна гэж өөртөө би амлая. |


| | |
|-----------------------------------|--|
| have no time to criticize others. | |
|-----------------------------------|--|

5. Сүнслэг байдлыг хөгжүүлэх чадварын тухай

| | |
|--|--|
| 11. I promise myself to think well of myself and to proclaim this fact to the world, not in loud words but great deeds. | Өөрийгөө сайрхан тунхаглаад байхгүй харин их үйлсийг өрнүүнэ гэж өөртөө би амлая. |
| 12. I promise myself to live in faith that the whole world is on my side so long as I am true to the best that is in me. | Өөрийн хүч чадалдаа найдаж ертөнц миний талд байхаар зөв амьдарна гэж өөртөө би амлая. |

Мэдээлэл технологийн англи хэлний хичээлийг судлан үзэж байгаа Соёл эрдэм дээд сургуулийн зургаан оюутнуудад өөдрөг итгэл шүлэгтэй ажиллах даалгавар өгч туршилт хийсэн. Энд оюутан бүрийн орчуулгын ур чадварын түвшин болон найруулга нь мэдрэмжийг илэрхийлэх үгийн сонголтоос хамаарч өөр өөр байсан ч утга нь санаа нь ижил байлаа. Энд сэтгэл хөдлөлөө удирдах СХУ, нийгэмтэй харилцах НХЧ, бэрхшээлийг даван туулах БДТ, сүнслэг байдлыг хөгжүүлэх СБХ чадваруудыг товчилсон болно. Энд 1, 4, 5, 6, 8, 10-р өгүүлбэр нь сэтгэл хөдлөлөө удирдах чадварыг бодох, ярих үйлдлээр гүйцэтгэж байхыг зөвлөсөн. 2, 3-р өгүүлбэр нь нийгэмтэйгээ харилцах ур чадвараа сайжруулах зааварчилгааг зөв ярих үйлдлээр хийхийг зөвлөжээ. Бэрхшээлийг даван туулах чадварыг 7, 9-р өгүүлбэр бодох, ярих үйлдлээр хийнэ. Эхний 1-10 өгүүлбэрүүдийн үйлдэл бүрийг ямар байдлаар хийхийг сүнслэг байдлыг хөгжүүлэх чадварын 11, 12-р мөрийн үйлдлээр гүйцэтгэх болон шүлэг цээжлэх нь сэтгэн бодох чадварын хөгжүүлнэ.

Шүлэг нь нэтээс <https://www.youtube.com/watch?v=HMsv4vq9aBI> цахим хуудсанд үгтэйгээ байгаа нь цээжилхэд оюутанд туслана. Зургаан оюутны хувь хүний хөгжлийг дөрвөн чадварын нийлбэр үзүүлэлтүүдийг туршилтын өмнө болон дараа байдлыг графикаар харуулбал:



Дүгнэлт:

Оюутан өөдрөг итгэл шүлгийн 12 мөр өгүүлбэрийг судалснаар англи хэлний энгийн өгүүлбэр, хавсарсан нийлмэл өгүүлбэрийн бүтцийг ойлгож авсан ба бүтцийн дагуу өгүүлбэр бичих, ярих, орчуулгын найруулга хийж сурлаа. Нийт зургаан оюутнуудын хувь хүний хөгжлийн нийлбэр үзүүлэлт 26.4% байснаа 50% болж сайн өөрчлөлт гарлаа. Эхэндээ нийт оюутнуудыг сэтгэл хөдөллөө удирдах чадвар 8.3%, нийгэмтэй харилцах чадвар 4.2%, бэрхшээлийг даван туулах чадвар 6.9%, сүнслэг байдлаа хөгжүүлэх чадвар 0 байсан бол туршилтын дараа тус бүр 13.9%, 9.7%, 11.1%, 5.6% болж өссөн эерэг үр дүн гарчээ. Оюутнууд өгүүлбэр бүрийг цээжилэн, утга санааг ойлгосноор сэтгэн бодох чадвар болон дараах дөрвөн гол чадварыг эзэмших зуршлыг бий болгоно. Үүнд:

1. Сэтгэлийн амар амгалан байдлаа хадгалах чадвар
2. Нийгмийн эерэг орчныг бүрдүүлэх эелдэг ярих чадвар
3. Урам зоригтой хөдөлмөрлөн оршин байх чадвар
4. Шүлгийн өгүүлбэрийн бүтцийг ашиглан англи хэлээр өөрийн өгүүлбэрийг зохион ярих чадвар

Энэхүү шүлгийг цээжилсэн бол хэзээ хэрэгтэй үедээ өөртөө уншиж байх нь далд ухамсарт нөлөөлнө. Эдгээр 12 зарчмуудыг хэрэгжүүлснээр бид амар амгалан, зорилготой, өөдрөг үзэлтэй байж орчин үеийн амьдралын ээдрээтэй зүйлсийг даван туулж чадна. Англи хэлээр ярих тохиолдолд шүлгийн өгүүлбэрийн бүтцийн дагуу чөлөөтэй ярих чадвартай болдог. Цаашид судалгааг сэтгэл судлал, философийн эрдэмтэд, англи хэлний хичээл заадаг багш нартай хамтарч нарийвчилсан судалгаа хийх сонирхолтой байна.

Ашигласан материал:

1. Affirmation Transformation, Law of Attraction Poetry, I promise myself - Christian D Larson, <https://www.youtube.com/watch?v=HMsv4vq9aBI>
2. Optimist International, <https://www.optimist.org/>

УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ



ИЙМ ХЭМЭЭН МИНИЙ СОНССОН НЬ

(Сайчунгагийн тухай Надмид гуайг сурвалжилсан тэмдэглэл)

ТОБА БАЙКРҮ

(Оберин их сургуулийн профессор)

2019 оны 6 дугаар сарын 22 болон 9 дүгээр сарын 15-нд 85 настай Надмид гуайн байгаа Хөх хотын үндэсний дээд сургуулийн хүүрэн дэх гэрт нь 2 удаа очиж Сайчунга гуайн тухай сурвалжилсан юм. Сурвалжилсан тэмдэглэлээ эмхэтгэх явцад олон дахин утас авч мадагтай зүйлсийг лавлан тодруулав. Ингээд эмхэтгэж байсан тэмдэглэлээ Надмид гуайд илгээж хянуулсан хянуулан засуулав. Үжигд Надмид бол Хэл шинжлэлийн эрдэмтэн, профессор хүн. Цахарт чуулганы Хөл хөх хошууны Очир амбаны отгон хөвгүүн. 1957 онд Өвөр Монголын их сургуулийн монгол хэл утга зохиолын салбарт элсэж, төгссөнийхөө дараа Өвөр Монголын Монгол хэл бичгийн тусгай мэргэжлийн сургууль, Баруун Хойдын Үндэстний дээд сургуульд багшилж байгаад тэтгэвэртээ гарчээ. Хөх хотод Монгол зан үйл, шашин шүтлэгийн соёлын тухай судлал хийж иржээ.

Нэг. Сайчунга 2 эхнэр авсан учир

Сайчунга бол миний хүргэн ах болно 1945 оны намар Монгол Улсад очиж суралцах болтлоо манайхантай үргэлж ойр байсан Сайчунга миний эгч Цээпилмаатай хуримлах үед Сэржмядагтай хуримлаад хагас жил хэртэй болж байсан гэнэ ээ. Тэгвэл манай шиг ийм бэр ийм байр суурьтай айл яагаад нэгэнтээ хуримласан хүнд хүүхнээ өгсөн бэ? Дахиад хэлбэл Сайчунга яагаад хагас жилийн дотор 2 эхнэр буулгаж авсан бэ? Энэ нэгэн оньсогыг одоо мэдэх хүн цөөрч байна.

Сайчунга миний эгчтэй хуримлах үед би төрөөгүй байсан. Гэвч гэрийн хүмүүсээс сонсож мэдсэнээ лавлалт болгон ярья аа.

Миний өвөө лам Балган, Сайчунгагийн авга Зуузуу ламтай их сайн, ах дүү мэт байж. Зуузуу ламын жинхэнэ нэр нь Чогсонжав. Бүүр нэр хүндтэй дээд давхаргын ламтан. Миний өвөө лам Хөлөө Хөх хошууны Найман хүрээ сүмийн Да лам болж байсан. Зуузуу лам манай лам өвөөд “Манайх манай ач хүүд ээ танай ач хүүхнийг гуйя аа. Хоёр гэрээрээ ураг садан болъё” гэхэд миний лам өвөө ч зөвшөөрдөг юм байна. Ингээд хоёр лам толгой мэдэж ураг тогтжээ. Сайчунгагийн эцэг Насандэлгэр харин хүүдээ Сэржмядагийг бэр болгохоор хадаг тавьсан байсныг хоёр лам мэдээгүй байжээ.

Гэвч хадаг тавьбал буцааж болдоггүй ёстой. Ийм байдал дор урьд урьдаар нэгнийх нь хуримыг хийе хэмээн ярилцаад сайд, Сайчунгаг урьдаар Сэржмядагтай хуримлуулсан. 6 сарынх нь дараа манай эгчтэй хуримлуулсан. Тэр үед ураг хуримын учир учрыг бол бүүр гэрийн ахмад нь толгой мэдэж тогтдог байсан. “Чөлөөт орон” гэдэг үг ч байгаагүй. Сайчунга нэг л доор хоёр

эхнэр авсан учир бол ийм явцтай, ийм л түүхтэй. Сайчунгагийн “Хөх торгон тэрлэг” гэх шүлэгт түүний хувийнх нь амьдралын олон мөрүүд мэр сэр тусгагдсан байдаг.

Хоёр. Миний эгч бол Сайчунгагийн “Нэр заасан эхнэр нь биш”.

Тэр үед 2 эхнэр авах үзэгдэл нийтлэг байсан. Хэд, хэдэн эхнэртэй хүн ч байсан шүү. Харин “Нэр заана” гэдэг бол өөр учир. Зарим ядуу айл буюу хөдөлмөр хүчингүй дээрээ хүргэн олдохгүй айлуудын хүүхэн [охин хүүхэд] нь 13 нас хүрвэл ямар нэгэн эрэгтэй хүнд “Нэр заана” гээд үсийг нь хагалж, гэр зуур хурим хийгээд, гэртээ сууж гэрийн ажил ажлаа хийдэг.

Хуримд шинэ хүргэн ирдэггүй, мөргүүлсэн эцэг ч байдаггүй. Хурим хийчихсэн учраас хүүхэн нь хүүхэд гаргах нь ёстой гэж үздэг. Харин миний эгч Цээпилмаа бол Сайчунгагийн нэр заасан эхнэр нь биш. Тэр 16 настайдаа Сайчунгатай хуримласан.

Хурим хийхэд заавал “Мөргүүлсэн эцэг” гэж байдаг. Мөргүүлсэн эцэг нь хурим дээр шинэ бэрийн үсийг нь хагалж өгдөг бөгөөд шинэ бэр шинэ хүргэнийг зүүн, баруун талдаа хөтлөн, тэнгэр, гал голомт болон эцэг эхэд нь гурвантаа мөргүүлдэг. Тэр үед ургийн батлавар бичиг гэж байсангүй. Хурим хийх нь ураг барилдсаны гэрч юм. Мөргүүлсэн эцэг бол даруй гэрч хүн бөгөөд батлах хүн.

Миний эгч ба Сайчунгагийн мөргүүлсэн эцэг нь 5 дугаар сумны хүн, нэрийг нь мартжээ. Сэржмядагт ч мөргүүлсэн эцэг байсан. Иймээс Сайчунга 2 мөргүүлсэн эцэгтэй. Мөргүүлсэн эцгийг нь төрсөн эцэг адил насаараа хүндэтгэн явдаг. Миний эгч Сайчунгагийн гэрт очиж суусангүй. Гэвч төрхөмдөө суусан ч биш, манайтай нэг хот, цуг байсан төдий. Гэр тэрэг мал унаатай чинээтэй айл байсан. 3 монгол гэртэй зарагдаж байсан хүн нь, зүүн талынх нь нэг бага шиг монгол гэрт суудаг.

Манай эгч Гозон хөгшин гэж (жинхэнэ нэрийг нь мэдэхгүй) Хадан хошуу сүмийн өмнө хавьд нутагтай Хэ жин вангийн сүргийн хүн Лхамцоо гэдэг зарагдах хүнтэйгээ хамт амьдардаг байсан. Лхамцоогийн охин дүү нь Цэенрэгзэн бас хамт байсан. Тэр эгч дүү 2 бол одоогийн Баян-Улаан гацаа билүү, Баянхангай гацааны хүн. Тэр эгч дүү 2, манай эгчийнд хэдий суусныг мэдэхгүй. 1947 оны үеэр нутагтаа буцахад нь миний эгч 1, 1 тэмээ бэлэглэж байсныг цээжилж байна.

Бас Оджаа (жинхэнэ нэр нь миний аавын нэртэй адил Очир гэдэг тул бид Оджаа гэж дууддаг. Ролмаажавын эцэг Нямын ах) гэдэг хүн мал адууг нь хариулж өгч байсан. Сүүлээр нь манай адуучин болсон. Манайх адуу олон учраас хэдэн адуучинтай байсан.

Сайчунга тэр үед хөдөө гэртээ дэмий суудаггүй байсан. Сургуульд суух буюу эсвэл хошуун дээр ажил албатай гээд явсан л байдаг. Сайчунга хөдөөдөө ирвэл Сэржмядагийн тэнд очно. Бас манай эгчийнд ч ирнэ. 1934 онд манай эгчээс хүү төрсөн. Нэр нь Боргил гэдэг. Сайчунга Баруун Сөнид хошуунд багшилж байхад миний эгч хүүтэйгээ очоод, нэлээд удаан сууж байсан.

Сэржмядаг ч эхлээд төрхөмдөө сууж байсан. 1934 оны үеэр хадамдаа ирж суусан. Миний эгчийг ч дуудсан гэдэг. Сайчунгаг хуримлах үед миний аав Хөл хөх хошууны Бага залан байсан. 1945 оны эхээр Хөл хөх хошууны Амбан болсон. Мөн ч хамгийн сүүлчийн Амбан.

Тэр үед, тэр нийгэмд манай шиг айлын хүүхдэд хүргэн олдохгүй болоод буюу эсвэл хүүхнээ гэртээ суулгаж зарахын төлөө, айлын хуримласан хүнд нэр заасан эхнэр болгож болгох учир байхгүй.

Гурав. Сайчунга болон миний аав

Сайчунгагийн угийн нэрийг Загпүрэв гэдэг. Хуримлах үед нь миний аав Сайчунга (Сайшаал гэдэг утгатай манж нэр)-ийг өгсөн юм. Сэржмядагийн настны нэр нь Пүрэв гэдэг. Тэгээд л сольсон гэдэг. Сэржмядаг хуримлахаас өмнө өөр нэртэй байсан уул нэрийг нь мартжээ. Миний эгчийн уулын нэр нь Мөнхцэцэг гэдэг. Зуузуу лам ач хүүгийнхээ 2 эхнэрт “Сэржмядаг” (Алтан цэцэг), Цээпилмаа (Насан мэнд) хэмээх төвөд нэр сольж өгсөн.

Нутгийн хүмүүс миний эгчийг Мөнхөө хэмээн дуудаад заншжээ. Миний аав, Сайчунга болон Маадай (Халтууд Магадбүрэн) хоёрыг Японд батлан явуулсан хүн. Хошуу засгаас зохих мөнгө олгож өгсөн. Дэ ван бол энэхүү учрыг өөрийн өөрөө гардаж хийсэн юм.

Дэ ван харин Сайчунгаг манай хүргэн гэснийг мэдэхгүй байсан. 1942 оны эхээр Дэ ван Хаалганд дахь ордондоо Жиан ниутай уулзалт хийжээ. Дэ вангаас миний аавд “-Орчуулагчаа өөрөө дагуулж ирээрэй” гэсэн байжээ. Жодовжав бас иржээ. Сайчунга тэр үед Японд суралцаж төгсөөд Хаалганд ирээд байсан тул, миний аав түүнийг дагуулж очиж, орчуулагч болгожээ. Ингээд Дэ ван “-Сайхан цахар хэлтэй залуу байна” гэхэд миний аав, “-Манай хүргэн” хэмээн танилцуулжээ. Дэ ван Сайчунгад “-Би удахгүй нутагтаа харихаар байх тул, маргааш манайд хүрч, жаахан хавсарч өгөөрэй” гэжээ. Маргааш нь Дэ вангийн сууж байсан газарт хүрч, юм хумыг нь бэлдэж төхөөрч өгчээ. Дэ ван түүнээс “-Чи төгсөж ирээд юу хийе гэж бодож байна вэ?” хэмээн асуухад, Сайчунга “-Одоохондоо тогтоогүй байна. Би багш болох дуртай” гэж хариулжээ. Дэ ван “-Тэгвэл манай тэнд сургууль байдаг. Маргааш манай тэрэг явна. Чи яваарай” гэжээ.

Ингээд л Сайчунга Баруун Сөнид хошуунд очсон юм. Сайчунга тэнд очсоны дараа миний эгч, хүүтэйгээ очиж нийлээд, урт хугацаанд хамт суусан. Миний эгч Дэ вантай тэнд танилцсан байна. Юу болсон ч Дэ ван болон түүний хүү Очирбат нарыг сайн таньдаг байсан.

Захчидсэцэн гуай “Нэгэн монгол настны дуртгал” гэдэг номдоо 1945 оны 8 сард манай анхны өвөлжөөгөөр дамжин, өмнөшөө дутаасан тухай бичихдээ, миний их эгч Цээпилмаатай уулзаж ярилцсан гэж тэмдэглэж байгаа нь андуу болжээ. Манай их эгч Цээпилмаа Хагийн талын хойд дээр Элст зуслан, Баруун зуслан дээр байсан тул, уулзсангүй. Харин миний 2 дугаар эгч Удвалтай уулзсан.

Захчидсэцэн манай аавтай хамт өмнөшөө явах санаатай байсан. Гэтэл Маадай бол хойшоо гарч Монголын цэргийг угтах саналтай. Миний аав их цэргийг угтах нь таарна гэж зориг шийдэж, Маадай болон Батбуян, Сайнзаяа

нарыг томилж, авга Сөнөдийн зах дахь Зараа ширээ гэдэг газарт Монгол-Зөвлөлтийн цэргийг угтан авсан юм.

Ингэж байтал Сайчунга, Дэ Вангийн тэндээсээ Рүй Юүнг дагуулан манайд хүрч ирсэн. Рүй Юүн бол дагуур хүн. Гүү До Фүгийн төрөл садан гэдэг. Тэгж байтал Нарованчин гэдэг лам мянган хошууны төв Туянг дээр Цахарын амбан тушаалтныг дагуулж, хурал хийгээд “Би бол Монголоос томилж ирүүлээд нууц ажил хийж байсан хүн. Иймээс Цахарыг би хариуцна” хэмээн зарлаж, миний аавыг Хөл хөх хошууны амбан, Содномжамцыг Мянган хошууны амбан, Цэвэгжавыг Баруун гар тайвасын амбан, Цэрэннамжилыг Зүүн гар тайвасын амбан, Хас-Очирыг Хөвөөт цагаан хошууны амбан Буянг Хөл Цагаан хошууны амбанаар тус, тус томилжээ.

Тэгээд тэд Долоннуур хүрч, Монгол улсын Лхамжав сайдад хариу мэдүүлэлт хийжээ. Хариу мэдүүлэлт хийж дууссаны дараа гэнэт бачим хурал хийж “Нарованчин энэ хүн бол Дэнзэнгомбо гэдэг нэртэй. Манай тэндээс урваж гарч ирсэн хүн. Энд ирээд Японы тагнуул болжээ. Иймээс бид түүнийг хууль ёсоор баривчлав. Энэ учир та нарт хамаагүй. Та нарын хийсэн хариу мэдүүлтийн дотор Сайчунга гэдэг хүн сайхан ярьлаа. Тэр Цахар чуулганыг хариуцах болтугай. Бусад хүмүүс хууль ёсоор ажлаа хийгээрэй. Та нарын гол үүрэг бол манай Монголын цэрэгт морь, унаа, хүнс идэш бэлтгэж өгөх явдал болно” гэж тушаажээ.

Сайчунга Лхамжав сайдад, Монголд очиж суралцах тухай хүсэлт тавихад Лхамжав сайд зөвшөөрч, түүнд Чойбалсангийн хэргийг өгч, хэзээ яаж холбоо барих тухай хэлж өгчээ.

Сайчунга Сайхан нуурын анхны өвөлжөөндөх гэртээ буцаж ирж, ажлын бага дугуйлан байгуулж, Баруун тамайд байсан Монголын цэргийн хуаранд цэргийн агт, идэшний үхэр, хонь цуглуулан өгч байв. Тэр бага дугуйланд Хас, Минжүүр, Эрдэнэдүүрэн, Цэрэн зэрэг хүмүүс байсан. Тэгээд 11 сарын үеэр миний аав түүнийг Ханхалын Шувуу цагаанд хүргэж, Монгол зүг мордуулсан. Хүмүүс 10 сар хэмээн андуурч байна. Нэлээд хүйтэн орсон байсан шүү.

Сайчунга манай хошууны бичээч байсан Лхамжавтай хамт явсан. Лхамжав Монголд очоод сургуульд суралцсангүй, нарийн боовны үйлдвэрт ажиллаж байсан. 1953 онд нутагтаа буцаж ирсэн гэдэг.

Монгол Улсын Лхамжав сайдтай нэг нисгэлээр хамт явсан биш, Монгол улсын цэргийг буцах үес, манай нутгийн нэлээд хүмүүсийг холбоочин болгосон тэр үед, Монгол Зөвлөлттэй харилцах нь давшингуй ажиллагаа юм. Харин Гоминдантай харилцах нь тэрслүү ажиллагаа. Гэвч их хөдөлгөөний үед тэд бүгд “Монголын тагнуул” гэж цохигджээ.

Сайчунга Монголд явах үед Боргил 11 настай байв. Ичинхорлоо ээжийнхээ гэдсэнд байв. Ичинхорлоо 1946 онд хавар төрсөн. Нохой жил төрсөн учраас багын нэр нь “Хөсрийн нохой” гэдэг. 1950 онд Жан жа хүүд Сайчунгаа Цээпилмаатай хууль ёсоор ураг салж, гар гүйцэтгэл хийсэн. Хүү Боргилоо өөрийн нэр дээрээ авч, хүүхэн Ичинхорлоогоо эхийг нь дагуулав.

Сайчунга надад “-Шинэ нийгэмд би 2 эхнэр авч болохгүй болжээ. Сэржмядаг бол манай гэрт ирээд, гэрийн хүмүүсийг харгалзаж явсан. Иймээс

түүнээс салж болохгүй аргагүй байдлын дор, эгчээс чинь салах болжээ” гэж өөрийн сэтгэлийн үгээ ярьж байсныг би тодорхой цээжилж байна.

Өвөр Монголын Ардын засгийн ордон Жан жа хүүгээс Хөх хотод шилжин ирсний дараа Ичинхорлоо Хөх хотод ирж бичиг үзэв. Ичинхорлоог хөдөөнөөс тосон авчрахаар Боргил бид 2 хамт харьсан. Ичинхорлоо бага байсан тул Хөх хотод ирээд нэг үе Сайчунгагийн гэрт сууж байв. Сайчунга дугуй тэргээр Монгол сургуульд хүргэж, тосож байв. Сүүлээр нь сургуулийн байранд суусан. Амьдрал сурлагын аливаа зардлыг сайчунгаа өгдөг.

Сайчунга бас дүү нарынхаа 2 хүүхэд Саранчимэг ба Цогбадрахыг Хөх хотод авчирч сургуульд суулгасан. Цогбадрахыг үрчлэн авсан гэдэг. Сайчунгаа ийм хэдэн хүүхдийг гар дээрээ өсгөн бойжуулжээ

Дөрөв. Сайчунгагийн тухай

Сайчунга бол шинэ соёлыг хүртэж шинжлэх ухаанд итгэсэн хүн. Гэвч гэрийнх нь хүмүүс нь лам биш ч байсан ч ламын шашны сүжигтэн. Тэгэх мөртөө зарим нь бас дээд лам. Бүгдээрээ бурханд их сүжигтэй. Сайчунга тэднээс салж дийлэхгүй шашныг эсэргүүцвэл гэрийнх нь хүмүүс холбогдчихно. Шинэ ёсоор явуулбал гэрийн хүмүүсээ бас гомдоочихно. Энэ бол түүний дотор байдаг нэг зүйлийн зөрчил.

Сайчунга бас хувьсгалч больё гэж их бодож байсан хүн. Гэвч амбаны хүүхэнтэй хуримласан. Энэхүү түүхийг бол салгаж дийлэхгүй шүү, салж ч чадахгүй. Түүнд “Амбаны хүргэн”, “Дэ вангийн бичээч” гэдэг тамгыг ясан дээр нь нэгэнтээ арилшгүй дараад тавьчихсан. Энэ бас нэг их зөрчил шүү.

Тэр үндэстнээ ихээр хөгжүүлэе мандуулья хэмээн уриалж байсан. Гэвч түүний тэр үеийн үзэлтэй бас зөрчилтэй болсон тал бий. Сайчунга гуай Японыг их магтаж байлаа. Маш олон шүлэг бичсэн, би уншиж байсан. Дэ ванг магтсан шүлэг ч нэлээд олон байсан. Сүүлээр нь Чойбалсанг магтлаа. Улаанхүүг магтлаа. Мао зэ дунг магтлаа. Хамтад нь хадам ааваа бас магтлаа. Магтсангүй хүнгүй гэж хэлж болно.

За яах вэ! Хүн ер нь зөрчлийн дунд явах юм чинь.

Сайчунга хүнээр их сайн хүн, их хариуцлагатай, нямбай, ямар юманд ч их сэтгэл зөөлөн ханддаг, шүлэг сайхан бичдэг, найруулга сайтай, хэллэг сайтай манай Цахарын дотроо хэлэлгээнгүй тэргүүн зэрэгт орно. Нэг юмыг оролдвол ойгүй нухлаад суудаг. Нухалсаар байгаад нэг юм болчихно. Жишээ нь тэр бол шүлэг бичдэг хүн шүү дээ. Гэвч “Хаврын наран Бээжингээс” гэдэг тууж маягтай юм бичээд гаргачихсан.

Их хөдөлгөөнөөс өмнө би үргэлж гэрт нь очдог байсан 1954 оны үеэс нэг удаа гэрт нь очиход тэр “-Би танайхнаар очъё гээд боддог байсан. Очиж болохгүй байна. Намайг бас итгэхгүй байна байна шүү. Монголд байхад ч тийм байсан. Тэнд Дотоод яамны Самдан гэдэг хүн үргэлж намайг эрин ирж, энэ тэрийг асууж ярилцдаг байлаа” гэж ярьж байсан.

Их хөдөлгөөн эхлээд бид явалцаж чадахгүй болсон. Би бол үндэстний хагацуулагч болсон. Бид хагацуулагч болсон. Сайчунга ч тэндээ “хар юм” болчихсон.

Их хөдөлгөөний үед сонин дээр Сайчунгаг “Дэ вангийн бичээч”, “Дэ вангийн мэйрин”, “Амбан ноёны хүргэн” гэх мэтээр илчлэн шүүмжилж байдаг. Голдуу тэдний байгууллагын хүмүүс буюу нарийн байдлыг сайн мэддэг ойр дотно байсан хүмүүсийг нь бичиж байсан. Ингээд түүнтэй ойртох хүн бүр байхгүй болсон. Тийм сүрхий цаг үед түүний зарим төрөл садан нь ч ирэхээ больсон гэнэ. Чингээд тэр өвчин эмгэг сэтгэл санааны дараас, ганцаардах, зовох зэргээс болоод ходоодны өвчин хүндэрч муудсан гэж сонссон.

Ер нь өдрийн тэмдэглэлд нь ч байна шүү. Сэтгэлээр их шархалсан байжээ. Тэгэхгүй яах вэ! Зааг шугамын учир хэцүү шүү!.

Харин Боргил, Ичинхорлоо хоёр түүний амьдрал, онцгойлон эмнэлэг, эмнэх, асрах зэрэгт үргэлж гүйж хавсардаг гэсэн. 1969 оны үед Сайчунга Засгийн ордны ард, нэг тасалгаа хуучин байшинд хөгшин болон Цогбадрахтайгаа гурвуул сууж байсан. Хөдөлмөрөөр өөрчлөгдөж байсан. Би нэг удаа чөлөөгөөрөө хүмүүсээс нуугдаад гэрт нь очсон. Надад “-Би бас өвдөж байна. Чи бас өвдөж байна. Бид явалцаж болохгүй шүү” гэхэд “-Тэгье” гэж хэлсэн.

Гээг үс нь хэсэг, хэсгээр зулгарсан их хөөрхийлөлтэй байсан. Сайчунга бас нэлээд нэрэлхүү хүн юм. “Намайг яах гэж гадуурчилж байна вэ?”, “Намайг ингэж зодож тэгж цохиж байна” гэж ер ярьдаггүй. Өдрийн тэмдэглэлдээ ч зодуулж тамлагдсанаа ер бичсэнгүй. Түүнийг зодоод алчих шахсан юм. Гэвч зөвхөн хөдөлмөр хийснээ л бичсэн байдаг.

1973 оны эхээр Сайчунгагийн өвчин нь улам хүндрэхэд Боргил түүнийг Шанхайд эмнүүлсэн. Сүүлээр нь Ичинхорлоо бас очиж хэдэн өдөр асарч суусан. Тэр үед түүний намын амьдралыг ч, амь амьдралыг нь ч сэргээж өгөөгүй. Нэр хүндийг нь ч сэргээж өгөөгүй. Боргил чармайж байгаад Шанхайд эмнүүлэхээр аваад явсан ч ходоодны хорт хавдар нь нэгэнтээ засвар авахаас өнгөрчихсөн байжээ.

УРАН ЗОХИОЛЫН ИЛЭРХИЙЛЭЛ БА ТҮҮНИЙ ЗУРАГ
ДҮРСЖҮҮЛЭЛТ

(Телевизийн кино бүтээлийн жишээн дээр тайлбарлах нь)

Дай Юн Жин
(БНХАУ, ӨМБИС-ийн
Монгол судлалын дээд сургуулийн
2022 оны аспирант)

Агуулгын товч: Бичиг болон зураг дүрс бол урлагийн хоёр өөр хэлбэр ч энэ хоёр зүйлийн уялдаа холбоонд зохих хэмжээний “химийн урвал” үүссэн байна. Энэ бол телевизийн кино. Телевизийн кино бол утга зохиолын орчин үеийн байдал болохын зэрэгцээ уран зохиол ба түүнийг зураглан дүрсжүүлэхтэй холбосон нэгэн хэлбэр нь болно. Телевизийн кино бүтээл нь үзэгчдийн дур сонирхлыг татахын тулд утга зохиолын текстэд өөрчлөлт хийж дүр ба өгүүлэмж, үйл хэрэг явдлыг улам төгөлдөржүүлж өгдөг. Өгүүлэлд телевизийн кино бүтээлийн жишээн дээр уран зохиолын бүтээлийг хэрхэн теле кино болгосон, мөн энэ нь утга зохиолын орчин үеийн бүтээл мөртлөө зохиолыг хэрхэн дүрсжүүлсэн, ингэхдээ утга зохиолын текстэд яаж өөрчлөлт хийж дүр, өгүүлэмж, үйл хэрэг явдлаа, ялангуяа орон цагийн агуулгыг яаж цогцлоосон бэ? гэдэг асуудлыг авч үзэв.

Түлхүүр үг: Утга зохиол, Телевизийн кино, Кино дүрсжүүлэлт

Дуу чимээ судлал буюу физикийн шинжлэх ухааны судалгаа, биологийн шинжлэх ухааны судалгаанаас үзэхэд, хүн төрөлхтөн нь, эхлээд өөрийн эрхтэн болон үйл ажиллагаагаараа өөрийнхөө яах гэж байгаа, юу хийх гэж байгаа, ямар орчин нөхцөл үүссэн, тайван байгаа юм уу, эсвэл аюул осол, айдастай байгаа юм уу...зэрэг тэр олон янзын утга санаагаа өөрөөс гаргаж болох дуу чимээ, авиагаараа илтгэж иржээ. Гэхдээ энэ бол хүний хөгжлийн анхны үеийн илэрхийлэх арга болно. Хөгжлийн дараагийн шатанд энэхүү эхэн үеийн байдалдаа тулгуурлаад, өөрийн эзэмшсэн багаж хэрэгсэл, бусад элдэв зүйлээр утга санаагаа илтгэж иржээ. Энэхүү бусад зүйл гэдэг агуулгад хүний өөрийнх нь бүтээсэн элдэв янзын тэмдэг (үсэг бичиг), зураг дүрс, ая эгшиг, бэлгэдэл ... зэрэг олон янзын элемент багтаж байгаа ба энэ нь нэг талаар хүний оюун ухааны хөгжилтэй холбоотой зүйл болж байгаа ч эхэн үеийн байдалтай нь холбогдуулан үзвэл яахын аргагүй хүний хөгжил дэвшилд гарсан хоёр дахь удаагийн хүчин зүйлийн илэрхийлэл болж байгаа юм. Энэ хүчин зүйлийн илэрхийлэл хөгжин хөгжсөөр, анхны ба түүний дараах үеийн хөгжлийн уялдаа холбоо нь улам дэвшсээр, үүнтэй холбоотойгоор буй болсон хүн төрөлхтний сэтгэлгээний ахиц гүнзгийрэл, шинжлэх ухаан, техник технологийн дэвшил нь яахын аргагүй телевизийг бий болгож, улмаар өнөө цагт телевизийн кино хэмээх бүтээгдэхүүнийг буй болгожээ. Энэ үүднээс нь

үзвэл телевизийн кино гэдэг бол уран зохиол [үсэг бичиг] ба түүнийг зурагжуулан дүрслэх гүүр болно.

Телевизийн кино нь угтаа уран зохиолын бүтээлийг кино, телевиз жүжгийн хэлбэрээр үзүүлэхийг л хэлж байгаа билээ. Уран зохиолд хэдий хүүрнэл голлодог ч, “уран зохиолын бүтээлийг теле кино болгох гэдэг нь тэдгээр хүүрнэл зохионы анхны суурин дээр өөрчлөлт хийж телевизийн кино болгохыг хэлж байна. [1]

Теле кино бол орчин үеийн шинжлэх ухааны мэргэжил хийгээд бас уламжлалт урлаг хоёрын уялдсаныг харуулдаг бүтээгдэхүүн мөн. Зураглал, дуу, үйл хэрэг явдлыг хайчлан [монтажлан] дэглэх аргаар хүмүүсийн анхаарлыг татдаг.

Улс үндэстний нийгэм, эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан техник технологийн мэргэжлийн хөгжилтийг дагалдан, хүмүүсийн дур сонирхол ялангуяа дижиталчлал, модерн маягийн зүгт шилжиж байгаа энэ нөхцөлд уран зохиол ба теле кино нь ертөнцийг дуурайхад харьяалагдах болов. Гэсэн ч энд уран зохиол ба кино хоёр нь илэрхий ялгаатай хоёр зүйл байдаг. Уран зохиол нь мэдээж бичгийг арга барилаа болгох бол, телевиз кино нь хөдөлгөөний зураглал ба дуугаар арга барилаа гол болгодог. Энэ бол энэ хоёр зүйлийн урлагийн хоорондын хамгийн үндсэн ялгаа болно. Иймээс уран зохиолын бүтээлийг теле киночлох үед уран зохиол дахь зарим дүр, зарим үйл байдалд тохируулалт хийх хэрэгтэй болж байна.

Нэг. Дүр төрхийн дахин бүтээлт

Дүр бүтээлт бол уран бүтээлийн амжилт олж чадах эсэхийн чухал элементийн нэг мөн. Сонгодог бүтээл нь хүмүүст гүн суугдан үлддэг нь мэдээж зохиолын баатраас шалтгаалдаг. Уран зохиол ба телевизийн кино дүр бүтээх арга нь өөр. Уран зохиолын дүр бүтээлт нь зохиогчийн үзэл санааных нь хийсвэр үүдэлтэд түшиглэсэн бүтээгдэхүүн болдог учраас зохиолын баатрын олонх нь маш зөрчилтэй, балархай чанартай байдаг. Гэтэл кино телевиз дахь дүр бол үнэн бодитой амьдралын орон зай дахь оршихуй байх учраас дүр нь ахуйн чанартай байдаг. Иймээс кино телевизийн явцад зөрчилтэй дүрийг өөрчлөх, зөрчилгүй дүрийг зөрчилдүүлэх маягаар өөрчилдөг.

(Нэг.) Зөрчилт дүрийг зөрчилгүйжүүлэх

Зөрчилт дүрийг зөрчилгүйжүүлэх үзэгдэл телевизийн киноны явцад байнга тохиолддог. Уран зохиол нь цагийн хязгаарлалгүйгээр нэгэн бүрэн бүтэн амьд дүрслэг дүрийг бүтээж чаддаг бол телевизийн кинонд цагийн хязгаарлалаас болж, найруулагч уран зохиолын бүтээлээс гол үйл явдлыг сонгож дүрд үйлчлүүлж, гол бус үйл явдлыг нь хасах буюу багасгадаг. Энэ нь дүрийн зөрчлийн байдалд нөлөөлж, зөрчилтэй дүрийг зөрчилгүй болгон үзүүлдэг. Жишээ нь “Улаан шиш” хэмээх зохиолын эрэгтэй дүр Юй зан юу бол алдартай домогт баатар бөгөөд хар хортой дээрмийн тэргүүлэгч байсан юм. Японыг эсэргүүцэх дайны үед тун зөрчилтэй дүрийг бий болгосон байна.

Хуарт хүзүү Дэй фен лианыг дээрэмдэж 1000 зоос авна гэхэд Юй зан юу урьдгаар дахин зоос гаргаж Хуарт хүзүүд өгч тэдний амьдралыг дахиж үймүүлэхгүйг баталжээ. Гэтэл Юй зан юу долоон тэргүүлэгч цэцэгт буунд сайн сурч, эцэстээ Хуарт хүзүүг алжээ. Энэ нь Юй зан юуны арга бодлого байсан бөгөөд түүний хар хортойг харуулсан юм. Киноны Юй зан юу бол дээрмийн тэргүүлэгч биш бас өөрийн санаагаар хүн цохиж алсан ч биш, харин нэгэн энгийн тариачны дүр байдаг. Тэгвэл Занг мео найруулагч Юй зан юугийн дүрийн хувиралтын тухай ингэж тайлбарлажээ.

“Үзэгчдийн дээрмийн тухай ойлгогдохуун нь хүний сэтгэлгээ ба сэтгэлийн нэвтрэлцээнд харшилж, дүрээр дамжин илрүүлэх гэж байгаа гол сэдэвтэй зөрчилтэй. Иймээс бид түүнийг энгийн тариачны байранд тавьж, түүний бие дээрх оргилом халуун амь насны дүрийг илрүүлэхэд хүч тавина” [2]

гэв. Кино жүжигт Юй зан юуны идэвх чанарын товойлгон байдлаар дамжин зөв талын дүрийг бүтээж богино хугацаанд үзэгчдийн сэтгэлд хүрчээ. Телевиз жүжгийн цаг ба агуулгын багтаамж нь кино жүжгээс чөлөөтэй болохоор дүр бүтээх талаар киноноос хол багтаамжтай байдаг.

“Улаан шиш” гэх телевиз жүжигт Юй зан юуд хоёр удаа өөрчлөлт гарав. Энгийн тариачнаас дээрэмчин болж, тэгээд дээрэмчний тэргүүлэгчээс зүй ёсны журамт дээрэмчин болон хувирч. Аажмаар Японыг эсэргүүцэх үндэстний баатар болон хувирчээ. Үүнийг зохиолтой нь харьцуулбал цагийн уртаар хязгаартай ч, Юй зан юугийн идэвх чанарыг товойлгохын төлөө жүжгийн үйл явдалд зохих хэмжээний тохируулалт хийх хэрэгтэй болно. Жишээ нь зохиолд санаатайгаар хүн алсныг гар алдаж хүн алсан гэж өөрчлөв. Түүнд алагдсан нь эсрэг талын дүр болохоор үзэгчид зөв талын дүрийг өрөвдөхөөр барахгүй, түүний эрэлхэг баатар зоригийг ч ойлгож, үнэлж чадна. Телевиз жүжигт Юй зан юу болон Хуарт хүзүү, шианы даргын хоорондох зөрчил ба Юй зан юугийн төрөл садан амь үрэгдсэн зэргийг дэлгэн үзүүлж, Юй зан юугийн найр журмыг хүндэтгэсэн талыг чухалчлан үзүүлж, зохиол дахь төв бөгөөд гажуу зөрчилтэй дүрээс найр журмыг хүндэтгэж, үндэстний төв журмыг хөөцөлдсөн зөв талын баатар болжээ.

Дараа нь эмэгтэй гол баатартай Фен лиан. Зохиолд Дай фен лиан бол арван хэдэн настай хөдөөгийн хүүхэн боловч цөс зоригтой, арга самбаатай, хурц сэргэлэн эрс тасархай, ёс суртахууны хүлээслэлийг эвдэх амьжралын хүчинтой аруухан баатар байдаг. Тэр Лувэ ханаар шиш худалдан авах өдрийг хойшлуулж, худалдан авах үнээ бууруулж, Лувэ ханы цустай шишийн архийг тэргүүлэн уусан зэрэг нь Дай фен лианы хурц сэргэлэн ба түүний цөс зоригтой байхыг үзүүлсэн юм.

“Улаан шиш” гэдэг кинонд Юй зан юугийн хоорондох учрал болон Юй зан юуг өдөн, япон хүний машин тэргийг дэлбэлснээс гадна бусад үйл явдлыг хасаж, зохиолд бүтээсэн юунаас ч айхгүй баатарлаг дүртэй харьцуулбал, кино нь үнэн сайн сайхныг товойлгон, цэвэр ариун эмэгтэй хүний дүрийг үзүүлжээ. Энэ дүр нь охорхон хугацаанд олны ташаасан дуртай дүр болсон. “Улаан шиш” телевиз жүжгийн эмэгтэй дүрийг ч ингэж шийдвэрлэжээ. Найруулагч зохиолын үндсэн дээр тус хүний сүүдэртэй талыг

хасаж, хурц чадамгай, зөв буруу тодорхой, үндэстний төв ёсыг мэддэг эмэгтэй баатрын дүрийг бүтээсэн байна.

(Хоёр) Зөрчилгүй дүрийг зөрчилтэй болгох

Уран зохиол ба телевизийн кинонд зөрчилгүй дүрийг зөрчилтэй болгоход зохих тооны хавсрагч дүр гарч ирдэг. Тэд гол дүрийн, дүрээ бүтээхэд оролцлог. Телевизийн киноны явцад найруулагч зохиолын зөрчилгүй дүрийг бодит болгон, тэдний давуу ба дутагдлыг арилгаж, хүн хүний хоорондох зөрчлийг бий болгоно. Жүжгийн үйл явдлыг улам төгөлдөржүүлэн телевизийн кино жүжгийн шинжийг улам чангаруулна. “Улаан шиш”-ийн зохиолд Луве хан бол архи нэрэгч, гэрийн эзэндээ үнэнч шударга, Дай фен лианыг хүрээлдэг эелсэг дүр байдаг. Цор ганц удаагийн ширүүн эсэргүүцэл нь гэрийн эзнийхээ хоёр илжгийг хамгаалахын төлөө байдаг. Энэ нь түүний улсаа хайрлах илрэл болж, эцэстээ япон цэрэг арьсыг нь өвчиж олонд үзүүлэв.

Энэхүү үйл ажиллагаа нь Гоо ми үндэстний зориг санааг сэргээжээ. “Улаан шиш” кино нь Луве ханы угийн дүрд Эв хамт намын гарлыг нэмэгдүүлж, түүнд нэлээд өндөр үзэл санааны ухамсар олгож, япон цэргүүдэд арьсаа өвчүүлж хорлогдсон үйл явдлыг нэн зохистой болгож, түүхийн үнэнийг гүнзгийрүүлж өгчжээ.

“Улаан шиш” телевиз жүжиг дотор Луве ханы дүрийг ихээр өөрчлөн найруулж, хүний дүрийг нэн баялаг болгожээ. Нэг нь найруулагч Дай фен ляны хайр сэтгэлгээний шугамыг хасаж, Шоу шианы хайр сэтгэлийн шугамыг нэмж, япон цэрэг арьсыг нь өвчиж, олонд үзүүлсэн хэсгийг Шоу шиантай цаазын хурим болгон өөрчлөн найруулж, хүний дүрийг ил тод онцлогтой болгож, ард түмний цуст чанарыг товойлгожээ.

Нөгөө нь Луве хан хийгээд шишин архины харьцааг дахин шийдвэрлэж, Луве ханыг энгийн нэг архи нэрэгчээс нэртэй архи нэрэгч болгон өөрчлөн нэг ам амталбал даруй архи нэрсэн он жилийг хэлж гаргаж дайлна. Тэр япон цэрэгт баригдсан нь япон цэрэг амуу будааг хэтэрхий татварлан, шишийн тариаг эвдсэнээс болж Луве хан уурлаж, япон цэргээс өшөө авснаас болсон юм. Энэ нь Луве ханы шишийн архи дахь хайр сэтгэлийг улам тодорхой илрүүлж, дүрийг нэн өвөрмөц шинжтэй болгожээ.

Теле киноны явцад дүр бүтээлт нь маш чухал болно. Телевизийн киноны дүр бүтээлт нь уран зохиолтэй адилгүй, цагийн хязгаарлалаас болж найруулагч нь зөвхөн гол үйл явдлыг нь сонгож дүр бүтээдэг. Зохиол дахь дүртэй хэдий ойртсон ч бүрмөсөн сэргээж чадахгүй. Иймээс зохиол дахь зөрчилтэй дүрийг зөрчилгүй болгох, зөрчилгүйг нь дүрийг зөрчилтэй болгох бол телевизийн киноны явцад ямагт тохиолддог дүр бүтээх арга мөн. Найруулагч ийм хэлбэрээр нэн амьд дүрслэг дүрийг бүтээж, теле киноны жүжиглэг шинжийг чангаруулан үйл явдлыг ахиулдаг.

Хоёр. Орон зайн дахин бүтээлт

Орон зай бол жүжигчдийн тоглох гол талбар, орон зайг зураглах байдлаар дамжин текстэд нуугдаж баягаа гүн гүнзгий сэтгэлгээ ба бат

зогсолтыг илрүүлдэг. Орон зайг ерөнхийдээ гурван төрөлд хувааж болно. Энэ гурван төрлийн орон зай нь харилцан сүлжилдэж, бодит ба хийсвэр давхаргаас текстийн дотоодод гүн гүнзгий агуулагдахууныг олгодог. [3]

Нэгд, Байгалийн орон зай: Энэ нь ердөө текст доторх байгалийн орчин тойрны, байгаль ертөнцийн аяндаа бий болсон хүмүүсийн нөлөөг хүртэхгүй орон зайг заадаг .

Хоёрт, Нийгмийн орон зай: Энэ нь нийгмийн ажиллагаа ба нийгмийн зохион байгуулалтын эзэлж байгаа орон зай байж, хот буюу барилгатай холбоотой, олонх байдалд энэ бол хүн хийгээд хүний хооронд харьцаа байгуулах гол талбар болно.

Гуравт, Соёлын орон зай: Энэ нь ер нь хийсвэр, байгалийн орон зайгаар суурь болгож, нийгмийн орон зайгаар нийгмийн онц чанарыг илрүүлдэг.

(Нэг.) Далд зүйрлэлийн чанартай орон зай: Байгалийн орон зай

Хэрэв Анайн “Буцашгүй төрөл” туужийг Жежиан мужийн Бин хай хотын нутаг усаа хүүрнэсэн бүтээл гэж хэлэхэд хүрвэл, нутаг усны тухай эргэцүүлэл ба мөрөөдөл нь уг зохиолын чухал онцлог болсон байна. Зохиолд их хэмжээний орчин тойрныг дүрслэн бичсэн нь үсэг бичгийн чөлөөт дүрслэлтэй холбоотой. Орчин тойрон ба хүний хөгжлийг яг хамтад нь дүрслэх боломжгүй болохоор, ээлжлэх байдлаар зохиолдоо уусган оруулжээ. Иймээс, уран зохиол орчин тойрон нь нэг зүйлийн сэтгэлгээ ба зогсолтын төлөөлөл болдог. Зохиолын төгсгөлд ингэж бичжээ:

Тайфун салхи, Номхон далайн усан уураас бий болж, түүнийг бузгайруулан, түүнд сүр хүчин олгодог. Гэвч Номхон далайн онцгой агаарын урсгал түүнийг хавчиж түүнийг өдөөн хөдөлгөдөг, тэр өөрийн эрхгүй байдаг. Тайфун салхи бол их гангийн үеийн хур бороон, аагим халуун үеийн сэрүүн салхи, мөн ч газрын гамшиг, гэр хотлоорыг сөнөөнө! Салхины нүд бол Тайфун салхины бодлогошрол, далай тэнгис болон эх хуурайн мөргөлдлийн агшин зуурын нам гүм байдал болно. Тайфун салхи мөргөлдлийн дунд урагшилж, үргэлжлэн урагшилж, буй бүхий Тайфун салхины их хандашийг дагана. [4]

Зохиолын баатар Шиу бан шиан яг тайфун салхи шиг цаг үеийн хөгжилтийн дунд, өөрийн хурц чадамгайдаа түшиглэн цаг үеэс олгосон аз тохиолын дунд хөгжин бузгайрч байгаа боловч тайфун салхи шиг их урсгалд хамрагдан урагшилснаас болж өөрийн зарим зүйлсийг хаяхгүй байхын аргагүй болжээ. Хэдийгээр тэр өөрөө гэмшин харамссан боловч, тэр нэгэнт буцаж дчадахгүй болжээ. Зохиогчоос тайфун салхи, Номхон далай, салхины нүд зэрэг байгалийн үзэгдлээр дамжин Шиу бан шаны үйлс бүтээх зам дахь нугарал бүдрэл илтгэжээ. Телевиз жүжигт, орчин тойрон нь ар үзэгдэл болон үйл явдал ба хүний хөгжилт дагалдан илэрч, далд зүйрлэлийн үйлдэл үзүүлдэг.

Иймэрхүү далд зүйрлэл нь утга зохиол дэх сэтгэлгээ ба зогсолтын далд зүйрлэлтэй адилгүй. Харин найруулагчийн бүхий л зохиолын тухай ойлголтыг тусгадаг. Анайн “Буцашгүй төрөл”-ийн үүсмэл бүтээл “Салхинд үлээгдсэн

зожир”-т, таван хүн гадаадад гарч, болд худалдан авах үед ширээн дээрх даван тохсон хүүхэлдэй нь тэдний урхинд орсныг далд зүйрлэжээ.

Гэвч хамгийн бага хүүхэлдэй нь нөгөө дөрвөн хүнээ харж юу нэгийг сэтгэж байгаа шиг энэ нь яг хамтран ажиллах үеийн бусад хүний тархи толгой нь хөөрч, зөвхөн Шиу бан шан л сэжиглэж, үнэн худлыг бодолхийлдогтой адил. Үүнээс гадна телевиз жүжиг “Салхинд үлээгдсэн зожир”-ийн Шиу бан шангийн адил босгох анхны үед, болд овоолох газар ба гарам байгуулахын төлөө загасчны нэг хэсэг сайргалыг худалдан авах гэсэнд, загасчин тасралтгүй үнээ өсгөсөнд Шиу чен арга гаргаж, Дүн шиу чи хүн дагуулан сайргалыг бузартуулж, хууль бус аргаар тэр хэсэг сайргалыг түрээсэлжээ.

Энэ бол Дүн шиу чи хүн дагуулан голын сайргалыг бохирдуулж бараад, дээрээс дорогш харах үеийн зураг болно. Найруулагч гэрлийн гэгээн харанхуйн харьцааг гүйцэд ашиглан араас нь гэрэл цохих үес өмнө нь хав харанхуй, энэ нь тэдний гэгээн саруулаас харанхуй зүг явсныг далд зүйрлэжээ.

Жүжигт, Шиу бан шан дотоод сэтгэлийн зэмлэлээс болж хохирол хүртсэн гэр бүлд буруу хүлээсэн бөгөөд тэдгээрт зоос өгсөөр иржээ. Эцэстээ Шиу бан шан болон Дүн шиу чи хууль цаазын шийтгэл хүртжээ.

(Хоёр) Бодит чанартай орон зай: Нийгмийн орон зай

Байгалийн орон зай бол хийсвэр оршихуй болохоор телевизийн кинонд далд зүйрлэлийн агуулгаа олгодог. Нийгмийн орон зай нь бодит ухамсрын оршихуй байж, хүн ба хүний хоорондох харьцааг бичихийг нэн чухалчилж нийгмийн харьцааг бий болгодог.

Телевизийн кино нь тоглогчийн тоглолтоор дамжин үзэгчдэд нийгмийн харьцаа үнэн гэдгийг итгүүлэх хэрэгтэй. Телевизийн киноны үнэн бодит чанар ба байгаллаг чанарыг батлахын тулд уг зохиолын хүний хоорондох харьцаа ба хэсэг үйл явдлыг өөрчлөн найруулах хэрэгтэй. “Салхинд үлээгдсэн зожир” телевизийн кинон доторх “үйл хэрэг босгох гурван хүний дугуйлан”-ийн хоорондох хүмүүсийн харьцаа нь зохиолтой адилгүй. Зохиолд Шиу бан шан, Дүн шиу чи, Шиоёо чен нар бага сургуулиас дээд дундад хүртлээ хамт өсчө, Шиу бан шан хэдийгээр хүүхэн боловч, зодолдоонд өмнө нь ямагт тэргүүлдэг учир, “галын ах” гэж маш олон эрэгтэй хүүхдүүд дууддаг. Зохиолд Дүн шиу чи гяндангаас гарч ирээд Шиу бан шаны компанийн бараа тээвэрлэх ажлыг Дүн шиу чид даалгасанд Шиу чи маш шуурхай зөвшөөрчээ. Үүнийг зохиолд ингэж дүрсэлжээ.

“Шиу бан шан олон хор амссаныг Дүн шиу чи асуусангүй боловч мэдэх байлгүй, өндөр дундаас эхлэн ийм байдалтай, галын ах ерөөс өмнө нь гавшгайлж, хүчрийг хүнээс өмнө амсаж, жаргаж цэнгэхээс ч хоцрохгүй, тэр Шио чентай хамт Шиу бан шаны үгийг сонсож даджээ. Аль эртнээс гайхахгүй болжээ”. [4]

Тиймээс Шиу бан шаны дүр нь багаасаа хоёулын сэтгэлд үлдэв. Гэвч телевиз кинонд Шиу чен болон Шиу бан шан бол унаган багын найз, Дүн шиу чи ээждээ өвчин үзүүлэхийн тулд худгийн хавхаасыг хулгайлж, Шиу бан шан болон Шиу чений хаягдмал бодисын талбайд ирж худалдах үес Шио чен худгийн хавхаас нь хууль бус юм болохоор хураан авах дургүй байхад Шиу

бан шан Дүн шио чи-г өр өвдөн зоос өгч, худгийн хавхаасыг нь буцаалгав. Дүн шио чи сэтгэл догдолж, Шиу бан шан болон Шиу чентэй хамт үйлс босгохоор болж, гурвуулаа энэ үед танилцав. Иймэрхүү тохируулалт нь нэн өргөн удам нийгмийн үзэмжийг бүрэлдүүлж, энэхүү нийгмийн үзэмж нь нэн үнэн бодитой, цагийн онцлог ба орон зайн онцлогийн талаар нэн бодитой болж, хүүрнэлийн давхарга дээр хүний хоорондох логикийн харьцааг зүгшрүүлж чаджээ.

Үүнээс гадна нийгмийн орон зайн зураглалд телевиз жүжигт Шиу бан шан загасчин сайргалыг түрээслэх гэж тосгоны даргатай ярилцсанд тосгоны ард үнээ ахин дахин өсгөв. Тэгээд Шиу чен арга гаргаж, Дүн шиу чи голын сайргалд тэрэгний тос асгаж сэмээр бохирдуулав. Шиу бан шан мэдсэний дараа Дүн шиу чийн хацрыг алгалан гэрээсээ хөөн гаргав. Гэвч зохиол нь үүнтэй адилгүй ба тосгоны ардын хэдэнтээ үнэ өсгөсөн ажиллагаанд Шиу бан шан шүд зуун хорсож байлаа. Зохиолд:

“Би үнэхээр хүн хөлсөлж сайргал дээр нь юу нэгийг услан энэ хэсэг сайргалыг бохирдуулан хямдаар авах гэж бодож байна” Дүн чи бодож үзээд: “Миний нэгэн ах дүү буй. Надаас өмнө гяндангаас гарч ирсэн юм. Тэр яг энэ хэсэг загасчны эзэрхэгч байсан юм. Би түүгээр нэг онгоц хаягдмал тос тээвэрлүүлж болно. Түлхээн өсөх үед хаягдмал тосыг асгая, тэр үед тосгоны хүмүүс ахдахдаа дотроо боджоос биш чамаас өө сэв эрж чадахгүй, ийм гадар орны онгоц ч чамтай хамаагүй” гэв. Шиу бан шан сонсмогц ширээ алгалан: “Хурдал, барилгын анги удалгүй орж ирэх гэж байна. Чи тэрэгнээс буумагцаа найзтайгаа харилцаарай” [4]

гэв. Иймээс Шиу бан шан далайн данг эвдэх явдлыг мэдэх мөртлөө хоёр гараа өргөн зөвшөөрсөн байна. Телевиз жүжигт, энэ хэсэг сайргал нь зөвхөн газар зүйн утга агуулга дээрх орон зай биш, тэр нь зураг дүрс, дуу чимээ зэргээр дамжин үзэгчдийн өмнө бодитой илэрч, түүний дотор агуулагдаж байгаа нийгмийн харьцаа ба хайр сэтгэл нь уран зохиолоос нэн будилаантай бөгөөд нэн баялаг болсон байна.

(Гурав) Үндэстний чанартай орон зай: Соёлын орон зай

Телевизийн кино дотоодод байгалийн орон зайгаар суурь болгож, нийгмийн орон зайгаар нийгмийн онц чанар болгосон нэг зүйлийн орон зайг бүрэлдүүлдэг. Тэр нь даруй соёлын орон зай. Тэр цаг ямагт уйл явдлын хөгжилтийг дагалддаг. Уран зохиол болон теле кино нь зөвхөн нэг зүйлын урлаг болохоор барахгүй, нэн ч нэг улс үндэстний хөгжилтийн явцын гэрч мөн. “Салхинд үлээгдсэн зожир” бол БНХАУ-ын цаг үеийн хөгжлийн хураангуй дүрс болно. Үйл хэрэг босгохын өмнөх хугацаанд “үйл хэрэг үүсгэх гурван хүний дугуйлан”-ын хайр сэтгэлээр гол болгож, тэд гурвуул хамтаар үйл хэргээ босгож, хаягдмал болдыг амжилттайгаар гадаадаас оруулсан нь 1996 оноос 1997 он хүртэлх том хэлбэрийн үндсэн бүтээн байгуулалтын ахуй байдалтай нийцэж байна.

Үйлс босгосон дунд хугацаанд амжилттайгаар болдын үйлдвэр байгуулсан нь 1997 оноос 1999 он болтол улсаас ардаас эзэгнэсэн аж ахуйллыг

тэтгэж байсан их ахуй байдалтай зохицолдуулан, БНХАУ-ын аж ахуйн хөгжилтийн байдалтай нийцэв. Үйлс босгосон сүүлчийн хугацаанд арилжааг улсын гадаадад хандуулж, “оруулж авчрах” ба “гадагш гаргах”-ыг уялдуулж, тасралтгүй цэгцлэв. Тэд эрх чөлөөт дур таваар эзэгнэж байснаасаа дүрэмтэй эмх дэглэмтэй эзэгнэн, идэвхтэй өөдлөн давшсан нь БНХАУ-ын цаг үеийн хувиралт болон аж ахуйн хөгжлийг дэлгэн үзүүлж чаджээ. Энэ нь нэг зүйлийн гүн гүнзгий түүхийн зураг дүрсийг дэлгэн үзүүлжээ. Иймэрхүү зураг дүрс нь хэрэг дээрээ байгалийн орон зай ба нийгмийн орон зайн хооронд нийцсэний дараа бий болсон холбогдол бүхий үндэстэн буюу улсын соёлын үзэмж болно. Тэр нь зохиогчийн тус биеийн бодит ойлголт төдий биш, бас ч тус үндэстнийхээ нийгмийн харьцааны бүрэлдлийн онцлогийн тухай магадлал болох юм.

Теле киноны бүтээл нь эцэстээ тус үндэстний хамтаар мэдэрсэн соёлын орон зайн хэлбэр, мөн ч бодисын орон зайд хадгалагдаж байгаа үндэстний зориг санаа ба хэв намбыг уламжилсан байдаг. Иймэрхүү үндэстний зориг санааны агуулгаа нь телевизийн кино текстэд шууд илэрч чадахгүй харин хайр сэтгэл ба өртгийн давхаргаар дамждаг. Жишээ нь, “Салхинд үлээгдсэн зожир” теле жүжгийн завсрын дуу нь олонх нь цөм ерээд онд дэлгэрч байсан дуу болно. “Миний нүдэнд чи л байна”, “Салж ядам”, “Уудам огторгуй”, “Их дундад улс”, “Хаврын сайхан туяа” зэрэг дуунууд нь нэг бүлэг хүмүүсийн дурсамжийг сэргээж, нэг бүлэг хүмүүсийн хүрээллийг олсон байна. Эдгээр дуу нь теле жүжгийг нэн цаг үеч чанартай, үндэстний чанартай болгосон байна. Уран зохиолоос телевизийн кино бүтээл хүрэх бол нэг зүйлийн текстийн хоорондох давалт мөн. Зохиогчийн зохион бүтээлтэй байгалийн орон зай, нийгмийн орон зай ба соёлын орон зай харилцан сүлжилдэж байдаг. Телевизийн кино бүтээлд байгалийн орчин тойрон нь хүмүүсийн хөгжилт болон үйл явдлын ахицтай хамтад нь илэрч, завсрын дуу зэргээр дамжин уран зохиолын текстийг нэн гүнзгий агуулгатай болгожээ.

Гурав. Утга агуулхууны дахин цогцлол

Зохиол ба телевизийн кино нь багажаар илтгэх айд харьяалагдах бөгөөд ертөнцийг дуурайхад багтдаг. Гэвч энэ хоёр нь илэрхий ялгаатай байдаг. Нийгэм ба аж ахуйн түргэн хөгжлийг дагалдан, хүмүүсийн хөөцөлдөл нэн орчин үежсэн ба өвөрмөц болжээ. Телевизийн киноны мэргэжил нь яг орчин үеийн шинжлэх ухаан мэргэжлийн арга барилаар утга зохиолын бүтээлийг дэлгэн үзүүлж, утга зохиолын бүтээлийг нэн амьд дүрслэг, нэн ойлгомжтой илрүүлсэн бөгөөд утга зохиолын сонирхолт шинжийг нэмэгдүүлсэн байна. Занг мао найруулагч Мо яны бичсэн бүтээлтэй учрах үед амьжралын хүчнээр бялхам үндэстний тууль “Улаан шиш” мэндэлжээ. Тай фен лиан Ван венийн эхнэртэй хамт япон золигийг цохисон партизан ангийнханд боов хүргэх үед зохиолд: Миний эмээ нэг дамнуур боов дамнаж, Ван венийн эхнэр ногоон буурцгийн шөл дамнаж, Муе шүй хе гол дахь харсалтай том чулуун гүүрийг олж харжээ. Эмээ нь баярлангуйгаар Ван венийн эхнэрт: “Бэргэн ээ! Зовлон амссан боловч хүргэж ирэв “ гэж хэлэв. Эмээ харьд мордсоны дараа.ер нь хал амссангүй болохоор энэ хүнд боов нь

түүний зөөлөн мөрийг нь нэг гүн бор тамга дарж, энэхүү бор мөр нь түүнийг дагалдан хүний ертөнцөөс салж тэнгэрт гарав. Энэхүү бор мөр бол миний эмээгийн эрэлхэгээр японыг эсэргүүцсэн яруу алдрын бэлгэ тэмдэг мөн. Аав эмээгийн цээжин дээр хоёр буудсаныг нүдээрээ олж харав. Эмээгийн нуруун дээр, хөвөө нь урвасан хоёр бууны сумны нүхтэй. Нэг шинэ соргог шишийн архины үнэр тэр нүхээс гарч иржээ. [5] Тай фен лиан хамгийн сүүлд суманд оногдон нас барж урссан цус нь шишийн тариаг улайлгав.

Уран зохиол нь уншигчдад баялаг төсөөлөн бодолтын орон зай хангав. Занг маогийн найруулсан кинонд энэхүү байдлыг маш урлагийн чанартай шийдвэрлэжээ. Кинонд олон улаан өнгийн зураглал бий. Шиш нь улаан өнгөтэй, шишийн архи нь улаан өнгөтэй, галын дөл нь улаан өнгөтэй, баатруудын цус нь ч улаан өнгөтэй байдаг. Шиш, архи, цус, дайны гал нь киног оргилд хүргэж, түрэмгийлэгдсэн үндэстний цөхөршгүй сүг сүнс ба чанга хүчтэй амьжралын хүчнийг илрүүлжээ. Үүнээс гадна Лиан шиу шенгийн “Хүний ертөнц” хэмээх зохиолын I бүлэгт хамтын цэнгэлийн тойргийн ирэлт жич үлгэрийн ахуй байдлыг нарийн тодорхой үзүүлсэн бөгөөд ойлгогдошгүй түүхийн мэдлэгийг ч харуулжээ. Хэрэв сэтгэл тавин уншихгүй бол ойлгоход бэрхтэй байж мэднэ. Телевиз жүжиг харин бүрмөсөн адилгүй, үйл хэрэг үүссэн газрыг нуур цөөрөм, уул ус, цаст тал, мөрөн гол, тутарганы түрүү, хот, галт тэрэг зэрэг аль олон аугаа сүрлэг зургаар үзүүлж, дараа нь гэр бүлийн хамтын сүүдэр сүүдэрлэсэн үзэгдэл, хэсэг зээлийн үзэмж, гол баатрын суугаа газрыг сүүдэрлэжээ.

Эхлэлтийн хуудас нь ихэмсэг, өчүүхэн ч сунжруулалгүй, товч авсаархан болохоор үзэгчид хүч оруулж бодолхийлох чухалгүй болжээ. Уран зохиол дахь зохиогчийн зурагласан ертөнц маш нарийн, түүний дайралтын хүчин нь дотогшоо байж, хүмүүст оюун санааны ханамжийг олгодог. Телевизийн кино бүтээл нь зураг, харааны дүр, үг хэл, дуу зэрэг телевизийн киноны хэлээр дамжин харааны дайралтыг авчирч, хүмүүст охорхон хугацааны хангамжийг олгодог. Алдарт найруулагч Занг мао: “Би ерөөс БНХАУ-ын кино БНХАУ-ын утга зохиолоос салж чадахгүй гэж үздэг. Киноны хөгжилтийг нарийн ажиглавал, аливаа дорвилог кино бүр өгүүллэгийг үндэслэн өөрчлөн найруулсныг олж мэднэ. БНХАУ-ын кино нь хэзээд утга зохиолоос салж чадахгүй” [6] гэжээ.

Утга зохиолоос салсан телевизийн кино бүтээлийн утга санаа хүйтэн бөгөөд болхи бүдүүлэг, утга зохиол бол телевизийн кино бүтээлийн аваад баршгүй, хэрэглээд дуусашгүй ховор нандин эх баялаг мөн. Хэрэв чи хөл доорхи 960 түмэн тэгш дөрвөлжин километр нутаг дэвсгэрт гүн зузаан хайр сэтгэлтэй бол Фен шиу ганы сүүдэрлэсэн “1942” -г үзэхээр барахгүй, нэн ч Лю жен юны уул бүтээлийг унших хэрэгтэй. Хэрэв хөрөнгөтөн ангийн доройтлыг ойлгоё гэвэл “Модены цаг үе”, “Иргэн Кейн”, “Америкийн гоё хүн” -г үзэхээр барахгүй, Фижиратын “Ер бусын гайцеб”-г унших хэрэгтэй. Телевизийн кино бүтээл нь уран зохиолыг орлож болохгүй. Телевизийн кино бүтээлийг гүн болгох гэвэл гоо таашаалын чанарыг дээшлүүлэхээр барахгүй нэн чухал нь уг зохиолыг хүндэтгэж, зохиогчоос уг зохиолын гол үзэл санааг эзэмших хэрэгтэй. Шилдэг уран зохиолын бүтээл нь телевизийн кино бүтээлд соёлын агуулхуун ба оюун санааны агуулхуунаар хангана. Уран зохиол нь дотоод

дахь нарийлаг содчилсон зураггүй ертөнцийг зураглаж, кино жүжиг бол гадаад дахь олон түмэнчилсэн дүрстэй ертөнцийг зураглана. Хэдийгээр хоёулангийнх нь илтгэх арга зам ба арга барил нь адилгүй боловч телевизийн киноны бүтээл нь утга зохиолоос ирэлтэй байдаг. Бахекин: “Дан цулгуй дуу нь юуг ч дуусгаж чадахгүй, юуг ч шийдвэрлэж чадахгүй. Хоёр янзын дуу бол сая амь насны хамгийн доод нөхцөл, оршин тогтнох хамгийн доор нөхцөл мөн” [7] гэжээ. Утга зохиол болон телевизийн кино хоёрын адил бус дуу нь эцэстээ “том бүтээл”-г бүтээж чадна.

Дүгнэлт

Уран зохиол ба телевизийн киноны бүтээл бол хоёр зүйлийн адил бус урлагийн хэлбэр мөн. Телевизийн кино бол уран зохиолын орчин үеийн илэрхийлэл мөн ч ирээдүйн хөгжилтийн зайлшгүй хандаш мөн. Уран зохиол ба телевизийн кино бүр ертөнцийг дуурайж байгаа боловч дуурайх хэлбэрийн адилгүйгээс болж зохиолын дүрслэл ба зураг дүрсийн илэрхийлэл нь нэлээд их зөрөөтэй байдаг.

Тус өгүүлэлд голдуу зуучлуурын мэргэжлийн хөгжлийг дагалдан, уран зохиол телевизийн кино бүтээл тийш шилжих үед, өөрөөр хэлбэл зохиолын илэрхийлэл нь зураг дүрсийн илэрхийлэл зүг шилжих явцад уран зохиолд илэрсэн хувиралтыг задлан шинжилж, уран зохиол ба зураг дүрсийн харьцаа ба зөрөөг хайн шинжилжээ. Нийгмийн аж ахуй ба цаг үеийн хөгжлөөс болж хүмүүсийн хөөцөлдөл нэн орчин үежсэн бөгөөд өвөрмөц болж, зохиол болон зураг дүрсийн хооронд улмаас улам нягтарч аль нь ч дутагдаж болохгүй болжээ. Уран зохиол нь үсэг бичгээр дамжин уншигчдын оюун санааны ертөнцийг төгөлдөржүүлж, зураг дүрсийн илэрхийлэл нь телевизийн киноийн хэлээр дамжин үзэгчдийн хараан сэрэлд түр зуур сэдэлт өгч, уран зохиолыг үнэн бодитойгоор үзэгчдийн өмнө дэлгэн үзүүлдэг. Телевизийн кино нь төв чанга, эрхэмсэг уран зохиолын бүтээл болон хялбар ойлгомжтой, зугаа цэнгэлийн шинжтэй телевизийн киноны бүтээлд зохицолдох цэг олгож, утга зохиолын “гүн” ба телевизийн киноны “гялс цэг” -г бүтэмжтэй уялдуулсан байна.

НОМ ЗҮЙ

- [1] 张伟强.热点文学作品的影视化改编[J].新闻研究导刊, 2016,(7).
- [2] 中国电影出版社中国电影艺术编辑室编《中国电影艺术家研究丛书·张艺谋》, 中国电影出版社, 1994年, 第161页。
- [3] 黄海贝、张晓龙.《红高粱》影视化创作的空间特征--从文本到文本的跨越[J].电影文学, 2019,(21).
- [4] 阿耐著《不得往生》, 四川文艺出版社, 2012年, 第1336, 14, 15-16页。
- [5] 莫言著《红高粱家族》, 浙江文艺出版社, 2017年, 第121--124页。
- [6] 李尔崑著《张艺谋说》, 春风文艺出版社, 1998年, 第10页。
- [7] 钱中文主编, 白春仁、顾亚铃译《巴赫金全集第5卷 诗学与访谈》, 河北教育出版社, 1998年, 第340页。

УРЛАГИЙН ДҮР ХИЙГЭЭД БЭЛГЭДЭЛ

*(Малчин зохиолч Эрдэнэтогтохын “Тэнгэрийн хатавчны өмнө”
романы жишээн дээр)*

ХАСЧИМЭГ

*(БНХАУ, ӨМБИС-ийн Монгол судлалын
дээд сургуулийн 2023 оны аспирант)*

Агуулгын товч: Амьдралын үнэн ба урлагийн үнэнийг дээд хэмжээгээр нэгтгэсэн хүүрнэл зохиолд реалист байдлыг үзүүлэхдээ уран дүрээр дамжуулж цаг эриний үзэл ухамсрыг тусгасан байдаг. “Тэнгэрийн хатавчны өмнө” романд өнчин тэмээний дүрээр амь ахуйн эвдэгдэл, хүн амьтны оршихуйн асуудлыг үзүүлж, үүнд тусгагдсан Монголчуудын амьдрал ахуй, соёл зүй, бэлгэдэл санааг тусгажээ.

Түлхүүр үг: “Тэнгэрийн хатавчны өмнө”, Урлагийн дүр, Бэлгэдэл

Малчин зохиолч Эрдэнэтогтох 1968 онд Шилийн гол аймгийн Шулуун хөвөөт цагаан хошууны Их нуур сумын Отолт хэмээх газарт төржээ. 1980-аад оноос шүлэг яруу найргаар уран бүтээлээ эхэлж, 1986 онд “Сүнс” хэмээх анхны өгүүллэгээ нийтлүүлэв. “Араг үүрсэн ээж” шүлэг нь “Өнөр цэцэг” сэтгүүлийн 1999 оны богино шүлгийн уралдааны нэгдүгээр байр, “Холд хөөрөх нарны дуу” шүлгээрээ “Шилийн голын өдрийн сонин”-ы малчин зохиолчдын шүлгийн уралдааны нэгдүгээр байр эзэлжээ. 2002 онд “Тэнгэрийн хатавчны өмнө”, 2010 онд “Цасан бурхан” зэрэг хоёр романаа хэвлүүлэв. Цаг үе баатрыг төрүүлдгийн адилаар уран зохиол нь ч цаг үеийн бүтээгдэхүүн юм.

Шинэ зууны амь ахуйн сэдэвт монгол хүүрнэлд байгалийн аюул сүрдүүлэл байгаль ахуйн эвдрэл, амьтан араатны устал, оршихуйн хямрал зэрэг агуулгыг үзүүлэх болжээ. Эрдэнэтогтохын анхны роман “Тэнгэрийн хатавчны өмнө” нь хүн төрөлхтний оршихуйн асуудалд тунгаалт хийж байгаль дэлхий, амьтан ургамал, хүмүүний амьдран орших хэлбэрийн тухай санааширсан амь ахуйн сэдэвт зохиол болно.

Нэг. “Тэнгэрийн хатавчны өмнө” романы урлагийн дүр

Амь ахуйн уран зохиолд авч хэлбэл хүн хийгээд амьтны дүр нь байгаль ахуйд шууд нөлөөлдөг этгээд мөн. Зохиогч III биеийн хараасаас амь ахуйн асуудлыг гаргаж чадсан нь урлагийн дүр нь амилж чадсан гэдгийг харуулна. Үүгээр хүн - амьтан - байгалийн харьцаа холбоог тусгажээ.

(Нэг) Амьтны дүрийн төлөөлөл - Монцоон бөхт

Амьтны дүрээр бэлгэдэл шинж болгож, ямар нэгэн ухамсар, зориг санаа буюу үзэлт ойлгогдохууныг тусгадаг нь шинэ эриний хүүрнэл дэх бас нэгэн бичлэгийн арга мөн. Жишээ нь Аянгын “Бүргэд” дэх бүргэд, арвины

“Хөгшин шарга” дахь хөгшин шарга, Гэрэлтийн “Махчин чоно” дахь чоно зэрэг олон зохиолыг дурдаж болно. Тэгвэл “Тэнгэрийн хатавчны өмнө” роман нь хэвшиж хэлбэршсэн уран дүрээс зайлсхийж, амьтны хараасаас нийгмийн зөрчилт харьцаа, амь насны дотоод чанар жич оршихуйн тухай үзүүлж чаджээ. Тухайлбал “Тэмээгээр сэдэвлэж малжих орны амь ахуйн эвдэгдэл, муудлыг тусгасан байдаг. Амь ахуйн уран зохиол нь амь ахуйн хямралд санааширдаг. Уул роман нь тэмээний гунигт нэг нас, гашуун төгсгөлийг зураглан бичээд амь ахуйн санаашралаа илтгэсэн” [1]

Шинэ эриний монгол амь ахуйн сэдэвт хүүрнэлийн дурдууштай бүтээл болсон байна. Монцоон бөхт бол хөх ингэний амь насны үргэлжлэл болсон өнчин ботго. Мөн ч нэг насаараа амьдрахын төлөө тэмцэл хийсэн гунигт дүр юм. Тэр элснээс талд ирж, талаас ууланд гарч, уулнаас говьд ирж, говиос дахин талд очоод бууранд баригдсан нь хүн, амьтан эе зохицонгуй оршин амьдрах ёстой оршихуйн асуудлыг илтгэжээ. Зохиолын эхэнд хөх ингэ аж үйлдвэрийн хувьсгалын хөлд дайрагдан, улаа цоортол, нуруугаа тасартал ачаа тээвэрлэж бэртэж тамирдахын эрхэнд нутгаасаа салж, баян Хишигт зугтаж ирсэн боловч ахин хүний гарт орж, хамгаас тэсвэр даацтай хэмээн үнэлэгддэг тэмээнээс арьс, яс, амь гурав л үлдэж, эцэстээ зовлонтойгоор үхэв.

Хөх ингэний үргэлжлэл болсон өнчин ботго оршин амьдрахын төлөө тэмцэл хийв. Амь нас бол нэг зүйлийн салгаж болшгүй явц мөн. Монцоон бөхт эхээ алдсанаас хойш Дүн тайж гэжээсэн боловч анх эхэндээ хүнд дасахгүй яах аргагүй эхээ санагалзан байв. Сүүлээр нь хүүхэд тэмээ хоёр дасалцаж эрх дураар тоглох гэхэд нялх амьтан Замбалын хүрзний ишинд оногдож, хайр найргүй цохигдов. Энэ бол түүний гунигт хувь тавилангийн эхлэл нь байжээ. Үүнээс хойш Монцоон бөхт өсөн торнихын зэргээр ижил сүргээ эрж, Баян талаас явж одсоноос түүнд нэн их гай зовлон тулгарав. “Тэр намар Монцоон бөхт хүнд баригдав. Ногтны толгойн эрүүвч ингэж нэг чангарснаас хойш намраас дараа жилийнх нь зун болтол суларсангүй”. [2]

Монцоон бөхтийг салтаатай болгон нь унаж, эдлэн, тарчилган зовоож, хойтон хавар нь сая Дүн тайж олж авсан гэдэг боловч, түүний амьдрал нь сайнаар эргэсэнгүй. Өвөл бордоо зөөвөрлөх ба отор нүүхэд хал зовлонг ханатал амсаж, өлсөж ундаасаж, зовж зүдэж байсан боловч, хэдэн зуун жингийн гурилыг ачдагаараа ачиж, хүн малгүй муудсан зудын бартаат замаар аялж байв. Яг энэ үес тарга муутай шарууд үхэж, бүх хүнд ачаа Монцоон бөхтийн дээр ирэв. Эдгээр мал адгуус нь зөвхөн хүмүүсийн нүдний өмнөх хүсэл шаардлагыг биелүүлэх багаж буюу бодис болж хувирснаас шар ба тэмээ нь өөрийн амь насны өртөг ч үгүй болжээ. Ямар нэгэн өртгийн дэгтэр дээрээс хэлбэл хүмүүс амь насыг хүндэтгэн үзэхгүй, мал унаагаа хайрлан хамгаалахгүй нь үнэндээ амь ахуйн үйлдвэрлэлийн хүчнээ алдаж, өөрийн оршин тогтнол ба хөгжихийн бодисын суурьд тун муу нөлөө үзүүлж буй хэрэг юм.

Бас нэг зол бус учрал нь амьтны хүрээлэнд хашигдаж эрх чөлөөгөө бүрмөсөн алдсан явдал болно. Хэрэв хүний ийнхүү шуналын сэтгэл байсангүй бол амьтны хэвийн оршихуй алдагдах бололцоо бага байж болох юм. Гэвч Монцоон бөхт энэ тавиланг өөрчлөхийг хүссээр байж, алтан дэлхийд илүү нэг өдөр сайхан амьдрахын төлөө жинхэнэ ястай төрсөн гэдгээ харуулж, үхэлтэй

тэмцээр ирэв. Тэр хэдэн хулгайчид уягдаж чонын идэш болох шахсан. Цасанд булагдах шахсан үед ямар нэгэн далдын хүчинд амь мултарч байв. “Хүн төрөлхтний оршин амьдрах орон зайн өргөдөл нь бусад зүйлийн амь насны оршин тогтнох эрхийг булааж, явах тутам тэдний орон зайг явцууруулсан буюу булаан дээрэмдсэнээс олон зүйлийн ургамал, амьтан үндэс тасрах аюулд тулгарчээ.” [3]

Амьтан араатны оршихуйн орон зайг эцсийн эцэстээ мөн л хүн төрөлхтний хариуцлагагүй үйлдэл шалтгаалагдана гэдгийг энэ өнчин ботгоны дүрээр ил тод үзүүлжээ. Хүмүүс амьдралын түшиг, сэтгэлийн ханиа болгодог малаа ингэж эдэлж байх нь хүн чанарын доройтол болно. Нэн гунигтай нь тэр тэмээ төрөлтний жинхэнэ амьдралыг эдэлж өнгөрсөнгүй. Монцоон бөхт эцэс сүүлдээ эхийнхээ нутагт ирж төрлөө олсон боловч, ингээ харамнадаг орооны цагийн галзуу буурт баригдав. “Гагцхүү тэмээ болж төрөл олсны хувьд тэмээний жаргал, элэг зүрхээрээ мэдрэх амьдрал ахуй, тэмээ болгонд байх ёстой байдаг. Тэр бүгдийг эдэлж ер чадсангүй.” [4] Монцоон бөхтийн нэг насны үрэгдлээр дамжуулж, тэмээ - хүн - байгалийн гурамсан холбоон дээрх амьдрал оршихуйн гуниг зовлонг илчлэн дүрсэлжээ.

(Хоёр.) Хүний дүрийн төлөөлөл - “Гозгор”

“Дүр бол хүүрнэл дэх нийгмийн хүний урлагжсан илрэл мөн.”[5] Зохиолч оршин тогтнолын ахуйг олон талаас нягтлан шинжилж “Гозгор” зэрэг дүрүүдийг бүтээж хүн амьтан хэрхэн эе зохицолтой оршин амьдрах тухай бодлогошрол, эрэл хайлт хийжээ. Романд Хөх ингэ, Монцоон бөхт зэрэг амьтны дүрээр амьтны оршин амьдрах баталгааг “Гозгор”-ууд эвдэж, хэвшин тогтсон доод ертөнцийн журам горим явах тутмаа тэдэнд эвдэгдсэнийг тод харуулсан юм. “Гозгор”-ууд амьтны ивлээд баршгүй ааш авирыг давж, Хөх ингэд хүнд чулуу тэгнээд, ташуураар биш харин хуурай модны галаар сүүлийг нь хэрштэл түлж, голынх нь дууг сонсож санаа амардаг. “Гозгор”-уудын Монцоон бөхтийг тушсан, амьтны хүрээлэнд худалдсан зэрэг шунаг өмчирхөг, нүгэл хилэнцэт олон хийдэл нь, эдгээр амьдран оршигч амьтан ургамалд гамшиг хөнөөл авчирчээ.

Энэ нь тэмээ ба хүний дүрийг ил тод харьцуулал болгож, хүн төрөлхтний муу муухай хийдлийг буруушааж, хүний ховдог шунахай амь хувинцарыг тусгасан юм. Нийгмийн хувиралт Баян тал бригадыг бүрхжээ. Хүн оюун чадварт амьтан болсноос санаа зоригоороо эвдлэг хийж, өвс бэлчээрийн муудал, тал нутгийн элсэрхэгжил зэргийг бий болгож, амь ахуйн тогтолцоог эвдэв. Халзан толгой шиг болсон энэ нутагт элсэн шуурга, цасан шуурга зөндөө дэгдэж, тэрчлэн таван хошуу малын хүснэгт дээрх “Тэмээ” гэдэг үсгийн тоо “0” гэж бичихээс ондоо аргагүй болов.

Баян тал бригадад тэмээ нэг ч үгүй болсон нь, таван хошуу малын нэг болсон тэмээ устан сөнөж байгаа байдлыг сэрэмжлүүлжээ. Амьтны олон янзат чанарыг хамгаалах нь нийгэм нийтийн анхаарах чухалтай асуудал мөн. Хүний зориудын ажиллагааны дүнд төрөл зүйлийн бүтэц дан цулгуй болж байна. “Одоо үеийн монгол уран зохиол дох амь ахуйн эвдрэл хямралын гол шалтгааны тухай задлалтаас үзэхэд, хүний ханашгүй олон шунахай, хязгаар

үмхий хахир ховдог, туйлгүй атгаг хувинцар зэрэг муу муухай мөс чанар нь зузаарч” [6] хүн чанарын доройтлоос хүн амьтанд сүрдүүлэл болов.

Зарим үед хүн нь адгуус амьтан ч хүрэхгүй, тэднээс дор байх явдал байдаг. Зохиолд Баян тал бригадынхан чоныг үүр нүх, үндэс зулзагатай нь үлдээлгүй устгах гэж алж хороон, олон чоно улсын хилийг давж Монголд орсон байдаг. Мөн хээрийн амьтан ховордсоноос чоно айлын хашаатай хонин сүргийг барьсан зэрэг нь хүн чоно хоёр идэш булаалдаж байгаа цаг үе ирж, байгаль ертөнцийн хүн амьтан нь эе зохицолтойгоор оршин тогтнох бус, харин харилцан дайсагнаж, харилцан сүйтгэж, өшил хорсолтэй болсныг дүрслэн үзүүлсэн байна. “Өргөн уудам шилдэг сайн тал нутаг бол монголчуудын оршин тогтнох хөгжихийн үндэс байж, гэрийн амьтан, хээрийн араатан жигүүртэн бол тэдний амьдралын шууд ирэлт нь болж байдаг болохоор, өөрийн амь нас аргацааж оршин тогтонох ба хөгжихөө батлах гэвэл эрхбиш тэднийг хайрлан хамгаалах хэрэгтэй.” [7] Өөрөөр хэлбэл, ами нас орших орон зай, хүн, амьтан, байгаль нягт холбоотой байж, эе зохицонгуй амьдран оршихуйг яасан ч олтгойлж болохгүй. Эрх биш жам хуулийн дагуу явах хэрэгтэй гэдгийг гүнзгий илтгэжээ. Амьдран орших орчин ахуй нь эвдэгдэх үед амьтан ургамал мөхөж сөнөхийн учир бий. Зохиолд японы зочин Дааганы элсийг ирж үзээд хэлсэн нь, зүүн азийн дээр элс, хулан шаргын элс их салхинд агаарт дэгдээд, японы буй бүхий арал тэр элсэн шуурганд дайрагджээ. Түг түмэн ховор нандин амьтан ургамал гэнэтийн хувирлаас болоод устан сүйтгэгдсэн юм. Хүн төрөлхтний аж үйлдвэрээс шалтгаалагдсан санаачлаагүй байдал, ашиг олзыг хөөцөлдсөн эвдлэгт ажиллагаанаас байгалаа түшиж амьдардаг амьтдын орших орон зайг нэгмөсөн явцууруулж, аяндааны устлыг бий болгож буй.

Ямарваа амьд бодис оршин амьдрах орон зайгаа алдвал амь нас үнэ өртгөө алдана. Энийг задлахад ганц нийгмийн шинжлэх ухааны задлалт хийж болохгүй. Мөн бас байгалийн шинжлэх ухааныг ашиглах хэрэгтэй. Амьд бодисын амь, хүний амьтай адил бөгөөд ялгаатай тал оршиж буй. “Амь насны урсгалын зам ер нь шууд шулуун шалтгаан үр дүнгийн харьцаан дахь хийсвэрээр тогтоогдох зам биш, түүнд гэнэтийн хувиралт хувьсал цаг ямагт оршино.” [8] Амьтан араатны өндөг зулзагаа өсгөн үржүүлэхээ баримтлан, эрх таваар аж төрөн амьдрахыг хамаг нөлөөлж байгаа нь хүн хар тэргүүтэн - “Гозгор”-ууд болно. Байгалийг өөрчлөх, байгалийг эрхшээх “Гозгор”-уудын ажиллагаа нь байгалийн жам хууль, амь ахуйн хуульд тэрсэлж, хүн төрөлхтөн нь өөрийн оршихуйгаа эвдэж байгаа мөртөө өрөөлийн оршихуйг ч эвдэн сүйтгэж байгаа ял нүглийг “Тэнгэрийн хатавчны өмнө” романд илчлэн шүүмжилж чаджаа.

Хоёр, “Тэнгэрийн хатавчны өмнө” романы бэлгэдэл”

Бэлгэдэл буюу Бэлгэдэл зүй гэдэг нь бараг утга зохиол, урлаг, хүн зүй, шашин шүтлэг, аж амьдрал ... зэрэг соёлын ай савд бүр оршиж байдаг.”[9] “Тэнгэрийн хатавчны өмнө” романд “Цагаан шуумал” ба “Тэнгэрийн хатавчны өмнө” гэдэг хоёр зүйлээр соёл уламжлалаа хамгаалах тэмдгийн бэлгэдэл жич хүн амьтан эе зохицонгуй оршин тогтнохын бэлгэдэл болгож,

амь ахуйн тогтолцоо эвдэгдэж, үндэстний шилдэг соёл орхигдон мартагдаж байгааг харуулж, хүн амьтны оршихуйг бэлгэджээ.

(Нэг.) Соёл уламжлалаа хамгаалах бэлгэдэл - “Цагаан шуумал”

“Сүргээр малжих бол монгол малжлын соёлын нэг гол чөмөг, мал малжих үндсэн бодлого. Монголчууд малыг амгалангийн төлөө малладаг” [10] бөгөөд “Хүн айлаар амьдрана. Малыг сүргээр хариулна” гэдгээр адуун сүрэг, тэмээн сүрэг гэж малжиж ирсэн монголчууд ганц хоёр малыг “алдуул мал” гэж сүрэгтээ хураан нийлүүлдэг заншилтай. Баян талын эрдэнийн тэмээ болсон Монцоон бөхт ижил сүргээ эрж явах зам дунд давхиж ирэх буух тэргээс чинээ мэдэн зугтааж, харин түүний дэргэд байсан цагаан шуумлыг олж үзсэнээс хойш зуны туйл шувтарч, намрын сар гартал хоргоджээ. Энэ нь үнэндээ сүрэгжиж амьдардаг малын төрөлх чанарыг харуулав. “Цагаан шуумал” ба галт тэрэг нь хүний гараар зохиогдсон боловч Монцоон бөхт зөвхөн “Цагаан шуумал”-г ижил төрлөө гэж эндүүрэн байгаа нь амь ахуй муудаж, мал адгуус ховордож цөхөрсөн гашуун үнэнийг үзүүлсэн төдийгүй таван хошуу малын хишиг муудаж байгааг дохиж, шинэ зуунд малжил амьдралын тогтолцоо эвдэгдэж, малжих соёл ч дагалдан гээгдэн орхигдож байгааг тусгажээ. “Урьдын хүн өөрсдийнхөө соёл, шинжтэй ойролцоо ухагдахуун- “тэмдэг”-ээр илтгэж” [11], таван хошуу малын нэгэн болсон тэмээний шуумал нь монголчуудын соёл, малжих амьдралыг бэлгэдсэн тэмдэг болжээ.

“Цагаан тэмээ” гэж тодотгож хэлсэн нь монголчуудын өнгийн бэлгэдлээс болжээ. “Цагаан зүсмийн есийн тоот мал нь төр ёсны эрхэм дээд бэлэг буюу есөн цагааны бэлэг болдог бол, туульсын баатрууд үр хөвгүүддээ таван цагаан бэлгээ барьж байдаг” [12] ерийн байдалд цагаан зүсмийн бод мал цөөн байдаг. Түүхийн сурвалж бичигт “Даян хаан бэтгэ өвчин болсон ажгуу. Тэр өвчнийг цагаан тэмээний сүүгээр гурван мөнгөн аяга цоортол илэн эмнэв. Тэгж эмнэсэнд замаг мэт долоон хэсэг өвчин унаж сайн болов” [13] гэж тэмдэглэсэн байдаг. Мөн урьд хаан эзэнд өргөн барьдаг бэлэгт найман цагаан морь, нэг цагаан тэмээ оруулдаг ёс бий. Монголчууд цагаан өнгийг эрхэмлэж дээдэлдэг нь сүүн цагаан сэтгэлтай, хиргүй ариухан байдагтай холбогддог бөгөөд монголчуудын шашин шүтлэг, бэлэг дэмбэрэлтэй нягт холбоотой юм.

Амьгүй тэр “Цагаан тэмээ”-г Монцоон бөхттэй учруулсан нь нутгийн хөрс шороонд бэлчиж байгаа мал цөөрч, нэн цаашилбал устах хэмжээнд хүрсэн аюулын хэнгэргийг далдаас бэлгэдэж, монголчуудын мал аж ахуй, малжлын соёл зүй гэгдэж байгаа түгшүүрийг цагаан зүсмийн тэмээгээр тусган, таван хошуу малын өсөж үржих бэлгэ тэмдэг болжээ.

(Хоёр.) Хүн амьтан эе зохицонгуй оршин тогтнохын бэлгэдэл -
“Тэнгэрийн хатавчны өмнө”

Орон зайн олон хэмжээсний бэлгэдэл болсон зүг чигийн бэлгэдэлд дээр доорын ялгал бас багтдаг. Монгол утга соёл, домог зүйд “Дээр хүй ихт 99 хөх мөнх тэнгэр, дор хөвчин ихт 77 дайр бор этүгэн эх” [14] хэмээх хос

өргөлийн дотор зүг чигийн хувьд дээр, доор гэсэн хэвтээ босоо хоёр цэг тэнхлэг гэж гаршуулан гаргадаг.

“Монголын нууц товчоон”-д тэмдэглэснийг үзэхэд монголчуудын гарал үүслийг дээд тэнгэрээс заяат төрсөн бөгөөд монголчууд эртнээсээ бөөгийн шүтлэгтэй байж, тэнгэртэй шууд харьцдаг хэмээн үздэг. Тиймээс тэнгэрийг шүтэж, тэнгэртээ даатгаж, өршөөл энэрэл гоёдог заншил аль эртнээс бий болжээ. Зохиолч романаа “Тэнгэрийн хатавчны өмнө” гэж нэрлэсэн нь монгол хүний тэнгэрлэг сэтгэхүйтэй холбоотой. “Тэнгэрлэг сэтгэхүй” бол юм үзэгдлийн босоо цогцыг илтгэж байдаг. Монголчуудын “Тэнгэрийн чинээ”, “Тэнгэрийн хязгаар” гэх мэт зүйрлэл нь орон зайн хувьд хэмжээлшгүй, хязгааргүй гэдгийг илтгэдэг. Зохиолд тэнгэр бол хүлцэнгүй, эервүү тансаг эх газартай хэзээ үүрд тодорхой зааггүй юм. Уул тэнгэрийнх байж болно. Овоо ч мөн адилхан, газрынх ч байж болно. Зааг ялгаагүй гэдэг нь энэ юм. Дааганы элснийхэн энэ учрыг бүр мэддэг. Тэнгэрээс Дааганы элсний бүх зүйлийг харж байдаг. Зохиолд их цас орж байсан нэгэн өдөр Монцоон бөхт уягдаж, амь наана, там цаана байхад дээд их тэнгэр хатавчных нь яг дор нэгэн аварга том амьтан аюулд учирсныг мэдээд үүрээр салхи цасны хоёр их сайдаа албадан зогсоов гэж дүрслэн бичсэн нь Монцоон бөхтийн амь мултарсан ба Чинбат, Дүн тайж зэрэг хүмүүс цаг ямагт “Тэнгэр минь өршөө!” гэж тэнгэртээ наманчлан даатгаж, өршөөл энэрэл гоёдог үйл явдал нь тэнгэр түмэн нүдтэй гэдгийг итгэж, дээд тэнгэрээс тусламж хүсэж байгаа явдал мөн.

Тэнгэрийн тухай монгол хүний тайлбар таамаг туйлын баялаг байдаг. Эдгээр тайлбар таамгийн нэгэн жишээ бол тэмээг тэнгэртэй зүйрлэх явдал болно. Монгол аман зохиол, бичгийн уран зохиолын нэгэн удамшил бол тэмээг тэнгэртэй холбодог заншил. Багцлаад хэлбэл, тэмээ - тэнгэрийг холбон зүйрлэсэн явдал бол амьдралд хайртай монголчуудын босоо цогцын ойлголт сэтгэхүй жич элбэг баялаг дүрслэг сэтгэхүйн үр дүн болно.

Хатавчны өмнө гэдэг нь монголчууд монгол гэрээ барьж, нүүдэл амьдрал хийж байсны улмаас өвөрмөц шинж бүхий босгын соёлтой байдагтай холбоотой. Босгын соёл бол монголчуудын орон сууцын соёлын нэг болно. Босгыг монголчууд бас “Хатавч”, “Элх”, “Хавьс” гэх зэргээр нэрлэн хэлдэг. Монголчууд үүд хаалгаа “Эрхэм хүндэт үүд”, “Хутагт их хаалга” хэмээн хүндэтгэдэг бол хатавчийг өрөө гэрийн эзэн сахиус хэмээн үздэг бөгөөд муу зүйлийн дарлагаар үздэг нь монголын эртний бөө мөргөлийн гурван ертөнцийн ойлголтоос болж, “тоононы дээд, ханын толгой дотоодын дунд, хатавч, ханын шийрийг доод ертөнц хэмээн төсөөлж байсан” [15] талтай.

Зохиолд өвгөн буурал нар өнө эртний тэнгэр, хоёр хатавчны өмнө болсон энэ бүхнийг угийн адил тольдсоор гэж хүн төрөлхтний ял нүгэл үйлдэхийг цээрлэж, амьтан зургаан зүйл амар тайван оршихыг бэлгэджээ. “Тэнгэрийн хаяа хязгааргүй, нүүдэл төгсгөлгүй” гэж Г.Мэнд-Ооёо “Тэнгэрийн хаяанаас нүүдэлчин айсуу” хэмээх номдоо бичсэн нь, амьдрал үргэлжилсээр, аажуухан хэм хэмнэлээр өөрийн хөшгөө хөтлөн нүүсээр байна гэдгийг илтгэж, тэнгэрийн дор амьдран оршигч бүхэн амьдралын өөр, өөр хэмнэлтэй байж, өөр, өөрийн зүй ёсны амьдран орших орон зайгаа олох нь чухал гэдгийг бэлгэдсэн юм. Зүг чигийн төлөөллөөр тэнгэрийн жаргалан, газрын зовлонг ялгаж, хүн өөд болоход тэнгэрт дэвшин диваажин бурхны оронд явлаа хэмээн

үзэж, тэнгэрийн орныг жаргалын орон болгож, доод ертөнцийг түмэн бодисын оршин тогтнолын зөрчлөөр дүүрсэн будилаантай орон болгосон байдаг.

“Тэнгэрийн хатавчны өмнө” гэж гарчигласан нь дээрээс дор хатавчнаас гадагш ертөнцийн аливааг хараандаа багтааж, хүн төрөлхтний үйл ажиллагааг хянаж, тэрчлэн сэрэмжүүлж байгаа ба хүн амьтны эе эвтай оршил тогтнолыг хүсэн бэлгэджээ.

Дүгнэлт

Өнчин тэмээний дүрээр элсэрхэгжин тачиршиж байгаа байгаль ахуй ба улиран хувирч байгаа нийгэм ахуйг амьтны хараасаас туурвиж, тэнгэрийн дор оршин тогтнох хүн амьтны оршихуйн том асуудлыг үзүүлсэн “Тэнгэрийн хатавчны өмнө” роман нь амь ахуйн эвдэгдэл, адгуус малын устал жич монголчуудын нүүдэл малжлын оршихуйн ухамсрыг тод харуулжээ.

Романд үйлдвэрлэлийн хэлбэрийн хувьсал, түүнээс болсон сэтгэхүйн гажилтыг дүрслэн харуулж, “Гозгор” зэрэг дүрээр тэмдэг болгож хүн төрөлхтний үйл ажиллагааг илчлэн, хүн амьтан эе зохицонгуй орших ба өөрийн өв соёлоо хамгаалах хэрэгтэй гэдэг бэлгэдэл санааг дэвшүүлжээ.

НОМ ЗҮЙ

[1] Эрдэнэгэрэл “Шинэ зууны амь ахуйн сэдэвт хүүрнэлт дүрслэгдсэн байгалийн аюул сүрдүүллийн зөн совингууд”, Өвөр Монголын Багшийн их сургууль. 2003 оны хоёрдугаар хугацаа.

[2] [4] Эрдэнэтогтох “Тэнгэрийн хатавчны өмнө”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2002 он. 68-303 дугаар нүүр.

[3] [6] Б.Сүхээ “Монгол үндэстний амь ахуйн уран зохиолын судлал”, Лионингийн үндэстний хэвлэлийн хороо. 2015 он, 323- 348 дугаар нүүр.

[5] С.Отгонбаяр “Шинэ эриний монгол хүүрнэлийн дүр судлал”, Өвөр Монголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 2006 он. 5 дугаар нүүр.

[7] Үү фенг, Боу чин де “Монголчуудын амь ахуйн содон билэг”, Лионингийн үндэстний хэвлэлийн хороо. 2014 он.122 дугаар нүүр.

[8] Билгүүндалай “Шинэ эриний монгол хүүрнэлийн хүний дүрийн амь насны ухамсар”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2006 он. 14 дүгээр нүүр.

[9] [12] [14] [Монгол] С.Дулам “Монгол бэлгэдэл зүй”, Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 2001 он. 3-25-213 дугаар нүүр.

[10] Сампилноров “Монгол малжлын соёл зүй”, Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо.1999 он. 1 дүгээр нүүр.

[11] В.Сайнцогт “Тэмдгийн соёл”, Үндэстний хэвлэлийн хороо. 2000 он.12 дугаар нүүр.

[13] [Монгол] С.Жамбалдорж “Тэмээ - Тэнгэрийн амьтан”, Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо 2008 он. 44 дүгээр нүүр.

[15] Мү.Сайжрах “Монгол заншлын олон ишит соёлын хам бүтэц”, Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 2007 он. 133 дугаар нүүр.

**НОБЕЛЫН ШАГНАЛТ ЗОХИОЛЧ АННИ ЭРНОГИЙН
“УРТ УДААНЫ САР” РОМАНЫ ШИНЭЧЛЭЛТ ЧАНАР**

(Эзэн биегүй тоочилт, саармаг зохион бичлэг, хамтын дурсамж)

Тэргэл

(БНХАУ, ӨМБИС-ийн

Монгол судлалын дээд сургуулийн

2022 оны аспирант)

Агуулгын товч: Францын орчин үеийн зохиолч Анни Эрногийн 2008 онд нийтэлсэн өөрийн намтарчилсан зохиол “Урт удааны сар” нь дахины төлөөлөх бүтээл болох юм. 2022 оны Нобелийн утга зохиолын шагналыг хүртэхээс өмнө нэгэнт тэрээр 1984 онд "La Place" романаараа Ренодогийн шагнал, 2008 онд "Les Années" романаараа Маргерит Дурасын шагнал [Франц], мөн онд "Les Années" романаараа Франсуа Мориаккийн шагнал, Бүтээлч байдлын нийт франц хэлний шагнал зэрэг олон шагнал хүртжээ. Тус зохиолд өөрийн намтрыг хэрхэн эзэн биегүй тоочилтын хэлбэр ба саармаг чанартай зохион бичих аргаар ганц хувь хүний өнгөрөлтийг тусган үзүүлсэн, бодгаль биеийн дурсамжээс хамтын мэдрэмжийг олсон, хамтын дурсамжийг байгуулах эрэл хайлт хийжээ.

Түлхүүр үг: “Урт удааны сар”; эзэн биегүй тоочилт; саармаг зохион бичлэг; хамтын дурсамж

Анни Эрногийн жинхэнэ нэр нь Анни Дюшен бөгөөд тэрээр 1940 оны 9-р сарын 1-нд Нормандийн Лиллебонн хотод төржээ. Түүний эцэг эх нь Аннид боловсрол олгохын тулд маш их хүчин чармайлт гаргадаг байв. Тэрээр 16 настайгаасаа өдрийн тэмдэглэл хөтөлж, 1960 онд сурагч солилцооны хөтөлбөрөөр Английн Лондон хотод суралцахын хамт анхны романаа бичиж эхэлсэн байна. Анни, Руан их сургууль ба Борт их сургуульд суралцаж, 1967 оноос дунд сургуульд багшилж хожим нь Францын Алсын зайн сурган хүмүүжлийн төвд ажиллажаа. Уран бүтээлийн ажил эрхэлсэн дөч гаруй жилийн хугацаанд 23 томоохон бүтээлээ нийтлүүлжээ.

Түүний ихэнх бүтээл намтар зохиолоор голлодог. Цаг хугацаа өнгөрөлттэй зэрэгцэн, нас ахих тусам Эрно нийгмийн улирал хувьсал ба хүний амьдралын утга учрын нэн гүн танилтай болжээ. Иймээс тэр цаг хугацаа хэрхэн өнгөрдгийг тусгасан бүтээл бичихээр болов. Гэвч тэр Вольф шиг орчин үеийн өгүүллэгийг өөрийнхөө стил, имиж болголтгүй, бас түүхийн зохиол бичилгүй, харин олонх хүний дурсамжийг тусгахыг туурвил зүйн гол харасаа болгосон байна. Үүний төлөө тэр наяд оны дунд үеэс эхлэн бэлтгэж, 2008 онд “нийгмийн намтар” хэмээгдсэн “Урт удааны сар” хэмээх эзэн биегүй намтрын зохиол нь хэвлэгдэж, хятад хэвлэлийг нь Ардын утга зохиолын хэвлэлийн хорооноос хэвлүүлжээ. Эрногийн эзэн биегүй тоочилт ба саармаг зохион бичлэгийн арга нь зохиогчийн тус биеийг хэрэг явдлын гадна байршуулж, үл мэдгээр, хийсвэр ахуй байдлын тусгалаар дамжуулж,

уншигчдад хязгаарлашгүй орон зай үлдээж, үнэлэн сэтгүүлэхийн дагуу хүмүүсийн хамтын өнгөрөлтөөр хамтын дурсамжтай нийтийн ертөнцийг цогцлоов.

Нэг. Эзэн биегүй хүүрнэл

Өрнө дахинд ч гэсэн, дорно дахинд ч гэсэн, намтар нь өнө удаан түүхтэй юм. Намтар тэмдэглэлийг дан ганц “намтар” гэдэг, найрууллын доторх нэг зүйлийн зохиолын дэг болно. Хүний үйл явдлыг тэмдэглэсэн зохиол. Намтрын агуулгыг их төлөв хоёр их төрөлд хувааж болно. Нэг төрөл нь түүхэн үйл явдлыг тэмдэглэн тоочихыг гол болгож, түүхэн намтар буюу намтарчилсан тэмдэглэлийн утга зохиол болдог. Нөгөө нэг төрөл нь утга зохиолын хүрээ хэвчээнд багтана. Олонхдоо дүрслэг аргаар алдарт хүмүүсийн амьдралын өнгөрөлт, оюун санааны дүрс байдал, түүхэн ахуй байдлыг зураглаж, түүхийн бодит хэргийг үндэслэл болгодог боловч үсэг бичгээр зураглахыг эрхэмлэдэг. Өөрийн намтар гэдэг нь өөрийн нэг насны үйл явдлаа тоочсон үсэг бичгийг хэлж байна. Филип - Лерене тэрийг “зохиогч өөрийн амьдралаараа бор материал болгож, эргэцүүллийн аргаар хүүрнэж, өөрийн амьдрал ба зан чанараа чухалчилсан түүх болно.” [1] гэж томьёолжээ.

Намтрын зохиол туурвихад ихэнхдээ I биеийн тоочилтын аргыг хэрэглэдэг. Намтар бичсэн хүн нь ердөө өөрийн хувь хүний намтраа бичдэг. Эрно харин “намтар биш, тууж ч биш, харин утга зохиол, түүх ба нийгмийн ухааны нийлэл” гэх шинэ маягийн утга зохиолын хэлбэрийг зохиох санаатай байдаг. Эзэн биегүй өөрийн намтрын бэлгэдлийн онцлог нь уламжлалт өөрийн намтрын анхны биетэй эрс ондоо тоочилтын хэлбэр юм. Эрногийн зохион бүтээсэн эзэн биегүй тоочилт бол тогтсон эзэн биегүй тоочилтын арга болно. “тэр (эрэгтэй) (эмэгтэй)” “бид” “тэд” “тэд (эрэгтэй), (эмэгтэй)”, “хүмүүс” гэх олон хүний нэрийн хувиралтын тоочилтын аргыг хэрэглэн, өөрийн намтарт харьяалагдах бодит цогцын чанарыг хийсвэр цогцын чанар болгон хувируулсан байна.

“Кино гаргах техникийн хүнгэнэх дууны дунд, унтлагын өрөөндөө дэлгэсэн дэлгэц дээр, бид анх удаа өөрийн алхах, уруулаа хөдөлгөх, дуугүй инээдэг шившигт байдлаа олж харав. Бид өөрөө хөлд орсон, уруулаа хөдөлгөж дуугүй инээх зэрэг өөрийн хөдөлгөөндөө цочдог. Тэд маш их татах хүчинтэй том худалдааны талбарт буцаж, өөрийн хурим ба үржлээс болж алдсан дэлхий дээрх аливаа хачин учралын өмнө тодорсноо дахин олж мэдэв. Түүний амь насны энэхүү мөчид тэр нөхрөөсөө салж, ганцаараа хоёр хүүхэдтэйгээ хамт амьдарч, нэг ханилсан нөхөртэй, тэр арга бус түүнийг цочоосон ажиг ч үгүй байдлаар есөн жилийн өмнө худалдан авсан гэр байшин, гэрийн хэрэгслээ худалдав.” [2]

Энэхүү бүтээлд “бид”-ээс “тэдэн”, ” хүмүүс” -ийн нэрийн солигдол нь уламжлалт I биеийн намтрын тоочилтын аргаас өөр ондоо байдаг. Хүмүүсийн хэлдэг солигдол нь бүтээлийн бүдэг төрөгдөл ба хөдлөнгүй чанарыг бүрэлдүүлж, зохиогч өөрөө эргэцүүлэхийн хамт уншигчдын эргэцүүллийг ахиулж, хүмүүсийн хамтын өнгөрөлтөөр цаг үеийн хувиралтыг тусгасны улмаас хүмүүсийн сэтгэлийг хүчтэй догдлуулдаг.

Робин Фейворс “Намтрын эргэцүүлэл ба хувийн тоочилтын цогцлолт” гэдэг номдоо: “Намтрын тоочилт ба өөрийн биеийн гарал бол хувирч болдог, хөдлөнгүй байдаг. Зохион бичлэгийн байдлыг дагалдан тасралтгүй хувирдаг” [3] гэж бичжээ. Хүний нэг насанд хүний биеийн гарал нь тасралтгүй хувирах ба төгөлдөржих явцад оршдог. Цаг хугацааны улиран шилжихийг дагалдан, нийгэм хувирч байна. Хүн ч хувирч байна. Бүхий л хүн төрөлхтний түүхийн ахиц тасралтгүй ахих явцад, өнөөдрийн “би” бол хуучин “би”-н үргэлжлэл мөн. Гэвч өнөөдрийн “би” бол хуучин “би”-ээсээ тасралтгүй тэрсэлсний үр дүн болохыг гэрчилж байдаг. Үүний явцад “би” бол үргэлжлэлт чанартай, тасраагүй оршихуй болох мөртлөө бас аль олон “би”-ийн тасраагүй оршихуй болох юм гэдгийг бид олж мэдсэн юм.

Намтрын тоочогсод авч хэлбэл, түүний тоочин өгүүлсэн нь хэчнээн урт удаан өнгөрөлт болсон ч одоогийн “би”-гээс бүрмөсөн салж чадахгүй юм. Өнөөдрийн “би” өнгөрснөө эргэцүүлэхээр дамжин, түүхийг дахин хянан шинжиж, дэлхийн хувиралтаас хувь биеийнхээ хувиралтыг илэрхийлэв.

Эрно хүүрнэлийн эзэн биеийн хэрэглэлтийн тухай өвөрмөц үзэлтэй байж, “Гадаадын өдрийн тэмдэглэл”-дээ тэр хүүрнэлийн эзэн биеийн адил бус хүүрнэлийн зөрөөг илэрхийлж байжээ. “тэр (эрэгтэй)” буюу “тэр (эмэгтэй)” бээр зохион бичихдээ дэндхүү олон гадаад чанартай мөртлөө ушигчдаас зайдсан байдаг. “Би”-ийн дотор бас тогтворт чанараар чанга байдаг. Иймээс уншигчид үргэлж хүүрнэгч бол зохиогч гэж сэжиглэдэг.

“Урт удааны сар” нь хуучин гэрэл зургаар бүх номын хүүрнэлийн гол шижим болгож, зохиолчийн хувь хүний амьдралын замыг зураглаж гаргасан мөртөө, зохиогчийн амьдралын өнгөрөлтийг цаг үе, нийгэм, түүхтэй нягт холбогдуулж, уншигч ба хүүрнэгчийн мэдрэмжийг бүрэлдүүлжээ. Зохиогчийн сурвалжилга, ном бичгийн зар, бүтээлийн эхлэлт зэрэг мэдээ занги нь ч ийм мэдрэмжтэй байдаг. Эрногийн дурсамж, эмэгтэйчүүдийн дурсамж, бидний дурсамж, тэдний дурсамж, нийгмийн дурсамж, гол баатарын зүс царайг ер нь тодорхой олж үзэхгүй бөгөөд олон нийт ба бодгал биеийн зааг шугамыг ч ялгаж чадахгүй байдаг. Олон биет буюу эзэн бие илтгэхгүй арга нь Эрногийн хүүрнэлд нь түгээмэл оршиж байх энэхүү онцлог нь хувь хүний дурсамжийг хамтын дурсамж болгох чадвартай болгосон байна.

Хоёр. Саармаг зохион бичлэг

1953 онд Ролон бат “Зохион бичлэгийн тэг градус” гэх зохиолдоо “саармаг зохион бичлэг” гэх ухагдахууныг дурджээ. Саармаг зохион бичлэгийг бас “цагаан зохион бичлэг”, “тэг градусийн зохион бичлэг” гэдэг. Энэ нь нэг зүйлийн “шулуун тоочилтын маягийн зохион бичлэг” буюу “хэлний бус маягийн зохион бичлэг” юм. Иймэрхүү зохион бичлэг нь хэлний нийгэмч чанар ба домоглог шинжийг ор мөргүй арилгаж, ингэснээр нэг зүйлийн саармаг чанар ба хойрго чанарын хэлбэрээр илэрч, Маламвигийн дуугүй зохион бичлэгтэй адилгүй бөгөөд Прусс маягийн ямар нэгэн нийгэмч чанарыг түшиглэн оршдог зохион бичлэг ч биш байдаг.

Саармаг зохион бичлэг нь эртний сонгодог урлагийн хэлэнд тавьсан нэг зүйлийн шаардлагыг сэргээснийг мэдэж болно. Энэ нь даруй түүний

багажийн чанарын илрэл болно. Саармаг зохион бичлэг бол зохиолчийн шинэ байдалд хэрэглэсэн нэг зүйлийн хүүрнэлийн хэлбэр юм. Урам сэтгэлгээгүй болсон үг хэл нь хүнд нүсэр, зан аальтай. номхотгохын аргагүй үйл ажиллагаа биш болж, харин нэг зүйлийн цул саармаг, хувирч болох тэгшитгэлийн хэлбэрт орсон байна. Ролон бат “Хэлний бүтэц ба зохиолын стилийн хооронд, өөр нэг хэлбэрийн бодит ахуй оршиж байдаг. Энэ бол зохион бичлэг болно. Эл зүйлийн илтгэх аргыг хорогдуулж байгаад тодорхой нөлөөнд хүрсэн ярианы илтгэлтэй харьцуулбал, зохион бичлэг нь хэлний давхаргаас давсан нэг зүйлийн хэлбэр даруй бодит ахуй (réalitéformelle) -аар оршиж байдаг.” [4]

Саармаг зохион бичлэгийн санаа нь зохион бичлэгийн нөлөөлөх чанар, үнэ өртгийн үнэлэлт ба ашиг тусын өнгө будгийг арилгаж, зохион бичлэгийн тус биеийн багтаамж ба бололцоот чанарыг өргөтгөнө. Эрно “Бичгийн амьдрал” гэдэг зохиолын түүврийн өмнөх үгдээ “Тэмдэглэгдсэн амьдрал нь миний амьдрал биш, бусдын амьдрал ч биш, цаашилбал ямар нэгэн зүйлийн амьдрал бүр биш. Амьдралын агуулга нь хүн нэг бүрд авч хэлбэл адилхан байдаг. Гэвч хүмүүс өөр өөрийн арга хэлбэрээрээ бие махбод, сурган хүмүүжил, хүйсийн ялгал, харьяалал, нийгмийн зам мөр, бусдын оршин тогтнох, өвчин эмгэг, гашуудлыг өнгөрүүлж байдаг” гэж бичсэн байдаг.

“Урт удааны сар”-д саармаг зохион бичлэгийн арга нь бүх зохиолд байж, Эрно лав бөгөөд хийсвэр хүүрнэлээр буй бүхий хэрэг явдал ба хүмүүсийг тэмдэглэж, ажиг ч гүйгээр хувь биеэ олон нийтийн мэдрэмжтэй холбож, хувь хүний дурсамжаар хамтын дурсамжийг зурагласан байна. Саармаг зохион бичлэгийн аргаар хувь хүний амьдралын өнгөрөлт, дэлхийн хөгжлийн ахицыг тусгах нь Эрногийн утга зохиолын хэлний шинэ үүдэлт болох бөгөөд уламжлалт намтрын зохиолийн загварын нэг удааны давалт болох юм.

Эрно “Үнэлэлт хийхгүй, далд зүйрлэл, романтик харьцууллыг хэрэглэхгүй, өргөн магтахгүй мөртлөө муушаахгүй, харин түүхэн хэрэг явдал ба сурвалж бичгийн сүвэгчийг дагаж урагшлах” зохион бичих арга нь “Урт удааны сар” гэдэг энэхүү бүтээл бол зохиогчийн бодит оролцооны бүтээгдэхүүн биш. Харин хийсвэрээр бичсэн зөв оновчтой үр дүн мөн гэдгийг гүйцэд тодорхойлсон байна. Жишээ нь, зохиогч эсэргүүцэх хөдөлгөөнийг бичих үед “1942 оны өвлийн хүйтэн өлсгөлөн ба бөөрөнхий ишит ногоо, амуу хүнс, тамхины ишийг тэд хэзээ ч хэлээд барахгүй юм. Дэлбэчилт нь умард орны дайны Эрногийн гэгээрэхийг харуулж байна. “Бутран ухрах” үес их зам дээрх дугуй тэрэг ба хоёр дугуйт тэрэг, булаагдсан дэлгүүр, гамшигдсан ард, нуранхай хэрэм тасархай хайсны дотроос тэдний сүүдэр ба зоос мөнгөө эрнэ. Герман хүн ирлээ - Хүн бүр хаана байхаа, ямар нэгэн хотод байхаа тодорхой мэднэ ... Өлсгөлөн ба хамтын ахуй байдалд аливаа бүхнийг цөм “бид” ба “хүмүүс”-ийн хараагаар хүүрнэв.” [5]

Эрно тус зохиолдоо дайны гай гамшгийг зориуд уудалсангүй. Уламжлалт утга зохиолд уншигчдын урам сэтгэлгээг хамгаас илүү хөгжөөж чаддаг хайр сэтгэлийн дэвсгэр ба эмгэнэлт уур амьсгалын давуулал нь тус зохиолд бүр чухалчилдаггүй. Саармаг зохион бичлэг нь Эрногийн хүүрнэлд мэс засал хийх мэт нарийн оновчтой бөгөөд хатуу ширүүн сэтгэлийг эвэрлүүлж, хэрэг бодисыг нарийлаг бичлэгийн хэлбэрээр зураглаж, өдөр

тутмын амьдрал, үлгэрийн явцыг дотогшоо сунган, доторх орон зайг нь ямх ямхаар өргөтгөдөг. Жишээ нь зохиогч гэр бүл салах үеийг бичихэд: “Эд хөрөнгийн данс нь эр, эм хоёулангийн үхсэнийг нотлов. Дараачийн алхамд нэгэн хуульчаас лавлан асууна. Манай үлгэрийг нэг зүйлийн хууль цаазын үг хэл болгож, хагацлын дундаас оргилом сэтгэлийн хүчин зүйлийг арилгаж, түүнийг нэг зүйлийн эгэл ерөндөг ба нэр буруулсан “эр эм хоёулангийнх нь хамтын эд хөрөнгийн задрал” -д оруулав. Бид зайлах буюу төгсгөлийг хүснэ. Гэвч бид эргэж ирэх бололцоогүй гэдгийг сэрэн мэдэж, гэр бүл салахын зовлонг амсахаар бэлтгэж, их дуугаар сүрдүүлэн айлгах буюу доромжлон харааж, ялимгүй юмыг хөөцөлдөж, зоос мөнгө нь хоёр дахин дутуу болсон амьдралыг өнгөрүүлэхээр бэлтгэл хийж, аливаа бүхнийг хайхралгүйгээр ирээдүйн тухай хүсэн эрмэлзэнэ” [6] гэжээ.

Эрно гэр бүл салах явдлын тухай өгүүлэхдээ хийсвэр талаас үүсэж, сэтгэлгээний талаар хашгиралгүй, гэр бүл нь эвдрээд нэг эмэгтэй хоёр хүүхдийг асран тэжээх ганцаардалгүй, зөвхөн зоос хоёр дахин дутуу амьдрахаар бэлтгэнэ гэсэн нэг л үг байдаг. Гэр бүл салах явдлын тухай Эрногийн хүүрнэл нь гүн тогтуун хийсвэр бөгөөд оновчтой тодорхой, яг л энэхүү ялагдсан гэрлэлтийн өнгөрөлт нь зөвхөн хүний амьдралын нэг хэсэг, эе найрсаг бус завсрын ая төдий юм шиг болжээ.

Бүхий л хүүрнэлийн аргын дунд Эрно хайр сэтгэлээ нууж, харааны сэрлийн хөдөлгөөнийг хэрэг бодисын өнгөн талд хязгаарлах хүүрнэлийн арга маягийг бүх зохиолд ашиглаж, үнэн бодитой түүхэн үзэгдлүүдийг хийсвэрээр тэмдэглэж, уншигчдад хязгааргүй шүүмжлэн сэтгэх орон зай үлдээж өгсөн байна.

Эрно саармаг зохион бичлэгийн аргаар ХХ зууны Францын нийгмийн одоогийн байдал ба дэлхийн хөгжлийн ахицыг дөхөм бичлэгээр зураглахдаа эзэн биегүй хүүрнэлээр үг уншигчдын сэтгэлийг хөгжөөж, хувь хүний дурсамж ба хамтын дурсамжийн солигдол ба нийлэлтийг хайн сүвэгчилжээ.

Гурав. Бодгаль биеийн дурсамжаас хамтын дурсамж хүрэх

Хүн төрөлхтний дурсамжийн тухай танилт нь аль эртнээс байсан боловч дурсамжийн тухай эрдэм шинжилгээний хайн шинжлэлт нь харин хожмын явдал болох юм. 1925 онд Францын нийгмийн ухаантан Maurice Halbwachs бодгаль биеийн дурсамжийг нийгмийн хамтлагийн давхаргад хүртэл өргөтгөн шинжлэн байцааж, хамтын дурсамжийн ухагдахууныг дурдав. “Нэгэн тоогдсон нийгмийн хамтлагийн бүрэлдэхүүн өнгөрсний явдлаа хамтаар эргэцүүлэх явц ба үр дүн мөн. Хамтын дурсамж бол нэгэн хамтлагийн утга агуулга, соёл, үнэ өртөг, туршлагын цугларал мөн. Хамтын дурсамж бол тогтсон ухагдахуун биш, харин нийгмийн байгуулалтын ухагдахуун юм. Энэ нь ямар нэгэн нууц далд үзэл санаа биш, харин хүмүүсийн одоогийн хамтын өнгөрөлтийг үндэслэн ойлголт хийх буюу цогцлон байгуулж, эргэцүүлэн бодож, дахин илрүүлнэ” [7] гэжээ.

Түүний үзэж байгаагаар, хамтын дурсамж нь эрх биш нийгмийн хоорондох бүрэлдэхүүнүүдийн харилцан үйлдэлцэх, харилцах явцад аажмаар бүрэлдэж, түгээмэл ба баримжаа чанартай болдог байна. Харин тус, тусдаа

ялгаатай бодгал биеийн дурсамж биш юм. Иймээс хамтын дурсамж нь нийгмийн харилцааны хөдөлгөөнөөс үүсэж, хамтын хөдөлгөөн ба дурсгалын ёслолоор илэрдэг. “Урт удааны сар”-д Эрно хамтын дурсамжийн байгуулалт нь гэр бүлийн хамтын хооллолын хэсэг бусад нийгэм ба улс төрийн хамтын хөдөлгөөн дээр төвлөрч байдаг.

“Урт удааны сар” нь 11 гэрэл зураг, 2 фильмээр 15 жижиг хэсэг болгон хувааж, тус бүр 10 - 20 хуудсыг эзэлжээ. Хэсэг бүр нь сүүдрийн тухай дүрслэлээр эхэлж, гэр бүлийн хамтын эргэцүүлээр төгсөж, цагийн алгасал нь 60 жил, сүүдэр бүрийн ард цөм тодорхой сүүдэрлэсэн цагтай, хоорондох зай нь 4 - 7 жил болно. Материалын тус бие нь уншигчдын нүдэнд үзэгддэггүй юм. Зураг дүрс нь зохиогчийн дүрслэлээр дамжаад сая “олж үзэж”, сүүдэр дэх адил бус “тэр”-тэй харьцуулагдаж байгаа нь хүүрнэгч “тэр” хийсвэр талаас өөрийгөө “тэр”-ийг хянан үздэг.

Үзэхэд өчүүхэн ч хамаагүй мэт үг өгүүлбэр болон эрий хурайгүй хэсэг бусгийн хооронд, үнэндээ нэг тасалж чадахгүй он сарын дээс нэвтэрч байна. Гол зохиолын нэгдүгээр өгүүлбэр “Аливаа суугдал бүр арилна”-аас эхлэн, аливаа дурсамж уулыг нураан далайг юүлэх мэт тархинд тодрон, их хэмжээний хэсэг бусад хүүрнэл ба байдлын хүүрнэлийн дараа бол хэлхээлдсэн чанартай цагийн хүүрнэл болно. Эрно өөрийн бодит цогцын чанараа уншигчдад шилжүүлж, түүнийг өөрийн байгуулсан ертөнцдөө оруулахын хамт түүнтэй хамт нийтийн сэтгэлгээтэй болжээ.

“Дайны дараах баяр дурсгалын өдөр дуусашгүй, туйлын удаан дайллагын дунд өнгөрч, үгүй байснаасаа байх болох цаг үе эхэлж, энэ нь ээж аав бидний эргэлзэлтэй харцанд хариулт өгөхөө умартсан цаг үе шиг, бид байхгүй, үүрд байж чадахгүй цаг үе. Урьдын цаг үе төгсөх үед тэд “Ээ!, тус газрын цагаан үзмийн архи” ба “Парисын цэцэг”-г дуулж эхэллээ. Чих дүлийрэм найрал дууны дунд, тэд дагалт дууны үгсийг орилон хашхирна. ...Хүүхдүүд ярихыг сонссонгүй. Зөвшөөрөл олмогц хоолны ширээнээс санд мэнд салж, баярын өдрийн хугацаан дахь нийтийн уучлалыг ашиглан тоглоом хийж, орон дээрээ үсрэн гарч толгойгоо тонгоруулан дүүжин наадна.” [8]

“Урт удааны сар”-д гэр бүлийн хамтын хоолонд хоёр үеийн хүмүүсийн мөргөлдлийг үзүүлж, энэ хоёр үеийн хүмүүсийн хооронд солбицон явагдах бөгөөд бас шулуун чанартай илтгэлтийн хэлбэлзэл болж, Эрно хувь хүний ширтэлтийг хамтлагийн үймээн шуугиан болгон хувируулахын хамт бас бодгаль биеийн дурсамжаар хамтын дурсамжийг цогцлоосон байна.

Цаг хугацааны өнгөрөлт ба мэргэжлийн хөгжил нь хүмүүсийн дурсамжийг үлгэр хэв болгон үлдээх төрөлх чадварыг хувируулсангүй. Үүнээс бусад зүйлтэй харьцуулбал, цаг хугацаа ба эргэцүүлэл нь онцгой тогтвортой байдаг. Түүх хүмүүсийн дуртгалд шингэж, тэр нь өөрийн бие биш болдог. Хамтын дурсамж ба түүхийн адил бус тал нь гэвэл, тэр нь нэгэнт түүхийн ахуй байдлын тухай өгүүлэлтээс давж, харин нэгэн олон нийтийн үзэл санаа, оюун ухаан, соёл жич өртгийн мэдрэмжийн төлөө хувирсанд оршино. Бодитой илрэл нь ямар нэгэн ёслолын их хэрэг явдал зэргээр илэрч байдаг болохоор Эрно, Францын одоо үеийн чухал их хэрэг явдлыг тоолон бүртгэх ба жагсаах нь уншигчдад мэдрэгдсэн бөгөөд олны хүрээллийг олсон байна.

“Урт удааны сар” нь дэлхийн хоёрдугаар дайн дууссаны дараах Францын орчин үеийн амьдралаас эхлэн хүүрнэж, тавиад оны үед Сталин нас нөгчсөн, Диян биан фүүгийн дайлалдаанд Францын цэрэг ялагдсан. Алжир аажмаар Францын төвөгтэй байдалд оров. Дахиад 1954 оны тэрхүү хүйтэн дайн аажмаар ширүүссэн боловч хүмүүсийн дотоодын бачимдал үргэлжлэн дүрэлзэж байсан цаг үе болоход хүрэв.

“Одоо тэр өөрийнхөө нийгмийн байр сууриа тодорхой мэдэв. – Гэрт нь хөлдүүр ч үгүй, угаалгын өрөө ч үгүй, жорлон нь гадна хүрээн дотор байв. Тэр Парист ч үргэлж очдоггүй - Ангийнхаа хамт сурагчийг хүрэхгүй. Тэд үүнийг олж мэдсэнгүй буюу түүний “инээдэмтэй” ба “хүнийг уужуу тайвшруулах” гэж бүдүүлэг үгээр “Миний өрөө” ба “Миний айсан хувь дээр түүнийг уучлахыг” тэр хүсдэг байв. [9]

Энд Эрно анги давхаргын зөрөө нь бодисын давхаргын олон цөөн төдий биш, хэлний илтгэх арга маяг мөн ч адил бус байдаг. Тэр нь нэг зүйлийн бүх талын зааг болно гэдгийг таньж олсон байна. Үүний сүүлээр Алжирийн тусгаар тогтнолын хөдөлгөөн нь аажмаар хүчирхэлэл ба нууц хорлол болон улиран хувирч, дэлхий ертөнц эхлэн хагацаж, хоёр эшт эсрэгцэл эхэлсэн байна. “Бид” удалгүй Францын чухал түүхийг гэрчлэх буюу цаашлаад түүнийг өөрчлөх нэг бүлэг хүн болсон байна. “Бид” гэх энэхүү эзэн биегүй төлөөний үг нь хувь хүнийг аяндаа балархайшуулж, хамт нийтийг товойлгосон байна. Тогтуун байдлын бүрэн бүтнийг арилгахын хамт хөдлөнгүй байдлын хэсэг талыг товойлгов.

“Мянга есөн зуу жаран найман он бол дэлхийн анхдагч жил мөн.” [10]. 1968 оны 5 сарын шуурга нь “Дэлхийн сонин” дээр “Франц халширлаа” гэж бичихтэй хамт хувьсгалын анхны бууг тавьсан байна. “Бид” энэхүү хэргийн гэрчлэгч болж, улс даяарын самуурлын өмнө Эрно тэр нэг бүлэг хүмүүсийн бие дээрээс өөрийн оршиж байхаа таньж олжээ. Учир нь тэд одоо яг “бидэн”-ы өнгөрсөнд хийвээс зохих боловч хийгээгүй зүйлийг хийж байгаа юм. Залгаад Горбаёв, Миттераныг үргэлжлэн хариуцсан явдал ба ЗХУ-ын задралыг өөрчилснөөс дахин “911” хэрэг гарав.

1968 оны хувьсгалын их бууны гал нь дэлхийн “Хэрэглээний нийгэм” тийш урагшлах алхмыг хориглож чадсангүй. XXI зуунд алхан ороход Эрно үзгийн үзүүрээ эргүүлж, дэлхийг шүүмжилж эхлэн, Францын оюун санааны дүрс байдлыг яс идэгдүүлэх мэтээр талхидаж байгаа хэрэглээний үзэл, дэлхийжилт, мэдээ занги дэлбэрэх цаг үеийн эл зүйлийн хог новшийн сураг зангийг шүүмжлэв.

Эрно цаг үе ба хамтлагийн им тэмдэгтэй хувь биеэ товойлгохын хамт бодитой, биеэ даасан өөрийн хөөцөлдөл ба бусдын туршлага жич хамтын танилтыг тасралтгүй арилгав. Эрногийн үсэг бичиг нь манай хүн нэг бүрийг оновчтой оноож чадсаны учир гэвэл, энэ нь Франц буюу Нормандын хязгаартай орон зайд зогсонгуйрч байгаа олон нийтийн туршлага биш, харин нэг зүйлийн өргөн дэлгэр түгээмэл танин мэдэхүй мөн. Дэлхий ертөнц арга бус дэлхийжилт ба туйлбартай хэрэглээний үзэл тийш урагшлах үед Эрно үсэг бичиг ба үг дууг дэлхийд шидэн гаргаж, хувь хүний өнгөрөлтөөрөө хамтын дурсамжийг бүтээх зорилгодоо хүрсэн байна.

Дөрөв. Дүгнэлт.

Анни Эрно “Урт удааны сар” гэдэг намтрын стилиэр нэг зүйлийн шинэ утга зохиолын хэлбэрийг нээсэн юм. Урлагийн бүтээл ч тэр, утга зохиолын бүтээлийн оршихуйн эцсийн хэлбэр нь түүний хэлбэрт байдаг. Энэ бол утга зохиолын хамгийн үндэс болох мөртлөө мөн анхдагч чанартай асуудал мөн. Эрногийн онцгойрсон хүүрнэл ба саармаг зохион бичлэгийн аргаар 1941 оноос 2006 оны хооронд зохиогчийн өөрийнхөө нэг насны цаг мөч ба их цаг үеийн бага ахуй байдлыг тоочжээ. Нэг талаар Францын эмэгтэйн 60 гаруй жилийн амьдралын элбэг баялаг өнгөрөлтийг илрүүлж, нөгөө талаар алс холын ертөнц ба хувь хүний дурсамжийг солбицуулсан, хүмүүсийн сэтгэл зүрхийг догдлуулсан ертөнц ба хамтын дурсамжийг бий болгосон байна.

НОМ ЗҮЙ

- [1] Филипп·勒热讷, 杨国政译, ”自传契约”, 北京生活读书·新知三联书店, 2001, 201页。
- [2] 安妮·埃尔诺, ”悠悠岁月”, 吴岳添译, 北京人民文学出版社, 104、120、134页。
- [3] FIVUSHR&HADEINC. Autobiographical memory and the construction of a narrative self: developmental and cultural perspectives New Jersey :Lawrence Erlbaum Associates Inc, 149.
- [4] Augusto Ponzio, «Le Neutre et l’écriture ante litteram», in Roland Barthes en Cours, Editions Universitaires de Dijon, 2009, p.132.
- [5] 安妮·埃尔诺, ”悠悠岁月”, 吴岳添译, 北京人民出版社, 13页。
- [6] 安妮·埃尔诺, ”悠悠岁月”, 吴岳添译, 北京人民出版社, 121页。
- [7] 莫里斯·哈布瓦赫, ”论集体记忆”, 毕然、郭金华译, 上海人民出版社, 39页。
- [8] 安妮·埃尔诺, ”悠悠岁月”, 吴岳添译, 北京人民出版社, 13、15页。
- [9] 安妮·埃尔诺, ”悠悠岁月”, 吴岳添译, 北京人民出版社, 52页。
- [10] 安妮·埃尔诺, ”悠悠岁月”, 吴岳添译, 北京人民出版社, 92页。

**ЗОХИОЛЧ АЯНГЫН “ШАТДАГ УС” ЗОХИОЛ ДАХЬ
АМЬ АХУЙН ХАМГААЛАЛТЫН СЭДЭВТ УТГА ЗОХИОЛЫН
ЗАДЛАЛТ ХИЙХ НЬ**

ЭҮ ХИ МИН

(БНХАУ, ӨМБИС-ийн

Монгол судлалын дээд сургуулийн

2024 оны аспирант)

Агуулгын товч: Зохиолч Аянгийн “Шатдаг ус” хэмээх зохиолд орчин үеийн амь ахуйн эвдэгдлийн асуудал өдөр ирэхүйе хүнд ноцтой оршиж байх ба хүн төрөлхтний нийгэм, соёл, өртгийн үзэлтийн талын өрсөлдөөн зэрэг нийгмийн байдлыг тусгажээ. Өгүүлэлд хүн байгалийн харьцаа, байгалийн эвдэгдлийг бичихээр дамжин хүмүүсийн амь ахуй орчин тойрноо хамгаалах үзэл ухамсрын тухай өгүүлэв.

Түлхүүр үг: Аянга, шатдаг ус, амь ахуй

НЭГ. ЗОХИОГЧИЙН ТУХАЙ

Зохиолч Аянга Ордос хотын Отог хошууны Бор хошуу сумны Олоннуур гацаагаар нутагтай. 1947 онд төржээ. 1968 онд Өвөр Монголын Монгол хэл бичгийн тусгай мэргэжлийн сургуулийн Орчуулгын ангийг төгссөн. “Ордосын сонин”-ы найруулагчаар ажиллаж байжээ. БНХАУ-ын Утга урлагийнхны их хурлын VI, VII хугацааны хорооны гишүүн, Өвөр Монголын Утга урлагийнхны их хурлын V, VI хугацааны тэргүүлэгч мөн.

Аянга 1976 оны 11 сард “Өвөр Монголын өдрийн сонин”-д анхны зохиол “Бүргэдийн хөмхий”-гээ нийтлүүлж, уран зохиолын замаа жинхэнээр эхлүүлэв. Хожим нь гучаад жилийн хатуужилтай зохион бүтээлгийн аяндаа “Хар шарын ертөнц”, “Жингийн хонхны тунил” “Жаргал ба түүний аваа”, “Хонь хужирлах замд”, “Манба-расан” зэрэг содон зохиол бүтээж, өргөн олон ард түмнийхээ хүрээллийг олжээ. Тэр олон шилдэг зохиолуудаас нь “Жаргал ба түүний аваа” гэдэг өгүүллэг нь анхдугаар удааны “Солонго” шагналыг хүртэж, “Жингийн хонхны тунил” нь хоёрдугаар удааны “Солонго” шагналыг гардаж, “Хонь хужирлах замд” гэх хүүхдийн зохиол нь гуравдугаар удааны “Солонго” шагналыг гарджээ. Түүний “Жингийн хонхны тунил” нь бас зургадугаар хугацааны бүх улсын цөөн тоот үндэстний “Ажнай хүлэг шагнал” хүртэв.

2020 оны 6 сарын 14-ны өдөр зохиолч Аянга 73 насандаа Хөх хотод нас нөгчжээ. В.Сарангоо “Аянгийн туужсын шинжлэл” гэх номдоо “Өөр бусдаас ялгагдах өөрийн гэсэн хэв намбатай, бас агуулгаар баялаг, амжилтаар өндөр, чанараар шилдэг үлэмж олон зохиол бүтээлтэй байдгаараа одоо үеийн Өвөр Монголын уран зохиол, ялангуяа шинэ эриний Өвөр Монголын туужсын зохиолч дотор бүтээл зүтгэлээрээ оройлж яваа зохиолчийн нэг нь болох юм.” [3] гэж Аянгийн одоо үеийн уран зохиол дахь байр суурийг нь үнэлсэн байдаг.

Хоёр. Зохиолын товч агуулга

Зохиолч Аяндын бичсэн “Шатдаг ус” гэх зохиолд голдуу европын шашны хар лам, шашин дэлгэрүүлэгч Сайшаан гэдэг хүн, түүний өвөг дээдсийн үеийн бичсэн өдрийн тэмдэглэл, зураг төлөвлөлгөөг үндэслэн, 80 жилийн өмнө их говьд ирж, шашны дуган байгуулан, говь нутгаас нэг зүйлийн “Шатаж чаддаг ус” эрж, нээн ашиглах зураг төлөвлөгөө зурагласан байна. Сайшаан энэхүү зураг төлөвлөгөөний төлөө аливаа бүхнээ зориулснаар барахгүй, амь насаа үрэгдүүлж хамгийн сүүлд хэдийгээр ялагдлаар дууссан боловч, хожим нь тэр говь нутагт их хор хөнөөл авчирсан байна.

“Шатаж чаддаг ус”-г хайн шинжлэх ажил нь их говь нутагт олон жил явагдаж, Сангаа мэтийн хэдэн үеийн хүмүүсийг нөлөөлсөн байна. Сангаагийн аав нь европт нефтийн мэргэжлээр суралцсан байлаа. Эцэстээ говь нутгийн гүнд нефтийн уурхайн ерөнхий инженер Сангаагаар толгойлуулсан “Нефть хайлуулах үйлдвэр” байгуулсан юм. Гэтэл тэр үйлдвэр нь орчин тойрны тал нутаг ба амьтан ургамалд хүнд ноцтой хор хөнөөл үзүүлснээс болж, үйлдвэрт дэлбэрэлт үүсэж, үйлдвэрийн 23 ажилчин амь насаа алдсан юм. Хэдийгээр “Нефтнээс болоод хүн төрөлхтний зам нэвтрэлцээ хурдан дээшилж, машин тэргэнд сууж, онгоцонд суугаад дэлхийн бөмбөрцгийн энэтээ талаас тэртээ талд хоногийн цагт хүрч чаддаг болсон” боловч нефть малтсанаас болж газар доорх ус доргошлоод, өвс ургахаа больсон, машин тэргүүд бэлчээр дээрх малыг үргээгээд, тарга авахад нь нөлөөлсөн, хортой утаа баагиж хүн малын эрүүл мэндийг нөлөөлж, дөрвөн эвэртэй ишиг, гурван хөлтэй тугал гэх мэтийн жигтэй юм гардаг болсон. Хэдийгээр говь нутагт хөгжилтийг авчирсан боловч мөн ч говь нутагт хүнд учиртай хор хөнөөлийг авчирчээ. Үүнээс болж галын аюул гарч, дэлбэрэлт үүссэн нь энэхүү үйлдвэр үр төлөөстэй болсон байна.

Говь нутгийн хүмүүс “Шатдаг ус” юу гэдгийг мэдэхгүй, сохор балайгаар “Далай тэнгисээр аялж чаддаг хөлөг онгоц, мориноос хурдан машин тэрэг, тэмээнээс илүү хүнд юм ачдаг галт тэрэг, шувуунаас өндөр мөртөө хол нисэж чаддаг нисэх онгоцыг авчирч чадна” гэж ойлгож байсан. Шалгах газраас үйлдвэрт “дэлбэрэлт гарсан үндсэн шалтгаан нь чухам юу вэ?” гэх асуултын тухай шалтгааныг нь эрж олсонгүй. Сангаа мэтийн хүмүүс цахилгаан утаснаас болсон гэсэн шийдвэр өгсөн. Эцэст нэгэн аспирант хүрч ирээд “Говьд гандаж тэнгэр халуун, орчин тойрны халууны хэмжээ дээшилсэн нь гол шалтгаан болсон ёстой, нефть гэж амархан авалцдаг эд” гэж хэлсэн байна.

Хувьсгалын онолыг анх үүдсэн нэг агуу их хүний хэлсэн “Хүн төрөлхтний шинжлэх ухааны шинэ нээлт нэг бүр нь мөн ч хүн төрөлхтний оршиж амьдрахад эвдлэг яршиг учруулахаар төлөөс болгодог” гэдгээр хүн төрөлхтний амьдралын хэр түвшин дээшилсэн боловч тэдгээр нь амь ахуйг эвдэн сүйтгэсний суурин дээр бий болсон байна.

Гурав. Байгалийн эвдэгдлийг харуулсан нь

Зохиолч Аянга шинэ зуунд “Дуут говь”, “Салаа замын уулзар” “Намрын бороо жихүүн” зэрэг амь ахуйн сэдэвт зохиол бичжээ. “Шатдаг ус”

гэдэг роман нь тус хугацаанд бичигдсэн амь ахуйн сэдэвт зохиол болно. Зохиолд нийгмийн хөгжилт, аж үйлдвэрийн хөгжилт зэргийн нөлөөнөөс болж Монгол нутгийнхаа эвдэгдэж байгаа байдлыг их бийрээ зарцуулан зураглажээ. Жишээ нь, “Шатдаг ус”-ын есдүгээр бүлэг “Сандарсан хүнд саад олон”-ы хоёрдугаар хэсэг “Аспирант”-д өмнө газар байгаа их сургуулийн аспирантын ерөнхий инженер Сангаа “Нефтийн бохирдлоос болсон хор хөнөөлийг та яаж үнэлэх вэ?” гэдэг асуултаар амь ахуйн эвдэгдлийн асуудлыг эхлүүлж дахин гуравдугаар хэсэг “Хөрш сумны асуудал”-даа нефтийн уурхайн хажууд байдаг нэг сумны намын даргын үгээр “Таны машин тэргүүд бэлчээр дээрх малуудыг үргээгээд тарга авахад нөлөөллөө”, “Манай тэнд дөрвөн эвэртэй ишиг, гурван хөлтэй тугал гэх мэтийн жигтэй юмс гэвэл түүрүү хоёр жилээс гардаг болсон. Энэ жилээс хонь ямаанд үүдэн шүд ургаж эхэллээ. Дараа жилээс нэн бас ямар аймаар юм үзэгдэхийг бүү мэд” гэж амь ахуй эвдэгдэж, орчин тойрон бохирдож байгаа байдлыг тусгажээ.

Дөрөв. Байгаль эвдэгдсэний шалтгааныг эрэн сүвэгчилсэн

Байгаль ахуйн эвдэгдлийн асуудал ойрын жилүүдэд л эхэлж гарсан явдлууд биш, энэ нь хэзээ өмнө байж байсан. Энэ асуудлыг зохиолч Аянга сэрэн мэдэж амь ахуйн сэдэвт зохиолоо бичсэн. Тэр зохиолдоо байгалийн амь ахуйн эвдэгдлийн байдлыг бичихийн хамт бас байгалийн амь ахуйн эвдэгдлийн шалтгааныг тайлбарлажээ. Зохиолд Сангаагийн өвөө аав хийгээд эцэг нь бүр “Шатаж чаддаг ус”-ны хойноос хөөцөлдөж байгаад амь насаа алдсан байна.

“Нефть хайлуулах үйлдвэр” нь газар доорх тосыг машинаар сорон гаргаж, ахин дахин хайлуулж боловсруулж байгаад пуужингийн даринаас түргэн авалцан дэлбэрч болох шингэн эд болгож, түүнээ хэдэн арван тун саванд хийж хадгалж билээ. Таван давхар асраас өндөр бузгай харагдах тэдгээр савнууд одоо цаадах утаан дунд сүмбэрлэн сэхийн харагдаж байна. Тэдгээр том сав дэлбэрвэл дэлхий дахиныг цочоосон том аюул болох нь дамжиггүй. Үүнээс үзэхэд хүн төрөлхтний ховдог шунахайгаар байгалийн эх баялгийг ашигласан нь байгалийн эвдэгдлийн чухал нэгэн шалтгаан болно гэсэн зохиолчийн үзэлтийг мэдэж болно.

“Хүн төрөлхтөн бол их байгалийн бүрэлдүүн хэсэг мөртлөө их байгалийг бүрэлдүүлэх хэсэг мөн”. Энэ бол хэчнээн жилийн туршид боловсруулсан амьдрахуйн гүн ухаан болно. Ийм учраас хүн төрөлхтөн юунд эх байгалиа өвтгөн сүйтгэх вэ? гэвэл гол шалтгаан нь хүн төрөлхтний өөрийн ашиг олохын төлөө юм. Зохиолд гал унтраах ангийн дарга Сангаад “Гурван ажлын өрөөнд бүр дэлбэрэлт үүсжээ. Одоо хөмрөгний галыг унтрааж дийлэхгүй хэцүү болж байна. Хөмрөгний гал цаашаа үрэвсээд тос хадгалах савтай авалцвал, атомын бөмбөг дэлбэрсэнтэй адил том аюул болно” гэж хэлж. “Иймээс чухам урьдаар хөмрөгний галыг унтраах юм уу, харин хүрээнд байгаа хүмүүсийг эрж олох юм уу гэх түвэгтэй асуудал тулгараад байна. Хүрээн дотроос гарч завдсангүй хүмүүсийг хурдхан эрж олохгүй бол тэдний амь нас цаг ямагт сүрдүүлэлд учирна. Эрт нэг минут эрж олбол илүү нэг хүн амиа алдаж мэднэ ...” гэнэ.

Сангаа том сав дэлбэрвэл дэлхий дахиныг цочоосон том аюул болохоос сэргийлж, гал унтраах ангийнх нь хөмрөгний галыг унтраахаар явуулжээ. Харанхуй болох үеэр хүрэн дотроос нийт хорин дөрвөн үхдэл олсон байна. Хэрэв “Нефтийн үйлдвэр” нь хэдэн арван тун хайлуулж хадгалаагүй бол, хүрэн дотор галын аюулд хураагдсан хүмүүсийг аварч чадах магад. Гэтэл Сангаа мэтийн хүмүүсийн ховдог шунахайгаас болж, нефтийн хөмрөгт хэдэн арван тун тос хадгалснаас, хүрэн дотор хоригдсон хүмүүсийг цаг тухайд нь аварч чадсангүй. Эцэстээ хорин гурван хүн амь насаа алджээ.

Энэ нь мөн хүн төрөлхтний шуналаас болсон байгаль хийгээд хүн төрөлхтний өөрийн биедээ авчирсан аюул болох юм. Нийгэмийн харьцааны хувиралт, хүний харьцааны хөндийрөл, хүний ховдог шуналын игдэл зэрэг нь онгон байгалийг сүйтгэж, амь ахуй тэнцвэрээ алдаж байгаа юм.

Монголчууд аль эртнээс газар дэлхийг “Эх” гэж хүндэтгэн, тал нутаг, эх байгалийнхаа ширхэг өвс шорооноос эхлэн хайрлан хамгаалж ирсэн мөртлөө, байгаль ертөнцийн түмэн бодисыг сүг сүнстэй гэж үзэн, тал нутгийг дураар хагалбарлаж, ой шугуйг огтлох, гол мөрнийг дураар бохирдуулан, араатан амьтан зэргийг дураар хөнөөхийг цээрлэдэг. Гэтэл одоогийн нийгмийн хөгжилт ба хүн төрөлхтний ховдог шунахайгаас болж, байгаль орчин тойрныг таваараа эвдэж, эцэстээ говь нутагтаа гай гамшгийг авчирчээ.

Говь нутагт “Нефтийн үйлдвэр”-г байгуулж, ашиг хонжвор олохыг л бодоод, харин энэхүү үйлдвэр нь тухайн говь нутагт зохицох эсэхийг анхаарсан хүмүүс нэг ч байхгүй. Хүн төрөлхтний ховдог шунахайгаас бусад байгалийн амь ахуйн эвдэгдэл нь аж үйлдвэрийн хаягдмалын нөлөөтэй шууд холбоотой гэдгийг зохиолч зохиолдоо бичжээ.

“Шатдаг ус” зохиолын есдүгээр бүлгийн “Хөрш сумны асуудал” гэх хэсэгтээ зохиолч хөрш сумны намын даргаар дамжуулж, “Танай эндээс хортой утаа баагиж, манай тэрүүгээр хүрээд хүн малын эрүүл мэндийг нөлөөлж байна” гэж хэлж гаргасны хамт “дөрвөн эвэртэй ишиг, гурван хөлтэй тугал”, “Хонь ямаанд үүдэн шүд ургасан” зэргийн үзэгдлээр дамжуулж, энэ үзэлтдээ баримт болгож бичжээ.

Тав. Хүн хийгээд байгалийн харьцаа

Хүн ба байгалийн харьцаа нь нийгмийн оршин тогтнож хөгжихийн чухал харьцаа мөн. Хүн байгаль эе зохицолтой байх ба амь ахуйн орчин тойрон, эх байгалийг зүй зохистойгоор нээн ашиглах ба хамгаалах нь хүн төрөлхтний нийгмийн оршин тогтнож хөгжихөд чухал бодисын нөхцөл болох юм. Жишээ нь, 2015 оны 3 сар, 12 хугацааны Бүх улсын Ардын төлөөлөгчдийн их хурлын Жианши мужийн төлөөлөгчдийн бүлгэмийн хянан зөвлөхөд оролцох үес” амь ахуйн орчин тойрныг хамгаалахыг чармайн ахиулж, нүдэн цөцгийтэйгөө адилхнаар амь ахуйн орчин тойрныг хамгаалж, амь настайгаа адил амь ахуйн орчин тойронд хандах хэрэгтэй” [2] гэж яриа тавьсан байна. Амь ахуй нь хөгжихөд чухал бодисын нөхцөл болох юм.

“Шатдаг ус” романд хүн хийгээд байгаль ахуйн харьцааг тайлбарласан хэсэг байдаг. Тус романы есдүгээр бүлгийн “Аспирант” гэх хэсэгт зохиолч “Өмнө газар байгаа шинжлэх ухааны их сургуулийн аспирант”-аар “Нефтийн

бохирдлоос болсон хор хөнөөлийг та яаж үнэлэх вэ?” гэж хүн хийгээд байгаль аж үйлдвэр хийгээд амь ахуйн харьцааны үзэлтээ тайлбарлахын эхлэлт болгож, энэ хэсгээс эхлэн олон арвин явдлаар дамжуулж, романыхаа төгсгөлийн арван зургадугаар бүлэг “Төгсөөгүй төгсгөл”-д аспирант хийгээд Сангаагийн “Чиний санааг би одоо ойлгож байна. Нефтийн тус бие нь гал гарсны үндсэн шалтгаан гэж чи хэлэх санаатай байгаа шүү” гэж Сангаа хэлээд, уртхан сүүрс алдаж, гэвч нефтийг үргэлжлүүлэн малтах хэрэгтэй. Улс орон хөгжлийн одоочлолтоор дутаж болохгүй” гэв.

“Тийм ээ, нефьтгүй бол бид бусад улс гүрэнд дарлагдана. Энэ бол аргагүй явдал” гэж аспирант хэлээд “Хувьсгалын онолыг анх үүдсэн нэгэн агуу их хүний хэлсэн үгийг та мэдэх үү?” гэв. “Ямар үг?” “Хүн төрөлхтний шинжлэх ухааны шинэ нээлт нэг бүр нь мөн ч хүн төрөлхтний оршиж амьдрахад эвдлэг яршиг учруулахаар төлөөс болгодог гэх шуухан үг байгаа юм ...” гэх ярилцаагаар хүн төрөлхтөн хөгжих гэвэл байгаль ахуй эвдэгдэх нь лавтай. Гэхдээ энэ бол зайлшгүй гэдэг үзэлтээ илтгэжээ.

Дүгнэлт

Амь ахуй нь хүн төрөлхтний оршин тогтнох байгалийн орчныг заана. Гэтэл бид юунд өөрийн оршин амьдарч байгаа эх байгалаа эвдэн сүйтгэх вэ? Хүн төрөлхтөн байгалиас ирж эцэстээ байгальдаа буцах ёстой. Нийгмийн хөгжилт ба шинжлэх ухааны хөгжихийг дагалдан амь ахуй хүнд ноцтой эвдэгдэлд учирч байна. Жишээ нь, ойрын хэдэн жилээс ган хагсраан, үер ус, салхи шуурга, агаарын бохирдол зэрэг хүнд ноцтой асуудал илэрч байна. Гэтэл хүмүүс өөрийн ховдог шунахай санал ба үйлдэл хэрэгцээгээ хангахын төлөө хэтэртэл малтах, амьтан араатныг хөнөөх, эх байгалийг хоосортол уудлах зэрэг үйл ажиллагаанаас болж бидний оршин амьдарч байгаа эх байгаль амь ахуйн тэнцвэрээ алдаж байна.

Иймээс хүн төрөлхтөн одоогоос эхлэн амь ахуй орчин тойрны асуудлыг чухал болгон үзэх хэрэгтэй. 2017 оны 5 сар, арван наймдугаар хугацааны Төв хорооны Улс төрийн товчооны дөчин нэгдүгээр удаагийн хамтын суралцлагад “Амь ахуйн орчин тойрны асуудлыг үндэснээс нь хэлбэл эх байгалийг хэтэртэл ашигласан, бүдүүлгээр нээн ашигласан, бүрэлгэн хэрэглэснээс болсон юм. Эх байгалийг нээн ашиглахад одоо үеийн хүмүүсийн жаргалт амьдралыг тулгуурлах мөртөө бас үр хойчисдоо оршин амьдрах үндэс суурь тавьж өгөх хэрэгтэй” [1] гэсэн яриа тавьсан байна.

Иймээс бид эх байгалийгзүй зохистойгоор нээн ашиглах ба хамгаалах хэрэгтэй мөртөө байгаль амь ахуйн тухай хүмүүсийн үзэлт танилт ба ойлгогдохууныг дээшлүүлэг чухалтай. Хүн ба байгал харилцан түшиглэн, харилцан нөлөөлж оршдог ёстой.

НОМ ЗҮЙ

[1] “Өвөр Монголын өдрийн сонин” 2017 оны 5 сарын 27-ны өдөр

[2] “Өвөр Монголын өдрийн сонин” 2015 оны 3 сарын 10-ны өдөр

- [3] “Аянгын туужсын шинжлэл” О.Сарангоо Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо 2005 оны 10 сар, 4 дугаар нүүр
- [4] Аянга “Шатдаг ус”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2006 оны 12 сар
- [5] Чин хуа “Одоо үеийн монгол уран зохиолд тусгагдсан амь ахуйн эвдэгдлийн үр нөлөө” Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан 2015 оны 5 дугаар хугацаа
- [6] Зан шиуе жиюн “Амь ахуйн боловсныг бүтээн байгуулахын утга чанарыг өгүүлэх нь”, Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан 2011 оны 2 дугаар хугацаа

СОЁЛ СУДЛАЛ



МОНГОЛ ТҮҮХЭН ЗОХИОЛД СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ
ДҮРСЛЭН ХАДГАЛЖ, ДАМЖУУЛАН ӨВЛҮҮЛЖ ИРСЭН
УЛАМЖЛАЛ, ТУРШЛАГА

САРАНТУЯА

*(БНХАУ, Өвөр Монголын Үндэстний цэцэрлэгийн багшийн
тусгай мэргэжлийн дээд сургууль,
МУИС-ийн ШУС-ийн ХУС-ийн
Утга зохиолын тэнхимийн докторант)*

Хүн төрөлхтний бүтээн бий болгосон соёл, өв уламжлал, туулж өнгөрүүлсэн түүх нь уран сайхны ертөнцөд шингэсэн уран дүрийн хүчээр амьд, тодорхой хадгалагдан үлдэж, эргэн дурсагдаж байдаг. Иймээс уран сайхны бүтээл туурвилаас нэгэн улс үндэстэн төдийгүй нийт хүмүүн төрөлхтөн өөрсдийнхөө туулсан хөгжлийн замын түгээмэл хийгээд өвөрмөц онцлогийг олж харж, ирээдүйн хөгжил дэвшлийнхээ сургамж сануулгыг авдаг болохоор, судлаачид энэ зүгт анхаарлаа хандуулах шаардлага гарч байгаа юм.

Нөгөө талаар монгол үндэстний хэмжээнд гэхэд өнөөгийн байдлаар өөрсдийн бүтээсэн соёлын биет бус өвөөс 16-г ЮНЕСКО-ын соёлын биет бус өвийн янз бүрийн түвшний ангилалд бүртгүүлсэн байдаг нь бидэнд энэ чиглэлийн судалгааг яаравчлахыг сануулж байна.

Хүмүүн төрөлхтний түүхэн хөгжлийн урт урт удаан харгуй замд утга соёл гэгч зүйл ямагт удамшин тухайн угсаатны туулсан замыг тодотгох хүч болсоор иржээ. Бидний эрхэмлэн дээдэлдэг Хүннү гүрэн өөрсдийн бүтээсэн утга соёлын өвтэй байсныг тэр нь угсаатныхаа ой ухааныг баяжуулагч ардын аман зохиолд хадгалагдан шингэж ирснийг түүхийн буурал тоосон дундаас үлдэж хоцорсон утга зохиолын өв дурсгалаас харж болно. Хүннү нарын үед дуулагдаж байсан “Чилегийн дуу”-ны домогт:

“Хүннүгийн Шаньюй маш гоолиг охинтой юм санж. Улсын иргэн тэднийг нь “Тэнгэрийн охид” гэгцгээнэ. Шаньюй: - Хөөрхөн охидоо хадамд яаж өгөх вэ! Тэнгэрт өргөө гэж хэлж гэнэ. Хүннү нар бөө мөргөлтэй аж. Түүний улмаас улсынхаа умард зэлүүд газар өндөр асар татаж босгоод, түүнийхээ дээр тагт байгуулан хоёр охиноо дотор нь оруулаад “Тэнгэр минь өөрөө аваарай” хэмээн залбирч мөргөөд буцаж гэнэ. Гурван жил болжээ. Эх нь охидоо санаад

- Очиж авъя гэв. Шаньюй:

- Цаг нь болоогүй гээд үл зөвшөөрөв. Дахиад нэг жил өнгөрч гэнэ. Нэг хөгшин чоно ирээд охидыг өдөр шөнөгүй харуулдаж байдаг болжээ. Тэгдэг ульдаг болж гэнэ. Ульсаар л байж. Асрын ёроолд нүх ухаад тэндээсээ ер гарахаа болов. Нэгэн өдөр дүү охин нь “-Одоо энэ чоно эндээс салахаа байлаа. Энэ лав тэнгэрийн тэмдэг биз? Тэнгэр үүнийг илгээсэн байлгүй. Доошоо бууж түүнд очтугай гэв. Эгч нь их эмээхэд, дүү нь эгчийнхээ үгэнд оролгүй доошоо бууж чонотой нөхцөж гэнэ.

Удалгүй тэд хүүтэй болов. Түүний удам өсөн үржсээр улс болжээ. Тэрхүү улсын иргэд чоно улих лугаа адил уянгалсан урт дуутай болсон гэнэ.”

Ингэж уянгалсан урт дуу буюу нэгэн соёлын биет бус өв - уртын дуу үүссэн тухай домогложээ. Тэгвэл бас нэгэн домогт өгүүлэх нь:

Хүннүгийн Модун Шаньюйгийн үед юм гэнэ. Хүннүтэй зэргэлдээ аймгийн ноён нь нэг удаа: - Хүлэг сайн морио өг гэжээ. Энэ үгийг түшмэл нь Модун Шаньюйд дамжуулбал хэсэг бодолхийлснээ:- Айл зэргэлдээ аймгийн ноён юм. Надад хүлэг сайн морь минь тустай чиг, ноён сайн морьтой байя гэж бодсоны буруу юу байх вэ, гуйсан морийг өг гэжээ. Дараа нь төд удалгүй өнөөх ноён: - Хацар гоо хатнаа өг гэж хэлүүлжээ. Модун Шаньюй энэ үгийг сонсоод бага цочирдсон ч: - Эр хүн хацар сайт хатнаар өөрийгөө чимэх гээ биз. Хоёр аймгийн найрсаг харилцааг бодоод хатныг өг гэжээ. Тэгээд удаагүй байтал өнөөх ноён: - Газар нутгаасаа багахныг өгөөч гэж хэлүүлжээ. Түшмэл Шаньюйд энэ үгийг дамжуултал асар их хилэгнэж байчхаад бүүр газар нутагт минь санаархана гэнээ. Миний нутгийн газраас хэн ч гуйсан алга дармыг ч хэзээд ч бүү өг хэмээн хамаг цэргээ дайчилж хөрш аймгийг эзлэн авав”

гэжээ. Домгийн ганц энэ үг л монгол угсаатны хувьд зуун, зууныг дамжсан газар нутгаа хамгаалах дуудлага болж урлаг, утга зохиолд мөнхөжсөн юм.

Энэ домог үргэлжилсээр, он жил улирсаар Монголчуудын хүчирхэг болсон XIII зуунтай золгов. Чингээд Монголын нууц товчоонд Чингис хааны гарлыг дурдахдаа “...Дээд тэнгэрээс заяат төрсөн Бөрт чоно, Гуа марал хоёр тэнгис далайг гаталж...” хэмээн эхэлдэг байна. Хэрвээ энэ домог бичгийн утга зохиолоор дамжин, хожим хойч үедээ уламжлаагүй бол бидний өвөг дээдсээрээ бахархдаг үнэт зүйлийн сэтгэлгээ өөр байх байсан. Домгийн энэ санаа уламжлагдан залгамжлагдсаар XX зууны төгсгөл болоход “Тэнгэрийн тамга” дууны шүлгийн:

“Ууланд чоно улих шиг дуулдах

Ухаант дээдсийн минь

Удам ч биш байгаа даа?...”

гэсэн мөрөөр өвлөгдсөн байна. Энэ бол соёлын биет бус өвийн гол төрөл болсон аман зохиолын уламжлал, түүнийг илэрхийлэх хэлбэрийн нэг – домог монгол уран зохиолд салахгүй дүрслэгдсээр өдий хүрснийг харуулж байгаа нэгэн баримт болж байна. Үүнд нэн ялангуяа монгол хүний үүсэл гарлыг чонотой холбон өгүүлсэн домгийн зүйлийг онцлон дурдаж болно.

Тэгвэл 1976 онд эрдэмтэн М.Гаадамбын хэвлүүлсэн “Нууц товчооны нууцаас” [УБ, УХГ] бүтээлийг авч үзэж болно. Энэ бүтээлд Монголын нууц товчоонд ашиглагдсан соёлын биет бус өвийн аман зохиолын уламжлал, түүний илэрхийллийн хэлбэрүүдийг тодорхойлон гаргасан нь бидний судалгаанд үнэт хэрэглэгдэхүүн болж байгаа билээ.

Ер нь Монголын нууц товчоог судалсан олон эрдэмтэд энэхүү дурсгалт бичигт аман зохиолын холбогдолтой олон зүйл байдгийг тэмдэглэсээр ирсэн юм. Академич Б.В.Бартольд Монголын нууц товчоог

“Баатарлагийн туульд хамруулбал зохино”¹⁹ гэж дүгнэсэн бол академич Б.Я.Владимирцов “Монголын нууц товчоог” наад зах нь бичгээр тэмдэглэгдсэн, утга зохиолын үүднээс боловсруулсан тал нутгийн туульсын зохиолын хамгийн сонирхолтой жишээ мөн”²⁰ гэжээ. Тэгвэл академич С.А.Козин Нууц товчоог олон талаас нь судлан бичсэн эрдэм шинжилгээнийхээ өгүүллийн удиртгалд “Аман захиа бол дурсгалт бичигт орсон олон зүйр цэцэн үг, мэргэн оновчтой үгс, ардын уянгын болон түүхэн уянгатай дууны хэсэг тууль, орчилт туулийн тасархай зэргийн нэг адил ардын аман зохиол”²¹ гэж дүгнэжээ.

Энэ бүхнээс улбаалан Монголын нууц товчоог дагнан судалсан эрдэмтэн М.Гаадамба “Бидний санавал Монголын нууц товчоонд тэр цагийн монголчуудын хэл яриа, аман зохиолд тэр цагт өргөнөөр хэрэглэгдэж байсан зүйр цэцэн үг, дуу домог үг, үлгэр туулийн хэсэг үнэхээр байхаас гадна орчин цагт уламжилж ирсэн аман зохиолын олон зүйлийн учир утгыг тайлахад чухал холбогдолтой материал, хэрэглэгдэхүүн их бий...”²² хэмээн нэгтгэн дүгнэсэн юм.

Судлаачийн энэ үг бол, бидний судалж байгаа монголын соёлын биет бус өв нь уран зохиолоор тээгдэн, үеэс үед хадгалагдаж ирсний бодит жишээ мөн. “Монголын нууц товчоо”-ноос уламжилсан олон зүйл хожмын утга зохиол, урлагийн бүтээлийн уран сайхны дүр бүтээх, зохиолын сонирхолтой үйл явдлын үр үндэс болсон нь арвин юм. Тухайлбал өнөөгийн манай уран зохиолд ахчлах, дүүчлэх ёсны тухайд: “Хүн ахтай Дээл захтай” гэсэн зүйр үг буй. Үүний гарал хэдий үеэс уран зохиолын зүйлд хэрэглэгдэх болсныг мөшгөвөөс, нэн эртний, лавтай мянга шахам жилийн өмнө энэ зүйр үг баатрын дүр бүтээхэд оролцож байсныг батална. “Монголын нууц товчоо”-ны 33-р зүйлд:

“Бодончир, Буха - Хатаги ахынхаа хойноос даган хатиран явж өгүүллрүүн: “ - Ахаа, ахаа, Бие тэргүүнтэй \толгойтой\ Дээл захтай нь сайн” гэв. Ах нь Буга - Хатаги тэр үгийг тоосонгүй.”

Мөн 34-р зүйлд:

“Өнөөх дахин хэлбэл ах нь бас тоосонгүй, хариу ч хэлсэнгүй. Бодончир цааш явахдаа мөнөөх үгээ бас хэлэв. Ах нь сая Хариу болгож “Чи энэ үгийг юунд дахин, дахин хэлээд байна”

гэв. 35-р зүйлд:

“Саяын Түнхилэг - Горхиноо бүхий хүмүүс - их бага сайн, муу толгой шийр үгүй, бүгд эн чацуу, хялбар хүмүүс байна. Бид тэднийг хуульяа \эзлэн авъя\”

¹⁹ В.В.Бартольд.Сочинения.т.1.1963.М.,Стр.91.

²⁰Б.Я.Владимирцов. Монгольская литература.сб.,Литература востока. Вып.2.Петроград.1920.стр.94.

²¹ С.А.Козин. Сокровенное сказание Монголов.Монгольская хроника 1240.под названием Юань чао би ши монгольский обыденный изборник.Т.1.М- Л.1940. стр.50.

²² Ш.Гаадамба. Монголын нууц товчооны судлалын зарим асуудал. Улсын Хэвлэлийн Газар. Улаанбаатар. 1990.,103-р тал

гэв. 36-р зүйлд: “Ах нь өгүүдрүүн: “За тийм бол гэртээн хүрч ах – нар дүү – нэр зөвлөлдөж тэд иргэнийг хуульяа\ гэвэлцэж.

37-р зүйлд:

“Гэртээн хүрээд ах – нар, дүү нэр хэлэлцэж хуулахаар мордов. Бодончирыг хошууч болгон довтлуулав”.

38-р зүйлд:

Бодонцор, хошууч довтолж нэгэн жирэмсэн эмийг барьж, “юун хүн бэ? чи” гэж асуув. Тэр эм өгүүдрүүн: “Зарчууд омгийн алдарт Урианханы эмэгтэй байна би”

гэв. 39-р зүйлд:

“тэдгээр хүмүүсийг ах – нар, дүү – нэр тавуулаа олзлон авч \Бодонцор\ мал хөрөнгөтэй, зарц, шивэгчинтэй, гэр оронтой, тухтай суух болов”

гэж гарч буй нь “Хүн ахтай Дээл захтай” гэсэн зүйр үг нь их эртнээс үүсэлтэй бөгөөд монголчуудын мандаж, дэвжин дээшлэхэд ямар их тустай байсныг бичгийн уран зохиолд тусган үзүүлж, улмаар ардын сурган хүмүүжүүлэх ухаанд хүүхдийг багаас нь өөр хоорондоо эв найртай явах ухааныг төлөвшүүлэх үндэс болж иржээ. Энэ тухайд Монголын нууц товчоо-ны 19-р зүйлд:

“Хаврын нэг өдөр үүцэлсэн хонины мах чанаж Бэлгүүндэй, Бөхөөндэй, Буга – Хатаг, Бухат – Салжий, Бодонцор – Монхог эд таван хөвгүүдээн зэрэгцүүлэн суулгаж, нэг, нэг сумыг хугалагтун гэж өгөв. Нэг сумыг юу байхав, хугачиж орхив. Бас таван сумыг хамт цуглаж хугалагтун гэж өгөв. Тавуул таван цугтай сумыг гар дамжуулан тойруулж хугалж чадсангүй.”

20-р зүйлд:

“Тэгэхэд Алан – Гоо эх нь хэлбээ. “Бэлгүүндэй, Бүгүнүтэй та хоёр хүү минь намайг энэ гурван хөвгүүнийг төрүүлчихлээ. Хэний, юуны хөвүүд байдаг байна гэж сэрдэн хэлэлдэнэ. Сэрдэх тань зөв.”

21-р зүйлд:

“Шөнө бүр цэгээн шар хүн, гэрийн өрх тогтоны ярзангаар \Гэрт\ орж ирээд хэвлий минь илж гэрэл туяа нь хэвлийд минь шингэдэг билээ. Гарахдаа наран, сарны хилээр \үүрээр\ шар нохой мэт шазвалзан гарах бөлгөө...”

гэх буюу Мөн дараагийн зүйлд:

“Бас Алан - Гоо, таван хүүхдэдээ сургаал хэлсэн нь: Та таван хөвүүн минь ганц хэвлийгээс төрөв. Та нар саяын таван сум мэт ганц ганц болбол, тэр нэг сум мэт хэнд ч хялбар хугалагдах. Та нар тэр таван цугтай сум мэт хамт нэгэн эетэн болбол хэнд ч яахин хялбар дийлдэх вэ? гэв”

Энэхүү зохиолд хадгалагдсан сургаал олон үеийн уран зохиолоор дамжин, тээгдэн, өвлөгдөн уламжлагдаж ирэхдээ уг санаа нь анхных нь мэт гүн гүнзгий байдаг нь гагцхүү түүх–уран зохиолоор дамжсан соёлын биет бус өв нь тухайн үндэстэнд хэдэн зуунаар ч өвлөгдөх суурьтай байдгийн илэрхийлэл болж байна.

Ардын аман зохиол хийгээд бичгийн зохиолоор өвлөгдсөн соёлын биет бус өв нь улс орны хөгжил шинэчлэгдэх тутам санах, сэрэх, сургахын

ухаан нь болдог учраас утга учир нь улам гүнзгийрдэг зүй тогтолтой байна. Энэчлэн соёлын биет бус өвийн хэрэглээ, түүний утга учрыг эртний бичиг соёлын олон зүйлээс олсны үр дүнд тэрхүү соёлын биет бус өвийн агуулгын шинэ нэгэн холбоос, шинэлэг нэгэн утга учир гарч ирдэг байна. Тухайлбал энэ цаг үеийн утга зохиолд монголын эрт болон дундад үеийн түүхийн сэдвээр, “Монголын нууц товчоо”-оос сэдэв, зохиомжоо уламжилсан бүтээл олон байна. Үүний учир нь тухайн үндэстэн, ард түмний урлаг, утга зохиолын шим тэжээл авах хөрс нь өмнөх үеийн шилдэг уламжлал болсоор байгаад оршино.

Нүүдэлчин ард түмний бүтээсэн биет бус соёлын нэгэн содон өв бол сацал мялаалгын ёс, зан үйл билээ. Энэ өв Монголын нууц товчоонд маш тодорхой дүрслэгджээ. “Монголын нууц товчоон”-ы 103-р зүйлд:

“...Тэмүжин “тэдгээр гурван мэргэд үнэхээр гэрийн зүг явав уу? эсвэл бүгж байна уу? гэдгийг мэд гэж Бэлгүдэй, Боорч, Зэлмэ гурвыг мэргэдийн хойноос туршуулахаар даган мөрдүүлж мэргэдийг нэгэнт зайлан одсоныг мэдээд Тэмүжин Бурхан дээрээс бууж, өвчүүндээ мөхлийдөн залбирч өгүүлрүүн:

“Ухаагчин эхийн солонго болж

Сонсоны хүчээр үен болж

Үзсэний ачаар

Бүтэн биеэн

Буруулан

Бугиа морьт \аргамжааны морьтой\

Бугын ором оромлож \Бугын жимээр замнаж\

Бургасан “Гэр” гэрлэн \Бургас модыг гэр болгон ашиглаж\

Бурхан дээр гарлаа.

Бурхан – Халдунд

Бөөсний чинээ амиан

Булзуулагдав, би.

Ганцхан \заяасан\ амиан хайрлан

Ганц морьт \гадаа байсан ганц морьтой\

Хандгайн ором оромлож \Хандгайн жимээр замнаж\

Халхасан “гэр” гэрлэн \халх нөмрийг гэр болгон ашиглаж\

Халдун дээр гарлаа би.

Халдун – Бурханд

Харцаагийн \цагцаагийн\ төдий амиан

Халхдагдав – заа би \хамгаалагдав би.\

Маш айгуултав би \маш их айдас хүрэв\

Бурхан – Халдуныг

Сацал өчүүл өгөв” \цацал өргөж залбирав\

Мялаасугай.

Өдөр бүр \Үдэш бүр\

Өчсүгэй. \залбирсугай\

Ургийн ураг минь наран зүг хандаж бүсээн хүз

Ухтугай.\Энэ учрыг мэдтүгэй\ гэж, наран зүг хандаж, бүсээ хүзүүндээ эрхийлж, малгайгаа гартаа шээзгийлж, гараан

өвчүүндээ мөхлийдөж, есөнт сөгдөж сацал өчүүл өгөв. \цацал өргөж өчин залбирав\

Энэ бол “Монголын нууц товчоо”-оор уламжлагдаж ирсэн соёлын биет бус өвийн аман уламжлалын илэрхийллийн нэг гол төрөл сацал мялаалгын маш эртний зан үйл болно. Тэртээ XIII зуунаас өмнө бий болсон сацал тахилын төрт ёсны энэ зан үйлийн уламжлалыг Тэмүжин өвлөн залгамжилж, тээж байгаа учраас “...Наран зүг хандаж, бүсээ хүзүүндээ эрхийлгэж, малгайгаа гартаан шээзгийлж, гараан өвчүүндээ мөхлийдөж, есөнтөө сөгдөж...” зан үйл, ёслолоо гүйцэтгэсэн байна. Улмаар энэ зан үйл, соёлын биет бус өв утга зохиолд бичгээр тэмдэглэгдэн үлдсэн учраас хадгалагдан баримтат өв болж, үүний ачаар нүүдэлчин монголчууд эртнээс аваад өнөөдрийг хүртэл Бурхан – Халдун хайрхнаа болон бусад уул овоогоо тахих ёсоо алдалгүй мэдэж буй билээ. Үүний тул бид уран зохиолоор уламжилж ирсэн соёлын биет бус өвийг дээдлэх, өвлөн уламжлах ёстойг хойч үедээ ямагт ойлгуулан ухааруулах ёстой билээ.

Монголчуудын бүтээсэн соёлын биет бус өвийн нэг содон уламжлал бол аман захидал юм. Монголын нууц товчооны 179-р зүйлд:

“...Бас Чингис хаан Жамуха андад хэл гэж аман захидал явуулсан нь: Хан эцэгт байсны минь үзэн ядаж хагацуулав чи. Чи, бид хоёрын хэн урьд боссон нь Хан эцгийн хөх сөнгөөс айраг залгилах бөлгөө. Би эрт босож залгилж байсанд чи атаархав, чи. Өдгөө чи хан эцгийн хөх сөнг хуурайлагтун. Хэдий хороох вэ? чи” гэж илгээв. Бас Чингис хаан “Алтан, Хуцар хоёрт хэл” гэж аман – захидал явуулсан...”

гэж буй. Аман захидал, аман бичгийн хэл гэдэг томьёолол нь монгол туургатны ардын аман зохиолоос улбаалж бичгийн соёлд нэвтэрсэн өвөрмөц соёлын өв болохын дээр эрт болон дундад үеийн монголчуудын дунд уламжилсан соёлын биет бус өвийн маш сонирхолтой жишээ мөн.

Үүнчлэн Монголчуудын эртнээс өвлөн уламжилж, тээн хадгалж, дамжуулж ирсэн соёлын биет бус өвийн нэгэн илэрхийлэл нь бэр гуйх зан үйлийн ёсон билээ. Тэгвэл энэ соёлын зан үйлийг Монголын нууц товчоонд маш өвөрмөц дүрслэлээр тээн хадгалсан байна. Үүнийг үзвэл:

“...Есүхэй баатар Тэмүжинийг 9 настай байхад Өөлүн эхийн төрхөм Олхонуд иргэнд нагац нараас нь охин гуйя гээд Тэмүжинийг аваад явав. Явах зуур Цэгцэр, Чихургу хоёрын зүүр Хонхэрэйдийн Дэй–Сэцэн тохиолдов.”

гэсэн байдаг. Энэ зүйл бол монголчуудын гэрлэх зан үйлийн маш өвөрмөц ёс юм. Улсын үүсэл болсон өрх гэрийг үүсгэх ёсон их эртний, хатуу тогтсон дэгтэй байжээ Тэр цагт эцэг, эх, хөвүүд, охидыг багаас нь сонгон ижилсүүлж байв. Тэгэхдээ хаанаас охин авах ёсон нарийн дэгтэй байлаа. Зохиолын энэ хэсэгт гарч байгаагаар бол хөвгүүнд заавал нагацын талаас охин сонгодог. Тэгэхдээ худууд харилцан шинжиж хэн хэнийхээ сэтгэлд хүрсэн хөвгүүн, охиныг ижилсүүлдгийг:

“Дэй–Сэцэн өгүүллүүн “Есүхэй худ хэнд зорьж явнам?” гэв. Есүхэй өгүүллүүн: Энэ хөвгүүний минь нагац нар–Олхонууд иргэнээс охин гуйя гээд явж байнам гэв. Дэй–Сэцэн өгүүллүүн: - Энэ хөвүүн чинь нүдэндээн галтай, нүүрэндээн гэрэлтэй хөвүүн байна.”

гэснээс үүдэн Дэй–Сэцэн урьд шөнийн зүүдээ ярьж тэгээд өөрийн нь зүүд Есүхэй баатрыг хан–хүүгээн авч ирэхийг үзжээ.

“-Бидний Хонхэрэйд иргэд эртнээс эхлэн “Зээгийн зүс, охины өнгөтөн” \Зээгийн зүсээр, охины өнгөөр явагсад хэмээн өгүүлээд:

Харь улс эзлэхээр үл тэмцэлдэж
Хацар гоо охидыг
Хатнаар заяагдсан Та нарын
Хасагт тэргэнд суулгаж
Хар буур хөллүүлж
Хатируулж одож
Хатан сууринд хамт суулганам бид...”

хэмээн бэлгэт үгийг хэлж:

“Нуган хүүхэд маань нутаг харюу
Охин хүүхэд маань өнгө үзэгдюү”

хэмээн Есүхэй баатрыг гэртээн авчирдаг. Тэгээд охиныг нь үзвэл үнэхээр нүүртээн гэрэлтэй, нүдэндээн галтай охиныг үзэж сэтгэлдээн оруулав. Охин Тэмүжинээс нэг нас их аравтай ажгуу. Бөртэ нэртэй сөнө хонож маргааш охины нь гуйвал Дэй–Сэцэн өгүүллрүүн:

“Олонтаа гуйлгаж өгвөөс дээжлэгдэх
Цөөнтэй гуйлгаж өгвөөс доромжлогдох
Охин хүний заяа
Төрсөн үүдэндээн өтлөхгүй.
Охиноон би өгье.
Хөвгүүнээн хүргэнд тавьж од”

гэж байна. Монголын нууц товчоонд гарч байгаа энэхүү “Хүргэнийг шинжих”, “Охиныг гуйх ёс” хэмээх соёлын биет бус өв нь гагц уран зохиолоор л тээгдэн олон зууныг дамжин өнөөг хүрсэн байна.

Мөн нүүдэлчин монголчуудын нэгэн үнэт зүйл болсон зан үйл бол анд болох, андалдах ёс билээ. Андлал гэдэг бол итгэлцэл юм. Жаргавч хамт, зововч хамт явъя гэсэн гүн бат барилдлагын илэрхийлэл болно. Соёлын биет бус өв болтлоо хэвшин тогтсон энэ үнэт зүйлийг “Монголын нууц товчоо”-нд олонтоо дүрслэн өгүүлсэн байна. Монголын нууц товчооны 116-р зүйлд:

“...Тэмүжин, Жамуха хоёр Хурхунаг–Жуварт нийлэн бууж, эртний анд бололцсоноо дурдалцаж” андлалыг бататгаж, андын хайрыг улам зузаатгая гэлдэв...”

гэжээ. Тэмүжин хөвгүүн байхаасаа олон андтай байсан. Энэ олон андын дотор Жамуха анд хамгийн чухал байр эзэлнэ. Тэмүжин, Жамуха хоёр эхний удаа андын барилдлагаа байгуулахад Жамуха, Тэмүжинд гурван шагай өгчээ. Түүний хойд хавар хавчаахай нумтан харвалдан наадаж бүхүйд “Жамуха бярууны хоёр эврийг нааж нүхэлж хийсэн дуут булцуугаа Тэмүжинд өгч, Тэмүжиний хайлаас модон булцуу солилцон андалдав. Хоёр удаа анд хэмээлдсэн нь тийм”²³ хэмээгээд

Анд хүний амь нэг
Үлтэвчилдэн, үл салалдан

²³ Монголын нууц товчоон. Улаанбаатар. 2019 он.

Амийг хамгаалж – аюулыг зайлуулна гэж
Амраглахын ёсон \нөхөрлөх\ ёсон тийм.

Одоо бас андыг бататгаж

Хайрыг зузаатгая гэлцэж Тэмүжин,

Мэргэдийн Тогтоогоос авсан алтан бүсийг жамуха андад бүслүүлэв.
Тогтогийн Омголон Халиуныг Жамуха андад унуулав. Жамуха, Ухаас
- Мэргэдийн Дайр – Үсүнээс хурааж авсан алтан бүсийг Тэмүжин
андад бүслүүлэв. Дайр – Үсэний Эвэрт – Ишгэн -Цагааныг Тэмүжинд
унуулав...”²⁴

гэжээ. Энэ ёс бол нүүдэлчин монголчуудын үүсгэн бүтээсэн маш эртний соёл,
ёс, зан үйл юм. Чухам эндээс Тэмүжиний эр бяр ид чадал гүйцэх хүртэл
амьдралын олон нугачаанд өстнийг сөхрүүлж явахын үүд нээгдсэн. Хүлэг
Боорчи, Мухулай зэрэг олон жинхэнэ анд нараа олсон. “*Өгсөх төрийн малгай,
дэвших төрийн дээл, мандах төрийн бүсийг солилцоно*” гэдэг бол
монголчуудын хамгийн эрхэм дээд ёс заншил юм.

Энэ мэт соёлын биет бус өвийн олон зүйл нь монголын түүхэн уран
зохиол, романы дүр дүрслэл, өгүүлэмж, үйл явдлаар дамжин уламжилсаар
өнөө хүрсэн нь соёлын биет бус өвөө унаган төрхөөр хадгалах, дамжуулах,
сэргээхэд чухал баримт, хэрэглэгдэхүүн болсоор ирсэн нь дамжиггүй билээ.
Жишээ нь “Лу. Алтан товч”-ийг онцлон дурдаж болно. Академич
Ш.Нацагдорж:

“Алтан товчийг нарийвчлан үзсэн хүнд түүний дотор хэд хэдэн
зүйлийн түүх тэр хэвээрээ бүхэл бүтэн яваа нь илхэн байна.
Жишээлбэл “Нууц товчоо”-ны хэдэн бүлэг, бас үүнээс гадна “Нууц
товчоо”-нд байдаггүй Чингисийн сургаал үгс зэрэг “Чингисийн
цадиг”-т байдаг зүйл ч байна...”²⁵

гэсэн байдаг. Энэ бол энэ бүтээлд бидний судлагдахуун болсон олон өвийг
багтаасан гэсэн үг болно.

Үүгээр зогсохгүй монгол утга зохиол, түүхэн уран зохиолын үнэт
чухал дурсгал болдог “Шар тууж”, Саган Сэцний “Эрдэнийн товч”, Жамбын
“Асрагч нэртийн түүх”, Ширээт гүүш Дармын “Алтан хүрдэн, мянган хигээст
бичиг”, Рашпунцгийн “Болор эрих” \1774\, Жамбалдоржийн “Болор толь”
\1835\, Галдан туслагчийн “Эрдэнийн эрих” \1841\, Лувсанпэрлэйгийн “Тэгээн
толь”, \1702\, Ишбалжирын “Энэтхэг, Түвд, Хятад монголын шашны түүх
Галбрвас модон” \1748\”, “Хөх нуурын домог”, Гомбожавын “Хятадын
шашны түүх”, Цэмбэл гүүшийн “Монголын шашны түүх” \1819\ болно.
Үүнээс гадна “Жанжаа хутагтын намтар”, “Ишдамбажалсаны цадиг”,
“Ширээт гүүш Цоржийн цадиг”, “Заябандидын намтар” зэрэг цадиг намтар ч
гарчээ. Үүнээс гадна Хэй Ингийн “Усан толь”, Гаван Шаравын “Дөрвөн
ойрдын түүх” “Жангарын түүх”, “Торгууд ханы цадиг”, Мэргэн гэгээний
“Алтан товч” зэрэг олон түүхэн бүтээлүүд гарсан нь энэ үед монголчуудын
түүхэн зохиолын тогтолцоо бүрэлдэн тогтнож, хожим хойчдоо уламжлагдах
гэрэлт зам болсон юм. Эдгээр түүхэн сурвалж бичгүүд монгол соёлын биет

²⁴ Монголын нууц товчоон. Улаанбаатар. 2019 он. 47 -р тал.

²⁵ Ш.Нацагдорж. Алтан товч”-ийн зохиогчийн тухай. ШУТ. сэтгүүл. 1958, 52-р тал.

бус өвийг тээн хадгалж, уламжлуулан дамжуулсаар иржээ. Тухайлбал аман соёлын илэрхийлэл болсон зүйр цэцэн үгнээс аваад ардын дуу, домог, туулийг түүхэн бүтээлдээ ашигласнаараа монгол номын эдгээр мэргэд үндэсний соёлын биет бус өвөө хадгалан үлдээх өөрийн гэсэн уламжлалыг тогтоосон гэж үзэх бүрэн үндэстэй. Учир нь монголын түүхэн зохиол бичсэн номын мэргэд нар соёлын биет бус өвийн гол төрөл нь болсон аман уламжлалын илэрхийлэл болгоныг бүтээлдээ ашигласангүй, зөвхөн өөрсдийн үндэсний сэтгэлгээний үнэт зүйл болон төлөвшсөн соёлын биет бус өв- аман уламжлалын илэрхийллийг оруулсан нь өөрийн гэсэн туурвил зүйн дэг болон хөгжсөн байдаг. Жишээ нь: “*Бөрт чоныг төвөдийн Алтан сандалт хааны отгон хүү*” гэдэг үзэл баримтлалыг огтхон ч зөвшөөрөөгүй байдаг. Нөгөө талаар “Монголын хаан нь энэтхэг, төвөдийн хаадаас уламжлалтай” гэсэн Пагва ламын үндэслэлийг ор тас үгүйсгээгүй ч, энэ тухайгаа:

“Энэтхэг Төвөдийн учир, түүх манай манай Монголд хэрэг нь бага мэт боловч тэнгэрийн хөвгүүн Бөртэ чоно гэгч хааны хөвгүүн бүхийг мэдэхийн тул бичив”

гэх зэргээр учирлан тайлбарласан оруулбар оруулсан байдаг²⁶.

Ер нь эрдэмтэн мэргэд монголчууд болоод Чингис хааны угсаа язгуурын талаар санал бодлоо дэвшүүлсэн нь элбэг. Тэдний дотор Мэргэн гэгээний санал ч бас өвөрмөц байдаг. Мэргэн гэгээн Чингисийн уг язгуурыг төвөдийн хаанаас гаралтай гэдгийг эрс эсэргүүцэж:

“Тийнхүү “айхгүй, ичихгүй, дэмий балай донгодох мунхгийн туйл хүрсэн мухар сохор зүг болой”

гэжээ. Мэргэн гэгээн “Монгол” хэмээх алдрыг анх Алан – Гоо хатны хүү Бодончир дуурьсгасан гэж үзээд:

“Бодончирын улс нь маш олон болж бүгдийг Монгол гэж нэрийдэв.

Тэрбээр:

Гэрт төр ёсны багштай
Хээрт замын сахиултай
Гэгээн онол, утгын тогтоолтой
Хэрэг авын жаргалтай
Адуу малын сүрэг өсөөд
Алт мөнгөн санхүү арвидан
Алдар чадал маш гийсэн дүр
Аймаг улс маш баясав”

гэсэн нь Мэргэн гэгээн, “Бодончир ээжийнхээ гэрээсийг маш сайн биелүүлсний ач” гэж үзсэн хэрэг юм. Гэхдээ энэ үеийн “товчоо”, “эрих”, “намтар”, “тууж” нь үйл хэргийн байдал, бичиг соёлын түвшин, зохиолч

²⁶ Энэ асуудалд эрдэмтэн Х.Пэрлээгийн дурдсаныг үзвэл, “энэ нь ...мухар сохор үг болмой” гэсэн байдаг. Чоно Төвөдөөс ирээгүй, харин Харин Хөвсгөл нуурын баруун хойд нутгаас, Тэнгис голыг гаталж ирсэн гэж үзсэн юм. Энэ бол эрдэмтэн хүний нарийн ажиглалт буюу болж өнгөрсөн үйл явдалд өгсөн гүнзгий дүгнэлт мөн. Хожмын хүмүүс Монголчуудын угсаа гарвацийг, эх нутгийг зүүн өмнө зүг рүү хандуулж санал дүгнэлтээ гаргасан нь элбэг байхад эрдэмтэн хөдөөгийн Пэрлээ монгол нутгийн умард зүгтэй холбон тайлбар өгсөн нь сонирхолтой юм.

туурвигч нарын мэдлэгийн цар хэмжээ, ертөнцийг үзэх үзэл, урлах эрдмээс шалтгаалж тэдгээр бүтээлд тусгагдсан, хадгалагдсан, тээн дамжуулж ирсэн соёлын биет бус өв нь өөр өөрийн гэсэн олон өнгө зохиролтой, энэ хэрээр тусгаж, тээж ирсэн соёлын биет бус өвөө уламжлуулан залгамжлуулахдаа тус тусын өвөрмөц үүрэг гүйцэтгэсэн онцлогийг тэмдэглэх хэрэгтэй. Эрдэмтэн Г.Жамсранжав ч судалгааны бүтээлдээ ийн тэмдэглэсэн байдаг билээ.

Тэгвэл XIX зуунд, монголын бичгийн их хүмүүн В.Инжаннашийн залган туурвиж дуусгасан “Хөх судар” роман бол:

“Одтой тэнгэрт орчиж Олон улс байлдаж Орондоо унтах завгүй Олзлон булаалдаж байв. Хөх тэнгэр хөрвөж Хөвчин улс хямралдаж Хөнжилдөө унтах завгүй Хөнөөлдөн тэмцэж байсан монголын олон аймгийг нэг жолоонд оруулсан яруу түүхийг бичиж Чингис хааныг гэгээн эзэн, богд хааны дүрийг бүтээж, түүнчлэн амьдлаг бодитой түүхэн баатрууд, эсрэг талын баатруудыг урлагийн аргаар бүтээн, үүгээрээ монголчуудыг дуудан сэрээж монголчууд Чингис хааны үеийнх шиг хүчирхэгжин мандахыг бэлгэдсэн байна.²⁷

Энэ бол яахын аргагүй анхааран үзэх санал мөн. Өдгөө Чингис хааныг ертөнцийг бүтээгч жолоодогч гэж үзэх, бичих болсон нь зөв чиглэл, зөв хандлага болох юм.

“Хөх судар” бол “Монголын нууц товчоо”-ны нэг адилаар соёлын биет бус өвийг монгол хүүрнэл зохиолоор тээн уламжилсан, тэгэхдээ тодорхой зохиогчийн нэрээр бидний үед хүрч ирсэн, тэгэхдээ нийт монгол угсаатны, монгол туургатны утга соёлын өвийг багтааснаараа онцгой бүтээл болох юм. Энэчлэн үндэсний уран зохиолын хөгжлийн үе бүхэнд соёлын биет бус өв нь ямар үүрэг гүйцэтгэж ирснийг он цагаар нь тодорхойлон үзэхэд сонирхолтой зам мөр гарч ирж байна.

²⁷ \ Лиу Вен Яан , Лай Бин Вен зохиов., Инжаннаши. \ намтар \ Улаанбаатар., 2023 он , 112 -р тал \.

**МОНГОЛ БӨХИЙН ЦОЛЫН ТҮҮХ УЛАМЖЛАЛ БОЛОН
ЗАНГИАНЫ ТУХАЙ ТОВЧ ӨГҮҮЛЭХ НЬ**

ТОМИКАВА РИКИДУ

*(Японы Велнесс эрүүл мэнд, спортын
их сургуулийн багш, доктор, профессор)*

ДАЛАНБАЯР

(МУБИС)

Өнөөдрийн байдлаар Монгол Улс нь Үндэсний баяр наадмаар улсын цол болон аймаг сумын цол олгодог бол Өвөр Монголын Шилийн гол аймаг нь 14 жил дараалан “Шилийн гол аймгийн цол олгох найр (наадам)”-ыг хошуу өртөөлөн зохион байгуулж, ард түмний дунд нэгэнтээ хэвшин тогтсон байна. Үүнээс гадна Орны бөхийн цол олгох найр, Хөлөнбуйр аймгийн цол олгох найр зэрэг явагдаж байгаа билээ. Харин ноднин 9-р сард Өвөр Монголын бөхийн нийгэмлэг нь Жангагаар цоллох шинэ дүрэм тогтоосон гэх сургаар бөхийн цолын талаар олон маргаан үүсэж байгаа болохоор, цол болон Жангарын талаар эрдэм шинжилгээний задлалт хийх нь зүйтэй буюу.

Бөхийн цолын талаар судалсан өгүүлэл зохиол ховор байгаа тул бөхийн цолын тухай хүмүүсийн ойлголт дутмаг байгаа нь мэдээж. Тэгвэл хэзээнээс монгол бөхөд араатан жигүүртнээр цол олгож байсан бэ? Жангар хэзээ үүссэн юм? Цол Жангар хоёр нь адилхан уу? өөр үү?

Эдгээр асуудлууд өргөн олон бөхийн сонирхлыг ихэд татаж байна. Тус өгүүлэлд аль болохоор дээрх асуудалд тайламж хийхийг хичээсэн боловч түүхэн материал дутмаг зэрэг шалтгаанаас хангалттай хариулт өгч чадахгүй нь дамжиггүй ээ. Гэвч эдгээр асуудлын талаар сүвэгч гаргаж, цаашдын судалгааны дэвсгэр болгох үүднээс энэхүү өгүүлэл дэвшүүлж байгаа билээ. Олж алдсан зүйлийн талаар мэргэн уншигч уншигчид минь шүүмжлэн тунгаамуй.

Нэг. Бөхийн цолны тухай түүхэн баримтууд

Бөхийн түүхэнд араатан, жүүртэн, хүч шид бүхий нэрээр баатар идтэн бөхөө цоллож байсан түүх уламжлал үлэмж харагддаг. Энэ удаан жил ам дамжин уламжлагдсан Жангар зэрэг баатарлаг туульд алдар ноён Жангарын баатар ялалт байгуулах болгонд нь цол гуншин олгож байсан өгүүлэмж бий. Жишээ нь, Хонгорын цол гуншин нь: “Агуу их хүчтэй Арслангийн араг улаан Хонгор баатар” гэх мэт.

Үүнээс гадна “Хүний начин Хүнд гартай Савар, Догшин хар Санал, Алтан цээж Баавай бөх, Мөнгөн шигшрэг” гэх мэт. Жангарын хамгийн хүчит 12 баатар нь бүгдээр цолтой бөгөөд эдгээр 12 хүчтэнийг “Ахмад 12 арслан” гэж нэрлэдэг. Жангарт Жангарын баатар төдийгүй дайсан баатар нь хүртэл

цолтой байдаг. Жишээ нь “Гүргилт Алтан соёо”, “Жигдэг Цагаан баатар”, “Дуншуур Гэрэл нэртэй Догшин шар мангас”, “Догшин бор магнай” гэх мэт.

Жангарын тууль бол 19-р зууны эхэн хүртэл туульч нар амаар хайлан уламжилж ирсэн монгол үндэстний эртний уран зохиолын охь дээж билээ. Баатарлаг туульд эерэг, сөрөг дүрийн баатрууд нь бүгд цолтой байгаа нь монголчууд эрт аль эртнээс цолоор баатараа алдаршуулж байсны гэрч юм. Туульд баатрууд нь эрийн 3 наадмаар мөчөөрхөж, эцсийн ялалтаа заавал бөхөөр байгуулж, мөрийцөөнөө авдаг өгүүлэмж олон байдаг. Жишээ нь: “Энэ 2 баатар агт хүлгээсээ буугаад, ээжийн хийсэн эгэм далаар нугалдъя гээд тахийн арьсыг тахим хүртлээ эвчээгээд, үхрийн чинээ чулуугаар шидэлцээд, ачаад, ачаад, цохилдоод” гэх мэтээр эрийн сайнаа барилдаж шалгадаг. (Д.Таяа 1999) Энэ мэтээр Жангарын туулийн баатрууд нь гарамгай бөхчүүд байсан бөгөөд баатар бөхчүүдээ “Арслан” гэж нэрлэдэг байсан нь нэн сонирхолтой. Энэ бол монгол бөхийн цолын ууган төрх язгуур утга бөгөөд бөхийн цолын гарваль гэж үзэж болно.

Монголын нууц товчооны 140-р хэсэг бидэнд 13-р зууны эхэн үеийн бөхийн талаар маш чухал 2 жилийн мэдээлэл хангадаг. Нэг нь Бүри бөх “Улсын бөх” гэж 2 удаа онцлон тэмдэглэсэн зүйл байдаг. Энэ нь Чингис хааны үед “Улсын бөх” гэсэн цол олгож байсан баттай мэдээлэл болно. Гэвч ямар наадамд, ямар нөхцөлөөр, улсын бөхийн цол олгож байсан нь тодорхойгүй. Дараа хэсэгт дурдсан мэт Чингис хааны үеийн төрийн бөх нь “Бухын тулалдаан” байсан болохоор, өнөөдрийн мэт нугалгаа барилдаан биш байжээ. Тийм учраас даваа үнэлж цол олгодоггүй байсан байх гэж бодож байна 209-р хэсэгт 4 нохойн нэгэн болох Хубилайг “Чи бээр хүчтэний хүзүүг, бөхчүүдийн бөгсийг дарж өгөв. Бүх цэргийн хэргийг чи ерөнхийлөн захиртугай” гэсэн Чингис хааны соёрхолтыг тэмдэглэсэн байдаг. Энд бөхөөр жишээлж байгаа нь Хубилай бол гарамгай бөх байсан бөгөөд олон баатар бөхчүүдийн дундаас эр чадлаар нь шалгаран гарч, Их Монгол улсын бүх цэргийн ерөнхий захирагчийн өндөр соёрхол хүртсэн гэж ойлгож болно. Нууц товчоонд “Баатар мэргэн бөх” гэх мэтийн цол олон гардгаас харахад “Улсын бөх” гэдэг цолыг улсад түрүүлсэн бөхөд олгосон гэх мэтээр таамаглахын арга ч үгүй ээ. “Бөхчүүдийн дундаас нь цолгорон гарсан гарамгай баатар” гэж тайлбарлах нь зүйтэй. Энэ тухай нарийвчилсан судалгаа шаардагдаж байна.

Ер нь бөх гэдэг үг нь тэр чигээрээ цол байсан бололтой. Нууц товчооны 50-р хэсэгт “Бүри бөхийн нэрийг анх тэмдэглэхдээ хажуугийн орчуулгад 力士 гэж, 140-р хэсгийг нь “Улсын бөх”-ийн хажуугийн орчуулгад 国的力士 гэж хадгалсан нь, түүний цолийг онцолсон учир юм. Харин анхны тэмдэглэлээс хойш Бүри бөхийг “Хүний нэр” гэж холбон хадгалсан нь түүний нэр цолыг нь холбон дуудсаар нэгэнтээ хэвшсэн байгааг харуулж байна. Өөр нэгэн жишээ дурдахад Нууц товчооны 41-р хэсэгт, Баарины өвөг Бааридайгийн хүү “Читхул бөх”-ийн хажуугийн орчуулгыг 力士 гэж хадсан байдаг нь түүний бөхийн цолыг учирлажээ. Нөгөө талаар Нууц товчооны 181-р хэсэгт Хэрэйдийн Сэнгүмийн анд Тогтоа бөхийн хажуу орчуулгыг 师公 буюу бөө удганы “бөө” гэж онцолж хадсан нь, тэр үед баатар буюу “бөх” (цол) зэргийг маш нарийн нягт ялгаж байсныг давхар гэрчилж байна.

Нууц товчоонд Хабич баатар, Начин баатар, Бүлтэт баатар, Есүхэй баатар, Хадаг баатар, Чирхатай баатар, Бүри бөх, Читхул бөх, Чилгэр бөх гэх мэтээр “Баатар”, “Бөх” гэдэг үг нь цолны хэлбэрээр олонтоо гардаг нь, соёл уламжлалын хувьд баатарлаг тууль жангартай ижил төсөөтэй байгаа билээ. Хэдийгээр мэдээллээр дутмаг ч, Чингис хааны үед цолны тогтолцоо тодорхой хэмжээнд бүрэлдсэн байна. Тэр үеийн бөхийн цолыг ямар нэгэн найр наадмаар олгож байлаа гэх тодорхой баримтгүй үгүй боловч олон бөхчүүдийн дотроос цолгорон гарсан хүчтэн бөхөөр цоллож нэр цолыг нь халуун алдаршуулж байсан нь баттай байна.

140-р хэсгээс хангах 2 дахь мэдээлэл бол Чингисийн үеийн бөх нь одоогийн бөхөөс эрс өөр, дээр зууны гучаад он болтол Монгол Улсын баруун Монголчуудын дунд уламжлагдаж байсан “Бух ноололдоон” Алшаа нутгийн “Шалбур бөх” хэмээх язгуур бөх байсан явдал болно. “Бүри бөх Бэлгүүтэйг өрөөсөн гараар барьж, өрөөсөн хөлөөр ташиж унагаагаад, хөдлөлөөр дарж чадах аж” гэж тэмдэглэсэн нь, тэр үед бөх нь **“хөдлөлгүй дардаг хэвтээ барилдаан”** байсныг харуулж буй. Харин язгуур бөх “Бух ноололдоон” нь бөхчүүдэдээ араатан жигүүртний цол олгодог мөртөө цолыг нь бэлгэдсэн өнгө бүрийн хадаг зүүж өгдөг тухай дараах мэт сонирхолтой судалгаа буй. (“Алагийн Баянтогтох, Балжирийн Баттогтох, 2015 он.”)

“Бөхчүүдийг гурван арван бүрд байр эзлүүлэн, **шонхор шандас, тулгат, гарди, харцага, бүргэд, барс, начин, заан, арслан, аварга, луу (их аварга)** зэрэг цолуудыг дагалдах чимгийн хамт олгож эдгээр цолонд тохирох өнгө бүрийн цагаан, шар, цэнхэр, улаан, ягаан, хөх, хар, улбар шар, ногоон, цайвар, ногоон өнгийн хадаг зүүж өгөх бөгөөд дараагийн наадмуудад хадгаа малгайныхаа залаагаас уядаг болохоор хэдэн удаа хэддүгээр байр эзэлж, ямар алдар цолд хүрсний илтгэл байжээ. Багалуур арав (хамгийн дээд зиндаа) -г түрүүлсэн бөхчүүд барс начин заан арслан аваргууд луу (их аварга) цол олгож байсан мэдээтэй.

Тэрэг хадгийг бөхийн зангианы үүсэл гарвалийн нэгэн учиг гэж үзэж болох бөгөөд бөхчүүдийн цол биш харин цолнын нь бэлгэдэл болж байгаа нь анхаарууштай билээ. Уг номд хэзээнээс цол олгож байсан тухай дурдаагүй ч он удааны уламжлал байж таарна. Өөрөөр хэлбэл дээрх судалгаанд тулгуурлавал 13-р зуунд бөхчүүдээ голцуу араатан жигүүртний нэрээр цоллож, цолны бэлгэдлийг хадгаар илтгэж байсан ажээ.

Манж Чин улсын түүхэн материалд монгол бөхөд цол олгосон нэн баттай тэмдэглэл буй. Манжийн хуучин товхимолд Чин гүрний Тэнгэрийн сэцэн хааны 6-р он буюу 1632 оны Цагаан сар. Гарамгай барилдсан Мэнд (門都) Түмэдхүү (杜而麻), Түмэн хүү (特木德黑) зэрэг 3 монгол бөхөд тус бүр “Арслан түшээт бөх”, “Заан бөх”, “Барс баатар бөх” хэмээх цол хайрлаж хойшид 3 бөхийг заавал цолоор нь дуудах хэрэгтэй. Хэрвээ нэрээр нь дуудвал хатуу торгоно” хэмээн зарлигджээ.

“Дүнхуа леу тэмдэглэл-Тэнгэрийн сэцэн- гэдэг номд тэмдэглэсэнээр Тэнгэрийн сэцэний 8-р он (1634 оны цагаан сар, Түшээт, Жонон зэрэг 3 хошууны бөхчүүд хааны ордонд барилдахад “Арслан гурван хошууны 6 шилдэг бөхтэй хүч үзэв. Арслан зогсож завдалгүй нэг, нэгээр нь өндөр өргөн

шиджээ. Улс даяар эс гайхсан хүмүүс нь үгүй бөлгөө” гэжээ. Энд гарч буй “Арслан” бол даруй дээр дурдсан “Арслан түшээт бөх” цол хүртсэн мэт болно. Анхаарууштай нь хааны зарлигийн дагуу энд бөхчнийг нэрээр нь биш, цолоор нь дуудаж байгаа явдал болно.

Энэ үеийн бөх бол Бух ноололдоон биш, харин одоогийн Өвөр Монголд барилдаж байгаа бөх болно. Манж гүрний эхний үед цэргийн боловсролдоо монгол бөхийг ихээр ашиглаж байсан бөгөөд өөрийн үндэстнийх нь бөхтэй уялдуулан хөгжүүлжээ. Энх-Амгалан хааны 8-р он буюу 1669 онд Хааны ордонд бөхийн хуаран гэдэг тусгай зохион байгуулалт байгуулагдаж 200 бөх тулалдааны бөхчүүд байжээ. Морь сурын 50, 50 тусгай хүмүүс байнгын сорилго дасгал хийж, хааны ордныг үзүүлгэ хийх, хаан эзнээ хамгаалах үүрэгтэй байсны далимд нь дурдъя.

Энэ их түүхт явдал нь Чин гүрний хааны эрх сүрийг Өвөр Монголд харуулсан ба эерүүлэн дагуулах улс төрийн бодлого байсан нь мэдээж. Үүнээс хойш 2 жилийн дараа Лигдэн хааны хөвгүүн Эрх Хонгороос Монгол хаадын үе уламжилсан хасбуу тамгаа Хуан тайжид өргөн барьж, Чингисийн алтан ургийн ноёрхол дуусжээ. Хэдийгээр Өвөр Монголд бөхийн цол чимэг өнөөдөр болтол бүрэн дүрэмжин уламжлагдаж ирээгүй боловч, Монгол бөхийн түүхэнд хаанаас соёрхсон цолын хувьд заавал тэмдэглүүштэй. Өнөөдрийн байдлаар сурвалж бичигт “Зангиа”-аар цоллосон тэмдэглэл харагдахгүй байсаар. Харин араатан жигүүртнээр цоллож байсан тэмдэглэл орон олон харагдаж байгаа билээ.

Бух ноололдоонд бөхийн цол нь өнгө бүрийн хадгаар бэлгэдэн малгайгаас нь зүүдэг байсан уламжлал нь маш сонирхолтой байна. Эрдэмтэн Жин Ганы “Монгол бөх бол арслангийн соёлын загварчлал мөн. Түүрүү бөх мотив бол арслан мөн” гэсэн үзэлт нь бөхийн соёлын чухал шинж чанарыг хөндсөн байна. (Жин Ган 1995 он.) Дээрх түүхэн тэмдэглэлүүдээс үзэхэд бөхийн соёлын түүхэнд араатан жигүүртнээр цоллодог уламжлалтай байсныг мэдрэхгүй байхын аргагүй мөртлөө цолны уламжлалын хувьд сэргээн хэрэгжүүлэх нь бөхийн соёлд нийцэж байна. Далимд нь дурдахад 17-р зууны дунджаас Халх Монголд явагдаж эхэлсэн Даншиг наадам нь Чин гүрний цолны соёрхлыг дуурайсан байж болзошгүй мөртөө өнөөдрийн үндэсний бөхийн цолны дүрмийн үндсийг тавьжээ. Тухайлбал Тэнгэрийн сэцнээс монгол бөхөд цол соёрхсон түүхт явдлаас 8 жилийн дараа буюу 1640 онд тухайн үеийн Халхын Түшээт хан аймагт анхдугаар дүрийн Жавзандамба хутагтад бат орших Даншиг наадам өргөж, түрүүлсэн, шөвгөрсөн бөхөд “Арслан”, “Заан”, “Начин” зэрэг цол олгосон түүхтэй. Гэвч үндэсний бөхийн цол нь олон удаагийн өөрчлөлтийг дамжин 17-18-р зууны хооронд боловсрон тогтжээ. (Батмөнхийн Баяндэлгэр 2017 он)

Хоёр. Монгол бөхийн амилгын ёсон болон бөхийн зангиа

Миний бие бээр Монгол бөхийн судалгаа хийх явцдаа Монгол тулгатны 8 төрлийн бөхийн хамран авч, Монгол бөхийг бэлгэдэл зүйн үүднээс эдгээр бөхийн нийтлэг тал болон ялгаатай талыг харьцуулан судалсан билээ. Үүнд Монгол бөхийн нэгэн төрөл зүйл болох Өвөр Монголын Шилийн гол

зэрэг аймгаар зангиа зүүж барилддаг бөх ч зүй ёсоор хамрагдаж, зангианы тухай ч монгол бөх дэх амилгааны ёстой холбогдуулж судалгаа хийж ирсэн юм. Эдүгээ та бүхэнд соёл хүн зүйн хараасаас бичсэн “Чоно болон Бөх: Монгол бөхийн амилгын ёсны тухай” (2005) гэдэг өгүүллээ товчлон танилцуулж, зангианы тухай ерөнхий ойлголт өгөхийг зорив.

Эрдэмтэн В.Сайнцогт “Амины шүтлэг” (1998) хэмээх зохиолдоо Өвөр Монголын олон нутгийн зан үйлийн тухай дэлгэрэнгүй бөгөөд нягт судалгаа хийж, “Бөх нь хамтын амины хэлбэр байсан” буюу “Хамтлагийн амин сүлд” гэж дурдсан нь монгол бөхийн соёлын маш чухал агуулагдахууныг илтгэжээ. Энэ бол маш үнэ цэнтэй үзэлт билээ. Миний бие бээр “Монгол бөхийн амилгын ёсон” дахь зангиа олох ба юүлэх зан үйлийн монголчуудын уламжлалт мал сэтэрлэх зан үйлтэй соёлын хувьд нягт холбоотой үзэж байна.

Бөхчүүдэд зангиа олгох нөхцөлийн талаар үзэмчин бөх (П.Дугар, Ү.Содном, 1986) маш тодорхой дурдсан байдаг. Үүнд: “Өнгөрсөнд их бага найр наадам хийж, ялгалгүй шан хүртсэн бөхөд зүсмэл зангиа (хуруу хэртэй өргөн зүссэн дурдан)-г шагналын хамт өгдөг. 32- 64 бөх барилдсан наадмын тэргүүн бөхөд хошуу зангиа (аман дөрвөлжин дурдангийн талыг хошуучлан зүссэн) шагнадаг. 128 бөх барилдсан наадмын тэргүүнд гол зангиа (зангидсан торгон хадаг) шагнадаг байв. Энэхүү гол зангиаг татахад, 3 удаа олсон бөх бол сая зангиа хийж зүүх эрхийг олдог” гэжээ.

Үүнээс үзэхэд зангиаг 128 бөх барилдсан наадамд 3 удаа түрүүлсэн бөхөд олгодог бөгөөд гол зангиандаа бусад барилдаанд шагнагдсан зүсмэл ба хошуу зангиагаа нь хуримтлуулан зүүдэг ажээ. Өнөөдөр зангиа олох нөхцөл ихээхэн хувиралт гарсан боловч, бөхчүүдэд зангиа зүүлгэх ёс нь бэлгэдлийн хувьд мал сэтэрлэх ёсонтой гүнзгий холбоотой гэж үзэж байна.

